ДОРНОГОВЬ АЙМГИЙН СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛГО, ЗОРИЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ
АРГА ХЭМЖЭЭНИЙ 2021-2022 ОНЫ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

2023 оны 01 дүгээр сарын 25 Сайншанд сум

| **Бодлогын баримт бичигт тусгагдсан, болон үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх зорилт** | **Стратеги /арга зам/** | **Шалгуур үзүүлэлт** | **Суурь түвшин** | **Зорилтот түвшин** | **Хүрсэн түвшин** | **Хэрэгжилт** | **Үнэлгээний хувь** |
|---|---|---|---|---|---|---|---|
| ***Ерөнхий чиг үүрэг 1. “Ковид 19” халдварт цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлогыг хэрэгжүүлэх*** | | | | | | | |
| ***Үндсэн чиг үүрэг 1.1:*** *“Ковид-19” халдварт цар тахлаас урьдчилан сэргийлэн, эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлогыг хэрэгжүүлж, төсөв санхүүг оновчтой зохион байгуулан, бэлэн байдлыг тогтмолжуулах.* | | | | | | | |
| **Зорилт 1.1.1.** “Ковид-19” халдварт цар тахал шинэ болон дахин сэргэж байгаа халдвараас урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ. | Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, ариун цэврийн дэглэм, эрүүл мэндийн сургалт сурталчилгааг зохион байгуулна. | ААН байгууллагын тоо | 105 | 460 | 204 | Өмчийн хэлбэр харгалзахгүйгээр 35 эмнэлэг, 26 эмийн сангийн үйл ажиллагаанд мөрдөгдөж буй Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Монгол Улсын MNS4990:2015,MNS6767:2019,MNS4969:2000, MNS4643:1998 стандартуудын хэрэгжилтэд хяналт үнэлгээ хийж үзэхэд эрүүл мэндийн байгууллагуудад хүний нөөц, орон тоо дутагдалтай, нэг ажилтан 2-3 ажлыг хавсарч гүйцэтгэснээр ажлын ачаалал өндөр, илүү цагийн хязгаарыг хэтрүүлсэн, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй хариуцсан албан тушаалтан байхгүй зэрэг нийтлэг зөрчил илэрсэн.<br>Хяналт үнэлгээний үр дүнгийн дагуу 17 байгууллагын 6 зөрчлийг арилгуулж, нийт 61 эмнэлэг, эмийн сангуудын удирдлагад Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилт, удирдлага зохион байгуулалтыг сайжруулах, холбогдох мэдээллийг самбартаа байршуулах, тоног төхөөрөмж, галын аюулгүй байдал, ажилтан болон үйлчлүүлэгчийн аюулгүй байдал, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн саадгүй үйлчлүүлэх нөхцөлийг хангах, нэгдсэн эмнэлгүүдийг Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй хариуцсан орон тооны ажилтантай болох, сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд орон тооны бус ажилтантай болох талаар зөвлөмж, зөвлөгөө өгч ажилласан.<br>Эрүүл мэндийн ажилтнуудад Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, холбогдох | 90 |
| | | Сургалтын тоо | 6752 | 26000 | 1492 | | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | стандартуудыг хэрэгжүүлэх чиглэлээр цахим сургалт хийж, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлсэн.<br>Нийт 1492 сургалт, сурталчилгаанд давхардсан тоогоор 204 байгууллага, аж ахуйн нэгжийн 20134 хүнийг хамруулж, 277 төрлийн 13947 ш зөвлөмж сэрэмжлүүлэг тарааж, 9 төрлийн дуут зөвлөмжийг олон хүн цуглардаг 97 цэгт байршуулан түгээсэн нь өмнөх оны мөн үеэс 91 сургалт, 4421 хүнээр нэмэгдсэн. | |
| | Шинэ болон дахин сэргэж байгаа халдвараас сэргийлэх мэдээлэл, сургалт сурталчилгааг иргэд, олон нийт болон мэргэжлийн байгууллагуудад зохион байгуулж, шаардлагатай дадлыг хэвшүүлж, чадавхжуулна. | Сургалт, сурталчилгааны тоо | 514 | 1000 | 1506 | Эрүүл мэндийн зөвлөгөө мэдээлэл өгөх "24 цагийн утас", "Call center" төвийг байгуулж, нийт 3019 дуудлага хүлээн авснаас 30.4% нь эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой зөвлөгөө мэдээлэл, 65.9% нь гэрийн тусгаарлалт, эмчилгээнд байгаа иргэдийн биеийн байдлын тандалт, дархлаажуулалтын зөвлөгөө, 3%-д нь эмнэлгийн тусламж шаардлагатай иргэнийг өрхийн эрүүл мэндийн төвтэй холбож, 0.7% нь талархал илэрхийлсэн дуудлага ирсэн гэх судалгааг гаргасан.<br>Ковид-19 халдварын эсрэг “Комирнэти” вакцины 5-11 настай хүүхдийн дархлаажуулалтын хамралтыг эрчимжүүлэх зорилгоор 5 удаагийн сургалтад 35 байгууллагын 108 ажилчид, эцэг эхийн төлөөллийг хамруулан, 9 төрлийн 455 зөвлөмжийг түгээж,“Хүүхдийн дархлаажуулалт–Бяцхан үрсээ халдварт өвчнөөс сэргийлье” өдөрлөг зохион байгуулж 400 гаруй хүүхэд, эцэг эхчүүдэд мэдээлэл хүргэсэн. Орон нутгийн телевиз, Өнөөгийн Дорноговь сонинтой 3.6 сая төгрөгийн гэрээ байгуулж, нийт 541 төрлийн мэдээ мэдээлэл /цаг үеийн үйл явдлын мэдээ мэдээлэл 211, “Эмч зөвлөж байна“, “Охид хөвгүүдийн цаг” буланд 45, хэвлэлийн бага хурал 6, шторк 279/ нэвтрүүлж, иргэдийг цаг үеийн мэдээ мэдээлэл, зөвлөмжөөр шуурхай хангаж ажилласан.<br>Ковид-19 халдвар, түүний хувилбаруудаас сэргийлэх мэдээлэл сурталчилгааг иргэдэд тасралтгүй хийж, 1506 удаагийн сургалт, сурталчилгаанд давхардсан тоогоор 204 байгууллага, аж ахуйн нэгжийн 20918 хүнийг хамруулсан нь өмнөх оны мөн үеэс 105 удаагийн сургалт, 5632 хүнээр нэмэгдсэн.<br>Цахим хэрэгслээр нийт 11119 төрлийн мэдээ мэдээлэл, сэрэмжлүүлэг, видео зөвлөмж байршуулж, 329153 хандалт авсан нь өмнөх оны мөн үеэс 808 мэдээлэл, 9399 хандалтаар нэмэгдсэн. Дээрх арга хэмжээний үр дүнд иргэдийн халдвараас сэргийлэх тухай ойлголт, мэдлэг, | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хандлага нэмэгдэж, халдварын тоо урьд оноос 11672 тохиолдлоор буурсан. | |
| | Сургалтын байгууллагын багш нарын цахим хичээл боловсруулах арга зүйн сургалт зохион байгуулж, үр нөлөөг дээшлүүлнэ. | Сургалтын тоо | 2 | 8 | 9 | Боловсролын ерөнхий газраас ерөнхий боловсролын 21 сургууль, Политехникийн коллеж, Анагаахын шинжлэх ухааны үндэсний сургуулийн Дорноговь аймаг дахь салбар сургуулийн хими-биологийн 31 багшид Эй Ар /AR/ төхөөрөмжийг ашиглах болон "Ухаалаг утсыг сургалтад хэрэглэх арга зүй" сургалт зохион байгуулсан.<br>“Microsoft Office 365 админ хэрэглэгчийн сургалт”-ыг 2 удаа зохион байгуулж, 36 цэцэрлэг, 21 сургуулийн захирал, эрхлэгч, сүлжээ хариуцсан 80 багшийг хамруулсан.<br>“Боловсролын мэдээллийн технологийн төв”-тэй хамтран “Ээлжит хичээлийн цахим контент боловсруулах багш нарт зориулсан сургалт”-ыг нийт 6 судлагдахууны 60 багш, мэргэжилтэнд, мөн цахим систем /Medle.mn/-д цахим контент байршуулах сургалтыг 3 удаа 4 сургуулийн 25 багшийг оролцуулан зохион байгуулсан.<br>Цахим систем /Medle.mn/-ийн мэдээллийн санд математик VI ангийн 11, дизайн технологи X ангийн 5, монгол хэл VI ангийн 6, мэдээллийн технологийн 19, нийт 41 цагийн ээлжит хичээл байршуулах эрх авсан ба мэдээллийн технологийн 6 цагийн хичээлийг нэмж оруулсан.<br>Багш нарын ээлжит хичээлийн "Цахим контент" боловсруулах 7 жишиг танхимыг 133,0 сая төгрөгийн өртгөөр Боловсрол шинжлэх ухааны газар, 2 сургууль, 4 цэцэрлэгт байгуулсан. Багш нарын тасралтгүй хөгжлийг дэмжих зорилтот 111 модуль сургалтыг Эй плас /Aplus/ платформд байршуулсан бөгөөд ерөнхий боловсролын 717, сургуулийн өмнөх боловсролын 395 багш цахимаар суралцахад 123,7 сая төгрөгийг зарцуулж, цахим хичээл боловсруулах арга зүйн сургалтыг 9 удаа зохион байгуулж, 906 багшийг хамруулсан нь урьд оноос 1 сургалтаар илүү үзүүлэлттэй байна. | 100 |
| | Шинэ болон сэргэн тархаж байгаа халдварын чиглэлээр хяналт шинжилгээ, тандалт судалгаа, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлнэ. | Тандалт, зөвлөн туслах үйлчилгээний тоо | 96 | 800 | 737 | Коронавируст халдварын омикрон хувилбарын дэгдэлт бүхий 3 сумын 70 хүнд Ковид-19 халдварын цар тахлаас сэргийлэх, тандалт хариу арга хэмжээг эрчимжүүлэх чиглэлээр арга зүйн зөвлөгөөг өгч, зөвлөн туслах үйлчилгээг үзүүлж, Ханги боомтын 482 жолоочид лабораторид суурилсан Пи си ар 10 /PCR/ хувилбар тогтоох тандалт хийсэн. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Эрүүл мэндийн газрын даргын баталсан удирдамжийн дагуу 8 эрүүл мэндийн байгууллагад үзүүлэх дэмжлэгт хяналт хийж, зөвлөмж хүргүүлэн, хэрэгжилтийг эргэн шалгаж, алдаа зөрчлийг арилгуулан сайжруулах арга хэмжээг цаг тухай бүрд авсан. Цар тахлаас сэргийлэх чиглэлээр 45 байгууллага, аж ахуйн нэгжүүдийг мэргэжил арга зүйгээр хангаж, хичээл сургууль эхлэхтэй холбогдуулан давхардсан тоогоор сургууль, цэцэрлэгийн захирал, эрхлэгч, эмч, багш нийт 140 хүнийг халдвар хамгаалал, дархлаажуулалтын чиглэлээр сургалтад хамруулсан.<br>Халдварын нөхцөл байдалтай холбогдуулан “Тандалт судалгааны баг”-ийн үйл ажиллагааг тогтмолжуулж, цахим судалгаа /google form/-аар асуумж судалгааг авч, 9738 ойрын, голомтыг тогтоон тусгаарлан, сум, өрхийн албан хаагчидтай хамтран хяналт тавьж ажилласнаар Сайншанд, Замын-Үүд суманд 55612 түргэвчилсэн, 17952Пи си ар шинжилгээг хийхэд 8657 буюу нийт халдварт өвчний 95.3%-ийг Ковид-19-ийн халдвар эзэлж, өмнөх оны мөн үеэс 11674 тохиолдлоор буурсан. | |
| | Зорилтот бүлгийн хүүхдүүдийг томуугийн вакцинд хамруулна. | Хамруулсан хүүхдийн тоо | 650 | 2900 | 5090 | Томуу томуу төст халдварын дэгдэлт, бага насны хүүхдийн томуугийн халдвар, уушигны хатгалгаанаас сэргийлэх зорилгоор аймгийн Засаг даргын 2022 оны А/609,629 дугаар захирамжаар орон нутгийн төсвөөс 29,2 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлүүлж төв хөдөөгийн 06 сартайгаас 5 хүртэлх насны эмзэг бүлгийн, өвчлөмтгий 700 хүүхдийг сонгон томуугийн эсрэг Солонгос улсын Грийн кросс үйлдвэрийн 4 цэнт вакцинаар 2022 оны 10 сард багтаан 100%-ийн хамралттай дархлаажуулав.<br>Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/512 дугаар тушаалаар 11060 хүн тун Солонгос улсын Грийн кросс үйлдвэрийн томуугийн эсрэг 4 цент вакциныг татан авч, 9038 хүн хамруулснаас 4390 буюу 48.6%-ийг 01-12 хүүхэд эзэлж, зорилтот бүлгийн хүн амын 81,7%-ийг дархлаажуулалтад хамруулсан. | 100 |
| | Цэвэрлэх байгууламжийн эрүүл ахуйн аюулгүй бүсийг бий болгож, хөрсний бохирдлыг бууруулах арга хэмжээг авна. | Ажлын гүйцэтгэлийн хувь | 0 | 100 | 100 | “Чандмань-Илч” ОНӨХХК-ийн ахуйн бохир ус цэвэрлэх байгууламжийн цэвэршүүлсэн бохир уснаас дээж авч, Мэргэжлийн хяналтын газрын нэгдсэн лаборатори болон Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн лабораторид шинжлүүлэхэд усан орчин орох 4.8, гарах 4.7, температур орох 18.60С, гарах 18.30С, | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | жинлэгдэх бодис орох 110 мг/л, гарах 83 мг/л, биохимийн хүчилтөрөгчийн хэрэгцээ орох 115мг/л, гарах 54 мг/л, цэвэршилтийн хувь 53%, нян судлалын үзүүлэлтээр гэдэсний бүлгийн эмгэг төрөгч 1мл-т илрээгүй гэсэн дүгнэлт гарсан.<br>Сумд орчны халдваргүйтгэлийн сарын аяныг зохион байгуулах, цэвэрлэх байгууламжийн эрүүл ахуйн аюулгүй бүсийг 10 метрээр тогтоож, хөрсний бохирдлыг бууруулах зорилгоор улиралд нэг удаа буюу 2 жилийн хугацаанд нийт 8 удаагийн хөрсний ариутгал хийж, иргэдийн эрүүл аюулгүй нөхцөлд амьдрах боломжийг бүрдүүлэн ажилласан. | |
| | Ундны усны эх үүсвэрийг бохирдлоос хамгаална. | Цэвэршүүл эх төхөөрөмж ийн тоо | 40 | 80 | 46 | Хүн амын ундны усны эх үүсвэрийг шинжилгээнд хамруулах, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, ундны усны аюулгүй байдлыг хангах зорилгоор 14 сумын унд ахуйн хэрэглээний 95 (давхардсан тоогоор) цэгээс дээж авч, Мэргэжлийн хяналтын лабораторид 82, Улаанбаатар хотын Геологийн төв лабораторид 6 дээж, Ханлаб лабораторид 7 дээжийг шинжлүүлсэн.<br>“Чандмань-Илч” ОНӨХХК, "Чандмань бадрал” ОНӨХХК-ийн ундны усны чанар, аюулгүй байдал, түгээлтэд хяналт шалгалт хийж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн. Сайншанд, Замын-Үүд, Айраг сумдын ерөнхий боловсролын 9 сургууль, 20 цэцэрлэгийн унд ахуйн хэрэглээний уснаас 54 сорьцыг авч, Мэргэжлийн хяналтын газрын сорилт шинжилгээний лабораторид шинжлүүлж 11 дүгнэлт, 8 зөвлөмж хүргүүлсэн. Усны нөөцийг бохирдож, хомстохоос хамгаалах, урьдчилан сэргийлэх зорилгоор усны сан бүхий газар, түүний хамгаалалтын бүс, ойр орчмын 88,5 га талбайг цэвэрлэж, 178,7 тн хог хаягдлыг төвлөрсөн хогийн цэгт төвлөрүүлэх, хөрсний бохирдол үүсгэгч хүчин зүйлийн томоохон шалтгаан болж буй 18 нүхэн жорлонг буулган сөрөг нөлөөг бууруулсан.<br>Даланжаргалан сумын 3 аж ахуйн нэгжийн 4 худаг, Сайншанд, Алтанширээ, Дэлгэрэх сумдын тус бүр 1, Мандах, Улаанбадрах сумдын тус бүр 2 худагт эрүүл ахуйн бүсийг шинээр тогтоон хашаажуулж, тэмдэгжүүлсэн. | 70 |
| | Сургуулийн багш, сурагч, ажилтнуудыг жил бүр эрүүл | Үзлэгт хамрагдса н хувь | 0.8 | 0.9 | 34.2 | Эрүүл мэндийн сайдын 2022 оны 139 дүгээр тушаалын дагуу урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэгт цэцэрлэгээс хамрагдвал зохих 725 багш ажилтны 252 буюу | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | мэндийн үзлэгт хамруулна. | | | | | 35%, ерөнхий боловсролын сургуулиас хамрагдвал зохих 1153 багш, ажилтнаас 395 буюу 34.2% нь, 0-17 насны хүүхдээс 9804 буюу 38.4% нь хамрагдсан. Эдгээрээс 4154 хүүхэд буюу 42.6%-д ямар нэгэн эрхтэн тогтолцооны эмгэг илэрсэн. Үүний 69.5% нь шүдний өвчлөл бүртгэгдсэний 29.1%-ийг эрүүлжүүлсэн.<br>Эрүүл мэндийн сайд, Боловсрол шинжлэх ухааны сайдын хамтарсан 2021 оны А/238, А/340 дугаар тушаалаар батлагдсан эрүүл мэндийн 4 багцын нэмэлт үзлэгт сургуулийн 753 багш, цэцэрлэгийн 399 багш, удирдах ажилтан 100%-ийн хамргадалттай байна.<br>Ерөнхий боловсролын 21 сургууль, сургуулийн өмнөх боловсролын 36 цэцэрлэгийн нийт 778 багш нарыг Эрүүл мэндийн сайдын 2017 оны 145 тушаалын дагуу эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд 100% хамруулсан. | |
| **Зорилт 1.1.2.**<br>Шинэ болон сэргэн тархаж байгаа халдвараас сэргийлэх, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангана. | Эрүүл мэндийн байгууллагуудын хариу арга хэмжээний нөөцийн бэлэн байдлыг бүрдүүлнэ. | Бэлэн байдлын хувь | 49.4 | 51.2 | 0.2 | Эрүүл мэндийн газарт 165200 ширхэг хамгаалах хувцас хэрэгсэл, 9400 мянган ширхэг ариутгал, халдваргүйтгэлийн бодис, 19200 мянган ширхэг эм хадгалан, 2-3 сарын нөөцийг бүрдүүлж, бэлэн байдлыг хангасан.<br>Эрүүл мэндийн яамны 3 удаагийн ханган нийлүүлэлтээр 5 нэр төрлийн 37000 ширхэг 439,5 сая төгрөгийн эм, 11 нэр төрлийн 313000 ширхэг 439,3 сая төгрөгийн хамгаалах хувцас хэрэгслийг татан авч, 20 эрүүл мэндийн байгууллагад хуваарилж, нөөцийг нэмэгдүүлсэн.<br>Эрүүл мэндийн байгууллагууд Коронавирус халдвар, томуу, томуу төст өвчний үед эм, эмнэлгийн хэрэгслийн тасалдал, хомсдолгүй ажиллаж, эмийн 2 сарын нөөц, хамгаалах хувцас хэрэгслийн 3-5 сарын нөөц бүрдүүлж, өдөр бүр Эрүүл мэндийн яамны нөөцийн цахим сан /burtgel.mohs.mn/-д оруулж, Эрүүл мэндийн газраас өдөр тутмын хяналтыг тогтмол хийж ажилласан. | 100 |
| | Замын-Үүд хилийн боомтод зоонозын өвчин судлалын тандалтын нэгж байгуулна. | Байгуулагдсан нэгжийн тоо | 0 | 1 | 0 | Замын-Үүд сумын хилийн боомтод Зоонозын өвчин судлалын тандалтын нэгж байгуулах чиглэлээр Зоонoз өвчин судлалын үндэсний төвд 2, Эрүүл мэндийн яаманд 1 албан бичгийг тус тус хүргүүлж, Замын-Үүд сумын Нэгдсэн эмнэлгийн молекул биологийн лабораторийг түшиглэн тандалтын нэгж байгуулах, хүний нөөцийг бэлтгэж, зоонозын чиглэлээр мэргэшүүлэх чиглэл, зөвлөмж авч, эмч мэргэжилтнүүдийг мэргэшүүлэх, хүний нөөцийг бэлтгэх зорилгоор ерөнхий мэргэжлийн 5 эмчийг 6 сарын сургалтад /3 сар-танхим, 3-сар цахим/ хамруулж, | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | талбарын тархвар судлаачаар бэлтгэхээр шийдвэрлэн, хүний нөөцийн мэдээлэл, нэрсийг хүргүүлсэн.<br>Замын-Үүд сумын Нэгдсэн эмнэлгийн молекулбиологийн лабораторийн үйл ажиллагааг тогтворжуулах, хүний нөөцийн мэдлэг чадварыг дээшлүүлэх зорилгоор Халдварт өвчин судлалын Үндэсний төвийн молекулбиологийн лабораторийн эмч 1, лаборант 1 туршлага солилцохоор 2022 оны 8 дугаар сард тус сумaнд ажиллаж, мэдлэг чадварыг нэмэгдүүлсэн. | |
| | Сайншанд сум болон Ханги хилийн боомтыг РТ-ПСР оношлуураар хангана. | Хангалтын хувь | 0 | 100 | 100 | Аймгийн нэгдсэн эмнэлэг, Замын-Үүд сумын нэгдсэн эмнэлгүүдийн "Молекул биологийн лаборатори"-ийн хүний нөөцийн тогтвортой байдлыг хангаn, танхимын болон цахим сургалтад 9 эмч мэргэжилтэн, ажлын байрны дадлагажих сургалтад 2 лаборантыг тус тус хамруулан чадавхжуулсан.<br>Халдварт өвчин судлалын үндэсний төвийн нэгдсэн лабораторийн баг аймгийн Нэгдсэн эмнэлгийн лабораторийн үйл ажилагаанд хөндлөнгийн үнэлгээ хийж, 12 эмч мэргэжилтнүүдийг ажлын байрны сургалтад хамруулж, арга зүйгээр хангаснаар аймгийн Нэгдсэн эмнэлгийн молекулбиологийн лаборатори нь бүсийн лавлагаа лаборатори болох боломжтой болсон.<br>Энэ онд 2 Нэгдсэн эмнэлэг нийт 107,8 сая төгрөгийн лабораторийн оношлуурыг худалдан авч, нөөцийг тасралтгүй бүрдүүлж, 10111 ширхэг оношлуурын нөөцтэй, нийт 13725 PCR шинжилгээ хийж, 7650 халдварыг эрт илрүүлэн, халдварын голомтыг тухай бүрд нь цомхотгон ажилласан | 100 |
| | Шуурхай арга хэмжээний хамтарсан багийг чадавхжуулан, ажиллах нөхцөл, салбар хоорондын уялдаа холбоог сайжруулна. | Төлөвлөгдсөн арга хэмжээний биелэлтийн хувь | 90 | 100 | 100 | Халдварын тархалтын байдалтай уялдуулан аймгийн Шуурхай штабын нэгдсэн ажиллагааг татан буулгаж, байгууллагын хүрээнд хуваарийн дагуу хариуцлагатай жижүүрийг томилгоожуулан ажиллуулж, аймгийн Онцгой комисс, Эрүүл мэндийн яам, Эрүүл мэндийн хөгжлийн төвийг мэдээллээр шуурхай хангаж ажилласан.<br>Ковидын нөхцөл байдалтай уялдуулан аймгийн эрсдэлийн үнэлгээний баг 1 удаа үнэлгээ хийж, Тохиолдлын удирдлагын тогтолцооны баг 1 удаа хуралдаж, төлөвлөгөөндөө 2 удаа тодотгол хийж багуудыг үүрэгжүүлсэн.<br>“Тандалт судалгааны баг”-ийн үйл ажиллагаа тогтмолжиж, цахим /google form/-аар асуумж судалгааг авч, 9738 ойрын тохиолдол болон голомтыг тогтоон | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | тусгаарлаж, сум, өрхийн албан хаагчидтай хамтран хяналт тавьж ажилласнаар өдөрт бүртгэгдэх халдварын тохиолдол Сайншанд, Замын-Үүд суманд 49264 түргэвчилсэн, 17519 ПСР шинжилгээг хийсэн.<br>Онцгой комиссоос томилсон ажлын хэсэг Хатанбулаг “Ханги” боомт, Иххэт, Алтанширээ сумдад дэмжлэгт хяналт хийж, хамтарсан багуудад арга зүйн дэмжлэг үзүүлж, салбар хоорондын уялдааг хангаж ажилласан. | |
| **Зорилт 1.1.3.**<br>“Ковид-19” халдварт цар тахлын эрсдэлээс урьдчилан сэргийлж, бэлэн байдлыг хангахтай холбоотой төсвийн санхүүжилтийг нэмэгдүүлнэ. | Орон нутгийн төсвийн нөөц сангийн санхүүжилтийг нэмэгдүүлнэ. | Нэмэгдсэн санхүүжилтийн хувь | 0.25 | 0.5 | 0.5 | Орон нутгийн төсвийн нөөц хөрөнгийг оны эхэнд 550,0 сая төгрөгөөр батлуулсан. Ковид-19 халдварт цар тахлын эрсдэлээс урьдчилан сэргийлж, бэлэн байдлыг хангах зорилгоор төсвийн тодотголоор 450,0 сая төгрөгийг нэмж батлуулан, нийт 1,0 тэрбум төгрөгөөр санхүүжилтийг нэмэгдүүлсэн. | 100 |
| | Орон нутгийн гамшгийн эрсдэлийг бууруулах зардлыг төсөвт тусгана. | Төсвийн хэмжээ | 1130 | 380 | 500 | Орон нутгийн 2022 оны төсөвт гамшгаас хамгаалах зардалд 500,0 сая төгрөгийг баталж хүн, мал амьтныг гоц халдварт өвчин болон тэсэрч дэлбэрэх аюулаас урьдчилан сэргийлэх, хамгаалах ажил, арга хэмжээнд зориулан нийт 152,3 сая төгрөг зарцуулсан. | 100 |
| | Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн нөөцийн агуулахыг шинэчлэн барьж, ашиглалтад оруулна. | Баригдсан агуулахын тоо | 0 | 1 | 1 | Ковид-19 халдварт цар тахлын эрсдэлээс урьдчилан сэргийлж, бэлэн байдлыг хангахтай холбоотой төсвийн санхүүжилтийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд 2021 онд Сайншанд сумын 3 дугаар багт "Тотал дистрибюшин" ХХК-ийн хөрөнгө оруулалтаар хүнсний агуулахын барилгыг ашиглалтад хүлээн авсан. | 100 |
| | Замын-Үүд, Ханги авто замын шалган нэвтрүүлэх боомтод ариутгал, халдваргүйтгэлийн байгууламжийг байгуулна. | Байгууламжийн тоо | 0 | 2 | 2 | Засгийн газрын 350,1 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Замын-Үүд боомтын экспорт, импортын зам дээр 2 байгууламжийг худалдан авч, бүрэн угсран ашиглалтад оруулсан.<br>Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн 261,4 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Ханги боомтын автозамын шалган нэвтрүүлэх хэсгийн экспорт, импортын 2 зурваст халдваргүйтгэлийн байгууламжийг суурилуулж үйл ажиллагааг эхлүүлсэн.<br>Нийт 2 боомтоор 23497 тээврийн хэрэгсэлд ариутгал, халдваргүйтгэл хийсэн. | 100 |
| ***Ерөнхий чиг үүрэг 2. Хүний хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх*** | | | | | | | |
| ***Үндсэн чиг үүрэг 2.1:*** *Өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх тогтолцоог бэхжүүлж, орчин үеийн оношилгоо, эмчилгээний технологийг нэвтрүүлж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах.* | | | | | | | |
| | “Эрүүл, идэвхтэй амьдрал” арга | Сургалтад хамрагдса | 54236 | 55200 | 94895 | “Эрүүл, идэвхтэй амьдрал” арга хэмжээний хүрээнд иргэдийг идэвхтэй амьдралын хэв маягт хэвшүүлж эрүүл | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| **Зорилт 2.1.1.** Халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, иргэн бүр эрт илрүүлгийн үзлэг, оношилгоонд тогтмол хамрагдах нөхцөлийг бүрдүүлж, эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, идэвхтэй амьдралын хэв маягийг төлөвшүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ. | хэмжээг хэрэгжүүлж эрүүл мэндийн зөв мэдлэг дадлыг төлөвшүүлж, халдварт бус өвчнийг илрүүлэх явуулын үзлэг зохион байгуулна. | н хүний тоо | | | | мэндийг хамгаалах зорилгоор 6105 удаагийн аян, өдөрлөг, уралдаан тэмцээн, сургалт, сурталчилгааг зохион байгуулж давхардсан тоогоор 179 байгууллагын 94895 албан хаагчид, иргэд хамрагдаж, 1567 төрлийн 88696 зөвлөмж тараан, цахимд 10164 төрлийн мэдээлэл, зөвлөмж байршуулж, 124683 хандалт авсан. Арга хэмжээний хүрээнд аймгийн аварга шалгаруулах “Ажлын байр–Эрүүл мэндийн дасгал”, “Хийн дасгал”, “Эмч спорт”, “Флаш моб”, “Цахим алхалт”, “Илүүдэл жингүй-Эртэч Монгол” зэрэг тэмцээн уралдаан, аян, зохион байгуулж, дасгал хөдөлгөөнийг сурталчилснаар хөдөлгөөнөөр тогтмол хичээллэдэг хүний тоо 13295 болж өмнөх оны мөн үеэс 4279-р өсч, биеийн жингээ бууруулах, дархлаагаа дэмжих иргэдийн идэвх оролцоо, хандлага нэмэгдсэн.<br>Аймгийн Засаг даргын 2022 оны А/590 захирамжаар 10.8 сая төгрөгийг шийдвэрлэж "Шүдний эмчийн явуулын үзлэг"-ийг хойд бүсийн 5 суманд зохион байгуулж, 908 хүн хамрагдсаны 73.7% нь 0-18 насны хүүхэд, 26.2% нь 19-аас дээш насныхан байсан. Үзлэгээр 836 шүдний эмгэг илрүүлэн, 1369 шүдэнд эмчилгээ хийж, 706 хүнийг /84.4%/ эрүүлжүүлсэн нь 2020 оны явуулын үзлэгтэй харьцуулахад эрүүлжүүлэлт 0.9%-иар нэмэгдсэн.<br>Эрүүл мэндийн сайдын 2022 оны А139 тушаалын дагуу “Эрүүл мэнд-Эрхэм баялаг” уриан дор “Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэг, шинжилгээ”-г 5 сарын 1-нээс эхлүүлж, Замын-Үүдийн нэгдсэн эмнэлэгт "Эрүүл мэндийг дэмжих төв"-ийг байгуулж, 1,8 тэрбум төгрөгийн тоног төхөөрөмж, засвар үйлчилгээ хийсэн. Эрт илрүүлэг үзлэгээр 2681 удаагийн сургалт сурталчилгаанд 77021 хүнийг хамруулж, 34 төрлийн 47956 ширхэг зөвлөмж мэдээллийг түгээсэн. 2022 онд үзлэгт хамрагдвал зохих хүн амын 26.3% хамрагдаж, эмгэг өөрчлөлттэй 5269 хүнийг илрүүлсэн. Эдгээр иргэдээс 404 нь насанд хүрэгчид, 4865 нь 17 хүртэлх насны хүүхэд байсан.<br>Эрүүл мэндийн сургалт сурталчилгаанд нийт 94254 хүнийг хамруулсан нь зорилтот түвшнээс 2,3 дахин их, үзлэгт хамрагдсан иргэдийн тоо 73134 байгаа нь зорилтот түвшний 98,8 % байна.<br>Хүүхдийн өвчлөлийн 89.1%-ийг амны хөндийн өвчлөл эзэлж, насанд хүрэгчдээс 62 хавдрын урьтал өвчин, 16 хавдрын сэжигтэй тохиолдол илэрч 15 нь эрт үедээ | |
| | | Үзлэгт хамрагдсан хүний тоо | 4197 | 5000 | 5269 | | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | эмчилгээнд хамрагдсан."Эрүүл, идэвхтэй амьдрал” арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт 93.4% байна. | |
| | “Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх” арга хэмжээг хэрэгжүүлж, идэвхтэй тандалтыг аймгийн хэмжээнд зохион байгуулна. | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 85,1 | 90 | 88.5% | “Зонхилон тохиолдох халдварт өвчний тандалтын тогтогтолцоог бэхжүүлэх нь” сэдэвт бүсийн зөвлөлдөх уулзалтыг ДЭМБ-ын 16,9 сая төгрөгийн санхүүжилтээр зохион байгуулж, 8 аймгийн 32 эмч, тархвар судлаач нар хамрагдаж, халдварын сэргийлэлт, тандалтын мэдлэгээ дээшлүүлж харилцан туршлага солилцсон.<br>Эрүүл мэндийн салбарт 17.0 сая төгрөгийн хүйтэн хэлхээний тоног төхөөрөмж нийлүүлэгдэж, хангалтыг 100% -д хүрсэн. НҮБ-ын 9,0 сая төгрөгөөр вакцины агуулахыг засварлаж, 48,1 сая төгрөгийн 18 компьютер олгон, дархлаажуулалтын цахим программын ашиглалтыг сайжруулсан. Дээрх ажлын үр дүнд товлолын дархлаажуулалтын хамралт 89,1% хүрсэн. | 100 |
| | | Идэвхитэй тандалтад хамрагдсан хүний тоо | 26043 | 27000 | 10144 | В вирус тээгч эхээс төрсөн 34 нярайд В гепатитийн эсрэг иммуноглобулин эмчилгээг хийж, эхээс урагт халдвар дамжихаас сэргийлсэн. Коронавируст халдварын эсрэг дархлаажуулалтыг эрчимжүүлж 12-аас дээш насны хүн амын хамралт 1-р тунд 96,4%, 2-р тунд 92,9%, 3-р тунд 55.9%-д хүрч халдварын тархалт, хүндрэл, эмнэлэгт хэвтэлт буурсан.<br>Сүрьеэгийн идэвхтэй тандалтыг эрчимжүүлж эрт илрүүлэг үзлэгт 3497 хүнийг, Глобаль сангийн 7,2 сая төгрөгийн санхүүжилтээр 7 суманд зохион байгуулсан эрт илрүүлэг үзлэгт 1360 хүн хамруулж, 13 сумын 184 хүний 213 цэрийг тээвэрлэж нийт 6 шинэ сүрьеэг, 6647 хүнийг БЗДХ-ын идэвхтэй тандалтанд хамруулж, 339 шинэ өвчлөл илрүүлсэн.<br>Тайлант хугацаанд нийт халдварт өвчний 93,7%-ийг эзлэх “Ковид19”-ын халдвар өмнөх оны мөн үеэс 11674-р буурч, нийт 9232 халдварт өвчин бүртгэгдсэн 10000 хүн амд 1288.1 болж өмнөх оноос 1641,7-оор буурлаа. | 70 |
| | “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд” арга хэмжээний хүрээнд эмэгтэйчүүдийн дурангийн мэс заслыг хөгжүүлэх, эмгэг нярайн тасгийг байгуулж, зайн | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 95 | 98 | 93 | Бүх шатны эрүүл мэндийн байгууллагууд 540 сургалтад 14860 жирэмсэн эхчүүд, гэр бүлийн гишүүдийг хамруулж, 529 төрлийн 16328 сурталчилгааны материал тарааж, эх барих эмэгтэйчүүдийн эмч нартай хамтран нарийн мэргэжлийн эмч нарын зөвлөгөө, мэдээллийг пэйж хуудсууд ашиглан 729 эрүүл мэндийн зөвлөгөөг өгч, давхардсан тоогоор 31719 хүн хандалт авсан.<br>Шинээр 2 эх барих эмэгтэйчүүдийн эмчийг бэлтгэн ажиллуулж, мэргэжил дээшлүүлэх, олгох сургалтад 3 эх | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | оношилгоо, зөвлөгөөг өргөжүүлж, эх нярайн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ. | | | | | барихын эмчийг, 5 удаагийн богино хугацааны сургалтад 69 эмч мэргэжилтнийг хамруулан, мэдлэг чадварыг дээшлүүлж, "Эх хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд" арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийг 98,3% хангаснаар 1000 амьд төрөлтөд ногдох перинаталь эндэгдэл 4.8 промильд хүрч урьд оны мөн үеэс 0.7-оор буурсан. | |
| | | Нярайн нэн шаардлагатай тоног төхөөрөмжийн хувь | 54 | 70 | 90 | "Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулснаар эх нярай, хүүхдийн эндэгдлийг бууруулах" төслийг Замын-Үүд сумын Нэгдсэн эмнэлэг дээр хэрэгжүүлж, 46,0 сая төгрөгийн нэн шаардлагатай 12 төрлийн 26 ширхэг, улсын төсвийн 53,2 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар аймгийн Нэгдсэн эмнэлэгт 4 төрлийн 5 тоног төхөөрөмж, сумын Эрүүл мэндийн төвүүдэд 4,4 сая төгрөгийн ургийн доплер тус тус нийлүүлсэн.<br>Эх, нярайн зайн оношилгооны хуваарийг гаргаж, нэгдсэн эмнэлгүүд Realtime-аар Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвтэй холбогдон, маш хүнд, онош тодруулах шаардлагатай 4 эмэгтэй, 16 нярайд зөвлөгөө авч, нөхөн үржихүйн насны 163 эмэгтэйг багажийн шинжилгээнд хамруулж, эмгэг өөрчлөлттэй 24 тохиолдлын оношилгоо эмчилгээний асуудлыг шийдвэрлэсэн. Нийт 129 жирэмсэн эхэд зөвлөгөө өгсний 16 нь эрсдэлтэй, 27 нь хөгжлийн бэрхшээлтэй эхчүүд байсан. Дээрх хөрөнгө оруулалтын үр дүнд 2 нэгдсэн эмнэлгийн төрөх тасгийн эх нярайн нэн шаардлагатай тоног төхөөрөмжийн хангалт 90%-д хүрсэн. | 100 |
| | "Хавдрын эсрэг" арга хэмжээг хэрэгжүүлж хавдрын эрт илрүүлэг, үзлэгийн хамрагдалтыг нэмэгдүүлнэ. | Хавдрын эрт илрүүлэгт хамрагдсан хүний тоо | 35852 | 36100 | 28263 | Аймгийн Нэгдсэн эмнэлгийн Хавдрын тасгийг 2 их эмчтэй, 10 ортой болгон өргөжүүлж, полихими эмчилгээг нэвтрүүлж, хавдрын эмч сувилагчийг ХСҮТ дээр туршлага судлуулж, хөнгөвчлөх эмчилгээнд 235, хими эмчилгээнд 123 хүнийг хамруулсан нь өмнөх оны мөн үеэс хөнгөвчлөх эмчилгээ 50 хүнээр, хими эмчилгээ 137 хүнээр тус тус өсч, тусламж үйлчилгээний хүртээмж нэмэгдсэн.<br>Хавдрын 3 төрлийн эрт илрүүлэг үзлэгт 28263 хүнийг хамруулж, дундаж хамралт 67.4% байгаа нь өмнөх оны мөн үеэс 4,3%-аар өсч, шинээр умайн хүзүүний хорт хавдар 1-ийг эрт үед нь илрүүлсэн.<br>"Хүүхдийн хавдрын өвчлөл, хяналт" сэдвээр хавдрын эмчийн арга зүйн зөвлөгөө, сургалт, орон нутгийн телевизээр "Хавдрын өвчлөлийн эрт илрүүлэг, хими туяа эмчилгээ" нэвтрүүлэг хийж, эмнэлгийн байгууллагууд 152 удаагийн сургалт сурталчилгаанд 3895 хүнийг хамруулан, 38 төрлийн 2857 зөвлөмж сэрэмжлүүлэг, цахимаар 56 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | төрлийн мэдээлэл түгээж, 11654 хандалт авсан нь өмнөх оноос 295 хандалтаар өсч иргэдийн мэдлэг, хандлага нэмэгдсэн.<br>Аймгийн Засаг даргын 10.5 сая төгрөгийн санхүүжилтээр Хавдар судлалын үндэсний төвийн нарийн мэргэжлийн эмч нарын багийг урьж, хавдрын эрт илрүүлэг үзлэг, оношилгоог зохион байгуулан, 1045 хүнийг хамруулан, шинээр 9 хавдар илрүүлсний 5 нь эрт үедээ оношлогдож, сэжигтэй 70 өвчлөл, биопси 9, цитологи шинжилгээ 97 хийж, дээд шатлалд 18 хүнийг илгээн, эмэгтэйчүүдийн 1 мэс засал хийж, 150 эмч нарт сургалт зохион байгуулж мэдлэгийг нэмэгдүүлсэн.<br>Үзлэгийн явцад нийт 603 хүнээс авсан хавдрын эрсдэлийн асуумж судалгаагаар хавдрын анхдагч эрсдэлттэй хүн 40.1%, хавдрын эрсдэлтэй хүн 45.4% байсан. "Хавдрын эсрэг" арга хэмжээний хүрээнд шинээр 112 хавдар бүртгэгдэж, үүнээс 34.0% нь эрт үедээ оношлогдож, хавдрын эмчийн хяналтад 467 хүн байгаагийн 42% нь 5-аас дээш жил амьдарч байгаа нь хавдар эрт шатандаа оношлогдсоноор амьдрах чадвар тодорхой хэмжээгээр уртасч байгаа илтгэж байна. | |
| | “Элэг бүтэн Монгол” арга хэмжээг хэрэгжүүлж, оношилгоо, эмчилгээний хамралтыг сайжруулна. | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 70 | 85 | 72 | “Элэг бүтэн Монгол” арга хэмжээг 3 зорилтын хүрээнд 18 арга хэмжээг төлөвлөн, 202 удаагийн сургалт сурталчилгаанд 4152 хүн хамруулж, 199 төрлийн мэдээллийг цахимд байршуулан 4876 хандалт авч, 125 төрлийн 2993 ширхэг гарын авлага тараасан. Гепатитын В, С вирусын халдвар илрүүлэх үзлэг, шинжилгээнд зорилтот бүлгийн 16684 хүнийг хамруулж, архаг В вирусын халдвартай 163 хүн, архаг С вирусийн халдвартай 197 хүнийг тус тус илрүүлсэн. “Элэг бүтэн Монгол” арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт 72%-ийн гүйцэтгэлтэй байна. | 90 |
| | | Оношилгооны хамрагдалтын хувь | 35 | 52,5 | 81,2 | Вирусийн идэвхжил тодорхойлох шинжилгээг 141 хүнд хийлгэж, вирусийн эсрэг эмийг 46 эмийн сангаар худалдаалан 508 хүн үнийн хөнгөлөлтөөр 21.2 сая төгрөгийн В, С вирусийн эсрэг эмийг авсан.<br>Элэгний цочмог гепатитын 6 тохиолдол бүртгэгдэн, 10 000 хүн амд 0.8 ногдож, өмнөх оны мөн үеэс 0.2 тохиолдлоор өссөн ба элэгний В вирустэй эхээс төрсөн 34 нярайд В гепатитын иммуноглобулин эмчилгээг хийж, хяналтад авснаар хүүхдүүдэд халдвар илрээгүй. | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | “Эрүүл чийрэг эр хүн” арга хэмжээг хэрэгжүүлж эрэгтэйчүүдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ. | Урьдчилан сэргийлэх үзлэгт эрэгтэй ажилчдаа хамруулсан байуллага/ хүний тоо | 57/ 520 | 78/800 | 83/4560 | “Эрүүл чийрэг эр хүн” арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөөний хүрээнд “Эрчүүдийн эрүүл мэндийг дэмжье”, “Малчдын эрүүл мэндийг дэмжье”, “Эрт илрүүлэг үзлэгийг эрчимжүүлье” аянуудыг зохион байгуулсан. Эрэгтэйчүүд олноор ажилладаг албан байгууллагуудад 155 удаагийн сургалт, сурталчилгаа зохион байгуулж, 4447 эрэгтэйг хамруулан, 70 төрлийн 2507 ширхэг зөвлөмж мэдээллийг цаасан хэлбэрээр тарааж, эрт илрүүлэг үзлэгт 6015 эрчүүдийг хамруулсан.<br>Аймгийн Нэгдсэн эмнэлэг улсын төсвийн 151,4 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар бөөр, шээс дамжуулах доод замын дурангийн мэс заслын 9 нэр төрлийн 10ш төхөөрөмж авч, Урологийн 1 эмчийг шинээр бэлтгэн, дурангийн мэс заслаар мэргэшүүлэн, нэгдүгээр эмнэлгийн эмч мэргэжилтнүүдтэй ажлын байранд хамтарсан мэс заслыг хийж, мэс заслын эмчилгээнд 21 хүнийг хамруулсан.<br>Аймгийн Засаг даргын 2022 оны А/203, А/222 дугаар захирамжаар 1-р ээлжийн цэрэг татлагын үзлэгт нийт 6 сумын 380 залуу хамрагдсанаас эрүүл мэндээр тэнцээгүй 76 хүнийг эмчлэн эрүүлжүүлсэн. Цэргийн төв эмнэлгийн Эрүүл мэндийн магадлан нягтлах үзлэгийн баг орон нутагт ажиллаж, эрүүл мэндийн шалтгаанаар цэргийн албанд тэнцэхгүй 111 хүний асуудлыг шийдвэрлэсэн. 2-р ээлжинд нийт 9 сумын 1027 эрэгтэй үзлэгт орсноос 316 нь дотор, мэс засал, гэмтэл, чих хамар хоолой, нүд, сэтгэц, мэдрэл, арьс харшил, сүрьеэ, шүдний эмгэг, жин өндрийн үзүүлэлтээр тэнцээгүй байсан. Цэргийн албанд тэнцээгүй залуучуудыг харьяа эмнэлгийн хяналтад авч, 42 залууг эрүүлжүүлсэн.<br>Эрэгтэйчүүдийн эрүүл мэнддээ тавих анхаарал хандлага өөрчлөгдөн, халдварт бус өвчний эрт илрүүлэг үзлэгт 28579 эрэгтэйг хамруулж, эрчүүдийн дундах элэгний хорт хавдрын шалтгаант нас баралтын түвшин 10 000 хүн амд 0,8 болж урьд оны мөн үеэс 0,8%-аар буурсан. | 90 |
| | “Эрүүл шүд” арга хэмжээг хэрэгжүүлж, амны хөндийн урьдчилан сэргийлэх үзлэг, эрүүлжүүлэлтийг | Хамрагдсан хүний тоо | 107 65 | 12000 | 12715 | "Эрүүл шүд-Эрүүл хүүхэд” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг 4 зорилтын хүрээнд 23 арга хэмжээг төлөвлөн, “Би эрүүл шүдтэй” дэвжээ тэмцээнийг 10 суманд, “Эрүүл шүд-Эрүүл хүүхэд” нээлттэй хаалганы өдөрлөгийг 9 суманд зохион байгуулж, 3750 хүүхэд, эцэг эхчүүдийн мэдлэгийг нэмэгдүүлсэн. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | нэмэгдүүлэх, амны хөндийн эрүүл мэндийн мэдлэг дадлыг олгох сургалт, сурталчилгааг нэмэгдүүлнэ. | | | | | Амны хөндийн эрүүл ахуйн зөв мэдлэг дадал төлөвшүүлэх 434 сургалт, сурталчилгаанд 18376 хүүхэд, эцэг эхчүүдийг хамруулж, цахим орчинд 299 төрлийн мэдээлэл байршуулан 12715 хүний хандалт авч, 272 төрлийн 10255 ширхэг зөвлөмж, санамж, гарын авлага тарааж, орон нутгийн DTV телевизийн “Эмч зөвлөж байна” булангаар 1 удаа шүдний эмчийн зөвлөгөөг өгч ажилласан.<br>“Театрт тавтай морил-2” аяны хүрээнд Хүүхэлдэйн театрын албан ёсны эрхтэйгээр "Миний хөөрхөн шүдний аялал” хүүхэлдэйн жүжгийг цэцэрлэгийн ахлах болон бэлтгэл ангийн 430 хүүхэд, ерөнхий боловсролын сургуулийн 1-2 дугаар ангийн 250 хүүхэд, нийт 680 гаруй хүүхдэд үзүүлсэн.<br>“Эрүүл шүдтэй хүүхдийн байгууллага, хамт олон” шалгаруулах болзолт уралдааны удирдамжийг хүүхдийн байгууллагуудад хүргүүлж, 6 хүүхдийн байгууллага, 40 анги хамт олонтой хамтран ажиллаж, 20 байгууллагын 35 албан хаагч, 8 байгууллагын 19 бүлэгт явцын дэмжлэгт хяналт хийж арга зүйн зөвлөгөөг өгснөөр иргэдийн мэдлэг хандлага нэмэгдэж, "Эрүүл шүд-Эрүүл хүүхэд" дэд хөтөлбөрийн төлөвлөгөөний хэрэгжилт 95,6%-д хүрч, зорилтот түвшинд хүрсэн. | |
| | | Эрүүлжүүлэлтийн хувь | 84 | 88 | 56.6 | Нэгдсэн эмнэлгүүдийн шүдний эмчийн орон тоог нэмэгдүүлэн нийт 7 эмчтэй болсноор тусламж үйлчилгээний хүртээмж нэмэгдэж, хүлээгдэл чирэгдэл буурсан. Аймгийн хэмжээнд төр, хувийн хэвшлийн 10 шүдний эмнэлэг, кабинетаар 0-18 насны нийт 8813 хүүхдийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж, шүдний өвчтэй 7851 хүүхдийг илрүүлэн, 4445 хүүхэд буюу 56.6%-ийг эрүүлжүүлсэн.<br>Аймгийн Засаг даргын 2022 оны А/590 дугаар захирамжийн дагуу 10.8 сая төгрөгийн санхүүжилтээр шүдний эмчийн явуулын үзлэгийг хойд бүсийн 5 суманд зохион байгуулан, 908 хүн хамруулснаас 670 /73.7%/нь 0-18 насны хүүхэд, 238 /26.2%/нь 19-аас дээш насныхан байсан. Шүдний өвчтэй 836 хүнийг илрүүлэн 1369 шүдэнд эмчилгээ хийж, 706 хүнийг /84.4%/ эрүүлжүүлсэн нь өмнөх үзлэгтэй харьцуулахад эрүүлжүүлэлтийн хувь 0.9%-аар нэмэгдүүлсэн. | 90 |
| **Зорилт 2.1.2.** | Эрүүл мэндийн байгууллагуудын | Шинэчлэгдсэн | 7 | 8 | 3 | Анхан болон лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагуудад 210,8 сая төгрөгийн өртөг бүхий | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| Орчин үеийн оношилгоо, эмчилгээний технологийг нэвтрүүлж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний төрөл, чанар, хүртээмжийг нэмэгдүүлэн, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудыг бодлогоор дэмжиж орон нутагтаа оношлогдон, эмчлүүлэх боломжийг бий болгоно. | яаралтай тусламжийн тоног төхөөрөмж, автомашины парк шинэчлэлийг хийж тусламжийн чанар хүртээмжийг сайжруулна. | автомашины тоо | | | | яаралтай тусламжийн 181 ширхэг тоног төхөөрөмжийг нийлүүлж, яаралтай тусламжийн тоног төхөөрөмжийн хангалт анхан шатанд 90%, лавлагаа шатлалд 97%-д хүрч, өмнөх оноос 2.5%-аар нэмэгдсэн.<br>Улсын төсвийн 561,7 сая төгрөгийн өртөг бүхий хүчилтөрөгчийн бэсрэг үйлдвэрийг барьж, орон нутгийн 116,4 сая төгрөгийн санхүүжилтээр хүчилтөрөгчийн дотор шугамыг бүх тасагт оруулан угсарч эмчилгээ үйлчилгээнд нэвтрүүлсэн.<br>Нэгдсэн эмнэлэгт улсын төсвийн 165,2 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Ланд-78, орон нутгийн хөрөнгө оруулалтаар нэг бүр нь 160,0 сая төгрөгийн өртөг бүхий Форд маркийн бүрэн тоноглогдсон түргэн тусламжийн 2 автомашиныг 2022 онд аймгийн болон Замын-Үүд сумын Нэгдсэн эмнэлэгт нийлүүлснээр нэгдсэн эмнэлгүүдийн автомашины парк шинэчлэл 100% болж тусламж үйлчилгээний бэлэн байдлыг хангаж ажилласан. | |
| | Босоо тэнхлэгийн автозам дагуух эрүүл мэндийн байгууллагуудын осол гэмтлийн үеийн яаралтай тусламж үзүүлэх чадавхийг сайжруулна. | Яаралтай тусламжийн нэн шаардлагатай тоног төхөөрөмжийн хувь | 80,2 | 83,0 | 93.5 | Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын 31,5 сая төгрөгийн санхүүжилтээр Гэмтэл согог судлалын үндэсний төвтэй хамтран "Осол гэмтлийн үеийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх цогц сургалт"-ыг зохион байгуулж, Эрүүл мэндийн газар, Онцгой байдлын газар, Цагдаагийн газар, Улаан загалмайн хороо зэрэг 6 байгууллагын 130 хүнийг хамруулсан.<br>Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/814 дүгээр тушаалаар шинэчлэн батлагдсан "Яаралтай тусламж, эрэмбэлэн ангилалтыг үзүүлэх журам"-ыг эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлэн, гэмтэл-мэс заслын эмч, сувилагч нартай хамтран Эрдэнэ, Өргөн сумдын эрүүл мэндийн төвүүдэд “Мэс засал, гэмтлийн үеийн яаралтай тусламжийн бэлэн байдал, анхны тусламж үзүүлэх” ажлын байрны сургалтыг хийж, 20 эмч мэргэжилтнийг хамруулан, дадлагажуулсан.<br>Нэгдсэн эмнэлгүүд, сумын эрүүл мэндийн төвүүдэд "Осол гэмтлийн яаралтай тусламжид нэн шаардлагатай багц"-ыг нийлүүлж, яаралтай үеийн тусламж үзүүлэх чадамж, боломж нөхцөлийг нэмэгдүүлсэн.<br>Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/501, А/502 тушаалаар осол гэмтэл гардаг хар цэг болох Айраг суманд 15.5 сая төгрөгийн 5 ширхэг, Эрдэнэ суманд 5.6 сая төгрөгийн 1 тоног төхөөрөмжийг нийлүүлсэн. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Анхан болон лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагуудад 195,7 сая төгрөгийн өртөг бүхий яаралтай тусламжийн 151 ширхэг тоног төхөөрөмж нийлүүлж, яаралтай тусламжийн тоног төхөөрөмжийн хангалт анхан шатанд 90%, лавлагаа шатлалд 97%-д хүрч өмнөх оноос 2.5%-иар нэмэгдсэн. | |
| | Анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудын лабораторийн тоног төхөөрөмжийн хангалтыг шат дараатай нэмэгдүүлж, сум орон нутагтаа оношлуулж эмчлүүлэх боломжийг бүрдүүлнэ. | Лаборатор ийн тоног төхөөрөмж ийн хангалтын хувь | 52 | 68 | 62 | Өрх, сумын эрүүл мэндийн төвүүдийн лабораторийн чадавхийг нэмэгдүүлэх чиглэлээр 17 сумын лаборантуудыг дадлагад суурилсан орон нутгийн сургалтад хамруулж, чадавхжуулсан.<br>Зүүнбаянгийн эмнэлэг, Хатанбулаг, Өргөн сумдын Эрүүл мэндийн төв, “Борхойн наран” өрхийн эрүүл мэндийн төв Мобайл технологийн төхөөрөмжтэй болсон. Өргөн сумын Эрүүл мэндийн төв, Зүүнбаянгийн эмнэлэгт орон нутгийн хөрөнгө оруулалт, хандив тусламжаар шээс, биохимийн хагас автомат анализатор зэрэг 5 нэр төрлийн 6 ширхэг 39,3 сая төгрөгийн тоног төхөөрөмж нийлүүлж, анхан шатанд лабораторийн тоног төхөөрөмжийн хангалт 62 %-д хүрсэн нь урьд оноос 2,1%-аар нэмэгдсэн. | 100 |
| | Лавлагаа шатлалд орчин үеийн болон нэн шаардлагатай оношилгоо эмчилгээний тоног төхөөрөмжийн шинэчлэл хийж, хангалтыг нэмэгдүүлнэ. | Тоног төхөөрөмж ийн хангалтын хувь | 84,2 | 87,0 | 85.7 | Аймгийн Нэгдсэн эмнэлэг ходоодны дурангийн иж бүрдэл, мэс заслын өрөөний тоног төхөөрөмж, мэс заслын хагалгааны гэрэл, иж бүрэн зөөврийн рентген аппарат худалдан авах 4 удаагийн тендерийг амжилттай зохион байгуулж, салбарын хөрөнгө оруулалтаар мэс заслын C-Arm рентген аппараттай болж оношилгоо, эмчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлсэн.<br>Замын-Үүд сумын Нэгдсэн эмнэлэгт шинээр компьютер томографийн оношилгоог нэвтрүүлэн, орчин үеийн дэвшилтэт тоног төхөөрөмж бүхий "Эрүүл мэндийг дэмжих төв"-ийг ашиглалтад оруулж, нарийн мэргэжлийн тусламж үйлчилгээг улам өргөжүүлснээр хэвлийн диализ, полихими эмчилгээ, дурангийн хагалгаа, чих хамар хоолой, нүд, хөнгөвчлөх зэрэг 11 нэр төрлийн тусламж үйлчилгээг орон нутагт хийн, шинжилгээ, оношилгооны тоо, чадавхыг нэмэгдүүлж, иргэдийн дээд шатлалд илгээх урсгалыг бууруулсан.<br>Нэгдсэн эмнэлгүүд мэргэшсэн тусламж үйлчилгээний багцын дагуу эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх, орон нутагтаа чанартай тусламж үйлчилгээ авах боломж нөхцөлийг бүрдүүлэхэд анхаарч, орон нутгийн төсөв хандив тусламж, салбарын хөрөнгө оруулалтаар 3,6 тэрбум төгрөгийн 248 ширхэг | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | эмнэлгийн тоног төхөөрөмж шинээр нийлүүлснээр тоног төхөөрөмжийн хангалт 85.7% болж өмнөх оны мөн үеэс 2.5%-иар нэмэгдсэн. | |
| **Зорилт 2.1.3.** “Цахим Монгол” арга хэмжээний хүрээнд эрүүл мэндийн мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлж, орон нутагт хийгдэх оношилгоо, эмчилгээнд алсын зайн технологи ашиглан, цахим эрт илрүүлэг, эргэн дуудах тогтолцоог бүрдүүлнэ. | Иргэдийн эрүүл мэндийн цахим мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх шаардлагатай арга хэмжээ авна. | Цахим санд байгаа мэдээллийн тоо | 220 000 | 260000 | 30362 | Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр хүсэх, сунгах 2 үйл ажиллагааг E-Mongolia цахим системд шилжүүлэн, аж ахуй нэгж, иргэд уг үйлчилгээг түргэн шуурхай авах нөхцөл бүрдэж, эрүүл мэндийн байгууллагууд үйл ажиллагааныхаа мэдээллийг иргэдэд цахимаар нээлттэй мэдээлж хэвшсэн.<br>Эрүүл мэндийн магадлан итгэмжлэлийн Health.acc.hdc.gov.mn цахим программыг шинээр нэвтрүүлж, магадлан итгэмжлэгдсэн 26 байгууллагын мэдээлэл, хугацаа сунгах хүсэлт, магадлан итгэмжлэлийн материалыг цахимаар илгээх, хяналт тавих үйл ажиллагааг зохицуулан ажилласан.<br>“E-mongolia” цахим системээр 2 нэгдсэн эмнэлэгт цаг авах болон цаг цуцлах зэрэг нийт 13 үйлчилгээг иргэдэд цахимаар үзүүлэн, энэ оны 3 сарын 1-нээс эхлэн анхан шатны 17 эрүүл мэндийн байгууллагуудад e-hospital программыг нэвтрүүлэн ашиглаж, 30362 иргэний эрүүл мэндийн мэдээллийг бүртгэн, сан бүрдүүлсэн.<br>Япон улсын Засгийн газрын “Ковид-19 халдварт цар тахлын хямралыг арилгахад яаралтай тусламж үзүүлэх хөтөлбөр”-ийн буцалтгүй тусламжийн хүрээнд дархлаажуулалтын бүртгэл мэдээллийг сайжруулах зорилгоор 38.6 сая төгрөгийн үнэ бүхий 17 ширхэг зөөврийн компьютер, дагалдах хэрэгслийг анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудад өгч, 24070 дархлаажуулалтын мэдээллийг цаг тухайд нь бүртгэлжүүлсэн.<br>Энэ онд 12 байгууллага цахимаар хүсэлт, материалаа илгээж, магадлан итгэмжлэл амжилттай явагдсан. Нэгдсэн эмнэлгүүд E-health программын хөгжүүлэлтийг хийж, эмнэлгийн тусламж үйлчилгээний мэдээллээс гадна шинээр урьдчилан сэргийлэх эрт илрүүлгийн мэдээллийг бүртгэж, цахим мэдээллийн санд нийт 511764 хүний мэдээллийн сан үүсгэсэн. | 100 |
| | Анхан шатлалд явуулын болон алсын зайн тусламж үйлчилгээний цахим | Мобайл технологи нэвтрүүлсэ | 3 | 22 | 14 | Мобайл үзлэгт хүн амын 36,1% буюу 5293 хүнийг хамруулж, 2318 шинжилгээ хийж, 319 өвчлөл шинээр илрүүлж, дээд шатлалд 192 хүн илгээн, 115 хүний эмчилгээний асуудлыг шийдвэрлэн, эрт үедээ байгаа хорт | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | технологийг нэвтрүүлж, цахим эрт илрүүлэг, эргэн дуудах тогтолцоог бүрдүүлнэ. | н АШЭМБ-ын тоо | | | | хавдар 8-ыг илрүүлэн, зүрх судасны эмгэгтэй 38 хүнийг зайн оношилгооны дамжуулалтаар оношилж, 16 хүнийг арьсны төвтэй холбогдон эмчилгээг заалгаснаар хөдөөгийн малчид жилдээ нэг удаа оношилгоо шинжилгээг орон нутагтаа хийлгэх боломжийг бүрдүүлсэн.<br>Мобайл технологийн төхөөрөмжөөр оношилгоо хийх 49 эмч мэргэжилтнийг орон нутгийн сургалтад хамруулан чадавхжуулсан. Нэгдсэн үндэсний байгууллагын "Оношилгоо, зайн тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх" төслийн хүрээнд 2021 онд 20 багийн эмчийг зайн оношилгооны багц төхөөрөмжтэй болгож, алслагдсан газарт нөхөн үржихүйн тусламж үйлчилгээг үзүүлэх, нарийн мэргэжлийн эмчээс зайнаас зөвлөгөө авах боломжийг бүрдүүлснээр энэ онд 74 жирэмсэн эхийг цахимаар хянаж, 13 эхийг нарийн мэргэжлийн тусламжид хамруулсан нь жирэмсний хяналтын чанарыг сайжруулж, жирэмсэн эхчүүдэд үзүүлэх тусламжийн хүртээмжийг нэмэгдүүлсэн.<br>Анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудын алсын зайн оношилгооны чадавхийг нэмэгдүүлж, хөдөөгийн малчид иргэд хаана байгаагаас үл хамааран эмнэлгийн тусламж үйлчилгээ авах боломжийг бүрдүүлэхээр нийт 13 сум, 1 өрхийн эрүүл мэндийн төвд Мобайл технологийг нэвтрүүлснээр сумын эрүүл мэндийн төвүүдийн 100% мобайл технологитой болсон. | |
| **Зорилт 2.1.4.** Гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн оновчтой арга, хэлбэрийг нэвтрүүлж, эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээний нэр, төрлийг нэмэгдүүлнэ. | Гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн оновчтой аргыг нэвтрүүлнэ. | Гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн хэмжээ /төг/ | 11700,0 | 34500,0 | 34.6 тэрбум | Орон нутагт 7 удаагийн арга зүйн сургалт хийж, анхан шатны 17 байгууллага, лавлагаа шатлалын 3 байгууллагын эмч, эмнэлгийн ажилчид, 14 байгууллагын дарга, нягтлан, эмч эмнэлгийн мэргэжилтэн нийт 204 хүнийг хамруулан холбогдох тогтоол, дагалдах тушаал заавруud, гүйцэтгэлийн санхүүжилт, эдийн засгийн тооцоолол, албан хаагчдын оролцооны чиглэлээр мэдээлэл өгч, чадавхжуулсан.<br>Лавлагаа шатлалын эмнэлгүүд 2021 оноос, анхан шатны эрүүл мэндийн байгууллагууд 2022 оноос эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд зарцуулах улсын төсвийг эрүүл мэндийн даатгалын санд нэгтгэж, нэг худалдан авагчийн тогтолцоонд шилжих санхүүжилтийн шинэчлэл хийгдэж, гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийг нэвтрүүлсэн.<br>Энэ оноос төрийн өмчийн 20 эрүүл мэндийн байгууллага гүйцэтгэлийн санхүүжилт авч байгаа бөгөөд эрүүл | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | мэндийн даатгалын санхүүжилт бүхий тусламж үйлчилгээг 169382 хүнд шуурхай чирэгдэлгүй хүргэж, санхүүжилт 2022 онд өмнөх оны мөн үетэй харьцуулахад орлогын гүйцэтгэл 90%, ковидын санхүүжилт 9,7 дахин, лавлагаа шатлалд 16,0%, хувийн хэвшлийн эмнэлгүүд 18,5%-аар тус тус нэмэгдсэн. | |
| | Эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээний нэр, төрлийг нэмэгдүүлнэ. | ЭМД-аар санхүүжиж буй тусламж үйлчилгээний нэр төрлийн тоо | 9 | 16 | 11 | 2022 онд нэгдсэн эмнэлгүүд үндсэн 11 төрлийн тусламж үйлчилгээгээр 7125,5 сая төгрөг, анхан шатны эрүүл мэндийн төвүүд 4 багц, 2 тусламж үйлчилгээгээр 259,6 сая төгрөгийн санхүүжилт авч, мөн “Коронавируст халдварын цар тахлын дэгдэлтийн үед үзүүлэх цогц тусламж үйлчилгээний багц, төлбөрийн хэмжээ” батлах тухай Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын 2021 оны А/387/99 хамтарсан тушаалын дагуу анхан шатны ЭМТ-д ПГУ шинжилгээний сорьц цуглуулах, гэрийн эмчилгээний багц, хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээ, дархлаажуулалтын гүйцэтгэлээр нийт 1399,6 сая төгрөгийн, лавлагаа шатлалын эмнэлгүүд ПГУ шинжилгээ, хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээний гүйцэтгэлээр 3766,9 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон. | 100 |
| | | ЭМД хамрагдалтын хувь | 67 | 80 | 70 | Хувийн хэвшлийн эмнэлгүүд, Уламжлалт анагаах рашаан судлалын төвд хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээний гүйцэтгэлээр 2104,4 сая төгрөгийн санхүүжилт авч, дутагдаж буй зардлуудад зарцуулахын зэрэгцээ цалинг нэмэгдүүлж, илүү цагийн хөлс, үр дүнгийн урамшуулалд зарцуулсан.<br>Эм зүйн тусламж үйлчилгээний чиглэлээр үнийн хөнгөлөлттэй зайлшгүй шаардлагатай эм 1041,3 сая төгрөг, элэгний В, С вирусийн 21,2 сая төгрөгийн эмийг 42 эмийн сангаар олгон, тусламж, үйлчилгээний нэр, төрлийг нэмэгдүүлсэн. Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын 2021 оны 3 дугаар тогтоолоор батлагдсан оношны бүлгээр санхүүжиж, төр, хувийн хэвшлийн эмнэлгүүдийн тусламжийн тариф ижил болж, лавлагаа шатлалын бүх эмнэлгүүд амбулаторийн тусламж үйлчилгээ, өндөр өртөгтэй оношилгоо эмчилгээ, өдрийн эмчилгээ, диализ, хэвтүүлэн эмчлүүлэх тусламж, хөнгөвчлөх, хими эмчилгээ, яаралтай, түргэн тусламж, урьдчилан сэргийлэх, жирэмсний хяналт нийт 11 төрлөөр, анхан шатны эмнэлгүүд 4 багц үйлчилгээгээр Эрүүл мэндийн даатгалын нэгдсэн сангаас санхүүжүүлсэн. | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| **Зорилт 2.1.5.** Эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, аюулгүй байдлыг хангаж, хүртээмжийг нэмэгдүүлэн бүртгэл, хяналтын цахим тогтолцоог бүрдүүлнэ. | Эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, аюулгүй байдлын стандартын хэрэгжилтийг хангуулна. | Хэрэгжилтийн хувь | 81 | 86 | 90 | Эрүүл мэндийн байгууллагуудын хэрэгцээт эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах ажиллагааг нэгтгэн зохион байгуулах эрхийг аймгийн Засаг даргын А/635 дугаар захирамжаар шилжүүлэн, Эрүүл мэндийн газрын даргын А/191, А/202 дугаар тушаалуудаар үнэлгээний хороог байгуулж, аймгийн болон Замын-Үүд сумын Нэгдсэн эмнэлгийн 2,9 тэрбум төгрөгийн 44 багц, сумын Эрүүл мэндийн төвүүдийн 279,0 сая төгрөгийн 29 багц бүхий нээлттэй тендерүүдийг цахимаар зарласан.<br>Захиалагчийн шаардлагад нийцэж хамгийн сайн үнэлэгдсэн 29 байгууллагатай гэрээ байгуулан, хуваарийн дагуу татан авалтуудыг тогтмол хийж, тендерийн гүйцэтгэл Нэгдсэн эмнэлгүүдэд 88.2%, Сумын эрүүл мэндийн төвүүдэд 91.8%-тай байна.<br>Төрийн худалдан авах ажиллагааны цахим дэлгүүрт 2019 оноос эхлэн зарим нэр төрлийн нэн шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл байршиж, худалдан авч эхэлсэн бөгөөд 2022 онд 114 болж өмнөх оноос 46 нэр төрлийн эм, эмнэлгийн хэрэгслээр нэмэгдэж, 15 эрүүл мэндийн байгууллага 1,5 тэрбум төгрөгийн худалдан авалт хийснээр, чанар стандартад нийцсэн эм, эмнэлгийн хэрэгслээр тасралтгүй хангагдаж эмийн чанар, аюулгүй байдлын стандартын хэрэгжилт 100% болсон | 100 |
| | Шинэчлэгдсэн цахим жорын программыг өргөжүүлж, эрүүл мэндийн даатгалын сангийн үнийн хөнгөлөлттэй эмийн хүртээмжийг нэмэгдүүлнэ. | Цахим жороор үнийн хөнгөлөлттэй эмээр үйлчлүүлсэн иргэдийн тоо | 42068 | 46000 | 45798 | Эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт үзүүлэх 159 ерөнхий нэршлийн, 590 эм хөнгөлөлттэй олгогдохоор батлагдаж, иргэд хурууны хээгээ уншуулан харьяалал харгалзахгүйгээр бүх шатлалын эмнэлгүүдээр хөнгөлөлттэй эм бичүүлэх боломжтой болсон.<br>Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас 71-ээс дээш насны иргэд, бусдын асаргаанд байдаг, уналт таталт, саажилттай иргэд хурууны хээ уншуулахгүй хөнгөлөлттэй эм бичүүлэх боломжийг бүрдүүлснээр эмийн хүртээмж нэмэгдсэн.<br>Эрүүл мэндийн байгууллагууд ZK9500 загварын, иргэдийн хувийн мэдээлэл хадгалагддаггүй 186 ширхэг хурууны хээ уншигч төхөөрөмжтэй болж, төрийн өмчийн 19 эрүүл мэндийн байгууллагын 81 эмч хөнгөлөлттэй эм бичиж, 42 эмийн сан 45798 хүнд, 1.2 тэр бум төгрөгийн хөнгөлөлттэй эмээр үйлчилж, гүйцэтгэл өмнөх оны мөн үеэс 7.8%-аар өссөн. | 100 |
| **Зорилт 2.1.6.** | Эмч, мэргэжилтнүүдийг | Сургалтад хамрагдса | 3432 | 3600 | 3329 | Сумдын болон өрхийн эрүүл мэндийн төвд ажиллаж байгаа 12 эмч эмнэлгийн мэргэжилтэнд 10,6 сая төгрөгийн | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| Эрүүл мэндийн ажилтны хөгжил, нийгмийн хамгааллын хөтөлбөрийн хэрэгжилтийг сайжруулах, хүний нөөцийн хангалтыг нэмэгдүүлэх нөхцөл боломжоор хангана. | гадаад, дотоодын ахисан түвшиний сургалтад хамруулж мэдлэг чадварыг дээшлүүлнэ. | н хүний тоо | | | | сургалтын төлбөрийн дэмжлэгийг тухайн байгууллагаас нь, мэргэшүүлэх сургалтад суралцаж ирсэн 8, суралцаж буй 5 эмчийн суралцах хугацаанд нь албан тушаалын үндсэн цалинг олгох зэргээр дэмжлэг үзүүлэн ажилласан.<br>Төрийн албаны мэргэшүүлэх багц, богино хугацааны сургалтад 2, Лондоны CIPD их сургуульд 1 албан хаагч, магистрт 3 мэргэжилтэн суралцаж, клиникийн профессор 4, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Анагаах ухааны магистр 2, Глобал удирдагч дээд сургуулийн магистрыг 14 мэргэжилтэн хамгаалж, 15 эмч мэргэжилтэн мэргэшлийн зэргээ ахиулсан.<br>Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжил олгох, дээшлүүлэх сургалтад 21, танхимын болон цахим сургалтад давхардсан тоогоор 3329, Эрүүл мэндийн байгууллагын дотоодын сургалтад давхардсан тоогоор 804 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамруулж, нийт 4154 хүний мэдлэг чадварыг дээшлүүлж, өмнөх оны мөн үеэс 734 хүнээр нэмэгдсэн. | |
| | Эрүүл мэндийн ажилтны нийгмийн хамгааллыг сайжруулан тогтвор суурьшилтай ажиллуулах эдийн засгийн хөшүүргийг оновчтой, хүртээмжтэй болгоно. | Хүний нөөцийн хангалтын хувь | 93,9 | 97,0 | 82,6 | Эрүүл мэндийн байгууллагууд сум орон нутгийн удирдлагуудтай "Хамтран ажиллах гэрээ" байгуулж, эмч мэргэжилтнийг орон сууц, өвлийн идшээр хангах, гэр бүлээрээ ажиллаж байгаа эмчийг малжуулах төсөлд хамруулах, зарим сургалтын төлбөрөөс чөлөөлөх зэрэг тогтвор суурьшилтай ажиллуулах хөшүүрэг хэрэгжүүлэхийг сумын Засаг дарга нарт чиглэл болгосон.<br>Сумдын эрүүл мэндийн төвүүдэд ажиллаж байгаа 34 эмч мэргэжилтнийг төрийн албан хаагчийн орон сууцанд 100% үнэ төлбөргүйгээр амьдрах, өвлийн идэш 4 хүнд 1,5 сая, мах хүнс 17 хүнд 1,8 сая төгрөг, эзэмшлийн газар үнэгүй 1, гэр 1 ажилтанд, 1,0 сая төгрөг, түлээ нүүрсний дэмжлэг 23 өрхөд 16,1 сая төгрөг, амьдрах нөхцөлийг сайжруулах зорилгоор 1 албан хаагчид био жорлон шийдвэрлэж, 4 эмчийг малжуулах төсөлд хамруулж, 12 эмч мэргэжилтний сургалтын төлбөрт 10,6 сая, төгрөг, эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд хөнгөлөлттэй болон бусад хэлбэрээр хамруулж 1,3 сая төгрөг, нийт 31,5 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.<br>Эрүүл мэндийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэгт зааснаар тэтгэврийн тэтгэмжийг 4 хүнд 85,4 сая төгрөг, тогтвор суурьшилтай ажиллаж буй 139 хүнд 646,6 сая төгрөгийн тэтгэмж, илүү цагийн хөлс, урамшууллыг давхардсан тоогоор 6257 хүнд 2,490,3 сая | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | төгрөг, үр дүнгийн урамшуулал 1609 хүнд 596,4 сая төгрөг, 212 ажилтанд 9,6 сая төгрөгийн витаминжуулалт, эмчилгээнд хамруулсан 151 ажилтан, 219 ажилтны ар гэрийнхнийг хамруулах зэргээр нийгмийн хамгааллын ажлыг зохион байгуулсан.<br>Эрүүл мэндийн салбарт шинээр 90 эмч мэргэжилтнийг ажилд авч,эрүүл мэндийн байгууллагуудын хүний нөөцийн хангалт анхан шатанд 86,1%, лавлагаа шатлалд 76.8%, салбарын хэмжээнд дунджаар 82,6% байна. Өнгөрсөн онтой харьцуулахад төрийн орон сууцанд амьдарч буй эмчийн тоо 3 дахин, дэмжлэг үзүүлсэн сум 6-аар, зарцуулсан хөрөнгийн хэмжээ 9.2 дахин буюу 28,4 сая төгрөгөөр нэмэгдсэн. | |
| **Зорилт 2.1.7.** Аймаг, сумын эрүүл мэндийн байгууллага, эмнэлгүүдийн барилга байгууламж, дэд бүтцийг сайжруулан стандарт, чанарын шаардлага хангасан үйлчилгээг үзүүлэх орчныг бүрдүүлнэ. | Аймгийн нэгдсэн эмнэлгийн барилгын их засвар хийнэ. | Гүйцэтгэлийн хувь | 0 | 100 | 0 | Аймгийн Нэгдсэн эмнэлгийн их засварын зураг төсвийг Эрүүл мэндийн яаманд хүргүүлсэн боловч, төсөв батлагдаагүй. | 0 |
| | Хүүхдийн эмнэлэг, халдвартын эмнэлгийн барилга шинээр барина. | Гүйцэтгэлийн хувь | 30 | 100 | 100 | Орон нутгийн хөгжлийн сангийн 2.6 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Сайншанд сумын 2 дугаар багт 30 ортой Халдварт, сүрьеэгийн эмнэлгийн барилга угсралтын ажлыг "Төгс-Өнөд" ХХК гүйцэтгэн ашиглалтад оруулсан.<br>Халдвартын эмнэлэг ашиглалтад орсноор халдварт болон халдварт бус өвчнийг тусгаарлах стандартын шаардлага хангаж, үйлчилгээний урсгалыг зөв чиглэлд оруулан үйлчлүүлэгчид болон ажиллагсдад ээлтэй орчин бүрдүүлж, халдварт өвчлөлийг бууруулах боломжийг олгов.<br>АНЭ-ийн Төрөх тасаг байсан хэсэгт хүүхдийн тасгийн байршуулж, орны тоог нэмэгдүүлсэн. | 90 |
| | Зарим сумдын эрүүл мэндийн төв, өрх, багийн эмнэлгийн барилгыг шинээр барих болон барилгын өргөтгөл, засвар үйлчилгээг хийнэ. | Гүйцэтгэлийн хувь | 0 | 100 | 86.6 | Орон нутгийн төсвийн 522,4 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Эрдэнэ сумын Эрүүл мэндийн төвийн барилгын өргөтгөлийн 9 өрөө бүхий амбулаторийн барилгын зураг төсвийг "Сант номун" ХХК-аар хийлгэн, барилга угсралтын ажлын гүйцэтгэгчээр "БЭМЭС" ХХК 100 хувь хийж гүйцэтгэн, 08 дугаар сарын 02-нд хүлээлгэж өгсөн.<br>Орон нутгийн төсвийн 950,1 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Замын-Үүд суманд Өрхийн эрүүл мэндийн төвийн барилга барих ажлыг “Төгс өнөд” ХХК гүйцэтгэж байгаа бөгөөд Барилгын угсралтын ажлын гүйцэтгэл 90%-тай байна. | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Даланжаргалан сумын Эрүүл мэндийн барилга хуучирч муудсан шинэчлэх шаардлагатай байсан тул Олон овоо багийн эмнэлгийн ажлыг хойшлуулж, улсын төсвийн 1,7 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Даланжаргалан суманд Эрүүл мэндийн төвийн шинэ барилга барих ажил хийгдэж байна.<br>Барилга угсралтын ажлыг "Элит конкрет" ХХК гүйцэтгэж байгаа бөгөөд барилгын каркасан хийц угсрах ажил бүрэн дуусаж, 1 дүгээр давхрын гадна, дотор ханын өрлөг, дээвэр, дотор магистраль шугам угсрах ажлууд бүрэн хийгдэж, ажлын гүйцэтгэл 70%- байна.<br>Ханги хилийн боомтод шинээр барих эмнэлгийн барилгын зохион байгуулалт, халдвар хамгааллын урсгал, ПГУ лабораторийн байршлын саналыг зураг төслийг боловсруулан, тендер зарлаж, ажлын гүйцэтгэгчээр "Энержи парагон" ХХК шалгарсан.<br>Хөвсгөл, Дэлгэрэх, Алтанширээ сумдын Эрүүл мэндийн төвийг төвлөрсөн шугам сүлжээнд холбосноор эмчлүүлэгч, ээлжийн сувилагч, эмч ажилчдад ажиллах таатай орчныг бүрдүүлсэн. 12 сумын эрүүл мэндийн төвөөс 84,6% нь төвлөрсөн шугам сүлжээнд холбогдсон. | |
| | Сумдын эрүүл мэндийн байгууллагуудыг инженерийн төвлөрсөн шугам сүлжээнд холбох ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ. | Гүйцэтгэлийн хувь | 0 | 100 | 84.6 | Хөвсгөл, Дэлгэрэх, Алтанширээ сумдын Эрүүл мэндийн төвийг төвлөрсөн шугам сүлжээнд холбосноор эмчлүүлэгч, ээлжийн сувилагч, эмч ажилчдад ажиллах таатай орчныг бүрдүүлсэн. 2022 онд Хөвсгөл сумын төсөвт байгууллагуудыг дулаан, цэвэр ус, бохирын сүлжээнд холбох ажлыг Орон нутгийн хөгжлийн сангийн 585,2 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар "Энержи парагон" ХХК гүйцэтгэж, улсын комисст хүлээлгэн өгч, байнгын ашиглалтад оруулсан.<br>12 сумын эрүүл мэндийн төвөөс 84,6% нь төвлөрсөн шугам сүлжээнд холбогдсон. | 90 |
| | Уламжлалт анагаах ухаан, рашаан сувиллын үйл ажиллагааг өргөжүүлэн, орчин нөхцөлийг сайжруулах шаардлагатай арга хэмжээ авна. | Гүйцэтгэлийн хувь | 0 | 70 | 60 | Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 55 дугаар тогтоолоор Уламжлалт анагаах ухаан, рашаан сувиллын төв, Халзан-Уул сувиллыг нэгтгэхээр шийдвэрлсэний дагуу аймгийн Засаг даргын 2022 оны А/612 захирамжаар хөрөнгө хүлээлцэх ажлын хэсгийг томилж, Халзан уул рашаан сувиллын үндсэн болон эргэлтийн хөрөнгийн тооллогыг хийсэн.<br>Тус сувиллын 92,7 сая төгрөгийн эргэлтийн, 346,1 сая төгрөгийн эргэлтийн бус хөрөнгийг Уламжлалт анагаах | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ухаан, рашаан сувиллын төвд шилжүүлж, 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар хаалтын баланс гарган, төрийн болон төрийн бус харилцагч байгууллагуудтай тооцоог бүрэн нийлүүлж дуусгасан.<br>Аймгийн Засаг даргын 2022 оны А/76 дугаар захирамжаар "Уламжлалт анагаах ухаан рашаан сувиллын төв"-ийн бүтэц орон тоог шинэчлэн баталсан.<br>Сувиллын ариун цэврийн байгууламжийг шинэчлэх 135,0 сая төгрөгийг 2023 оны орон нутгийн төсөвт тусгасан. | |
| **Зорилт 2.1.8.** АШУҮИС-ийн Дорноговь аймаг дахь салбар Анагаах ухааны сургуулийн мэргэжилтэн бэлтгэх тогтолцоог сайжруулж, төгсөгчдийг орон нутагт мэргэжлээрээ ажиллах хөшүүргийг оновчтой хэрэгжүүлнэ. | Элсэгчдийн тоог нэмэгдүүлж, оюутнуудад сургалтын төлбөрийн дэмжлэг үзүүлэн, орон нутагт тогтвор суурьшилтай ажиллах үр дүнтэй хөшүүргийг бий болгоно. | Бэлтгэж буй мэргэжлийн тоо | 6 | 28 | 5 | АШУҮИС-ийн Дорноговь аймаг дахь салбар сургуульд 2022-2023 оны хичээлийн жилд Хүний их эмч, сувилахуй (бакалавр), сувилагч (диплом), эм найруулагч, лабораторийн чиглэлээр шинээр 141 оюутан элсэн, 5 мэргэжлээр нийт 556 оюутан суралцаж байна. | 70 |
| | | Дэмжлэг үзүүлсэн оюутны тоо | 25 | 120 | 15 | Эрүүл мэндийн газар, сумдын Засаг дарга, Эрүүл мэндийн төвийн дарга нар хамтран жил бүр Анагаахын шинжлэх ухааны үндэсний сургуулийн Дорноговь аймаг дахь салбар Анагаах Ухааны сургуулийн төгсөгч нартай уулзалт зохион байгуулж, орон нутгийн эрүүл мэндийн байгууллагуудын үйл ажиллагааг сурталчлан, орон нутагт ажиллах саналыг тавьсан.<br>Тухайн онд сувилахуйн чиглэлээр 15 оюутан төгссөн ба үүнээс аймгийн Нэгдсэн эмнэлэгт 10, сумын эрүүл мэндийн төвд 1, Замын-Үүд сумын Нэгдсэн эмнэлэгт 2 сувилагч, сумын эрүүл мэндийн төвүүдэд шинэ төгссөн 3 эмч, 3 тусгай мэргэжилтэн ажилд орсон.<br>Тус сургуульд орон нутгаас суралцаж буй эм найруулагчийн 2 дугаар дамжаанд үргэлжлүүлэн суралцаж байгаа 15 оюутныг сургалтын төлбөрийн 100 хувийн тэтгэлэгт, 5 оюутныг Нутгийн зөвлөл, УИХ-ын гишүүдийн тэтгэлэгт тус тус хамруулан, төгсөөд орон нутагтаа тогтвор суурьшилтай ажиллах гэрээ байгуулсан. | 70 |
| | Хичээлийн байрны өргөтгөлийг барина. | Гүйцэтгэлийн хувь | 0 | 100 | 0 | АШУҮИС-ийн Дорноговь аймаг дахь салбар Анагаах ухааны сургуулийн хичээлийн байрны өргөтгөлийн 2 блок болон уламжлалт эмнэлгийн 1 блок, нийт 3 блок барилгын зураг төслийг "ТГТ" ХХК-д боловсруулж, сургуулийн хичээлийн байрыг засварлах, өргөтгөх, өөрийн болон бүс нутгийн эмнэлгийн мэргэжилтэн, эмч бэлтгэх бодлого хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр 2023 оны төсөвт тусгасан боловч, батлагдсан төсвөөс хасагдсан. | 0 |
| ***Үндсэн чиг үүрэг 2.2.*** *Нийтийн биеийн тамирыг эрүүл, идэвхитэй амьдралын хэв маяг, аж төрөх ёсны салшгүй хэсэг болгож, мэргэжлийн спортыг дэмжиж, тамирчдын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх* | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| **Зорилт 2.2.1.** Хүн амыг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, биеийн тамир, спортын хүртээмжтэй үйлчилгээ үзүүлэх төр, хувийн хэвшлийн түншлэлд суурилсан нээлттэй, уян хатан бодлогыг хэрэгжүүлнэ. | Төв цэнгэлдэх хүрээлэнгийн орчмыг “Соёл амралтын цэцэрлэгт хүрээлэн” болгож, байнгын ажиллагаатай болгоно. | Гүйцэтгэлийн хувь | 0 | 100 | 70 | Улсын төсвийн 5,44 тэрбум төгрөгийн төсөвт өртгөөр төв цэнгэлдэх хүрээлэнгийн орчимд “Соёл амралтын цэцэрлэгт хүрээлэн" хүүхдийн парк байгуулах ажлыг "Дэлгэр баясах зам" ХХК, "Энержи парагон" ХХК, "Уртын-Уул" ХХК-иар гүйцэтгүүлэн, үйлчилгээний барилга, нийтийн бие засах газар, тасалбар худалдах цэгийн барилга, тоглоом /алсын харагч, далайн дээрэмчний завь, агаарын гинж, морин тойруулга, эргэдэг аяга, мөргөлддөг машин/, гадна зам талбайн, гэрэлтүүлэг, хиймэл нуур, тохижилт ногоон байгууламжийн ажлууд хийгдэхээр төлөвлөгдсөнөөс үйлчилгээний барилга, нийтийн бие засах газар, тасалбар худалдах цэгийн барилгууд болон гадна цахилгаан хангамж, гадна хашаа, гадна бохир усны цооног, бохир усны шугам, гүний худаг гаргах мөн хиймэл нуурын төмөр бетон хийцийн ажлууд бүрэн хийгдэж дууссан.<br>Гадна зам талбайн явган замын хавтан 3000м2, автозамын хашлага, авто зогсоолын хашлага, ширхэг тоглоомын суурийн хийцлэл буюу арматурчлалын ажлууд хийгдсэн.<br>Гантиг чулуун хавтан, гантиг хашлага, тоглоомуудыг БНХАУ-аас захиалсан.<br>Улсын болон орон нутгийн төсөвт 3,1 тэрбум төгрөгийг 2022 онд батлуулан, төлөвлөсөн ажлаа бүрэн гүйцэтгэсэн. | 70 |
| | Спортын төрлүүдийг хөгжүүлэхэд хувийн хэвшлийн олон талт оролцоог дэмжиж хамтран ажиллана. | Хамтран ажиллагч байгууллагын тоо | 40 | 43 | 47 | Монголын бүх ард түмний спортын XV наадмын анхан шатны тэмцээнийг 22, Үндэсний спортын VII наадмын анхан шатны тэмцээнийг 14 төрлөөр спортын 20 холбоо, клубтэй хамтран 738 иргэнийг хамруулан зохион байгуулснаар Үндэсний спортын VII наадмын шигшээ тэмцээнд багийн дүнгээр 3 дугаар байр эзэлсэн амжилт үзүүлсэн.<br>Спортын төрлүүдийг жигд хөгжүүлэхэд анхаарч спортын бүх төрлийг дэмжин шинээр Жюү жицү, Граундгольф, Софтволейбол зэрэг спортын холбоодтой гэрээ байгуулан, 2022 онд 22 спортын холбоо, клуб, 25 аж ахуйн нэгж, байгууллагатай хамтран ажиллаж, бүс, аймгийн чанартай 32 тэмцээн, уралдаан зохион байгуулан оролцож, улсын чанартай тэмцээн, наадмаас 53, бүсийн тэмцээнээс 122, аймгийн тэмцээнээс 370, нийт 545 медаль хүртсэн амжилт үзүүлсэн нь медалийн тоо, чанар 2021 оноос 100%-аар өссөн. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Нийтийн биеийн тамирыг бүх нийтийн хөдөлгөөн болгох, биеийн тамир, спортоор хичээллэх орчин нөхцөлийг бүрдүүлэн, үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх | Хичээллэгсдийн тоо | 4782 | 7000 | 15000 | Ерөнхий сайдын санаачилгаар “Илүүдэл жингүй-Эртэч Монгол” аяныг улсын хэмжээнд 2022 оны 2 дугаар сарын 16-наас 6 дугаар сарын 1-ний хооронд зохион байгуулан, Биеийн тамир, спортын улсын хороо “Монголын Гимнастикийн холбоо”, “Үнэгүй Фитнес” төрийн бус байгууллага хамтран орон даяар шууд дамжуулсан өглөөний дасгалд 14 сумын 80 аж ахуй нэгж, байгууллагын давхардсан тоогоор 13730 иргэнийг хамруулсан ба идэвх санаачилгатай оролцсон 5 сум, 5 аж ахуй нэгж, байгууллага, 5 иргэнийг шалгаруулж, урамшуулсан.<br>Энэ арга хэмжээ нь иргэдийг нийтийн биеийн тамир, спортоор хичээллэх, идэвхжүүлэх нөлөөллийн ажил болсон ба 8 сумын 20 аж ахуйн нэгж, байгууллагын ажилтан, албан хаагч, иргэд нийт 600 гаруй хүн тогтмол дасгал, хөдөлгөөн хийж хэвшүүлсэн.<br>2022 онд нийтийн биеийн тамир, спортоор давхардсан тоогоор 15000 гаруй хүн хичээллэсэн нь 2021 оноос 10000 хүнээр өссөн үзүүлэлттэй байна. | 100 |
| | “Унадаг дугуй” арга хэмжээг хэрэгжүүлнэ. | Хичээллэгсдийн тоо | 55 | 90 | 60 | “Авто машингүй өдөр” арга хэмжээний үеэр аймгийн төвд ойрын дугуйн аялал, зугаалгыг зохион байгуулан Сайншанд татах хэсгийн ахмад дугуйчид, н.Ванжилдорж ахлагчтай дугуйчид нефтийн үйлдвэрийн засмал зам, Дорноговь Цагаан хаалга, Хан баянзүрх хайрхан, Хамарын хийд зэрэг газруудаар аялал хийж, ойрын бэлтгэл хийдэг хамт олон дугуйчдын бүлэг үүсгэсэн.<br>Монголын дугуйн холбооноос зохион байгуулсан “2021 оны Өсвөр үе, залуучуудын улсын аварга шалгаруулах” тэмцээнд “кросс каунтри” ангилалд эмэгтэй мөнгө, эрэгтэй хүрэл, “марафон” ангилалд эрэгтэй 4-р байр, эмэгтэй мөнгөн медаль хүртсэн амжилт үзүүлсэн. | 70 |
| | | Сонирхогчдын тоо | 200 | 450 | 148 | Аймгийн төвд ахмад дугуйчид 21, хүүхэд 32, залуучууд 17, Алтанширээ суманд 4, Дэлгэрэх суманд 6, Иххэт суманд 5, Замын-Үүд суманд 15, Даланжаргалан суманд 6, Айраг суманд 7, Сайхандулаан суманд 7, Хатанбулаг суманд 4, Хөвсгөл суманд 4, Эрдэнэ суманд 14, Өргөн суманд 6 нийт 148 хүн унадаг дугуйг ахуйн хэрэглээ болгон амьдрал ахуйдаа ашиглаж байгаа судалгааг нэгтгэн гаргасан. | 70 |
| | “Шанд ресорт” мөсөн гулгуурын талбайг хувийн хэвшлийн | Талбайн тоо | 0 | 1 | 0 | Улсын төсвийн 5,4 тэрбум төгрөгийн төсөвт өртгөөр “Соёл амралтын цэцэрлэгт хүрээлэн" хүүхдийн парк байгуулах ажлыг "Дэлгэр баясах зам" ХХК, "Энержи парагон" ХХК, "Уртын-Уул" ХХК-аар гүйцэтгүүлэн, ерөнхий | 0 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | оролцоотойгоор байгуулна. | | | | | төлөвлөгөөний дагуу хиймэл нуур байгуулж, хүйтний улиралд"Шанд ресорт" мөсөн гулгуурын талбайгаар ашиглахаар төлөвлөсөн. | |
| **Зорилт 2.2.2.** Иргэдэд үйлчлэх спортын зориулалтын стандарт талбайн хүртээмжийг нэмэгдүүлж, спортоор хичээллэх орчныг сайжруулна. | Сайншанд, Замын-Үүд суманд стандартад нийцсэн хөл бөмбөгийн болон граундгольфын талбай байгуулна. | Талбайн тоо | 2 | 4 | 0 | Сайншанд сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны 07/04 дугаар тогтоолыг үндэслэн, сумын Засаг даргын 2022 оны А/14 дүгээр захирамжаар 8 дугаар багт нийтийн эзэмшлийн ногоон байгууламж, цэцэрлэгжүүлэх, зүлэгжүүлэх газрын байршлыг баталсан.<br>"Говь парк" цэцэрлэгт хүрээлэнг байгуулах эскиз зургийн төлөвлөлтөд стандартад нийцсэн хөл бөмбөгийн талбай болон граундгольфын талбайг төлөвлөсөн. | 0 |
| | Сайншанд суманд “Буудлагын тир” байгуулна. | Талбайн тоо | 0 | 1 | 0 | АИТХ-ын хуралдаанаар тус ажлыг бодлогын баримт бичгээс хасуулсан болно. | 0 |
| | Үндэсний өв соёл, уламжлалт спортыг хөгжүүлэх “Монгол бахархал” төв байгуулна. | Төвийн тоо | 0 | 1 | 0 | “Соёмбо” цогцолборын хүндэтгэлийн өргөө, “Жаргалан” хүүхдийн зуслан, “Спорт цогцолбор”-ын үндэсний спортын танхимыг түшиглэн үндэсний өв соёл, уламжлалт спортыг хөгжүүлэх “Монгол бахархал” төв байгуулах ажил төлөвлөгдсөн.<br>2022 онд төрийн өмчийн 33 хүүхдийн цэцэрлэгт Монгол ёс заншил, бахархлын өргөө, танхимыг тохижуулан, сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж буй 3000 гаруй хүүхэд, багачуудад үндэсний өв соёлоо сурталчлан таниулсан. | 0 |
| | Зарим сумдад спортын ордон байгуулна. | Шинээр баригдсан спорт ордны тоо | 8 | 3 | 1 | Иргэдийн биеийн тамир, спортоор хичээллэх орчин нөхцөлийг сайжруулж зорилгоор Айраг сум ОНХС-ийн 61.0 сая төгрөгийн санхүүжилтээр 2 тоглоомын талбай шинээр байгуулж, чийрэгжүүлэх тоног төхөөрөмж, Алтанширээ сум 59,0 сая төгрөгийн ОНХС-ийн санхүүжилтээр сагсны талбай, Иххэт сум “Монгол соёл-Монгол хүмүүн” төслийн 7.9 сая төгрөгийн хөрөнгөөр 6 нэр төрлийн спортын хэрэгсэл, тоног төхөөрөмжтэй болж биеийн тамир, спортоор хичээллэх нөхцөлийг бүрдүүлсэн. Сайншанд суманд Хаан банкны санхүүжилтээр 3x3 сагсан бөмбөгийн талбай байгуулагдан ашиглалтад орсон.<br>Эрдэнэ сумын Соёл спортын цогцолборын барилгын зураг төслийг боловсруулах ажлыг "ТГТ" ХХК-аар гүйцэтгүүлсэн.<br>Улс, орон нутгийн 2023 оны төсөвт тусгуулахаар хүсэлтийг холбогдох газруудад хүргүүлсэн боловч шинэ төсөл, арга | 10 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хэмжээг санхүүжүүлэх боломжгүй улмаас шийдвэрлэгдээгүй болно. | |
| **Зорилт 2.2.3.** Их спортын төрөл, шигшээ багийг нэмэгдүүлж, гадаад, дотоодын тэмцээн уралдаанд оролцох тамирчдыг бэлтгэхэд дэмжлэг үзүүлнэ. | Их спортын төрөл, шигшээ багийг нэмэгдүүлж, олон улс, улс, бүсийн тэмцээнийг орон нутагтаа зохион байгуулна. | Спортын төрөл | 8 | 9 | 14 | “Дорноговь бага олимп-2021” спортын наадам 2021 оны 11 дүгээр сарын 21-24-ний өдрүүдэд сагсан бөмбөг, волейбол, шатар, даам, ширээний теннис, дартс гэсэн 6 төрлөөр 14 сум, Сайншанд сумын 8 баг, Замын-үүд сумын 2 багийн 926 тамирчин хурд, хүч авхаалж самбаагаа сорин өрсөлдөн, Замын-Үүд сум тэргүүн байрт шалгарч алтан медаль цомын эзэд болж дэд байранд Сайншанд сумын 2-р баг, гуравдугаар байранд Сайншанд сумын 1-р баг шалгарсан.<br>Монголын бүх ард түмний спортын XV наадмын анхан шатны тэмцээнийг 22, Үндэсний спортын VII наадмын анхан шатны тэмцээнийг 14 төрлөөр спортын 20 холбоо, клубтэй хамтран 738 иргэнийг хамруулан зохион байгуулснаар Үндэсний спортын VII наадмын шигшээ тэмцээнд багийн дүнгээр 3 дугаар байр эзэлсэн амжилт үзүүлсэн. | 100 |
| | | Зохион байгуулсан тэмцээний тоо | 1 | 9 | 32 | Спортын төрлүүдийг жигд хөгжүүлэхэд анхаарч спортын бүх төрлийг дэмжин шинээр Жюү жицү, Граундгольф, Софтволейбол зэрэг спортын холбоодтой гэрээ байгуулан, 2022 онд 22 спортын холбоо, клуб, 25 аж ахуйн нэгж, байгууллагатай хамтран ажиллаж, бүс, аймгийн чанартай 32 тэмцээн, уралдаан зохион байгуулан оролцож, улсын чанартай тэмцээн, наадмаас 53, бүсийн тэмцээнээс 122, аймгийн тэмцээнээс 370, нийт 545 медаль хүртсэн амжилт үзүүлсэн нь медалийн тоо, чанар 2021 оноос 100%-аар өссөн. | 100 |
| | Өсвөрийн шигшээ багийн төрлийн тоо, медалийн чанарыг нэмэгдүүлж, багш дасгалжуулагчдыг урьж хамтран ажиллана. | Шигшээ багийн төрлийн тоо | 8 | 11 | 10 | Биеийн тамир, спортын газраас “Өсвөрийн шигшээ багийг дэмжих жил” болгон, шинээр ширээний теннис, хөл бөмбөг, гандболын спортын холбоо, клубтэй хамтран ажиллаж, сагсан бөмбөг, жүдо бөх, гандбол, чөлөөт бөх, хөл бөмбөг, бокс, хөнгөн атлетик, волейбол, ширээний теннис гэсэн спортын 9 төрлөөр үнэ төлбөргүй секц, сургалтад 810 хүүхдийг хамруулсан.<br>2022 онд аймгийн өсвөрийн шигшээ багийг спортын 10 төрлөөр мэргэжлийн багш, дасгалжуулагч нартай хамтран 400 гаруй хүүхдэд сургалт, бэлтгэл хийсэн нь 2021 оноос 25%-аар өссөн. | 90 |
| | | Хичээллэгсдийн тоо | 370 | 450 | 2000 | “Хүүхэд хөгжил-2022” зорилтот жилийн хүрээнд өсвөр үеийн зүүн бүсийн аварга шалгаруулах ширээний теннисний тэмцээн, Монголын бүх ард түмний спортын | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | XV наадмын зүүн бүсийн сагсан бөмбөгийн тэмцээн, “Dornogovi open-2022” жюү жицүгийн нээлттэй тэмцээн, холимог насны боксчдын аварга шалгаруулах олон хотын нээлттэй тэмцээн, залуучуудын улсын аварга шалгаруулах сагсан бөмбөгийн тэмцээнийг 30 жилийн дараа амжилттай зохион байгуулж, тус томоохон тэмцээнүүдэд нийт 147 багийн 2000 гаруй тамирчдыг оролцуулсан.<br>Улс, бүс, аймгийн чанартай 32 тэмцээн, уралдаан зохион байгуулан, улсын чанартай тэмцээн, наадмаас 53, бүсийн тэмцээнээс 122, аймгийн тэмцээнээс 370, нийт 545 медаль хүртсэн амжилт 2022 онд үзүүлсэн нь медалийн тоо, чанар 2021 оноос 100%-аар өссөн.<br>Спортын арга хэмжээ болон тамирчдын амжилтыг ахиулахад зориулж орон нутгийн төсвөөс 95,0 сая, байгууллагын төсвөөс 70,0 сая, нийт 165,0 сая төгрөгийг зарцуулсан. | |
| | Тив, дэлхий, олимп, улс, бүсийн чанартай тэмцээнд оролцох тамирчид, дасгалжуулагчдад дэмжлэг, урамшуулал олгоно. | Урамшуулсан тамирчдын тоо | 60 | 290 | 32 | “Өсвөр үе, залуучуудын шигшээ багийг нэмэгдүүлж, үйл ажиллагааг нь дэмжих журам”-ыг батлан, тив, дэлхий, улсын хэмжээнд аймаг, орон нутгийнхаа нэрийг өндөрт өргөн, медаль хүртсэн 28 тамирчин, бэлтгэл сургуулилтыг ханган оролцуулсан 4 дасгалжуулагчдыг 2021 онд нийт 3,0 сая төгрөгөөр урамшуулсан.<br>Улс, бүс, аймгийн чанартай 32 тэмцээн, уралдаан зохион байгуулан, улсын чанартай тэмцээн, наадмаас 53, бүсийн тэмцээнээс 122, аймгийн тэмцээнээс 370, нийт 545 медаль хүртсэн амжилт 2022 онд үзүүлсэн нь медалийн тоо, чанар 2021 оноос 100%-аар өссөн.<br>Спортын арга хэмжээ болон тамирчдын амжилтыг ахиулахад зориулж орон нутгийн төсвөөс 95,0 сая, байгууллагын төсвөөс 70,0 сая, нийт 165,0 сая төгрөгийг зарцуулсан. | 70 |
| ***Үндсэн чиг үүрэг 2.3.*** *Хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, тэгш хамруулах тогтолцоог бэхжүүлэх* | | | | | | | |
| **Зорилт 2.3.1.** Сургуулийн өмнөх боловсролд 3-5 настай хүүхдийг хамруулж, 5 настай хүүхэд бүрийн сургуульд бэлтгэгдсэн байдлыг хангана. | "Хүүхэд бүр цэцэрлэгт" сургалтын арга хэмжээ зохион байгуулна. | СӨБ-ын хамран сургалтын цэвэр жин | 89.1 | 96 | 87.6 | Хүн амын статистик тоогоор 5 настай 1520 хүүхдээс 1432 хүүхэд 2021 онд цэцэрлэгт хамрагдаж, хамрагдалтын хувь 94.2% байсан бол 2022-2023 оны хичээлийн жилд цэцэрлэгийн 3-5 насны 4664 хүүхэд байгаагаас төрийн өмчийн цэцэрлэгт 3767, төрийн бус өмчийн цэцэрлэгт 57, төмөр замын цэцэрлэгт 542, нийт 4366 хүүхэд хамрагдаж, сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтын цэвэр жин 87.6 хувь, 5 настай хүүхдийн хамран сургалт 94.2 хувь байна. | 90 |
| | | Үүнээс 5 настай сурагчдын хамрагдалтын хувь | 97 | 99 | 94.2 | | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| **Зорилт 2.3.2.** Ерөнхий боловсролын сургуулийн сурагч, багш нарын үндэсний үнэлгээний чанарыг ахиулна. | "Анги хамт олны олимпиад", "Зорилгын хүч", "Дэвжээ" зэрэг шаардагдах олон талт арга хэмжээ зохион байгуулна. | Чанарын үнэлгээний гүйцэтгэлийн хувь | 34.6 | 39.1 | 34.6 | Элсэлтийн ерөнхий шалгалтад бэлтгэх ажлыг эрчимжүүлэх, сурагчдыг идэвхжүүлэх, сурлагын хоцрогдлыг бууруулах зорилгоор “Зорилгын-хүч-3” арга хэмжээг зохион байгуулан, 10 сургуулийн 12;дугаар ангийн нийт 22 ангийн 553 сурагчийг элсэлтийн ерөнхий шалгалтын өгөх сорилд хамруулж, сорилын үр дүн 92,1%, шалгалтын нэгдсэн дүнгээр 64,8%-тай шалгагдсан.<br>Сорилын шалгалтыг 10 хичээлээр 2 удаа авч, давхардсан тоогоор 2473 сурагч хамруулан, Сорил-1-50,2%, Сорил 2-54,2%-тай шалгагдаж, "Сорил-2" нь "Сорил 1"-ээс 4,0 %-иар ахисан. Монгол хэл бичгийн ерөнхий шалгалтын "Ямар мэргэжилтэй болъё доо?" эссэ бичлэгийн уралдаанд 551 сурагчийг хамруулж, 63,8%-тай шалгагдсан.<br>Математикийн “Дэвжээ” тэмцээнийг зохион байгуулж, 10 сургуулийн 18 бүлгийн 180 сурагч, 30 гаруй багш оролцсон. “Шинэ Монгол” сургуультай хамтран 12 дугаар ангийн сурагчид болон математик, физик, англи хэлний багш нарт 2-3 өдрийн сургалт зохион байгуулж, 84 багш, 360 гаруй сурагчийг хамруулсан.<br>“Санаачилгатай эртэч хүүхэд” аянд 91%-ийн ирцтэй оролцсон. Ерөнхий боловсролын 6-9 дүгээр ангийн анги хамт олны "Үндэсний бичгийн олимпиад"-д 20 сургуулийн 36 бүлгийн 5171 сурагч оролцуулснаас Сайншанд, Замын-Үүд, Дэлгэрэх, Өргөн сумдын ерөнхий боловсролын сургуулийн анги, хамт олон тэргүүн байрт шалгарсан.<br>Элсэлтийн ерөнхий шалгалтын 2022 оны дүнгээр 520,8 дундаж оноогоор улсын хэмжээнд 5-р байр эзэлж, монгол хэл, түүх, газар зүйн хичээлээр улсын хэмжээнд тэргүүн байр эзэлсэн. | 90 |
| **Зорилт 2.3.3.** Монголын түүх, хэл, соёл, ёс заншлаа мэддэг, эх орноороо бахархдаг төлөвшсөн ухаалаг иргэдийг бэлтгэх арга хэмжээг цэцэрлэг, сургуульд хэрэгжүүлнэ. | Сургууль, цэцэрлэг бүрт орон нутгийнхаа онцлогт тохирсон хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ. | Боловсруулсан хөтөлбөрийн тоо | 4 | 5 | 1 | Монгол орны байгаль, говь нутгийн ахуй амьдрал, өөрийн аймгийн түүхэн дурсгалт газрууд, хилийн цэргийн амьдралтай танилцуулан, эх оронч сэтгэлгээг төлөвшүүлэх “Торгон хил” сургалт, аяллын арга хэмжээг зохион байгуулж, 2021 онд Сайншанд сумын ерөнхий боловсролын сургуулийн 40 суралцагч Дэлхийн энергийн төв Хамарын хийд, Хан Баянзүрх хайрхан, Шамбалын орноор, Хатанбулаг сумын ерөнхий боловсролын сургуулийн 9 дүгээр ангийн 21 суралцагч, багш нарын төлөөлөл Домогт Сулинхээрийн отрядын анги нэгтгэлтэй танилцах, 2022 онд ерөнхий боловсролын 20 сургуулийн | 30 |
| | "Хутагтын нутгаар", "Торгон хил" сэдэвт арга хэмжээг зохион | Хамрагдсан сурагчдын тоо | 400 | 2400 | 5151 | | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | байгуулж, оролцоог нэмэгдүүлнэ. | | | | | 9-р ангийн 40 сурагч, 8 багшийг хамруулан, Сайншанд-Зүүнбаян-Хөвсгөл-Хатанбулаг-Сулинхээр 5-р застав-Хөвсгөл-Зүүнбаян-Сайншанд гэсэн маршрутаар зохион байгуулсан.<br>Сурагчид “Торгон хил” сургалт, аяллын сэтгэгдлээ гар зургаар илэрхийлэн, сургуулийнхаа нийт сурагчдад үзэсгэлэн гаргаж, түгээн дэлгэрүүлсэн. Хичээлээс гадуурх сургалтын цаг дээр "Торгон хил-Хутагтын нутгаар" цахим хичээлийг 20 сургуулийн 6-9 дүгээр ангийн 5151 суралцагчдад зохион байгуулж суралцагчдад экологийн хүмүүжил олгох, сумдын байгаль, түүхийн гайхамшигт газруудын түүх соёлыг таниулах, эх орноороо бахархах, эх оронч үзлийг төлөвшүүлсэн. | |
| | Байгаль орчин, шинжлэх ухаан, танин мэдэхүйн олон талт арга хэмжээнд хүүхдүүдийг өргөнөөр хамруулан, орон нутгийн түүх, соёлыг таниулна. | Хамрагдсан сурагчдын тоо | 780 | 2750 | 6031 | Төрийн өмчийн ерөнхий боловсролын 21 сургуульд “Орон нутгийн онцлогтой хөтөлбөр” хэрэгжиж, Иххэт сумын сургууль “Байгалиа шинжихүй” сургалтын хөтөлбөрийн хүрээнд сурагчид хичээлийн бус цагаар Мэлхий хад, Сэнжит хад, Заан хад, Бүсийн чулуу, Даяанчийн хад зэрэг газруудыг үзэж, өөрийн амьдардаг орон нутгийн түүхэн дурсгалт газрыг танин мэдэж, нэрлэж, сумынхаа түүхэн газруудыг дүрслэн зурж сурсан.<br>Эрдэнэ сумын сургуулиас сурагчдад орон нутгийн түүх соёлыг таниулах ажлын хүрээнд 163 сурагчийг “Бүрдэнэ элс” байгалийн үзэсгэлэнт газрын түүх дурсгалыг таниулж сургалт, аялал зохион байгуулсан.<br>Даланжаргалан сумын сургууль “Их нартын байгалийн нөөц газар” үзэсгэлэнтэй байгалийн тогтоц, ховор ан амьтан, түүх соёлын баялаг өвийн өлгий болсон нутагтай танилцах аяллыг зохион байгуулсан.<br>Орон нутгийн түүх, соёлыг таниулах ажлын хүрээнд орон нутгийн онцлогтой хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхээс гадна аймаг, сумын Музейд түүхийн хичээлүүдийг заах, "Ёс заншлын өргөө"-гөөр зочлуулан монгол ахуй соёлыг танилцуулах, аялал, уулзалт зохион байгуулах зэрэг үйл ажиллагаанд 6031 сурагчийг хамруулж, мэдлэгийг нэмэгдүүлсэн. | 100 |
| **Зорилт 2.3.4.** “Чадварлаг багш” арга хэмжээг хэрэгжүүлж, багшийн мэргэжлийн ур | Багш нарын ур чадвар, сурган хүмүүжүүлэх илтгэлийн уралдаан, хичээл төрлийн олимпиадийг жил | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | 1 | 9 | 12 | “Чадварлаг багш” арга хэмжээг зохион байгуулан, “Сурлагын хоцрогдлыг бууруулж буй тэргүүн туршлага” уралдааны 1-р шатанд бүх цэцэрлэгийн багш нар, 2-р шатанд 30 багш, 3-р шатанд 6 багш, “Сайн хичээл-2022” ур чадварын уралдааны 1-р шатанд 51 багш, 2-р шатанд 12 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| чадварыг тогтмол дээшлүүлэн, хөдөлмөрийн бүтээмжид суурилсан үнэлэмжийг бодитой болгож, нийгмийн баталгааг хангана. | бүр зохион байгуулна. | | | | | багш оролцсноос Замын-Үүд сумын сургууль, цэцэрлэгийн багш тэргүүлсэн.<br>Дэлхийн багш нарын баярын өдрийг угтан “Speed action” ХХК-аас "Mind Tech" ухаалаг дэлгэц хэрэглэгчдийн дунд зарласан видео, контент бүтээх уралдаанд Сайншанд сумын 12-р цэцэрлэгийн багш Н.Наранбаяр 3 дугаар байр, "Багш нарын мэргэжлийн өсөлтөд ахмад багш нарын үүрэг оролцоог нэмэгдүүлэх нь" сэдэвт оны шилдэг илтгэл шалгаруулах уралдааны 1-р шатанд 25 илтгэл ирснээс Сайншанд сумын 1-р сургуулийн бага ангийн багш М.Наранчимэгийн илтгэл шалгарч, онлайнаар улсын хэмжээнд илтгэлээ танилцуулсан.<br>"Миний Монгол бичиг-2022" олимпиадыг сургуулийн өмнөх боловсролын, ерөнхий боловсролын сургуулийн багш, 6-9 дүгээр ангийн сурагчдын дунд 3 үе шаттай зохион байгуулж, сургуулийн өмнөх боловсролын 272 багш, ерөнхий боловсролын сургуулийн 275 багш, 1723 сурагчийг хамруулсан.<br>Хичээл төрлийн олимпиадыг 10 төрлийн судлагдахуунаар зохион байгуулж, 1-р шатанд нийт багш, сурагчид, 2-р шатанд 149 багш, 1312 сурагч оролцсоноос 9 багш 21 сурагчийг шалгаруулан, улсын олимпиадад оролцуулж, олон улсын логик паззлын уралдаанд Сайншанд сумын 2-р сургуулийн 8б ангийн сурагч Б.Батдорж алтан медаль, 6б ангийн сурагч Б.Пүрэвсүрэн мөнгөн медаль хүртсэн. | |
| | Багш нарыг урамшуулах, ажиллах урам зориг өгөх, хөгжүүлэх чиглэлээр нийтийг хамарсан томоохон арга хэмжээг шат дараатай хэрэгжүүлнэ. | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | 1 | 4 | 3 | "Алтанзул" арга хэмжээ, багш нарын баярын өдрийг хамтатган тэмдэглэж, боловсролын салбарын өнгөрсөн жилийн ололт амжилт, алдаа оноогоо нэгтгэн дүгнэх, ахмад багш нар болон амжилттай ажилласан хамт олон, багш нарыг алдаршуулах, хүндэтгэл үзүүлэх, багшийн хөгжлийг дэмжих, тэдэнд арга зүйн дэмжлэг үзүүлэх ”Багш бадрахуй” хөтөлбөрийг хэрэгжүүлсэн.<br>“Багш бадрахуй” хөтөлбөрийн хүрээнд Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Дорноговь аймаг дахь салбар Анагаах ухааны сургууль, Америкийн соёл мэдээллийн төв, Политехник коллеж, Саран хөхөө театр, “Говь” кино театр, Музей, сургалт, судалгааны төв, Данзанравжаа музей, Насан туршийн боловсролын төв, Төв номын сан, “Салхин парк”, Биеийн тамир, спортын газар, Сайншанд сумын улсын тэргүүний ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 340 хүүхдийн бага сургууль зэрэг 12 байгууллагад нийт 360 багш мэргэжлийн | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | чиглэл тус бүрээр практик сургалтад хамруулж, тухайн байгууллагуудын мэргэжлийн албан хаагчид, эрдэмтэн, багш нараас туршлага судлан, мэргэжил арга зүйн зөвлөгөө зөвлөмжийг өгсөн. Үүний үр дүнд багш нар харилцан суралцаж, багш мэргэжлээрээ бахархан, орон нутгийн онцлог давуу талыг мэдэрч, цаашдаа сургалтдаа хэрэгжүүлэх ямар нөөц боломж байгааг судлан хэрэгжүүлэх арга замаа тодорхойлсон.<br>"Багш дор мөргөмүй" багшийн багшийг алдаршуулах арга хэмжээг зохион байгуулж, боловсролын салбарт гэр бүлээрээ ажилласан ахмад багш У.Хадхүү, Ж.Хорлоо, Сулинхээрийн торгон хилд гэр бүлээрээ 38 жил тасралтгүй ажиллаж, хилчдийн үр хүүхдийг сурган хүмүүжүүлсэн багш Т.Пүрэвсүрэн, С.Оюунцэцэг, 1975 онд болсон Монголын багш нарын 4, 5-р их хурлын төлөөлөгч багш Н.Тэрбиш, Ө. Энэбиш, С.Банзрагч, Монгол Улмсын даян мэргэн харваач Д.Түвшин нарын 8 ахмад багшид хүндэтгэл үзүүлж, шавь 14 багшийг алдаршуулахын хамт "Алтанзул" шагналт багш С.Батхишиг, Р.Алтанцэцэг нарын туршлагыг орон нутгийн телевизээр олон нийтэд түгээсэн. | |
| | Орон нутагт нэн шаардлагатай багш нарыг бэлтгэхэд дэмжлэг үзүүлнэ. | Дэмжлэг үзүүлсэн багшийн тоо | 9 | 75 | 15 | Багш мэргэжлээр суралцаж байгаа 1-4 дүгээр курсийн оюутнуудын судалгааг гаргахад багш мэргэжлээр 1-р курст 46, 2-р курст-32, 3-р курст-39, 4-р курст 20 оюутан суралцаж байна.<br>Аймгийн Засаг даргын 2022 оны А/280 дугаар захирамжаар Саран хөхөө театрын хөгжимчин, бүжигчин 3 уран бүтээлчийн сургалтын хөтөлбөрийн төлбөрт нийт 5,0 сая, А/575 дугаар захирамжаар Соёл урлагийн их сургуульд дуу хөгжмийн багш мэргэжлээр суралцаж буй 5 оюутны сургалтын төлбөрт орон нутагтаа эргэн ажиллах нөхцөлтэй гэрээний дагуу нийт 20,0 сая, Даланжаргалан сумаас хөгжмийн багш мэргэжлээр сурч буй 1 оюутны сургалтын төлбөрт 4,0 сая, бусад мэргэжлээр суралцаж буй 6 оюутанд 16 сая, орон нутагт нэн шаардлагатай багшийг бэлтгэхэд 2022 онд нийт 15 оюутанд 45,0 сая төгрөгийн сургалтын төлбөрийн дэмжлэг үзүүлсэн. | 50 |
| | Их, дээд сургуулиудтай хамтран ажиллаж магистр зэрэгтэй багшийн тоог нэмэгдүүлнэ. | Магистр зэрэгтэй багшийн тоо | 54 | 21 | 15 | Ерөнхий боловсролын сургуульд ажиллаж буй 698 үндсэн багшаас магистр зэрэгтэй107, цэцэрлэгийн 202 үндсэн багшаас 37, Политехникийн коллежид 39 багшаас 15 магистр зэрэгтэй багш ажиллаж байгаа бөгөөд 2022 онд магистр багшийн эзлэх хувь өмнөх жилээс 6,3 хувиар нэмэгдсэн. | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Аймгийн Боловсрол, соёл урлагийн газрын барилгыг шинээр барина. | Гүйцэтгэлийн хувь | 0 | 100 | 0 | Аймгийн Засаг даргын 2018 оны А/867 дугаар захирамжаар Сайншанд сумын 1 дүгээр багийн нутаг дэвсгэрт 2-р сургуулийн зүүн талд албан конторын зориулалтаар 0.1580 га газрыг Боловсрол, соёл урлагийн газарт эзэмшүүлсэн.<br>Боловсрол шинжлэх ухааны газрын барилгыг шинээр барих саналыг Боловсрол шинжлэх ухааны яам, улсын төсвийн саналд хүргүүлсэн боловч санхүүжилт батлагдаагүй. | 0 |
| **Зорилт 2.3.5.** Боловсролын байгууллагын хүртээмжийг нэмэгдүүлж, орчин нөхцөлийг сайжруулна. | Зарим сумдад сургуулийн барилгыг шинээр барьж, сургууль, цэцэрлэг, дотуур байрны засвар үйлчилгээг хийнэ. | Гүйцэтгэлийн хувь | 0 | 100 | 90 | Сайншанд сумын 6 дугаар багт “640 хүүхдийн сургууль барих” төсөл арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж, аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 7,7 тэрбум төгрөгийг шийдвэрлэсэн. Сургуулийн барилга угсралтын ажлыг "Болор-Аграмба" ХХК-иар гүйцэтгүүлэн. хяналт тавьж ажилласан.<br>Барилгын үндсэн хийц бүтээц, дотор цахилгаан, сантехник, холбоо, дохиолол, хаалга, цонх суулгах, шалны ажлууд бүрэн, гадна фасадны металл өнгөлгөө, дотор заслын ажлуудын 90 хувь хийгдэж, барилга угсралтын ажил 95%-ийн гүйцэтгэлтэй байгаа бөгөөд энэ ондоо багтаан ашиглалтад хүлээн авна.<br>Улсын төсвийн 9,3 тэрбум төгрөгийн төсөвт өртгөөр Замын-Үүд сумын 3-р багийн нутаг дэвсгэрт 640 хүүхдийн сургуулийн барилга барих ажлыг "Билгүүн монгол констракшн" ХХК-иар гүйцэтгүүлэн, газар шорооны ажил 100%, суурийн ажил 100% хийгдэж, 1 дүгээр давхрын A, B, C, D, E блокийн төмөр бетон каркас болон 2 дугаар давхрын C, E блокийн багана дам нурууны бетон хучилт, A, B блокийн дам нуруу болон хучилтын арматур хийгдэн, 2022 онд төлөвлөсөн ажил бүрэн хийгдсэн.<br>Улсын төсвийн 7,6 тэрбум төгрөгийн төсөвт өртгөөр Хатанбулаг суманд 320 хүүхдийн сургуулийн барилга барих ажлыг "Ньюконстракшн" ХХК-иар гүйцэтгүүлэн, газар шороо, суурь, 1, 2-р давхрын каркасан хийцийн угсралтын ажил, 3-р давхрын багана, дам нуруу, хучилт цутгах ажил бүрэн хийгдсэн. Барилга угсралтын ажлын гүйцэтгэл 40%-тай, 2022 онд батлагдсан 2,0 тэрбум төгрөгийн санхүүжилтийн хүрээнд төлөвлөсөн ажлыг 100% гүйцэтгэсэн. | 90 |
| | Сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсролын | Тоног төхөөрөмж өөр | 3 | 8 | 5 | Сайншанд сумын ерөнхий боловсролын 1-р сургуулийн урлагийн танхимд 10,0 сая төгрөгөөр хөгжмийн тоног төхөөрөмж, 2-р сургуульд 8,7 сая төгрөгөөр 30 морин хуур, | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | сургуулийн урлаг, биеийн тамирын танхимыг стандартын тоног төхөөрөмжөөр хангана. | хангагдсан сургуулийн тоо | | | | 5-р сургуульд 4,8 сая төгрөгөөр 15 морин хуур хөгжмийг нийлүүлж, сургуулиудыг шаардлагатай хөгжмийн зэмсгээр хангасан.<br>Сайншанд сумын 3-р сургууль 3,0 сая төгрөгийн хөгжим, Хатанбулаг сумын ЕБ-ын сургууль 8,2 сая төгрөгийн хөгжим, Алтанширээ сумын хүүхдийн цэцэрлэгийн урлагийн танхимд нийт 7,2 сая төгрөгийн хөгжим, техник хэрэгсэл худалдан авч сургалтын орчныг сайжрууллаа.<br>Энэ онд 5 сургууль, цэцэрлэгийн биеийн тамирын залны тохижилт, хэрэгсэл болон урлагийн танхимын хөгжим, техник хэрэгслийг үе шаттайгаар нэмэгдүүлж, нийт 43,6 сая төгрөгийг зарцуулан, хүүхдийн хөгжлийг дэмжин ажилласан нь өмнөх 2021 оноос 66,6%-аар өссөн. | |
| **Зорилт 2.3.6.** Ерөнхий боловсролын сургуульд "Үдийн цай" арга хэмжээг "Үдийн хоол" үйлчилгээнд шилжүүлэн, шүүлтүүртэй ундны цэвэр усаар хангана. | "Үдийн хоол" арга хэмжээг хэрэгжүүлнэ. | Үдийн хоол хөтөл бөрт хамрагдсан буй сургуулийн тоо | 21 | 23 | 22 | Сургууль, цэцэрлэгийн 46 тогоочийг хамруулан хоолны технологийн картын бичилт, бодолт хийх арга зүйн сургалтыг зохион байгуулсан.<br>"Зохистой хооллолт ба эрүүл мэнд" нөлөөллийн сарын аяныг зохион байгуулж, 22 сургуулийн 15321 сурагчийг хамруулан, хүнсний шим тэжээлийн бодисыг нэмэгдүүлэх зорилгоор бага ангийн сурагчдад "Өглөөний цайны ач холбогдол", дунд ангийн сурагчдад "Зохистой хооллолт ба дасгал хөдөлгөөн", ахлах ангийн сурагчдад "Зохистой хооллолт ба эрүүл мэнд" сэдвээр хичээл, сургалтыг зохион байгуулсан.<br>Тогооч нарын ур чадварын уралдааныг зохион байгуулж, "Говийн брэнд-Говийн амт" хоолны үзэсгэлэн гаргасан ба Сайншанд сумын 2-р цэцэрлэг, ерөнхий боловсролын 1-р сургуулийн тогооч, тус сургуулийн үдийн хоол нийлүүлэгч "Батжим" ХХК-ийг шалгаруулсан.<br>Дэлхийн тогооч нарын баярын өдрийг угтан сургууль, цэцэрлэгүүдийн хүүхдүүд "Тогооч багшдаа баярлалаа" сэтгэлийн мэндчилгээ илгээж, нийт сурагчдын дунд "Тогооч мэргэжил сайхан" сэдэвт олон талт уралдаан, эцэг эх, асран хамгаалагчдад үдийн хоолны өдөрлөг зохион байгуулж, тогооч нар харилцан туршлага солилцсон арга хэмжээг зохион байгуулан, хоолны чанар, нэр төрлийг сайжруулах талаар тухай бүр зөвлөгөө өгч, сумдын сургууль, цэцэрлэгийн хоолны чанарт тогтмол хяналт тавьснаар үдийн хоолоо түрээслэн ажиллуулдаг 11 сургууль байснаас Мандах сумын сургууль энэ оноос өөрсдөө үйлдвэрлэдэг болсон. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн үдийн хоол хөтөлбөрт 2022-2023 оны хичээлийн жилд хамрагдвал зохих 21 сургуулийн 7937 хүүхэд бүрэн хамрагдсан.<br>“Хоол үйлдвэрлэлийн шинэ системийн танилцуулга” сургалтыг сургууль, цэцэрлэгийн тогооч, нярвуудад цахимаар зохион байгуулж, 21 сургууль, 36 хүүхдийн цэцэрлэг цахим системд хоолны мэдээллээ бүрэн оруулж хэвшсэн. | |
| | Сургуулийн гал тогооны тоног төхөөрөмжийг шинэчлэн сайжруулна. | Гал тогооны тоног төхөөрмж сайжруулсан сургуулийн тоо | 3 | 10 | 5 | Хатанбулаг сумын сургуулийн дотуур байрны гал тогооны тоног төхөөрөмжийг шинэчлэх ажлыг орон нутгийн хөгжлийн сангийн 25,5 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар "Чиглэл" ХХК-иар гүйцэтгүүлж, гэрээний дагуу 19 нэр төрлийн тоног төхөөрөмж нийлүүлсэн.<br>Даланжаргалан, Дэлгэрэх, Өргөн, Замын-Үүд сумын сургуулиудын дотуур байрыг нийт 42,3 сая төгрөгийн гал тогооны тоног төхөөрөмжөөр хангасан нь өмнөх оноос 3 хувиар өссөн. | 50 |
| | Ерөнхий боловсролын сургуулиудыг ундны усны шүүлтүүрээр хангана. | Ундны усны шүүлтүүр сайжруулсан тоо | 4 | 13 | 12 | “НИК” ХХК-ийн харьяа Дорноговь нефть хангамжийн салбараас нийгмийн хариуцлагын хүрээнд 2022 онд аймгийн төвийн 2 цэцэрлэг, 1 сургуульд 4 ширхэг ус цэвэршүүлэгч, Мобиком ХХК-ийн Замын-Үүд дахь салбар сумын ерөнхий боловсролын 3-р сургуульд 2 ширхэг ундны усны шүүлтүүрийг хандивлан, цэвэр усаар үйлчлүүлэх боломжийг бүрдүүлсэн.<br>Алтанширээ, Даланжаргалан, Хөвсгөл, Өргөн, Эрдэнэ сумдад 6 ширхэг 3,0 сая төгрөгийн ус цэвэршүүлэгчээр суурилуулж, сургууль, цэцэрлэгийн хүүхдүүд анги танхимдаа цэвэр ус хэрэглэх нөхцөлөөр хангагдсан. | 100 |
| **Зорилт 2.3.7.** Цахим сургалтыг хөгжүүлэхэд багш нарын оролцоог дэмжиж, цахим хичээл боловсруулан бүх насны иргэдэд насан туршдаа суралцахуйг дэмжих боломжийг бүрдүүлнэ. | Цахим сургалтыг хөгжүүлэх бүх талын арга хэмжээг авч багш, суралцагчдын оролцоог нэмэгдүүлнэ. | Нийлүүлсэн компьютерийн тоо | 135 | 200 | 34 | ЕБ-ын 12 сургууль, 2 цэцэрлэгийн цахим сургалтыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлж, нийт 96,9 сая төгрөгийн 34 зөөврийн компьютероор хангасан.<br>БШУЯ-ны хөрөнгө оруулалтаар 2 цэцэрлэг, 4 сургууль, БШУГ-т 8 нэр төрлийн 56 тоног төхөөрөмж бүхий нийт 133,0 сая төгрөгийн "Цахим контент"-ын жишиг кабинетыг байгуулсан. Сайншанд сумын 2-р сургуульд "Их нүүдэл" цахим сургалтын удирдлагын системийг хэрэгжүүлсэн. Замын-Үүд сумын "Үлэмж тэнгэр" цахим сургууль нь “Спийд Аксон компани”-ийн 4,0 сая төгрөгийн ухаалаг дэлгэц, ухаалаг дэлгэц IQ touch, компьютер, монитор дэлгэц, микрофоныг шинэчилж жишиг кабинеттай боллоо. | 50 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | АШУҮИС-ийн Дорноговь аймаг дахь салбар сургуульд тус сургуулийн Сүхбаатар аймаг дахь төгсөгчдийн салбар холбоотой хамтран “Компьютерын танхим байгуулах төсөл”-ийг хэрэгжүүлж, 15,0 сая төгрөгөөр кабинетыг иж бүрэн засвар, тохижилтыг хийсэн. | |
| | Зарим сургуулийг цахим сургууль болгох болон шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангана. | Жишиг цахим сургуулийн тоо | 2 | 4 | 1 | Замын-Үүд сумын "Үлэмж тэнгэр" цахим сургууль нь "Спийд Аксон" ХХК-ийн 4,0 сая төгрөгийн ухаалаг дэлгэц, ухаалаг дэлгэц IQ touch, компьютер, монитор дэлгэц, микрофоныг шинэчлэн, жишиг кабинеттай болсон.<br>Ерөнхий боловсролын 8 сургууль цахим журнал тогтмол хөтөлсөн. Улсын хэмжээнд зохион байгуулагдаж буй "Medle.mn цахим сургууль"-д 10-12 ангийн дизайн-технологийн хичээлийн зөвлөх ментор багшаар Сайншанд сумын 3-р сургуулийн технологийн багш Ц.Батбаяр хичээл зааж, цахимаар ажиллахаар болсон. | 50 |
| **Зорилт 2.3.8.**<br><br>Үндэсний Монгол хэл, бичгээ чанартай эзэмшиж, хэрэглэж хэвшинэ. | “Миний монгол хэл, бичиг-2025” арга хэмжээг хэрэгжүүлнэ. | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | 8 | 58 | 32 | Насан туршийн боловсролын төвөөс "Алтан нутгийн бүтээлийг ахмад настнууд бичиж байна" таталган бичлэгийн уралдаан, байгууллага, аж ахуйн нэгжийн захиалгаар 127 ажилтныг 80 цагийн үндэсний бичгийн сургалтад, 4 удаагийн 68 цагийн үндэсний бичгийн сургалтад 791 иргэнийг тус тус хамруулсан.<br>“Миний монгол хэл, бичиг-2025” арга хэмжээний хүрээнд “Үндэсний бичиг үсэг-2022” 3 сарын аяныг зохион байгуулж, сургуулийн өмнөх боловсролын багш, ажилтнуудын дунд “Миний монгол хэл, бичиг-2022” уралдааныг 3 үе шаттай зохион байгуулж, 824 багшийг хамруулсан.<br>Миний монгол хэл, бичгийн хөтөлбөр, сургалт, уралдаан, тэмцээн, үзэсгэлэн зэрэг 32 арга хэмжээнд давхардсан тоогоор 7800 гаруй хүнийг хамруулсан нь өмнөх 2021 оноос 29 арга хэмжээгээр өссөн. | 70 |
| | Монгол хэл, бичгийн улсын олимпиадыг орон нутагт зохион байгуулна. | Зохион байгуулсан олимпиад ын тоо | 0 | 1 | 0 | Д.Равжаагийн мэндэлсний 220 жилийн ойг угтсан ажлын хүрээнд Монгол хэл, бичгийн улсын олимпиадыг 2023 онд орон нутагт зохион байгуулах талаарх саналыг Боловсрол шинжлэх ухааны яам, Монгол Улсын боловсролын их сургуулийн Монгол хэлний олимпиадыг зохион байгуулах дэд хороотой зөвлөлдөж, саналыг хүргүүлсэн.<br>Ерөнхий боловсролын сургуулийн 6-9 ангийн анги хамт олны Үндэсний бичгийн олимпиадад 20 сургуулийн 5171 сурагчийг оролцуулан, тэргүүлсэн анги, хамт олныг 600,0 мянган төгрөгөөр шагнаж урамшуулсан. | 0 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Иргэдэд зориулсан үндэсний бичгийн танхимыг сургуульд түшиглэн байгуулна. | Танхимын тоо | 3 | 8 | 2 | Насан туршийн боловсролын төв, сумдын насан туршийн боловсролын нэгжийн сургалтын танхимд үндэсний бичиг, үсгийн чиглэлээр иргэд болон төрийн албан хаагчдын дунд түргэн уншлага, хүмүүн бичиг сонины захиалга, уншлага, сургалт, тэмцээн, уралдаан, арга хэмжээг зохион байгуулж, 2022 онд 32 төрлийн арга хэмжээнд давхардсан тоогоор 7800 гаруй хүнийг хамруулсан.<br>Нийт 30,0 сая төгрөгийн хөрөнгийг шийдвэрлэж, Хатанбулаг, Мандах сумдын насан туршийн боловсролын нэгжийн үйл ажиллагааг эрчимжүүлэн, үндэсний бичгийн танхимыг 2022 онд шинээр байгуулсан. | 50 |
| **Зорилт 2.3.9.** Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвд мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх тогтолцоог өргөжүүлнэ. | Политехникийн коллеж болгох асуудлыг судалж шийдвэрлэнэ. | Коллежийн тоо | 0 | 1 | 1 | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны харьяа Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв нь 2020 оны 11 сард Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлөөр байгууллагын магадлан итгэмжлэлд орж Хөдөлмөр нийгмийн хамгаалалын А/68 тоот тушаалаар Дорноговь Политехник коллеж болон өргөжиж 19 мэргэжлээр элсэлт аван үйл ажиллагаагаа явуулж байна. | 100 |
| | Багшлах хүний нөөцийг нэмэгдүүлж чадавхжуулна. | Багшийн тоо | 30 | 35 | 31 | Багш мэргэжлээр суралцаж байгаа 1-4 дүгээр курсийн оюутнуудын судалгааг гаргахад багш мэргэжлээр 1-р курст 46, 2-р курст-32, 3-р курст-39, 4-р курст 20 оюутан суралцаж байна. Аймгийн Засаг даргын 2022 оны А/280 дугаар захирамжаар Саран хөхөө театрын хөгжимчин, бүжигчин 3 уран бүтээлчийн сургалтын хөтөлбөрийн төлбөрт нийт 5,0 сая, А/575 дугаар захирамжаар Дуу хөгжмийн багш мэргэжлээр суралцаж буй 5 оюутны сургалтын төлбөрт орон нутагтаа эргэн ажиллах нөхцөлтэй гэрээний дагуу нийт 20,0 сая, Даланжаргалан сумаас хөгжмийн багш мэргэжлээр сурч буй 1 оюутны сургалтын төлбөрт 4,0 сая, бусад мэргэжлээр суралцаж буй 6 оюутанд 16,0 сая, эмч мэргэжлээр суралцаж байгаа 16 оюутанд 67,9 төгрөг, нийт орон нутагт нэн шаардлагатай багшийг бэлтгэхэд нийт 31 оюутанд 45,0 сая төгрөгийн сургалтын төлбөрийн дэмжлэг үзүүлсэн.<br>Нийт 698 багш ажиллаж буй бөгөөд багшийн хангалт 93,7% байна. | 90 |
| **Зорилт 2.3.10.** Орон нутагт мэргэжил сургалт, үйлдвэрлэлийн төв, коллеж, их, дээд | Орон нутагт сургалтын үйл ажиллагаа явуулдаг их дээд сургуулиудад шаардлагатай | Тэтгэлэг олгосон оюутны тоо | 24 | 120 | 16 | Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Дорноговь аймаг дахь салбар Анагаах Ухааны сургууль их эмч 6 жил, сувилагч 3 жил, дипломын 4 жил, эм найруулагч 3 жил, лабораторийн техникч 3 жилээр нийтдээ 4 мэргэжил, 5 чиглэлээр оюутан сургаж байгаа | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| сургуулиудын үйл ажиллагааг дэмжиж, оюутны сургалтын төлбөрийн дэмжлэг үзүүлнэ. | мэргэжлээр сурах оюутнуудад төлбөрийн дэмжлэг үзүүлнэ. | | | | | судалгааг гарган, сувилахуйн чиглэлээр Дорноговь аймгийн 15 оюутан төгссөн ба үүнээс аймгийн Нэгдсэн эмнэлэгт 10, сумын эрүүл мэндийн төвүүд 1, Замын-Үүд сумын нэгдсэн эмнэлэгт 2 сувилагч, сумын эрүүл мэндийн төвүүдэд шинэ төгссөн 3 эмч, 3 тусгай мэргэжилтэн ажилд орсон.<br>Эм найруулагчийн ангид 2020-2023 онд суралцаж байгаа 16 оюутантай орон нутагтаа тогтвор суурьшилтай ажиллах гэрээг байгуулан сургалтын төлбөрийн 100% -ийн тэтгэлэг болох 67.9 сая төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангаас олгож, орон нутгийн хүний нөөц бэлтгэх ажлыг бодлогоор дэмжсэн. | |
| | Орон нутагт их, дээд сургуулийн салбар байгуулах үйл ажиллагааг дэмжинэ. | Салбарын тоо | 0 | 1 | 0 | Орон нутгийн эрдэмтэн багш, зураач, докторуудтай хамтран 2022 онд зохиолч Л.Түдэвийн "Хорвоотой танилцсан түүх" бүтээлийг албан ёсны зөвшөөрөлтэйгөөр үндэсний бичгээр бичүүлэн, нутгийнхаа хүүхэд, багачуудын оюуныг тэлэх, хөгжүүлэх ажлыг шинээр санаачлан 600 ширхгийг 11,4 сая төгрөгийн санхүүжилтээр хэвлүүлэн, 20 сургуульд түгээж, хичээл сургалтын үйл ажиллагаанд нэвтрүүлсэн.<br>Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн “Захирлын нэрэмжит судалгааны тэтгэлэг”-т орон нутгийн багш, докторант Д.Долгорсүрэн хамрагдан, эрдэм шинжилгээ, судалгааны бүтээлд нь зориулан 3,0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Даланжаргалан сумын ахмад багш Д.Цогбадрах "Итгэлт овогтны ургийн шашдир" угийн бичгийн хөтөч номыг бүтээж, 500 ширхгийг олон нийтийн хүртээл болгосон.<br>Мөн өмнөх онуудад санхүүгийн дэмжлэг үзүүлсэн судалгааны ажил болох судлаач эрдэмтэн Ц.Баатархүүгийн "Хатны булгийн археологийн малтлага"-ын судалгааны ажил дуусаж, үр дүнгээ нэгтгэн "Хатны булгийн нууц" судалгааны ном хэвлэгдэхэд бэлэн болсон. | 0 |
| **Зорилт 2.3.11.** Насан туршийн боловсролыг тэгш хүртээмжтэй хүргэж, суралцах орчин бүрдүүлнэ. | Насан туршийн боловсролыг тэгш хүртээмжтэй хүргэх шинэлэг хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. | Хөтөлбөрийн тоо | 0 | 1 | 0 | Насан туршийн боловсролын төв, сумдын насан туршийн боловсролын нэгжээс 2022 онд иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан “Хүнсний ногоо, жимс жимсгэнэ тариалах, дарах” сургалтад 105 иргэн, дээл эсгэх арга, эмжих технологи, даалин урлалын сургалтад малчин өрхийн 21 иргэн, малчдын амьдрах ухаанаас суралцах экскурс сургалтад 80 гаруй сурагч, нийт 8 төрлийн амьдрах ухааны танхимын сургалтад 225 иргэнийг хамруулсан. | 0 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Ял эдэлж буй 11 иргэнд иргэний боловсрол, ёс зүйн боловсрол, санхүүгийн боловсрол олгох сургалтыг сард 2 удаа тогтмол зохион байгуулж хэвшсэн.<br>Үндэсний бичгийн анхан болон ахисан түвшний сургалт, "Монгол өв соёл" нөлөөллийн арга хэмжээ, гоо зүйн сургалт зэрэг цахим болон танхимын сургалт, нөлөөллийн 17 үйл ажиллагааг зохион байгуулж, давхардсан тоогоор 15800 гаруй иргэнд хүрч үйлчилсэн нь өмнөх оноос үйл ажиллагаагаа өргөжүүлэн, хамрагдсан иргэдийн тоо 5,3%-аар өссөн. | |
| | Насан туршийн боловсролын төвийн ажиллах нөхцөлийг сайжруулж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан сургалтын танхим байгуулна. | Барилгын гүйцэтгэлийн хувь | 0 | 100 | 0 | Хатанбулаг, Мандах сумдын насан туршийн боловсролын нэгжийн үйл ажиллагааг эрчимжүүлэн, үндэсний бичгийн танхимыг шинээр байгуулан, нийт 30,0 сая төгрөгийн хөрөнгө шийдвэрлэсэн.<br>Аймаг, сумдын насан туршийн боловсролын нэгжийн сургалтын танхимд үндэсний бичиг, үсгийн чиглэлээр иргэд болон төрийн албан хаагчдын дунд түргэн уншлага, хүмүүн бичиг сонины захиалга, уншлага, сургалт, тэмцээн, уралдаан, арга хэмжээг тасралтгүй зохион байгуулж, 32 төрлийн арга хэмжээнд давхардсан тоогоор 7800 гаруй хүнийг хамруулсан.<br>Аймгийн Насан туршийн боловсролын төвд нийт 30,4 төгрөгийн хөрөнгө оруулалтаар хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан тусгай хэрэгцээт хөтөлбөрийн хичээлийн танхимыг шинээр байгуулан, танхимаар 13, гэрээр 14, нийт 27 хүүхдийг тусгай боловсролын үйлчилгээнд хамруулсан. | 0 |
| ***Үндсэн чиг үүрэг 2.4.*** *Шинжлэх ухаан, технологи, инновацийг хөгжүүлэх* | | | | | | | |
| **Зорилт 2.4.1.**<br>Бүх төрлийн эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг орон нутгийн нийгэм, эдийн засагт өгч байгаа үр өгөөжийг шалгуур болгон дэмжинэ. | Орон нутгийн нийгэм, эдийн засгийн ач холбогдол бүхий бүх төрлийн эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг дэмжинэ. | Эрдэм шинжилгээний ажлын тоо | 2 | 9 | 3 | Орон нутгийн эрдэмтэн багш, зураач, докторуудтай хамтран 2022 онд зохиолч Л.Түдэвийн "Хорвоотой танилцсан түүх" бүтээлийг албан ёсны зөвшөөрөлтэйгөөр үндэсний бичгээр бичүүлэн, нутгийнхаа хүүхэд, багачуудын оюуныг тэлэх, хөгжүүлэх ажлыг шинээр санаачлан 600 ширхгийг 11,4 сая төгрөгийн санхүүжилтээр хэвлүүлэн, 20 сургуульд түгээж, хичээл сургалтын үйл ажиллагаанд нэвтрүүлсэн.<br>Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн “Захирлын нэрэмжит судалгааны тэтгэлэг”-т орон нутгийн багш, докторант Д.Долгорсүрэн хамрагдан, эрдэм шинжилгээ, судалгааны бүтээлд нь зориулан 3,0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Даланжаргалан сумын ахмад багш Д.Цогбадрах "Итгэлт овогтны ургийн шашдир" угийн | 50 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | бичгийн хөтөч номыг бүтээж, 500 ширхгийг олон нийтийн хүртээл болгосон.<br>Мөн өмнөх онуудад санхүүгийн дэмжлэг үзүүлсэн судалгааны ажил болох судлаач эрдэмтэн Ц.Баатархүүгийн "Хатны булгийн археологийн малтлага"-ын судалгааны ажил дуусаж, үр дүнгээ нэгтгэн "Хатны булгийн нууц" судалгааны ном хэвлэгдэхэд бэлэн болсон. | |
| ***Үндсэн чиг үүрэг 2.5.****Нийгмийн даатгалын тогтолцоог шинэчилж, нийгмийн халамжийг оновчтой болгон, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, хүн амын хөгжлийг хангаж, дундаж давхаргын хүрээг өргөжүүлэн Монгол хүний амьдралын чанарыг дээшлүүлэх.* | | | | | | | |
| **Зорилт 2.5.1.**<br>Нийгмийн даатгалын шинэчлэлийг хэрэгжүүлж, хамрах хүрээг өргөтгөж, сангийн орлогын төлөвлөгөөг биелүүлнэ | Нийгмийн даатгалын шимтгэл төлөгч ажил олгогч болон даатгуулагчийн тоог нэмэгдүүлнэ. | Ажил олгогчийн тоо | 697 | 971 | 736 | Нийгмийн даатгалд сайн дураар даатгуулах даатгуулагчдыг тоог нэмэгдүүлэх зорилгоор сайн дурын даатгуулагчдын анхдугаар зөвлөгөөнийг зохион байгуулж, 14 сумын 100 иргэнийг хамруулсан. Төгсөх ангийн оюутан, сурагчдад нийгмийн даатгалын ач холбогдол сэдвээр сургалт зохион байгуулсан.<br>Сайн дурын даатгалд 401, албан даатгалд 278 даатгуулагчийг хамруулж, идэвхтэй байгаа 736 ажил олгогч, 22626 даатгуулагчийг тус тус нийгмийн даатгалын цахим санд бүртгэсэн. | 70 |
| | | Даатгуулагчийн тоо | 19638 | 21927 | 22626 | | 100 |
| | Нийгмийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөөг биелүүлэх бүх талын арга хэмжээ авна. | Орлогын төлөвлөгөөний биелэлтийн хувь | 112 | 100 | 100 | Нийгмийн даатгалын шимтгэлийн насжилт өндөр, өртэй байгууллагуудын авлагыг барагдуулах талаар шат дараалсан арга хэмжээ авч, 9 байгууллагыг хуулийн байгууллагад шилжүүлж, 13 байгууллагад улсын байцаагчийн албан шаардлагыг хүргүүлэн 36 байгууллагын дутуу төлсөн шимтгэлийн барагдуулахаар Улсын байцаагчийн акт тогтоон төлбөрийг бүрэн барагдуулсан. Зөрчлийн хуулийн дагуу 5 байгууллагад 10,0 сая төгрөгийн шийтгэлийг ногдуулсан.<br>Тэтгэврийн даатгалын сан 31,3 тэрбум төгрөг орлого төвлөрч төлөвлөгөөнөөс 98,4 хувиар биелсэн Тэтгэмжийн даатгалын сан 3,2 тэрбум төгрөг төвлөрч 103 хувиар биелсэн үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сан 3,2 тэрбум 100 хувиар биелсэн ажилгүйдлийн даатгалын санд 649,6 сая төгрөг 95,8 хувиар биелсэн.<br>Нийт 17932 иргэнд 58,4 тэрбум төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийг хугацаанд нь олгосон. 2022 оны Нийгмийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөөг 100% биелүүлсэн. | 100 |
| **Зорилт 2.5.2.**<br>“Цахим нийгмийн даатгал” арга | Нийгмийн даатгалын үйл ажиллагааг цахимжуулан, | Төлөвлөгөөний | 90 | 100 | 70 | “Цахим нийгмийн даатгал” арга хэмжээний хүрээнд 12 нэр төрлийн үйлчилгээг төрийн мэдээлэл солилцооны нэгдсэн системээр дамжуулан, нийгмийн даатгалын цахим | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| хэмжээний хүрээнд нийгмийн даатгалын үйл ажиллагааг үе шаттайгаар цахимжуулж, иргэдэд үзүүлэх үйлчилгээг ил тод, шуурхай хүртээмжтэй болгоно. | иргэдэд үзүүлэх үйлчилгээг ил тод шуурхай хүртээмжтэй болгоно. | хэрэгжилтийн хувь | | | | дэвтрийг 456 иргэнд, тэтгэврийн цахим дэвтрийг 321 тэтгэвэр авагч, ажилгүйдлийн тэтгэмж 36 хүсэлт, хөдөлмөрийн чадвар алдалтын эмнэлгийн хуудас, жирэмсэн болон амаржсаны эмнэлгийн хуудас нийт 1321, ажил олгогчийн тодорхойлолт 744-г олгох зэрэг үйлчилгээг цахимаар хүлээн авч хуулийн хугацаанд шийдвэрлэсэн.Нийгмийн даатгалын 34 үйлчилгээнээс 24 үйлчилгээг цахимаар авах боломжийг бүрдүүлсэн. | |
| | Нийгмийн даатгалын архивын баримтыг бүрэн цахимжуулна. | Цахимжуулалтын хувь | 25 | 100 | 100 | Архивд хадгалагдаж байгаа нийгмийн даатгалын шимтгэл ногдуулалт, төлөлтийн 1995 оноос хойших цаасан суурьтай 285 хадгаламжийн нэгжийн 47514 хуудас бүхий цалингийн баримтуудыг бүрэн скайнердаж улсын хэмжээнд цахимаар ашиглах боломжийг бүрдүүлсэн. Нийгмийн даатгалын "Цахим архив" программын хөгжүүлэлтийг хийж тухайн хэлтэс нь шаардлагатай үед бусад аймаг, дүүргийн хэлтсийн мэдээллийн баазаас таталт хийж QR кодтой лавлагаа гаргах үйлчилгээг нэвтрүүлсэн. Үүний үр дүнд 168 иргэнд QR кодтой лавлагаа, 124 иргэнд цахим лавлагааг гаргаж чирэгдэлгүй үйлчилсэн. 2006 оноос хойших шимтгэл төлөлтийн лавлагааг иргэд өөрсдийн ухаалаг төхөөрөмжөөс бүрэн авах боломжийг бүрдүүлсэн. Аж ахуйн нэгж байгууллагын 1995-2005 оны 285 ширхэг хадгаламжийн нэгж бүхий 47514 хуудас шимтгэлийн тайланг цахимжуулсан. | 100 |
| **Зорилт 2.5.3.** Нийгмийн халамжийн үйлчилгээг зорилтот бүлэгт чиглүүлэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, ядуурлыг бууруулан, цахим системд үе шаттай шилжүүлнэ. | Нийгмийн халамжийн үйлчилгээг цахим системд шилжүүлнэ. | Үйлчилгээний цахим шилжилтийн хувь | 25 | 100 | 88 | 2021 онд 21 нэр төрлийн үйлчилгээ, 2022 онд 38 нэр төрлийн үйлчилгээ нэмэгдэж нийт нийгмийн халамжийн 64 нэр төрлийн үйлчилгээний хүсэлтийг цахимаар хүлээн авах боломжийг бүрдүүлсэн. Дээрх үйлчилгээнд хамрагдах хүсэлт 2021 онд 3162 иргэн, 2022 онд 13447 иргэн хамрагдах хүсэлт гаргасныг хугацаанд нь бүрэн шийдвэрлэсэн. E-mongolia системд 4 төрлийн лавлагаа, тодорхойлолтыг оруулсан ба нийт үйлчилгээний 88,8 хувийг цахимжуулсан. Нийгмийн халамжийн 72 нэр төрлийн үйлчилгээний 64 нэр төрлийг цахимд шилжүүлсэн. | 90 |
| | Хөдөлмөр эрхлэгчдийн орон нутгийн цахим бүртгэлийн | Мэдээллийн сангийн тоо | 0 | 1 | 1 | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас зохион байгуулсан EJOB платформыг хөгжүүлэлтийн сургалтад Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын удирдлагууд болон хөдөлмөр эрхлэлтийн мэргэжилтнүүд, сумдын | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | мэдээллийн санг байгуулна. | | | | | хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтний төлөөлөл 23 албан хаагчийг хамруулсан. Бүгд найрамдах Солонгос улсын Хөдөлмөр эрхлэлт, Хөдөлмөрийн яамнаас хэрэгжүүлж буй “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл”-ийн хүрээнд хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн сангийн системд бүрэн шинэчлэл, сайжруулалт хийж, Хөдөлмөрийн нэгдсэн систем EJOB платформыг хөгжүүлэн 2022 оны 12 сараас үе шаттайгаар нэвтрүүлж эхэлсэн. | |
| | Өрхийн амжиргааны түвшин тогтоох судалгааны чанарыг сайжруулж, нийгмийн халамжийн үйлчилгээг зорилтот эзэнд нь хүргэнэ. | Зорилтот иргэнд хүрсэн хувь | 100 | 100 | 100 | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны сайд, Үндэсний статистикийн хорооны даргын хамтарсан 2022 оны А/84 тушаалаар Өрхийн амьжиргааны түвшин тогтоох судалгааны маягт аргачлал шинэчлэгдсэн бөгөөд туршилтын журмаар зарим аймаг, дүүрэгт судалгаа хийхэд бүртгэлтэй 15343 өрх байгаа бөгөөд доод түвшний 1428, харьцангуй бага хэрэглээтэй 3231, дундаж түвшний 7356, дунджаас дээгүүр 2724, илүү өндөр хэрэглээтэй 604 өрх байгааг тогтоосон. Үүнээс өрхийн амьжиргааны түвшин тогтоох судалгаанд бүртгэлтэй доод түвшний 1428 өрхөөс нөхцөл байдлын үнэлгээ хийж амьжиргааг дэмжих зөвлөлөөр хэлэлцүүлэн 157 өрхийн 292 том хүн, 406 хүүхдэд хүнсний эрхийн бичгийн үйлчилгээ үзүүлж байгаа бөгөөд нийгмийн халамжийн сангаас өссөн дүнгээр 148,8 сая төгрөгийг зарцуулсан. Өмнөх оны мөн үеэс хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагдаж буй өрхийн тоо 146 өрхөөр буурч, халамжийн бусад үйлчилгээнд хамрагдсан иргэдийн тоо 4261 иргэнээр өссөн. Нийгмийн халамжийн үйлчилгээг 25470 иргэнд үзүүлж халамжийн сангаас 11.0 тэрбум төгрөгийг олгосон. | 100 |
| | Орлого багатай болон эмзэг бүлгийн өрхийн гишүүдийг чадавхжуулах замаар ажлын байранд зуучилж, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлнэ. | Зуучлагдсан ажлын байрны тоо | 1088 | 1500 | 214 | 2021 онд “Залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх оролцоо төсөл”-ийн хүрээнд 18-34 насны сүүлийн 3 сар ажил хөдөлмөр эрхлээгүй, их дээд сургууль болон мэргэжлийн боловсролын байгууллагад суралцдаггүй, ажилтай орлоготой болж ирээдүйгээ өөрчлөх хүсэлтэй 103 залуу сургалтад хамрагдаж, 54 оролцогч дадлагад гарч байнгын ажлын байранд 8, өөрөө өөртөө ажлын байр бий болгосон 2, шинээр мэргэжил сонгон суралцаж буй 6 оролцогч байв. 2022 онд ажил мэргэжлийн чиг баримжаа зөвлөгөө өгөх үйлчилгээ, мэргэжлийн ур чадварыг богино хугацаанд эзэмшүүлэх сургалт, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх | 50 |
| | | Зорилтот бүлгийн иргэдийн тоо | 84 | 130 | 133 | | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | "Оролцоо" төслийн сургалтад өрхийн мэдээллийн нэгдсэн сангийн 409-өөс доош оноотой нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай, орлого багатай болон эмзэг бүлгийн өрхийн 133 иргэнийг хамруулж чадавхжуулсан.<br>Үүнээс 214 иргэнийг байнгын болон түр ажлын байранд зуучлан ажилласан. | |
| **Зорилт 2.5.4.**<br>Орон нутгийн бүтээн байгуулалтын эрэлт хэрэгцээнд нийцүүлэн шинэ ажлын байр бий болгох, ажилгүйдлийг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлж, хөдөлмөр эрхлэлтийн түвшинг тогтмол нэмэгдүүлнэ. | Хөдөлмөрийн зах зээлийн судалгаанд үндэслэж мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэнэ. | МСҮТ төгссөн сурагчдын тоо | 261 | 1000 | 363 | "Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөр", "Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр", "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр" -ийн хүрээнд хөдөлмөрийн зах зээлийн судалгаа болон зорилтот бүлгийн иргэдийн эрэлт хэрэгцээнд үндэслэн богино хугацаанд мэргэжлийн ур чадвар олгох сургалтыг үсчин, тогооч, оёдолчин, гагнуурчин мэргэжлээр зохион байгуулан, 61 иргэнд чадамжийн гэрчилгээг олгож хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 11,9 сая төгрөгийг зарцуулсан.<br>Төмөр замын замчин, Барилгын засал чимэглэл, Гагнуурчин зэрэг мэргэжлүүдээр аймгийн Политехникийн коллежид 2020-2021 оны хичээлийн жилд 462 суралцагч, 2022-2023 оны хичээлийн жилд 337 суралцагч шинээр элсэж, 2,5 жилийн сургалтыг 7 мэргэжлээр 204, 1 жилийн сургалтыг 9 мэргэжлээр 159 суралцагч тус тус төгсөн уул уурхай, барилга, төмөр замын салбарын мэргэжилтэй боловсон хүчнээр бэлтгэгдсэн. | 70 |
| | Цагийн болон өдрөөр ажиллах хөдөлмөрийн уян хатан тогтолцоо, нөхцөлийг бүрдүүлнэ. | Түр шинэ ажлын байранд орсон иргэдийн тоо | 485 | 2000 | 722 | Ажил олгогч байгууллага, хувиараа хөдөлмөр эрхлэгч, иргэдийн цагийн болон өдрийн ажлын байрны захиалгыг тухай бүрд авч Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн программд нэгтгэн орон нутгийн DTV телевиз болон зарын цахим сайт, цахим хуудсаар долоо хоногт 2 удаагийн давтамжтайгаар ажлын байрны 61 захиалгыг 23 аж ахуй, нэгж байгууллага, 10 иргэнээс авч, шинэчлэн зар мэдээг хүргэж 46 иргэнийг ажлын байранд зуучилсан.<br>Түр ажлын байранд 126 иргэнийг зуучилж, төсөл хөтөлбөрийн хүрээнд 596 иргэнийг түр ажлын байраар ханган ажилласан. Нийт 722 иргэнийг түр ажлын байраар хангасан. | 70 |
| | Орон нутгийн бүтээн байгуулалтын хүрээнд шинээр бий болсон үйлдвэр, үйлчилгээний | Шинэ ажлын байрны тоо | 110 3 | 4800 | 969 | Аймгийн хэмжээнд байнгын 99, улирлын 7, түр 200, нийт 306 шинэ ажлын байрыг бүртгэснээс 123 нь орон нутгийн бүтээн байгуулалтын хүрээнд шинээр бий болсон үйлдвэр, үйлчилгээний салбарын шинэ ажлын байр байна. | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | салбарын шинэ ажлын байранд ажиллагсдыг зуучилж, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлнэ. | | | | | Нийт 556 иргэнийг зуучлан ажилласнаас орон нутгийн бүтээн байгуулалтын хүрээнд шинээр бий болсон үйлдвэр, үйлчилгээний салбарын шинэ ажлын байранд 413 иргэнийг зуучилсан бөгөөд 130 иргэн байнгын, 283 иргэн 2021 онд түр болон улирлын шинэ ажлын байранд зуучлагдсан.<br>2022 онд нийт 413 иргэнийг шинэ ажлын байранд зуучилсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал зуучлагдсан иргэдийн тоо 295 иргэнээр өссөн. | |
| | Хувийн хөдөлмөрийн бирж байгуулах иргэн, аж ахуйн нэгж байгууллагыг дэмжинэ. | Хувийн хөдөлмөрийн биржийн тоо | 0 | 1 | 1 | Дорнын говь тур ХХК нь цагийн ажилд иргэдийг зуучлах зорилгоор хөдөлмөрийн биржийг туршилтаар 2021 оны 4 сараас эхлэн үйл ажиллагаа явуулж, 2021 онд "Төгс-өнөд" ХХК, "Хангайн бигэр" ХХК, "Равжаа музей", "Дэлгэр баясах зам" ХХК зэрэг аж ахуй нэгж байгууллага болон засвар, барилгын ажил хийж буй хувь хүмүүст давхардсан тоогоор 150-200 иргэдийг 4-12 цагийн ажилд зуучлан ажиллуулсан.<br>"Өвлөх ухаан" төрийн бус байгууллагад хувийн бирж байгуулах боломж нөхцөлийн талаар мэдээлэл өгч, мэргэжил арга зүйгээр ханган ажилласан. Эдгээр байгууллагууд нь цаашид Хувийн хөдөлмөрийн биржийн албан ёсны зөвшөөрөл авах боломжийн талаар судалгаа хийж, бэлтгэл ажлаа ханган ажилласан. | 70 |
| **Зорилт 2.5.5.** Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмад настанд ээлтэй, хүртээмжтэй орчин нөхцөлийг бүрдүүлж, хөдөлмөр эрхлэх боломжоор хангана. | Говийн бүсийн ахмад настны төрөлжсөн Асрамжийн газрын барилга барина. | Барилгын гүйцэтгэлийн хувь | 0 | 100 | 80 | Говийн бүсийн ахмад настны төрөлжсөн асрамжийн газрын барилга барих ажлыг улсын төсвийн 2,6 тэрбум төгрөгийн төсөвт өртгөөр "Тогоруутай нуур" ХХК-аар гүйцэтгүүлсэн. Барилгын үндсэн хийц бүтээцийн угсралтын ажил дуусаж, дотор шавардлага, цахилгаан, сантехник, гадна шугам сүлжээний угсралтын ажил хийгдсэн.<br>Барилга угсралтын ажлын гүйцэтгэл 80%-тай. 2022 онд төлөвлөсөн ажлын хэрэгжилт 100 хувьтай биелсэн. | 100 |
| | Сайншанд суманд Ахмадын сувиллын барилга барина. | Барилгын гүйцэтгэлийн хувь | 0 | 100 | 80 | Улсын төсвийн 4,4 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Сайншанд суманд 60 ортой Ахмадын сувиллын барилга барих ажлыг "Элит Конкрет " ХХК-аар гүйцэтгүүлэн, барилгын үндсэн хийц бүтээц, дээвэр, цонх угсрах, дотор шавардлага, цахилгаан, сантехник, салхивч, гадна бохир усны цооног, цахилгаан хангамжийн ажлууд нь бүрэн, дотор засал, гипсэн тааз угсрах, гадна фасадны рам зангидах, гадна тохижилтын ажлуудын явц 80%-тай биелсэн. | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Хөгжлийн бэрхшээлтэй иргэн, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн “Эрүүлжин хөгжих төв”-ийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулна. | Хамрагдсан хүүхдийн тоо | 0 | 200 | 9 | Эрүүл хөгжих төвийн үйл ажиллагаа болон цалингийн зардалд орон нутгийн төсвөөс 66,9 сая төгрөг батлагдан, 09:00-16:00 цаг хүртэл үйлчилгээ үзүүлж, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн асран хамгаалагчид хөдөлмөр эрхлэх боломжоор хангах үйл ажиллагааг явуулж, 18,8 сая төгрөгийг зарцуулсан.<br>Олон улсын Holtinternational сургуулийн өмнөх боловсролын байгууллагын багш ажилчид болон тусгай хэрэгцээт цэцэрлэг сургуулийн бүлгийн багш нар, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн өдөр өнжүүлэх “Эрүүлжин хөгжих төв”-ийн ажилтнууд байнгын асаргаатай хүүхдүүдийн эцэг, эх нийт 50 иргэнд хүүхдийн асаргаа сувилгааны талаар сургалт, ”Бидний хүүхэд-Бидний ирээдүй” хэлэлцүүлэг зэргийг зохион байгуулан, 9 хүүхдэд сэргээн засах, өдөр өнжүүлэх үйлчилгээг тогтмол үзүүлсэн. | 90 |
| **Зорилт 2.5.6.** Залуучуудад бизнес эрхлэх зорилгодоо хүрэхэд шаардлагатай дэмжлэг, туслалцааг үзүүлэх, орчин, нөхцөлийг бүрдүүлнэ. | Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвийн үйл ажиллагааг өргөжүүлнэ. | Төвөөр үйлчлүүлсэн залуучуудын тоо | 448 | 2000 | 582 | Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвөөр 582 иргэн үйлчлүүлснээс 254 иргэнийг ажил хайгчаар бүртгэж, цахимаар 1 сургалт, танхимаар 2 төрлийн арга хэмжээ болон бусад арга хэмжээг 6 удаа зохион байгуулсан. | 70 |
| | | Сургалт, арга хэмжээний тоо | 5 | 20 | 15 | Best хөтөлбөрийн Дорноговь салбартай хамтран “модуль-4” “Би туршлагаасаа хуваалцаж чадна” сургалтад 35 залууг хамруулж, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар 2022-2023 онд хэрэгжүүлэх 7 хөтөлбөрийг танилцуулж, “Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр” болон бусад төсөл хөтөлбөрүүдэд хамрагдах боломжийн талаар мэдээлэл өгсөн, мөн амжилттай бизнес эрхэлж байгаа залуусын төлөөлөл, 2020 оны “Старт-Ап”-ийн шилдэг 5 оролцогчид туршлагаасаа хуваалцсан.<br>Модуль сургалтуудад давхардсан тоогоор нийт 66 иргэнийг хамруулсан. “Залуусаа сонсох өдөр” арга хэмжээг аймгийн Политехник коллеж дээр зохион байгуулж 5 ангийн 113 төгсөгчдөд “Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-ийн start-up арга хэмжээ, бусад Олон улсын төсөл болон сургалтын мэдээлэл өгсөн. “Оролцоо төсөл”-д 103 залууг бүртгэсэн бөгөөд төслийн 1-4 дүгээр ээлжийн сургалтад 64 залуу хамрагдсанаас 28 залууг түр болон байнгын ажлын байранд зуучилсан. Ажил хайгчаар бүртгүүлсэн залуучуудын төлөөлөлтэй уулзалт хэлэлцүүлэг зохион байгуулж 9 залууг мэргэжлийн ур | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | чадварыг богино хугацаанд эзэмшүүлэх сургалтад хамруулсан. | |
| | Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг бодлогоор дэмжинэ. | Төсөл, хөтөлбөр дэмжлэгт хамрагдсан бүлгийн тоо | 24 | 96 | 167 | Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2021, 2022 оны 1 дүгээр тогтоолоор батлагдсан “Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр” болон Монгол Улсын Засгийн газрын “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө”-ний 2.6 дахь, 2021 оны 58 дугаар тогтоолоор батлагдсан “Залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх-Оролцоо төсөл”-ийг хэрэгжүүлэн, Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт 2021 онд давхардсан тоогоор 178 залуу, 2022 онд 134 залуу хамруулснаас, 2 залууд тус бүр 10.0 сая төгрөгийн санхүүгийн буцалтгүй дэмжлэг олгож, 98 оюутан, залуусыг цагийн болон өдрийн ажлын байранд зуучлан ажилласан.<br>“Залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх-Оролцоо төсөл”-д 2021 онд 103, 2022 онд 64 залуучуудыг хамруулж, тэдгээрээс 61 залууг байнгын болон түр ажлын байранд зуучилсан. | 100 |
| **Зорилт 2.5.7.** Жендэрийн эрх тэгш байдлыг хангах орон нутгийн тогтолцоог бэхжүүлж, байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулж, төрийн бус байгууллага, иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ. | Жендэрийн эрх тэгш байдлыг хангах бодлогыг бүх түвшинд сурталчлан, хамтын ажиллагааг дэмжиж, жендэрийн хэвшмэл ойлголтыг арилгахад чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. | Зохион байгуулсан багц арга хэмжээний тоо | 3 | 20 | 24 | "Харилцан хүндэтгэе" цахим хэлэлцүүлэг, "Аавуудын өдөр", "Аавуудын өдөрлөг", "Аавтайгаа хамт", “Жендерт суурилсан гэр бүлийн хүчирхийлэл “Дэвжээ” танин мэдэхүйн тэмцээн, "Хайраа хайрлая", "Хандлагаа өөрчилье", "Хамтдаа үлгэрлэе" зэрэг арга хэмжээнүүдээс гадна урлаг спортын нөлөөллийн арга хэмжээнүүдийг зохион байгуулж 5000 гаруй иргэдийг хамруулсан.<br>"Тэгш хүртээмжтэй байдал залуусын манлайлал" сургалтад аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын Залуучуудын асуудал хариуцсан мэргэжилтэн сургагч багшаар бэлтгэгдэн "Жендерт хүйс хамаатай юу?", "Охид хөвгүүдийнхээ талаар ярилцъя", "Аз жаргалтай гэр бүлийг бүтээцгээе", "Эрүүл мэндээ хамтдаа хамгаалцгаая" зэрэг 10 сэдвээр 480 иргэнд сургалт мэдээлэл өгсөн.<br>Ерөнхийлөгчийн ивээл дор “Нийгмийн хөгжилд эрэгтэйчүүдийн оролцоо, манлайлал” үндэсний чуулганы хүрээнд 30 эрэгтэйчүүдийн төлөөлөл оролцсон аймгийн дэд хэлэлцүүлгийг зохион байгуулан, санал, эрэгтэйчүүдэд тулгамдсан асуудлыг нэгтгэж, үндэсний чуулганд хүргүүлж, аймгаа төлөөлж 5 эрэгтэй оролцсон.<br>Жендерийн хэвшмэл ойлголтыг халах зорилгоор "Залуу гэр бүлийн зөвлөгөөн", “Хосын сургалт", “Жендерт суурилсан гэр бүлийн хүчирхийлэл”, "Гэр бүлийн үнэ цэнэ", “Гэр бүлийн үндсэн үүрэг хариуцлага” "Нандин" чуулган, | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | "Охидын өдөр", "Цагаан сарнай" зэрэг 8 төрлийн арга хэмжээг зохион байгуулж 1510 иргэнийг хамруулан, "Харилцан хүндэтгэе" сарын аяны хүрээнд 14 суманд жендерийн эрх тэгш байдлыг хангах, жендерийн хэвшмэл ойлголтыг арилгахад чиглэсэн олон талт арга хэмжээг зохион байгуулсан. | |
| | Төрийн үйлчилгээ болон хөдөлмөр эрхлэлтийн харилцаанд иргэдийг бүх талаар тэгш хамруулах бодлогыг хэрэгжүүлнэ. | Төлөвлөгөө өний хэрэгжилтийн хувь | 90 | 100 | 70 | Хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх төсөл хөтөлбөрүүдийн төсөл сонгон шалгаруулах ажлын хэсэгт 2021 онд 9, 2022 онд 13-н төрийн бус байгууллага болон иргэдийн төлөөллийг оролцуулан шийдвэр гаргах түвшинд тэдний оролцоог ханган ажилласан. 2022 онд 4 төрийн бус байгууллагаар дамжуулан олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээг 363 иргэнд үзүүлсэн.<br>Төсөл хөтөлбөрүүдийн сонгон шалгаруулалтын ажлын хэсгийн нийт гишүүдийн 2021 онд 36 хувьд нь, 2022 онд 43.3 хувьд нь төрийн бус байгууллага, иргэний төлөөллийг оролцуулсан. | 70 |
| **Зорилт 2.5.8.** Гэр бүлийн үнэ цэнэ, тогтвортой байдлыг хангах, гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хүүхэд хүмүүжлийн эерэг аргыг түгээн дэлгэрүүлнэ. | Гэр бүлийн тогтвортой байдлыг хангах бүх талын бодлого, нөлөөллийн үйл ажиллагааг явуулна. | Арга хэмжээнд хамрагдсан иргэдийн тоо | 370 00 | 152000 | 52869 | Хууль ёсны тогтвортой гэр бүлийг дэмжих бодлогын хүрээнд 2021 онд “Хайрлах ухаан” цахим чуулганыг зохион байгуулж шинээр гэр болж байгаа 12 хосод гэрлэлтийн баталгаа гардуулсан бол 2022 онд 5 хос, нийгэмд үлгэр дуурайлал болсон залуу, дунд, алтан хуримаа хийсэн ахмад зэрэг нийт 5 гэр бүлийн амьдралын түүхийн талаар "айл гэр бүл" подкастыг бэлтгэн тэдгээрийн амьдралын сайн туршлагыг түгээн дэлгэрүүлсэн.<br>"Олон улсын гэр бүлийн өдөр", "Аавуудын өдөр", "Хүүхдийг зодож шийтгэхийн эсрэг өдөр" зэрэг тэмдэглэлт өдрүүдээр аймгийн хэмжээнд "Гэр бүлийн аз жаргалын үнэ цэнэ" зөвлөгөөн, ”Аав ба би”, “Би гэр бүлдээ үүнийг хүсдэг” зэрэг 20 төрлийн урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх арга хэмжээнд 13924 иргэнийг хамруулж мэдээлэл хүргэсэн бөгөөд Сайншанд, Өргөн, Мандах, Алтаншираэ зэрэг сумд "Жаргалтай гэр бүл", "Гэр бүлийн өдөрлөг" зэрэг гэр бүлийг дэмжсэн зөвлөгөөнийг хийж, мэргэжлийн лектор, сэтгэл зүйчдийг урьж оролцуулан хүүхдэд ээлтэй гэр бүлийн орчныг бүрдүүлэхэд анхаарч ажилласан.<br>Гэр бүлийн өдөрлөг, нөлөөллийн нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээ, тэмдэглэлт өдрүүдээр зохион байгуулсан арга хэмжээгээр дамжуулан 52869 иргэнд гэр бүлийн үнэ цэнэ, тогтвортой байдлыг хангах, хүүхэд хүмүүжлийн эерэг аргын төлөөр гэр бүлийн боловсрол олгоход чиглэсэн мэдээ мэдээллийг хүргэж ажилласан. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Гэр бүлд зөвлөгөө өгөх үйлчилгээний орчин нөхцөлийг сайжруулна. | Байгуулагдсан төвийн тоо | 0 | 1 | 0 | Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газарт мэргэжлийн 1 сэтгэл зүйч ажиллаж байна. Сэтгэл судлаач хүчирхийллийн хохирогч болон гэр бүлийн зөрчилтэй иргэдийн судалгааг гарган, сэтгэл зүйч, хүүхдийн эрхийн ажилтанд хандсан 28 иргэнд тулгамдсан асуудлыг нь шийдвэрлэх, сэтгэл зүйн анхан шатны үйлчилгээг үзүүлсэн.<br>Үүнээс хохирогч болсон 4 иргэнд хамгаалах байраар үйлчилгээ үзүүлж, сэтгэл заслын үйлчилгээг хүргэсэн.<br>Зөвлөгөө өгөх өрөө танхимын засварын саналыг 2023 оны төсөвт оруулахаар санал хүргүүлэн боловч батлагдаагүй. | 0 |
| | Иргэдийг гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ойлголт, хандлагыг сайжруулж, гэр бүлийн харилцаа болон хүүхэд хүмүүжлийн зерэг аргыг түгээн дэлгэрүүлнэ. | Арга хэмжээнд хамрагдсан иргэдийн тоо | 15000 | 60000 | 436859 | Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх аймгийн дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний дагуу гэр бүл, хүүхдийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хамтарсан багийн үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэх зорилгоор “Хамтарсан багийн үйл ажиллагааг идэвхжүүлэх нь” сэдэвт бичил төслийн уралдааныг зарлаж, 11 төслөөс 5 төслийг шалгаруулан, тус бүр 2,0 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон.<br>Хууль сахиулах чиг үүргийн байгууллагууд болон "Саран хөхөө" театртай хамтран гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор “Хайр нэмье, Хүчирхийллийг хасъя” нөлөөллийн аяны хүрээнд 8 төрлийн видео шторк, 18 постер мэдээлэл, 3 подкаст хийж, Facebook Boost хэлбэрийг ашиглан 560,0 мянган төгрөг зарцуулж цахим орчинд түгээснээр нийт 188935 хүнд хүрч, 1032 хүн бусадтай хуваалцаж, 934 хүнд таалагдаж, 1100 хүн нүүр зургаа сольж аянд нэгдсэн.<br>Аймгийн хэмжээнд эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа 435 өрхийн мэдээллийн сан үүсгэн, эрсдэл өндөртэй 36 өрхийн 164 иргэн, үүнээс 78 хүүхдэд 2 удаагийн 5378,0 мянган төгрөгийн хүнс, тэжээл, амин дэм, түлээ нүүрсний дэмжлэг үзүүлсэн.<br>Зорилтот бүлгийн иргэдэд эрх зүйн мэдлэг олгох зорилгоор 8 төрлийн 4914 гарын авлагыг 2361 эцэг эх, асран хамгаалагчид, 2553 хүүхдэд тараасан. “Тэвчье, цэглэе” нэгдсэн арга хэмжээний хүрээнд эцэг эхийн хуулиар хүлээсэн үүрэг хариуцлага, хүүхэд хүмүүжлийн зерэг аргын талаар 275 төрийн албан хаагч, 314 зорилтот бүлгийн иргэнд сургалт хийсэн. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Хэвлэл мэдээллийн хэрэгслээр 327 удаа хууль сурталчлах шторк, мэдээллийг цацаж, 500 гаруй постер, 26 төрлийн подкаст, видеог бэлтгэн цахим орчинд хүргэж, хамгийн олон хандагчтай 16-42 группт тухай бүр түгээж 436859 хүний хандалт авсан. | |
| **Зорилт 2.5.9.** Хүүхдийн хөгжил, хамгааллын бодлогыг хэрэгжүүлж, хүүхдэд ээлтэй орчныг бүрдүүлнэ. | “Хүүхдэд ээлтэй орон нутаг” арга хэмжээг хэрэгжүүлнэ. | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 0 | 100 | 92 | Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 53 дугаар тогтоолоор баталсан “Хүүхдэд ээлтэй орон нутаг” зорилтот хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр 7 зорилтын хүрээнд 85 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөн, хэрэгжилтийг 92% ханган ажилласан. Үндэсний хэмжээнд зохион байгуулагдсан "Майхант чуулган", “Хүүхдийн зөвлөлийн хэлэлцүүлэг” зэрэг арга хэмжээнд 215 хүүхдийг оролцуулж, аймгийн хэмжээнд Хүүхдийн нэгдсэн чуулган, “Яргуй” хүүхдийн урлагийн наадам зэрэг 10 тэмцээн уралдааныг зохион байгуулж, 2692 хүүхдийг хамруулан 29,8 сая төгрөгийг зарцуулсан.<br>“Хүүхдээ сонсох өдөр”-ийг тогтмол зохион байгуулж хэвшсэн бөгөөд хүүхдүүдээс гарсан саналыг нэгтгэн, Хатанбулаг сум "Үлгэр домгийн өргөө", монгол бичгийн кабинетыг 3,9 сая төгрөгөөр тохижуулж, Даланжаргалан, Хөвсгөл, Мандах сумд сургуулийн орчны авто замын хурд саарсуулагчийг сэргээн засварласан.<br>Гэр бүлийн боловсролыг нэмэгдүүлэх чиглэлээр Сайншанд, Алтанширээ, Өргөн зэрэг 5 сумдад гэр бүлийн зөвлөгөөн, Алтанширээ, Мандах сумдын хамтарсан баг “Дэвжээ” тэмцээн, 18 аж ахуй нэгж байгууллагын эцэг эхийн зөвлөлөөс 15 төрлийн нөлөөллийн арга хэмжээнд 4738 гэр бүл, иргэд олон нийтийг хамруулж, айл гэр цуврал подкаст, 7 төрлийн зөвлөмжийг хүргэн, 31 байгууллага “Хүүхэд хамгааллын бодлого”-ын баримт бичгийг батлан мөрдөж, 11 байгууллага хүүхдийн өрөөг тохижуулан хүүхдэд ээлтэй орчныг бүрдүүлсэн.. | 100 |
| | Хүүхдийн зуслан барьж ашиглалтад оруулна. | Гүйцэтгэлийн хувь | 10 | 100 | 100 | “Хүүхэд хөгжил – 2022” зорилтот жилийн хүрээнд хүүхдүүдийн сурч хөгжих, чөлөөт цагаа зөв зохистой өнгөрүүлэх, эрүүл аюулгүй орчинд сурч боловсрон хөгжих орчин нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор Сайншанд сумын 2 дугаар багийн нутаг дэвсгэрт баригдсан нэг ээлжинд 100 хүүхэд хүлээн авах хүчин чадалтай Хүүхдийн зусланг барьж, ашиглалтад оруулсан.<br>Хүүхдийн зусланд улс, орон нутгийн 2.3 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар амрагч хүүхдийн нийт 28 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байр ажилчдын байр-4, хооллох танхим, нийтийн ариун цэврийн байр, нийтийн халуун ус, анхны тусламжийн зэрэг 33 барилга байгууламжуудыг “Энержипарагон” ХХК, “Дэлгэр баясах зам” ХХК нар гүйцэтгэсэн ба орон нутгийн барилгын компаниудын дэмжлэгээр хүүхдүүдэд зориулж усан бассейн, усан оргилуурыг хийсэн.<br>Жаргалан хүүхдийн зуслан нь 2022 онд 1 менежер, 4 багш, 11 туслах ажилтантайгаар үйл ажиллагаагаа явуулж 3 ээлжийн 279 хүүхдийг хүлээн авч сүлжээ төлөвлөгөөний дагуу хөгжлийн арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Жаргалан зуслангийн үйл ажиллагаа эхлэн явуулахад дэвжлэг үзүүлж улсын болон орон нутгийн төсвөөс 38703,7 мянган төгрөгийн санхүүжилтийг хүлээн авч зарцуулсан байна. Мөн жаргалан зуслангийн үйл ажиллагааны орлогоос 38160,0 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн. | |
| | Хүүхдийн ордны дэргэд “Хүүхдийн урлан бүтээх төв” байгуулна. | Гүйцэтгэлийн хувь | 0 | 100 | 100 | Аймгийн Засаг даргын 2022 оны А/95 дугаар захирамжаар батлагдсан “Хүүхэд хөгжил-2022” зорилтот жилийн хүрээнд хүүхдийн ордныг “Хүүхэд хөгжлийн төв” болгосон ба тус төвд уран нугаралт, шатар, хөгжим, охидын клуб, илтгэх урлаг, уран зураг зэрэг 9 төрлийн дугуйлан хичээллэж 467 хүүхэд, багачууд хамрагдсан.<br>Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад дугуйлангийн тоо 6 төрлөөр, хүүхдийн тоо 25 хувиар өссөн. | 100 |
| | Байгууллага, аж ахуйн нэгжийн дэргэдэх эцэг, эхийн зөвлөлийн тоог нэмэгдүүлж, үйл ажиллагааг нь идэвхжүүлнэ. | Эцэг эхийн зөвлөлтэй байгууллагын тоо | 35 | 100 | 79 | Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн 2018 оны 03 дугаар тогтоол, “Хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх үлгэрчилсэн заавар батлах тухай” 2022 оны А/110 дугаар тушаалын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд 2 удаагийн чиглэл, зөвлөмжийг аж ахуйн нэгж байгууллагын дарга, эрхлэгч нарт хүргүүлэн, хүүхэд хамгааллын бодлогыг 31 байгууллага мөрдөж, Политехник коллеж, Улаанбаатар төмөр замын Сайншанд зангилаа, Замын-Үүд ерөнхий боловсролын 3 дугаар сургууль, Хатанбулаг сумын Эрүүл мэндийн төв зэрэг 6 байгууллага шинээр эцэг эхийн зөвлөл байгуулсан.<br>Эрүүл мэндийн газар, Нийтлэг үйлчилгээний газар, Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар, Алтанширээ сумын төсвийн 5 байгууллага зэрэг 11 байгууллага нөөц боломжоо ашиглан хүүхдийн өрөөтэй болж ажилтнуудынхаа хүүхдэд ээлтэй орчныг бүрдүүлж 11,3 сая төгрөгийн санхүүжилтийг зарцуулсан. | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Нийт 79 аж ахуйн нэгж байгууллага эцэг эхийн зөвлөлөөр дамжуулж хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилтийг хангаж, үүнээс 18 эцэг эхийн зөвлөл гэр бүлийн боловсролыг дэмжих чиглэлээр соён гэгээрүүлэх 15 төрлийн нөлөөллийн арга хэмжээнд 1347 ажилтныг гэр бүлийн хамт хамруулсан. | |
| **Зорилт 2.5.10.** Нийгмийн харилцаан дахь залуучуудын хөгжил, оролцоог сайжруулж, санал санаачилгыг дэмжинэ. | Залуучуудын хөгжил, оролцоо, эрх хамгааллын талаарх төрийн бодлого шийдвэр, дүрэм журмын хэрэгжилтийг хангана. | Арга хэмжээнд хамрагдсан залуучуудын хувь | 60 | 70 | 50 | Залуучуудын оролцоог хангасан үндэсний 1 цахим, 1 хэлэлцүүлэг, аймгийн 2 удаагийн чуулганыг зохион байгуулж нийт 15-40 хүртэлх насны 430 залуучууд оролцон өөрсдийн үзэл бодол, тулгамдсан асуудлын талаар хэлэлцэж дуу хоолойгоо бодлогын түвшинд хүргэх боломжийг бүрдүүлэн, бодлогын түвшинд хэрэгжүүлэх чиглэл зөвлөмжийн сумын Засаг дарга, залуучуудын хөгжлийн салбар зөвлөлийн тэргүүн нар 5 удаагийн зөвлөмж чиглэлийг хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан.<br>Даланжаргалан сум 8 залуу төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангаж орон сууцанд хамруулсан, 5 төрийн албан хаагчийн мэдлэг, чадвараа дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлж сургалтын төлбөрийн хөнгөлөлт үзүүлсэн. Замын-Үүд сумын 2 багт тоглоомын талбайг шинээр барьж хүүхэд, залуучуудын чөлөөт цагаа өнгөрөөх ээлтэй орчныг бүрдүүлсэн.<br>Айраг сум 2 оюутны төлбөрийг 100 хувь шийдвэрлэж, 38 айлын орон сууцыг ашиглалтад оруулж залуу гэр бүлийн амьдрах орчныг сайжруулсан, Хатанбулаг сум нүүдэлчин уламжлалыг өсвөр үе, залуучуудад сурталчлан таниулах, өвлүүлэх зорилгоор морин өртөө тэмцээнийг зохион байгуулсан зэрэг өсвөр үе залуучуудад чиглэсэн бодлого шийдвэрийг хэрэгжүүлж ажилласан.<br>Тайлант хугацаанд 5 сумын Засаг дарга, Залуучуудын хөгжлийн салбар зөвлөлийн тэргүүн нар "Залууст ээлтэй шийдвэр" сайн туршлагыг видео хэлбэрээр бэлтгэн орон нутгийн телевиз олон нийтийн мэдээллийн сувгаар дамжуулан олон нийтэд сурталчлан таниулсан. | 70 |
| | Залуучуудын хөгжил, оролцоог сайжруулж, санал санаачлагыг дэмжинэ. | Арга хэмжээнд хамрагдсан залуучуудын хувь | 60 | 70 | 50 | | 70 |
| | Сайншанд, Замын-Үүд сумдад хүүхэд, залуучуудын хөгжлийн төвийг байгуулна. | Гүйцэтгэлийн хувь | 0 | 100 | 0 | Залуучуудын хөгжлийн төвийн чиг үүргийн дагуу Зэвсэгт хүчний 336 дугаар анги, “Чандмань илч” ОНӨХХК, Сайншанд сумын Засаг даргын Тамгын газар зэрэг төрийн болон орон нутгийн өмчийн нийт 15 байгууллагын 335 албан хаагч, зорилтот бүлгийн 145 иргэн нийт 520 иргэнд “Сэтгэл хөдлөл, Стресс бухимдлаа зохицуулах”, “Жендерийн хэвшмэл ойлголт”, “Өөртөө итгэх итгэл” зэрэг | 0 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 11 сэдвийн хүрээнд амьдрах ухааны мэдлэг олгох сургалт зохион байгуулсан.<br>Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамнаас санаачлан “New history” хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд “Ирээдүйн эзэд” 5 удаагийн лекцийг 9-12 ангийн 1500 хүүхдэд хүргэсэн.<br>Төвийн дэргэдэх Лидер сурагч академи, Мэтгэлцээний клуб, Охидын клуб, Сайн дурынхны клуб, Гарааны бизнес эрхлэгчдийн бүлэг зэрэг өсвөр үе, залуучуудын 6 бүлэг идэвхтэй үйл ажиллагаа явуулж 25 арга хэмжээнд 2420 өсвөр үе, залуучуудыг хамруулсан. | |
| | Залуу гэр бүлийг орон сууцтай болгох төсөл, хөтөлбөрийг дэмжинэ. | Орон сууцанд хамрагдсан өрхийн хувь | 25 | 50 | 80 | "150 мянган айлын орон сууц" хөтөлбөрийн хүрээнд "Мандах наран-5" хорооллын 1152 айлын орон сууцны төслийг “Гантулга трейд” ХХК хэрэгжүүлэхээр гэрээ байгуулж Сайншанд сумын 7 дугаар багт эхний ээлжийн 384 айлын орон сууцны барилгыг гүйцэтгэж барилга угсралтын ажлын гүйцэтгэл 75%-тай байна.<br>Айраг сум 38 айлын орон сууцыг ашиглалтад оруулж залуу гэр бүлийн амьдрах орчныг сайжруулсан ба Даланжаргалан сум 8 залуу төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангаж орон сууцанд хамруулсан. Сумдын эрүүл мэндийн төвүүдэд ажиллаж байгаа 34 эмч мэргэжилтнийг төрийн албан хаагчийн орон сууцанд 100% үнэ төлбөргүйгээр амьдрах нөхцлийг хангаж, нийт 31,5 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. | 90 |
| ***Үндсэн чиг үүрэг 2.6.*** *Үндэсний үнэт зүйл, уламжлалт өв соёлоо дээдлэн, иргэдийг соён гэгээрүүлж, соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх.* | | | | | | | |
| **Зорилт 2.6.1.** Үндэсний бахархал, монгол өв соёлыг өвлүүлж, стандарт шаардлагад нийцсэн соёл урлагийн байгууллагын барилга байгууламжийн тоог нэмэгдүүлнэ. | Хамарын хийдэд ноён хутагт Д.Данзанравжаагийн нэрэмжит соёл аялал жуулчлалын цогцолбор байгуулах төслийг эхлүүлнэ. | Гүйцэтгэлийн хувь | 0 | 100 | 0 | Хамарын хийдийн 3-н замын уулзварт аялал жуулчлалын зориулалтаар 5 га газрыг “Бэст Эргэл” ХХК-д аймгийн Засаг даргын 2022 оны А/642 дугаар захирамжаар эзэмшүүлсэн.<br>Хувийн хэвшлийн 120.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 3-н замын уулзвар болон Хайрханы дэргэд боловсон ариун цэврийн 2 байгууламжийг “Энержипарагон” ХХК барьж ашиглалтад хүлээлгэн өгсөн. | 30 |
| | Сайншандад 700 хүний суудалтай "Саран Хөхөө" шинэ театрын барилга барина. | Гүйцэтгэлийн хувь | 0 | 100 | 70 | Улсын төсвийн 16,7 тэрбум төгрөгийн төсөвт өртгөөр Сайншанд суманд 700 хүний суудалтай Саран Хөхөө театрын барилга барих ажлыг "Болор-Аграмба" ХХК-аар гүйцэтгүүлэн, 2022 онд улсын төсөвт батлагдсан 2,8 тэрбум төгрөгийн санхүүжилтээр барилгын газар шороо, суурь, зоорины давхрын каркасан хийцийн угсралт бүрэн хийгдсэн. | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Тайзны хэсгийн багана, дам нуруу болон хөгжимчдийн хэсгийн дам нурууны угсралтын ажил хийгдсэн. 2022 онд олгогдсон санхүүжилтийн хүрээнд төлөвлөсөн барилга угсралтын ажлын гүйцэтгэл 100% биелсэн. | |
| | Зарим сумдад музей, номын сан, соёлын төвийн барилга байгууламжийг барьж ашиглалтад оруулна. | Барилга байгуулам жийн тоо | 0 | 2 | 2 | Замын-Үүд суманд 500 хүний суудалтай “Соёлын ордон” барих ажлыг улсын төсвийн 6,7 тэрбум төгрөгийн төсөвт өртгөөр "РСТ" ХХК гүйцэтгэхээр шалгарсан.<br>Улсын төсөвт 2022 онд 2,8 тэрбум төгрөгийн санхүүжилт батлагдаж барилгын каркасан хийцийн угсралтын ажил бүрэн хийж, тухайн жилд төлөвлөсөн ажлыг 100% гүйцэтгэсэн.<br>Сайншанд сумын 5 дугаар багийн “Соёлын ордон”-ы дээврийн засварын ажлыг орон нутгийн төсвийн 177.3 сая төгрөгийн төсөвт өртгөөр “Мөнх хархираа” ХХК-иар гүйцэтгүүлсэн. | 70 |
| | Замын-Үүд суманд 500 хүний суудалтай соёлын ордон барина. | Гүйцэтгэли йн хувь | 0 | 100 | 100 | Замын-Үүд суманд 500 хүний суудалтай “Соёлын ордон” барих ажлыг улсын төсвийн 6,7 тэрбум төгрөгийн төсөвт өртгөөр "РСТ" ХХК-аар гүйцэтгүүлсэн.<br>Тус ордны барилга нь тэнхлэгээрээ 46.0х45.0м хэмжээтэй, хагас зоорьтой, 2 давхар, төмөр бетон каркасан хийцтэй барилга бөгөөд 2021-2022 онд улсын төсөвт 2,8 тэрбум төгрөгийн санхүүжилт батлагдан, барилгын каркасан хийцийн угсралтын ажил бүрэн хийгдэж, тухайн жилд төлөвлөсөн ажлыг 100% гүйцэтгэсэн. | 100 |
| | “Монгол соёл-Монгол хүмүүн” төслийг зарим сумдад үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ. | Төсөл хэрэгжүүлс эн сумдын тоо | 0 | 8 | 8 | “Монгол соёл-Монгол хүмүүн” төслийн хүрээнд Айраг, Даланжаргалан, Өргөн, Иххэт, Алтанширээ, Дэлгэрэх, Мандах, Сайхандулаан сумын Соёлын төвд лед дэлгэц, компьютер, нөүтбүүк, гэрэл зургийн аппарат, музейн үзмэрийн зориулалтын тавиур зэрэг 27 нэр төрлийн 800.0 сая төгрөгийн тоног төхөөрөмж, эд хогшил нийлүүлж соёлын биет болон биет бус өвийн талаарх мэдээлэл, баримтжуулалтын ажил, хүн амд үзүүлэх соёл урлагийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулсан. | 100 |
| **Зорилт 2.6.2.** Соёл, урлагийн тогтвортой хөгжлийн зорилтыг хангаж, “Цахим соёл” арга хэмжээг хэрэгжүүлнэ. | Номын санд “Үүлэн сервэр” электрон каталогийг нэвтрүүлж, номын фондыг нэмэгдүүлж, интернэтэд суурилсан үйлчилгээг хүргэнэ. | Электрон хувилбар нэвтрүүлэх хувь | 0 | 100 | 100 | Аймгийн Засаг даргын 2022 оны А/663 дугаар захирамжаар Төв номын санд “Үүлэн сервер” электрон каталогийг нэвтрүүлж, ашиглах заавар, зөвлөмжийг ил байршуулан, уншигчдад хэрэгцээт ном хэвлэлийг түргэн шуурхай эрэн хайх боломжийг бүрдүүлэн, цахим лавлагаа мэдээллийг өгөх зэрэг үйлчилгээг үзүүлсэн.<br>Шинээр 569 ном, Зава Дамдингийн 17 судрыг цахим санд бүртгэн электрон катологи болгож, 1552 номоор | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | үйлчилгээ үзүүлж, үндсэн фонд болон гэрээр ном олгох танхимын 25575 номыг нэг бүрчлэн тоолсон.<br>“Үүлэн сервер” электрон каталогийг нэвтрүүлснээр дэлхийн хаанаас ч номын сангийн бүртгэлтэй номыг хайж унших боломжийг бүрдүүлсэн. | |
| | Соёлын байгууллагуудын үйлчилгээнд цахим технологийг нэвтрүүлнэ. | Цахим технологид нэвтрүүлсэн байгууллагын тоо | 1 | 10 | 2 | Төв номын сангийн дэргэдэх “Америкийн соёл мэдээлэл”-ийн төв нь АНУ-ын ЭСЯ-ны 63,0 сая, Орон нутгийн төсвийн 12,0 сая төгрөгийн санхүүжилтээр дотоод засал, техникийн бүрэн шинэчлэлийг хийж, 300 орчим англи ном, DVD кино, уншигч үйлчлүүлэгчдэд зориулсан өндөр хурдны интернэт, компьютер ашиглан үйл ажиллагаагаа явуулж, 3346 иргэнд үйлчилгээ үзүүлсэн.<br>Замын-үүд сумын Соёл, спортын төвд өндөр хурдны интернэтийн орчин бүрдүүлж, 2022 онд иж бүрэн 10 компьютерыг шинээр нэмэгдүүлсэн.<br>“Соёлын өвийг бүртгүүлэх, музейд эд өлгийн зүйлс худалдах хүсэлт гаргах” боломжийг E-Mongolia-д төрийн үйлчилгээний цахим системээр дамжуулан авах, Dornogobimuseum фэйсбүүк цахим группээр дамжуулан музейн үйл ажиллагаа болон зохион байгуулсан арга хэмжээний талаар мэдээллийг хүргэж ажилласан. | 50 |
| | Соёл урлагийн байгууллага, сургууль цэцэрлэгийн дуу хөгжмийн багш, мэргэжлийн уран бүтээлчдийг сургаж бэлтгэнэ. | Дэмжлэг үзүүлсэн багш, уран бүтээлчийн тоо | 9 | 18 | 15 | Аймгийн Засаг даргын 2022 оны А/280 дугаар захирамжаар Саран хөхөө театрын хөгжимчин, бүжигчин 3 уран бүтээлчийн сургалтын хөтөлбөрийн төлбөрт нийт 5,0 сая, А/575 дугаар захирамжаар СУИС-д Дуу хөгжмийн багш мэргэжлээр суралцаж буй 5 оюутны сургалтын төлбөрт орон нутагтаа эргэн ажиллах нөхцөлтэй гэрээний дагуу нийт 20,0 сая, Даланжаргалан сумаас хөгжмийн багш мэргэжлээр сурч буй 1 оюутны сургалтын төлбөрт 4,0 сая, бусад мэргэжлээр суралцаж буй 6 оюутанд 16 сая, орон нутагт нэн шаардлагатай багшийг бэлтгэхэд нийт 15 оюутанд 45,0 сая төгрөгийн сургалтын төлбөрийн дэмжлэг үзүүлсэн. | 90 |
| | Соёлын байгууллагуудын үйлчилгээнд шинэлэг арга барилыг нэвтрүүлж хүртээмжийг сайжруулна. | Арга хэмжээний тоо | 2 | 14 | 57 | Соёл, урлагийн байгууллагуудын үйлчилгээнд шинэлэг арга барилыг нэвтрүүлж, “Соёлын бүтээлч сар”, “Театрт тавтай морил”, “Музейтэй Дорноговь”, “Номтой Дорноговь” зэрэг аян болон томоохон арга хэмжээнүүдийг зохион байгуулж, музейн цахим болон танхимын үзвэр, үзэсгэлэнгээр 107079, номын сангийн цахим болон уншлагын танхимаар 26700, театрын үзвэрийн танхимаар 8400, нийт 57 арга хэмжээгээр давхардсан тоогоор 142179 иргэнд үйлчилсэн. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | “Соёлтой жолооч” аяны хүрээнд 8 төрлийн видео контентыг бэлтгэн 14000 хүнд түгээлээ. Хатанбулаг сумын Соёл, спортын төвд угсаатны зүйн судалгааны ажлыг эрчимжүүлэх зорилтот хөтөлбөрийг хэрэгжүүлж, орон нутгийн музейг шинэлэг орчин үеийн шийдэл дэглэлтээр зохион байгуулсан.<br>Соёлын байгууллагуудын үйлчилгээний шинэлэг байдлын хүртээмжийг нэмэгдүүлэн ажиллаж, үйлчилгээ үзүүлсэн иргэдийн тоо 2021 оноос 110%-аар өссөн. | |
| **Зорилт 2.6.3.** Соён гэгээрүүлэх үйл ажиллагааг идэвхжүүлж, орон нутгийн онцлог шингэсэн соёлын үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлнэ. | Баяр наадам, тэмдэглэлт ой, томоохон арга хэмжээнд зориулсан уран бүтээлийг дэмжиж ажиллана. | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | 2 | 3 | 7 | "Цагаан сар”, “Монгол цэргийн өдөр", "Хүүхдийн баяр", "Олон улсын эх хэлний өдөр", “Үндэсний бичиг үсэг номын баяр”, “Язгуур алтан өв” соёлын биет бус өвийн аймгийн анхдугаар наадам, “Нүүдэлчин Монгол-2022” соёлын биет бус өвийн их наадам зэрэг томоохон арга хэмжээнүүдэд нийт 85,0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.<br>"Нүүдэлчин Монгол" соёлын биет бус өвийн их наадамд 21 аймгаас нийлбэр дүнгээр гутгаар байр эзэлсэн нь өмнөх 2018 оны наадмаас 17 байраар ахиулсан өндөр амжилт үзүүллээ. Тус наадмыг үзэж сонирхсон иргэдийн сэтгэл ханамжийн үнэлгээ, шилдэг отгийн үнэлгээгээр 21 аймгаас хамгийн өндөр оноо авч, нутгийнхаа соёлын өвийг 2800 гаруй гадаад, дотоодын жуулчдад алдаршуулан, сурталчилсан.<br>Соёл, урлагийг дэмжих, шинэ шилдэг уран бүтээлийг сурталчлах, соёлын өвийг хадгалж, хамгаалах, түгээн дэлгэрүүлэх чиглэлээр 2022 онд нийт 255,0 сая төгрөгийг шийдвэрлэсэн. | 100 |
| | Хүүхдэд зориулсан шинэ уран бүтээл тогтмол туурвина. | Уран бүтээлийн тоо | 1 | 5 | 6 | “Хүүхэд хөгжил-2022” зорилтот жилийн хүрээнд Саран хөхөө театр, Монголын Хүүхэлдэйн театртай хамтран ажиллах санамж бичиг байгуулан, "Бяцхан хатагтайн хүүхэлдэйн театр" хүүхэлдэйн хамтарсан концерт, албан ёсны эрхтэйгээр “Могжоохон даагатай-Жогжоохон хүү” хүүхэлдэйн жүжиг, "Баатруудын адал явдал", “Саран охин, Хөхөө хүүгийн адал явдал” танин мэдэхүйн хүүхдийн жүжиг, “Миний хөөрхөн шүдний аялал” эрүүл дадал хэвшил олгох хүүхдийн жүжиг, “Мангасуудын хаан” танин мэдэхүйн хүүхдийн жүжгүүдийг тус тус шинээр туурвин, Сайншанд, Замын-Үүд сумын 6150 хүүхэд багачуудад хүргэж ажилласан. | 100 |
| | Нутгийн яруу найрагч, хөгжмийн зохиолчдын дууг | Зохион байгуулсан арга | 2 | 12 | 17 | Соёл урлагийн газар, Саран хөхөө театр, Музей, сургалт, судалгааны төв, Төв номын сан, Алтанширээ, Айраг, Дэлгэрэх, Хөвсгөл, Замын-Үүд, сумдын Соёл, | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | нутагшуулах, ардын авьяастнуудын дунд уралдаан зохион байгуулах, тоглолт хийх, шилдэг уран бүтээл, уран бүтээлчдийг сурталчлах зэрэг ажлыг хийнэ. | хэмжээний тоо | | | | спортын төв, Монголын зохиолчдын “Хурмаст тэнгэр” төв, “Арлааны Эрдэнэ-Очир сан” хамтран, хайрын шүлгийн “Оюу ай” наадам, зохиолч, яруу найрагч Содномдоржийн дурсгалд зориулсан шүлгийн наадам, А.Эрдэнэ-Очирын нэрэмжит “Нөмрөг тэнгэрийн дор” уншлага, “Борхойн цом” яруу найргийн наадам, “Алтан говийн унага” 60 жилийн ойд зориулсан Ч.Банзрагчийн нэрэмжит уртын дуу дуулаачдын улсын уралдаан зэрэг арга хэмжээ, уралдаан, наадмыг зохион байгуулж, 3200 гаруй иргэнд сурталчлан таниуллаа.<br>Сумын ардын авьяастнуудын хамтарсан тоглолтуудыг 14 суманд тоглоход дэмжлэг үзүүлэн, хамтран ажиллалаа. Дорноговь аймгаас төрөн гарсан хөгжмийн зохиолч, ая зохиогчид, яруу найрагчдын уран бүтээлийг алдаршуулан, сурталчлах, түгээн дэлгэрүүлэх, шинэ авьяастнуудыг нээн хөгжүүлэх “Хутагтын говиос эгшиглэсэн аялгуу цадиг” шилдэг уран бүтээлийн дуун цэнгүүн, арга хэмжээг 12 дугаар сарын 02-нд зохион байгуулахаар бэлтгэл ажлыг хангасан.<br>Саран хөхөө театрын дуучин, СТА Д.Эрдэнэсувдын "Ээжийн цацал", Дэлгэрэх сумын Соёл, спортын төвийн бүжгийн багш Р.Болортуяагийн “Нутгийн түмэндээ”, Иххэт сумын Соёл, спортын төвийн соёлын өвийн ажилтан Н.Сарантуяагийн “Өв соёлын эгшиглэн”, дуучин, СТА Б.Баяндалайгийн “Би өөрийнхөөрөө”, “Хүүхэд хөгжил-2022” зорилтот жилийн хүрээнд зохион байгуулсан Д.Болормаагийн “Хүүхдэд хөглөгдсөн он жилүүд”, “Намсрайн Батнасан сан”-гийн “Шинэ зууны наран”, шилдэг сурагч Г.Энгүүний “Мөрөөдлийн галт тэрэг” гэх мэт 30 гаруй шинэлэг уран бүтээлүүдийг дэмжин ажилласан. | |
| **Зорилт 2.6.4.** Соёлын биет болон биет бус өвийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулан, судлан сэргээх, өвлөн уламжлуулах, олон нийтэд түгээн дэлгэрүүлэх ажлыг зохион байгуулна. | Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчдын видео бичлэг, дуу дүрсийг хадгалж, цахим сан үүсгэн, өвлүүлэн үлдээхэд урамшуулна. | Урамшуулсан хүний тоо | 2 | 90 | 41 | Аймгийн Засаг даргын 2022 оны А/279 дүгээр захирамжаар “Язгуур алтан өв” соёлын биет бус өвийн аймгийн анхдугаар наадмыг 2022 оны 05 дугаар сард амжилттай зохион байгуулж, 7 ай савын хүрээнд 14 сумын 321 өвлөн уламжлагч оролцлоо. Наадмын 7 ай сав бүрээс нийт 31 өвлөн уламжлагчийг шалгаруулан шагнаж урамшуулсан.<br>“D media” агентлагтай хамтран шилдэг өвлөн уламжлагчдын өвийг цахим сан үүсгэн хадгалж, өвлүүлэн үлдээх зорилгоор ярилцлага, тоглолтын бичлэг бүхий нийт 8 нэвтрүүлэг, 14 сум тус бүрийн тоглолтын бичлэгээр цахим сан үүсгэн 300 ширхэг ном, 250 ширхэг DVD-г гарган сумд, ЕБ-ын сургууль, байгууллага, иргэдэд түгээсэн. | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | “Язгуур алтан өв” соёлын биет бус өвийн аймгийн анхдугаар наадмыг ЕБ-ын сургууль, цэцэрлэгийн нийт 3000 гаруй хүүхэд, багачууд, 2000 гаруй иргэд, нийт 5000 гаруй хүнд сурталчлан танилцуулсан нь нутгийнхаа соёлын өвөөрөө бахархах үзлийг төлөвшүүлэх үр дүнтэй арга хэмжээ болсон. Мөн орон нутгийн телевизээр шууд дамжуулан, DTV болон байгууллагын пэйж хуудсанд байршуулсан бичлэгийг 10,000 хүн үзсэн.<br>Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагч нийт 41 хүнийг 10,0 сая төгрөгөөр урамшуулсан ба арга хэмжээнд нийт 25,0 сая төгрөгийг зарцуулсан. | |
| | Музейн сан хөмрөгийг баяжуулж, түүх соёлын үл хөдлөх дурсгалыг бүртгэлжүүлэх, хадгалалт хамгаалалтыг сайжруулна. | Бүртгэлжүүлсэн үл хөдлөх дурсгалт газрын тоо | 198 | 50 | 2500 | Музей, сургалт, судалгааны төвийн музейн сан хөмрөгт “Бургасан ханатай гэр” үзмэрийг 3,0 сая төгрөгөөр худалдан авсан ба Ардын хувьсгалын партизан Д.Сүхээгийн шагнал болох 13 ширхэг одон медалийг музейн сан хөмрөгт авч бүртгэлжүүлсэн. 2000 оноос өмнөх нийгэм, цаг үе, ахуй амьдралын хувьсал өөрчлөлтийг харуулсан өрөөг тохижуулан шинэ үеийн 220 залуучуудад үзүүллээ.<br>Аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газартай хамтран Улсын тусгай хамгаалалтын газраас Улсын тусгай хэрэгцээний газарт ангилал, шилжүүлэн авахаар төлөвлөж буй түүх соёлын үл хөдлөх дурсгалт 5 газрын давхцлыг шалгаж, судалгаа, зураглалыг Соёлын өвийн үндэсний төвд хүргүүлсэн.<br>Ерөнхийлөгчийн ивээл дор хэрэгжиж буй “Монголын баялаг 330” төсөл хөтөлбөрийн хүрээнд 14 сумын 79 түүх, соёлын дурсгалыг дүрсжүүлэн баримтжуулж, архив үүсгэн, МҮОНТ-ээр иргэдэд түгээхэд аймгийн Засаг даргын 2022 оны А192 дугаар захирамжаар 43,0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.<br>Аймгийн Засаг даргын 2022 оны А/566 дугаар захирамжийн дагуу түүх, соёлын үл хөдлөх дурсгалын улсын тооллогыг 2022 оны 09 дүгээр сарын 14-ний өдрөөс эхлэн явуулсан. Тооллогод 13 сумын нутаг дэвсгэрийн 415 байршилд байгаа 2500 гаруй үл хөдлөх дурсгалыг бүрэн хамруулан, баримтжуулж газар зүйн байршлыг тогтоон rich.mongol.uv.mn программд мэдээллийг оруулах ажлыг хийж гүйцэтгэв. Түүх соёлын үл хөдлөх дусгалын улсын тооллогын нэгдсэн дүн, мэдээг Соёлын өвийн үндэсний төвд хүргүүлсэн. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Хүн бүр удмаа мэдэж, угийн бичгийг хөтлөх үндэсний уламжлалыг хэвшүүлэх зан үйлийг сургах, сургалт нөлөөллийн арга хэмжээг эрчимжүүлнэ. | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | 2 | 170 | 18 | Аймгийн Насан туршийн боловсролын төв, Улаанбадрах, Сайхандулаан, Даланжаргалан сумд болон аймгийн Төв номын санд “Угийн бичиг хөтлөх арга зүй” цахим 185 оролцогчдыг хамруулсан сургалтыг 2021 онд, аймгийн Татварын хэлтэс, Стандарт хэмжил зүйн хэлтсийн 25 ажилтан, албан хаагчдад “Угийн бичиг хөтлөх арга зүй, ач холбогдол” сэдвээр сургалтыг 2022 онд зохион байгууллаа.<br>Саранхөхөө театр, Мэргэжлийн хяналтын газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Стандарт хэмжил зүйн хэлтэс болон Улаанбадрах, Алтанширээ, Даланжаргалан сумд “Угийн бичгийг 9 үеэс дээш, 9 үеэс доош хэрхэн хөтлөх вэ”, “Угийн бичиг угийн хэлхээ, угийн бичиг хөтлөх арга зүй” сэдэвт 7 удаагийн сургалт зохион байгуулж 196 албан хаагчийг хамруулсан.<br>Угийн бичиг хөтлөх арга зүй сургалтыг энэ онд нийтдээ 9 байгууллагын нийт 184 албан хаагчдад, цахим болон танхимын сургалтыг Соёл, урлагийн газар, Музей, сургалт судалгааны төв, 14 сумын соёлын өв хариуцсан ажилтнууд, насан туршийн боловсролын нэгжийн сургагч багш нартай хамтран 72 өрхийн 288 иргэн, нийт 2112 хүнийг хамруулан зохион байгуулсан нь өмнөх оноос 6,3%-аар өссөн. | 90 |
| ***Ерөнхий чиг үүрэг 3. Эдийн засгийн бодлогыг хэрэгжүүлэх*** | | | | | | | |
| ***Үндсэн чиг үүрэг. 3.1.*** *Санхүү, эдийн засгийн хүндрэлийг богино хугацаанд даван туулж, төсвийн тогтвортой, хүртээмжтэй өсөлтийг хангах бодлогыг хэрэгжүүлэх* | | | | | | | |
| **Зорилт 3.1.1.**<br>Банк санхүүгийн зах зээлийн эрсдэл даах, найдвартай байдлыг сайжруулна. | Банкны үйлчилгээг цахимжуулах ажлыг эрчимжүүлэх замаар иргэдийн хуримтлал үүсгэхэд анхаарч бэлэн бус төлбөр тооцоог дэмжинэ. | Хадгаламжийн үлдэгдэл | 162 тэрбум төгрөг | 180 тэрбум төгрөг | 161.1 тэрбум | Харилцах дансны үлдэгдэл 53.1-73.0 тэрбум төгрөг болж 22,9 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн, хадгаламжийн үлдэгдэл 180.2-161,1 тэрбум төгрөг болж 19.1 тэрбум төгрөгөөр буурсан нь иргэдийн орлого буурсантай холбоотой байна.<br>Банкны үйлчилгээ, цахимжуулах болон хуримтлал үүсгэх ач холбогдлын талаарх мэдээлэл, зөвлөгөөг иргэдэд олон нийтийн цахим сүлжээ болон хэвлэл мэдээллийн байгууллагаар тогтмол хүргэн ажилласан.<br>2022 онд интернет банкны хэрэглэгч 54733, ПОС төхөөрөмж хэрэглэгч 1607, АТМ 69, мобайл банкны хэрэглэгч 38781, арилжааны банкны харилцах дансны үлдэгдэл 62,2 тэрбум төгрөг, хадгаламжийн үлдэгдэл 161,1 тэрбум төгрөг болсон өмнөх оны мөн үетэй харьцуулахад мобайл банкны хэрэглэгч 2,494 | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хэрэглэгчээр буурч, ПОС төхөөрөмж хэрэглэгчийн тоо 282 хэрэглэгчээр өссөн. | |
| | Иргэдийн мэдлэг, хандлагыг дээшлүүлэн санхүүгийн эрсдэл, дарамтад өртөхөөс сэргийлнэ. | Сургалтад хамрагдах хүний тоо | 620 | 4000 | 5000 | Иргэдэд санхүүгийн боловсрол олгох мэдээллийг "Дорноговь DTV" орон нутгийн телевиз, "Өнөөдрийн Дорноговь" сонинтой хамтран тогтмол хүргэн ажилласан. Мөн аймгийн удирдлагууд сумдад ажиллахдаа Засгийн газар, Монголбанкнаас явуулж байгаа төсөв санхүүгийн бодлого, хэрэгжилтийг ард иргэдэд танилцуулсан.<br>Иргэдэд мэдээлэл хүргэх чиглэлээр арилжааны 6 банкнаас “Global money week”, “Дэлхийн хуримтлалын өдөр” аяныг зохион байгуулж, нийт 2981 хүүхэд, 200 иргэн, 1989 оюутан сурагчдад санхүүгийн мэдээлэл хүргэсэн. Цахим гэмт хэргээс урьдчилан сэргийлэх мессежийг 69200 иргэнд масс мессежээр хүргэж, “Санхүүгийн залилан, луйврын шинжтэй гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нь” сэдвийн хүрээнд Анагаах шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Дорноговь аймаг дахь Анагаах ухааны сургуулийн 300 гаруй оюутнуудад мэдээлэл өгсөн.<br>Арилжааны банкууд нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулж, өөрсдийн үйлчилгээг иргэдэд сурталчилж, сурталчилгааны материалыг 5000 гаруй иргэнд тараасан. | 100 |
| | Иргэдийн санхүүгийн сахилга батыг дээшлүүлэхэд анхаарч хугацаа хэтэрсэн зээлийг бууруулж зээлжих чадварыг нэмэгдүүлнэ. | Чанаргүй зээлийн хувь | 5.5 | 5.0 | 5.9 | Чанаргүй зээл 18,1 тэрбум төгрөг байгаа нь нийт зээлийн багцын 5.9 хувийг эзэлж байгаа бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0,2 функтээр өссөн.<br>Хилийн боомтын үйл ажиллагаа зогсонги байдалд орж, иргэдийн орлого буурснаас шалтгаалж, зээлийн эргэн төлөлт удаашрах, Засгийн газраас хэрэгжүүлсэн ипотекийн зээлийг хойшлуулсан зэрэг үзүүлэлтээс шалтгаалан, Замын Үүд дэх банкны хугацаа хэтрэлт 12,2 тэрбум төгрөг болж, нийт багцад эзлэх хугацаа хэтрэлт 12,1%-д хүрсэн нь аймгийн нэгдсэн үзүүлэлтэд сөргөөр нөлөөлсөн. | 90 |
| **Зорилт 3.1.2.**<br>Төсвийн хөрөнгийг орон нутгийн хөгжилд чиглүүлэн үр ашигтай, хариуцлагатай | Татварын тайлагналт, хураалтын үйл ажиллагааг цахимжуулж, татвар төлөгчдийг татварт хамруулах хүрээг нэмэгдүүлнэ. | Цахимжуулалтын хувь | 81.2 | 96.6 | 100 | “Цахимаар татвараа төлж цагаа хэмнэе”, "Баримтаа аваарай" уриан дор цахим аяныг зохион байгуулж татвар төлөгчдөд чиглэсэн бүх төрлийн татварын үйлчилгээг 100 хувь цахимаар хүргэж ажилласан.<br>"Нэхэмжлэлд суурилсан" татвар ногдуулалт, төлөлтийн системийн ашиглалтыг сайжруулж цахим банкаар татвараа төлөх, тайлагнах боломжийг бүрдүүлсэнээр давхардсан тоогоор нийт 4828 татвар төлөгч цахимаар | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| зарцуулах бодлого баримтална. | | | | | | тайлангаа илгээсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4,5 хувиар өссөн.<br>Замын-Үүд, Сайншанд, Даланжаргалан сумдад явуулын посоор татвар хураах үйлчилгээг үзүүлж давхардсан тоогоор 5321 татвар төлөгчийн 132.7 сая төгрөгийн татварыг хураан барагдуулсан. Татвар төлөгчийн тоо 23560 болсон нь зорилтот түвшинтэй харьцуулахад 2631-ээр нэмэгдсэн. | |
| | Төсвийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулж, төсвийн сахилга батыг сайжруулна. | Зардлын хэмнэлтийн хувь | 2.4 | 3.5 | 40.8 | Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, бэлэн байдлыг хангах болон төрийн албан хаагчдын цалин хөлс, татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал, төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах, төсвийн байгууллагуудын халаалтын зардлыг эхний ээлжинд санхүүжүүлснээр 2022 оны төсвийг 40,8 хувь буюу 39,7 тэрбум төгрөгөөр хэмнэсэн. | 100 |
| | Төсвийн хөрөнгийн зарцуулалтад хийх санхүүгийн хяналт шалгалтын үр нөлөөг дээшлүүлнэ. | Шилэн дансны мэдээллийн хувь | 99,3 | 99.8 | 97.9 | Санхүүгийн хяналт болон дотоод аудитын төлөвлөгөөний дагуу 56 байгууллагын санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг хийж, нийт 624,7 сая төгрөгийн төлбөр зөрчлийг илрүүлж, орон нутгийн төсвийн орлогын дансанд 548,2 сая төгрөг, тухайн байгууллагын дансанд 76,5 сая төгрөгийг улсын (ахлах) байцаагчийн 207 акт, 19 албан шаардлага тогтоосон.<br>Орон нутгийн төсвийн орлогын дансанд 128,5 сая төгрөг, тухайн байгууллагын дансанд 68,7 сая төгрөг, нийт 197,2 сая төгрөгийг барагдуулсан.<br>Шилэн дансны тухай хуульд заасны дагуу 14 сумын 82 төсвийн байгууллага, аймгийн төвийн 14 байгууллага, нийт 96 байгууллага нийт 11455 мэдээллийг цахим хуудсанд хуулийн хугацаанд 97,9% мэдээлж, баталгаажуулсан. | 100 |
| | Улсын секторын нягтлан бодох бүртгэлийг онлайн системд бүрэн шилжүүлнэ. | Цахимд шилжүүлсэн хувь | 90 | 100 | 100 | Төсвийн хөрөнгийн зарцуулалтад хяналт тавих, улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартыг төсвийн байгууллагад мөрдүүлэх, төсвийн гүйцэтгэлийг тайлагнах үйл ажиллагааг сайжруулах зорилгоор орон нутгийн төсвийн багцад хамаарах байгууллага 117 байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн “ctsystem” программд 100% бүрэн шилжүүлсэн. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| **Зорилт 3.1.3.**<br>Төрийн худалдан авах ажиллагааг хариуцлагажуулан орон нутгийн аж ахуйн нэгж байгууллагуудыг бодлогоор дэмжинэ. | Төсөл, тендерийн шалгаруулалтыг олон нийтэд ил тод болгож “Шилэн тендер шалгаруулалт”-ын бодлого хэрэгжүүлнэ. | Цахимд шилжүүлсэн хувь | 85 | 100 | 100 | Худалдан авах ажиллагааны 2022 оны төлөвлөгөөнд тусгагдсан 73 төсөл арга хэмжээг 100 хувь хялбаршуулсан цахим хэлбэрээр зохион байгуулж тендерийн урилга, гарсан үр дүнг тухай бүр нь Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем tender.gov.mn, байгууллагын мэдээллийн самбар болон www.shilendans.gov.mn, аймгийн Засаг даргын Тамгын газрын цахим хуудаст байршуулсан.<br>Нээлттэй тендер шалгаруулалтын урилгыг тендер зарлагдсан өдөрт нь “Зууны мэдээ” сонинд нийтлүүлж худалдан авах ажиллагааны явцын талаарх мэдээллийг 100% олон нийтэд цахимаар хүргэж ажилласан. | 100 |
| | Тендер шалгаруулалтад хуулийн дагуу давуу эрх нь тооцогдох боломж бүхий аж ахуйн нэгжүүдийн чадавхыг нэмэгдүүлж, орон нутгийн хөдөлмөр эрхлэлт, орлогыг нэмэгдүүлэх бодлого баримтална. | Давуу эрхийн хувь | 10 | 80 | 98 | Тендерт оролцогч нэг аж ахуйн нэгжээс орон нутгаас ажиллах хүч авч ажиллуулах, дотоодод үйлдвэрлэсэн бараа материал худалдан авах хүсэлтийг хүлээн авч дотоодын давуу эрхийн зөрүүг 2021 онд 868,0 сая төгрөгөөр тооцож байсан бол 2022 онд ирүүлсэн хүсэлтийн хүрээнд 878,8 сая төгрөгөөр хийсвэрлэн тооцсон. | 100 |
| **Зорилт 3.1.4.**<br>Даатгалын хариуцлагын тогтолцоог сайжруулан, хамрах хүрээг нэмэгдүүлнэ. | Албан журмын даатгалын холбоо, даатгал, хөрөнгийн үнэлгээний компаниудын хохирол барагдуулах ажиллагааны уялдаа холбоог сайжруулна. | Арга хэмжээний тоо | 1 | 10 | 1 | Орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа даатгалын болон хөрөнгийн үнэлгээний компаниуд, албан журмын даатгалын холбоотой хамтарсан уулзалтыг зохион байгуулж 500,0 мянган төгрөг хүртэлх даатгалын нөхөн төлбөрийг орон нутгийн даатгалын салбар олгож байхаар шийдвэрлэсэн. | 70 |
| | Даатгалын байгууллагын нөхөн төлбөр олголтыг сайжруулна. | Нөхөн төлбөр олголтын хувь | 80 | 98 | 95 | Даатгалын 500,0 мянган төгрөг хүртэлх нөхөн төлбөрийг орон нутгийн даатгалын салбар шийдвэрлэж байгаа бөгөөд 69 даатгалын тохиолдолд 75,1 тэрбум төгрөгийн нөхөн төлбөрийг иргэн, аж ахуйн нэгжид олгосон нь 95 хувийн гүйцэтгэлтэй байна. | 100 |
| | Иргэдийг даатгалд хамруулах нөлөөллийн ажлыг дэмжинэ. | Иргэдийн даатгалд хамрагдсан тоо | 600 | 2000 | 1000 гаруй | Даатгалын компаниуд иргэн, аж ахуйн нэгжтэй 17906 гэрээ байгуулан ажиллаж байгаа бөгөөд жолоочийн хариуцлагын даатгалын хамрагдалтыг нэмэгдүүлэх, даатгалын бүтээгдэхүүнийг сурталчлахаар "Өнөөгийн Ялалт" сонинд 6 удаа нийтлэл хэвлүүлэн, аймгийн DTV, | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | DSB телевизээр 3 удаа мэдээ нэвтрүүлж, иргэдийг даатгалд хамруулах нөлөөллийн ажлыг зохион байгуулснаар давхардсан тоогоор 1000 гаруй иргэдийг даатгалд хамруулсан. | |
| **Зорилт 3.1.5.** Хөрөнгийн зах зээлийг иргэндээ ээлтэй, эдийн засагт өгөөжтэй байдлаар хөгжүүлнэ. | Хөрөнгийн биржид бүртгэлтэй үнэт цаасны компаниудыг орон нутагт үйл ажиллагаа явуулахад бодлогоор дэмжиж ажиллана. | Үнэт цаасны компанийн тоо | 1 | 5 | 3 | Хөрөнгийн биржид бүртгэлтэй үнэт цаасны "Бидисек", "Санар", "Гүүдсек" 3 компаний салбар үйл ажиллагаа явуулах зөвшөөрөлтэй байна. Үүнээс идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа "Гүүдсек ҮЦК" ХХК-тай хамтарч, банкны IPO, үнэт цаасны хувьцааны талаарх мэдээллийг 750 иргэн, аж ахуйн нэгжид хүргэн ажиллан, сургалт зохион байгуулах байр, иргэдийн оролцоог хანган ажилласан. | 100 |
| | Үнэт цаас, хувьцааны талаарх иргэдийн мэдлэгийг нэмэгдүүлнэ. | Сургалтад хамрагдах хүний тоо | 364 | 2554 | 713 | Иргэдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлж санхүүгийн эрсдэл, дарамтад өртөхөөс сэргийлэх, үнэт цаас, хувьцааны талаарх иргэдийн мэдлэгийг нэмэгдүүлэх зорилгоор Монгол банк, “Гүүдсек” үнэт цаасны компани, "Санхүүгийн хүртээмж хөгжил санаачилга" ТББ -тай хамтран, санхүүгийн залилан түүнээс сэргийлэх, банкны IPO, үнэт цаас хувьцаа, амьдралын санхүүгээ сайжруулах сэдэвт сургалт, өдөрлөгийг давхардсан тоогоор 713 бизнес эрхлэгч, иргэдийг хамруулан 2 удаа зохион байгуулсан. | 90 |
| **Зорилт 3.1.6.** Нийгэм, эдийн засгийн хөгжлийн бодлогыг тодорхойлоход шаардлагатай мэдээллийн эх үүсвэртэй болно. | Хүн ам, өрхийн мэдээллийн сангийн баяжилтыг төрийн бусад мэдээллийн сантай уялдуулан сайжруулж, хүн ам зүйн нарийвчилсан мэдээллийг гаргахад ашиглана. | Мэдээлэл ашиглах хувь | 85 | 100 | 100 | Хүн ам, өрхийн мэдээллийн сангийн үзүүлэлтийг УБЕГ-ын иргэний мэдээллийн сан, Боловсролын байгууллага, Нийгмийн даатгалын хэлтэс болон Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын мэдээллийн сангуудтай холбон мэдээллийг тогтмол шинэчилсэн.<br>Хүн ам, өрхийн мэдээллийн сангаас хүн амын жилийн эцсийн тоо, төрөлт, нас баралт зэрэг хүн амын салбарын зарим дүн мэдээг гаргаж, “Хүн амын үндсэн үзүүлэлт-2021” танилцуулга, “Хүүхэд хөгжил-2022” судалгааг тус тус нэгтгэн боловсруулж, цахимаар болон хэвлэмэл хэлбэрээр хэрэглэгчдэд тараан, төрийн байгууллага, олон нийтийг мэдээллээр хангаж, статистикийн мэдээллийг 100% ашиглах боломжийг бүрдүүлэн ажилласан. | 100 |
| | Мал, тэжээвэр амьтдын тооллогыг зохион байгуулж, хөдөө аж ахуйн салбарын түүвэр судалгаанд | Мэдээлэл ашиглах хувь | 90 | 100 | 100 | Мал, тэжээвэр амьтдын тооллогыг зохион байгуулж малчин, малтай өрхийн мэдээллийн санг шинэчлэн, хөдөө аж, ахуйн 2022 оны тооллого болон хагас жилийн малын түүвэр судалгааны үр дүнг боловсруулан мэдээлэл бэлтгэсэн.  Мал тооллогын үр дүнд үндэслэн 17 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хамрагдах өрхийн жагсаалт болон сэдэвчилсэн судалгааг гаргахад ашиглана. | | | | | зураг, 31 хүснэгт, 6 бүлэгтэй “Хөдөө аж ахуйн салбарын танилцуулга-2021” судалгааг боловсруулж ажилласан. Хөдөө аж ахуйн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэл, малын тоо, насаар, төллөх малын тооны өөрчлөлт, төлийн тооны өөрчлөлт, худаг ус, хашаа, малчдын тоо, тэдний соёл, ахуйн нөхцлийн талаархи мэдээллийг 2017-2021 оноор харьцуулсан дүгнэлт гаргаж 600 гаруй хэрэглэгчдэд цахимаар болон цаасан хэлбэрээр тараан, мэдээлэл ашиглах боломжийг 100% бүрдүүлсэн. | |
| | Албан ёсны болон захиргааны статистикийн мэдээ, тайланг боловсруулах, тархаах, шуурхай, хүртээмжтэй байдлыг сайжруулах, тооллого судалгааны мэдээллийн үр өгөөжийг нэмэгдүүлнэ. | Мэдээлэл ашиглах хувь | 90 | 100 | 100 | Албан ёсны статистикийн 52 нэр төрлийн мэдээ, тайлан, 5 төрлийн түүвэр судалгаа, 1 төрлийн нэлэнхүй судалгаанд сум, аж ахуйн нэгж, байгууллагын иргэдийг бүрэн хамруулж долоо хоног, сар, улирал, жилийн давтамжтайгаар мэдээллийг авч 6749 нэгж мэдээг графикт хугацаанд нь гаргасан. Жилийн эцсийн байдлаар цахим хуудасны мэдээллийн санд үнийн мэдээг 43 удаа, жилийн эцсийн танилцуулгыг 1 удаа, сарын нийгэм, эдийн засгийн танилцуулгыг 10 удаа, улирлын болон салбарын инфографикийг 6 удаа, тэмдэглэлт баярын өдрүүдтэй холбоотой инфографикийг 3 удаа, сар бүрийн нийгэм эдийн засгийн байдлын тухай танилцуулгыг 10 удаа, статистик динамикийг 23 удаа цахим хуудсанд байршуулж ажилласан. Хөдөө аж ахуйн салбарын судалгаа-2021, Хүн ам өрхийн үндсэн үзүүлэлт-2021, Амьдарч буй орчин, нийгмийн үзүүлэлтийн судалгаа-2021, Худалдаа үйлчилгээний салбарын танилцуулга-2021, Хүүхэд хөгжил-2022 танилцуулгыг төрийн болон олон нийтийн байгууллага, иргэдэд хүргэх ажлыг зохион байгуулж ажилласан. | 100 |
| ***Үндсэн чиг үүрэг 3.2.*** *Ил тод, хариуцлагатай уул уурхай, нэмүү өртөг шингэсэн газрын тос, нүүрс-химич, жонш, зэсийн баяжмал, төмөрлөг зэрэг үйлдвэрлэлийг хөгжүүлэх, дэд бүтцийн бүтээн байгуулалтыг орон нутгаас дэмжиж, олон тулгуурт эдийн засгийн бүтцийг бий болгох.* | | | | | | | |
| **Зорилт 3.2.1.** Эдийн засгийн өсөлтийг хангахуйц нэмүү өртөг шингэсэн уул уурхайн бүтээгдэхүүн | Цагаан суваргын зэс молибдений үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлыг үргэлжлүүлэхэд орон нутгаас дэмжлэг үзүүлнэ. | Бүтээн байгуулалтын ажлын гүйцэтгэлийн | 47 | 100 | 30 | Цагаан суваргын зэс молибдений үйлдвэрийн исэлдсэн хүдрийг боловсруулах катодын зэсийн үйлдвэрийн бүтээн байгуулалтын хүрээнд "МАК Аранжин зэс" ХХК нь "Цагаан суваргын нуруулдан уусгах байгууламжийн зураг төсөл"-ийг "Усны эрчим" ХХК-аар гүйцэтгүүлэн дууссан. Барилгын ажлыг "Түмэн харш" ХХК гүйцэтгэхээр төлөвлөсөн. Барилгын ажил эхлүүлэх зөвшөөрөл авах хүсэлт ирүүлснийг судалж байна. | 30 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ. | | Дэмжлэгийн тоо | 0 | 7 | 1 | Мандах сумын нутагт үйл ажиллагаа явуулж байгаа “Эрдэнэс цагаан суварга” ХХК орон нутагтай хог хаягдлын гэрээ байгуулж 1,8 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн. | 30 |
| | Зүүн цагаан дэлийн жоншны далд уурхайн дэд бүтцийн ажлыг гүйцэтгэхэд орон нутгаас дэмжлэг үзүүлнэ. | Дэмжлэгийн тоо | 0 | 8 | 2 | Зүүн цагаан дэлийн жоншны далд уурхайн дэд бүтэц байгуулах ажлын хүрээнд Иххэт сумын 2022 оны А/13 тоот захирамжаар 5 кВт-ын цахилгаан дамжуулах агаарын шугамын доорх 16.27 га газрыг "Монголросцветмет" ТӨХК-д эзэмшүүлж дэмжлэг үзүүлж ажилласан.<br>Мөн Говьсүмбэр аймгийн Усны сав газартай ус ашиглах гэрээ байгуулж, тус аймаг болон Хэнтий аймгийн Засаг дарга нартай замын трассыг батлуулж хамтран ажилласан. | 100 |
| | Уул уурхайн баяжуулах, боловсруулах үйлдвэрүүдийг байгуулахад дэмжлэг үзүүлнэ. | Шинээр байгуулагдах үйлдвэрийн тоо | 0 | 5 | 3 | Алтанширээт үйлдвэрлэл технологийн паркийн төслийн хүрээнд "Болдтөмөр Ерөө гол” ХХК-ний 420,0 сая ам долларын хөрөнгө оруулалтаар Алтанширээ сумын нутаг дэвсгэрт 140 га талбайд төмрийн хүдрийн баяжмал, баяжуулсан нүүрс, кокс, төмрийн хүдрийн хорголж үйлдвэрлэх дагалдах 4 үйлдвэр бүхий жилдээ 500 мян.тн ширэм үйлдвэрлэх хүчин чадалтай үйлдвэр барихаар төлөвлөснөөс төмрийн хүдрийн нойтон баяжуулах үйлдвэрийг 2021 онд ашиглалтад оруулж, 1000 ажилчид амьдрах орон сууцны барилга угсралтын ажлыг эхлүүлсэн.<br>"Олон ихт баян" ХХК-ийн хөрөнгө оруулалтаар баригдсан төмрийн хүдэр баяжуулах үйлдвэрийг 2022 онд ашиглалтад хүлээн авсан.<br>Монголросцветмет ТӨХК-д Иххэт сумын Засаг даргын 2022 оны А/13 тоот захирамжаар уурхайн газрын зориулалтаар 141.8 га, 5 кВт-ын цахилгаан дамжуулах агаарын шугамын доорх 16.27 га газрыг тус тус олгосон. | 100 |
| **Зорилт 3.2.2.**<br>Дотоодын түүхий эдэд тулгуурласан газрын тос боловсруулах үйлдвэрийг барьж байгуулна. | Алтанширээ сумын нутагт дотоодын түүхий эдэд тулгуурласан газрын тос боловсруулах үйлдвэр байгуулахад орон нутгаас дэмжлэг үзүүлнэ. | Үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлын гүйцэтгэлийн хувь | 30 | 100 | 90 | Газрын тос боловсруулах үйлдвэрийн технологийн бус барилга болох иргэний 9 барилга, байгууламж, 44 км ус дамжуулах хоолой, 30 мянган м.куб багтаамжтай усны нөөцийн резервуар, үйлдвэрийн дэд бүтцийн байгууламжийн бүтээн байгуулалтын ажлын явц 70 гаруй хувьтай хэрэгжсэн.<br>Газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах төслийн Технологийн бус байгууламжийн Инженерчлэл-худалдан авалт-барилга угсралтын ажлын ерөнхий гүйцэтгэгчээр “Жэй Эм Си Прожектс Индиа” компани шалгарсан. | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Үйлдвэрийн иргэний барилга байгууламж (Захиргааны байр, агуулах, засварын цех, гал командын байр, анхны тусламжийн төв, лаборатори, угтах байр), Ус хангамжийн систем, талбайн дэд бүтэц зэрэг барилга байгууламжуудыг барих ажлыг гүйцэтгэх ажилд туслан гүйцэтгэгч 8 компани ажиллаж, үйлдвэрийн гадна хашаажуулалт 100%-тай, усны нөөцийн савны арматурчлалын ажил 100%-тай, ус цуглуулах савны ажил 100%-тай, авто замын ажил 100%-тай, гал командын байр 100%-тай, ажилчдын байр 100%-тай, Захиргааны байр, агуулах, засварын цех, анхны тусламжийн төв, лаборатори, угтах байрны барилгын ажил 100%-тай байна.<br>Үйлдвэрийн цэвэр ус дамжуулах хоолойг татах бүтээн байгуулалтын ажлыг гүйцэтгэхэд орон нутгаас шаардагдах газрын асуудлыг шийдвэрлэн, цэвэр ус дамжуулах 84.58 км хоолой татах шугамын ажлыг “Оргилон дэлгэрэх ус” ХХК, “Хасу мигавает” ХХК-ууд гүйцэтгэж, 11 цэвэр усны худаг, 1 өргөх насосыг байршуулсан. Барилгын ажилд шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглах, барилгын ажил эхлүүлэх зөвшөөрлийг шуурхай олгож, Замын-Үүдийн боомтоор барилгын материалуудыг нэвтрүүлэх зэрэг дэмжлэг үзүүлэн хамтран ажилласан.<br>“Газрын тос боловсруулах үйлдвэрийн хашаа барих, талбайн тэгшилгээ, газар шорооны ажил”-ыг ашиглалтад оруулсан.<br>“Монголын газрын тос боловсруулах үйлдвэр”-ийн бүтээн байгуулалтад оролцож буй “Жи Эм Си Прожектс Монгол” ХХК-д түгээмэл тархацтай ашигт малтмал буюу 55,3 мянган куб элсийг ашиглуулах гэрээг байгуулж дэмжлэг үзүүлэн ажилласан. | |
| | Газрын тос боловсруулах үйлдвэрийг түүхий эдээр хангах, дамжуулах хоолой барих, бүтээн байгуулалтын ажлуудыг гүйцэтгэхэд орон нутгаас дэмжлэг үзүүлнэ. | Бүтээн байгуулалтын ажил | 20 | 100 | 100 | Алтанширээ сумын ЗДТГ-аас үйлдвэрийн усны шугам хоолой барих ажилд зориулан 2021 онд дүүргэлт хийх зориулалттай 80,350м.куб цагаан элс, 2022 онд 55,350 м.куб цагаан элс ашиглуулах гэрээ хийж хамтарч ажилласан. | 100 |
| | | Дэмжлэгийн тоо | 3 | 2 | 1 | Газрын тос боловсруулах үйлдвэрийг түүхий эдээр хангах хоолойн төслийн түр кемпийн зориулалтаар ашиглах 4,2542 га газрыг Алтанширээ сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлэж газар олгосон. | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Алтанширээ, Дэлгэрэх, Өргөн сумдын нутаг дэвсгэрт нийт 1334.66 га газрыг Үндэсний хэмжээний томоохон бүтээн байгуулалт, дэд бүтцийн төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх газрын зориулалтаар газрыг улсын тусгай хэрэгцээнд авах саналыг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 09/08 тоот тогтоолоор батлуулж, тогтоолыг Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газарт хүргүүлсэн. | |
| **Зорилт 3.2.3.** Байгаль орчинд ээлтэй, хариуцлагатай уул уурхайн үйл ажиллагааг дэмжинэ. | Хариуцлагатай уул уурхайг хөгжүүлж, байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлж байгаа уул уурхайн компанийн тусгай зөвшөөрлийг цуцлуулах хүртэл арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. | Хамтран ажиллах гэрээний биелэлтийн хувь | 0 | 80 | 80 | Алтанширээ, Дэлгэрэх, Хатанбулаг, Хөвсгөл, Улаанбадрах, Мандах сумдаас ашигт малтмалын ашиглалтын 3, хайгуулын 5 талбайг цуцлах хүсэлтүүдийг Байгаль орчин, аялал жуулчлалын яам болон Уул уурхай, Хүнд үйлдвэрийн яаманд 2021 онд тус тус хүргүүлж, "Халиун төгс" ХХК, "Легал медиа" ХХК, "Эм Жи Эл Геохүдэр" ХХК, 2022 онд Айраг, Даланжаргалан, Улаанбадрах, Хатанбулаг, Хөвсгөл сумдын нутагт ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа явуулж байсан "Асралт хайрхан дэлгэрэх" ХХК, "ЭНТЭ" ХХК, "Хутагт өлзийт говь" ХХК, "Хос орчлон" ХХК, "Террам Ресурсез Майнинг" ХХК, "Кингдаймонд" ХХК-ийн нийт ашиглалтын 3, хайгуулын 7 тусгай зөвшөөрлийг цуцлагдсан. Айраг, Даланжаргалан, Улаанбадрах, Хөвсгөл, Хатанбулаг сумдад ашигт малтмалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй 13 компанийн 2021 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар дүгнэсэн.<br>"МАК цемент" ХХК, "Эрдэнэс цагаан суварга" ХХК, "Олон ихт баян"ХХК, "Доншен газрын тос (Монгол)"ХХК-иуд орон нутагтай хамтран ажиллах гэрээг байгуулсан. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2022 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн А/128 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг тус аймгийн малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүдийн талбайд ажиллаж хууль тогтоомжийн хэрэгжилтийг шалгаж, Даланжаргалан, Айраг сумдын нутагт үйл ажиллагаа явуулж буй 11 компанийн тусгай зөвшөөрлийг цуцлуулах үндэслэлтэй гэсэн санал, дүгнэлт гарч, орон нутгийн мэргэжлийн байгууллага, холбогдох сумдаас тодруулга, мэдээллийг БОАЖЯ-нд хүргүүлэхээр болсон.<br>Ашигт малтмалын ашиглалтын 211 тусгай зөвшөөрөл, хайгуулын 128 тусгай зөвшөөрөл, түгээмэл тархацтай | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ашигт малтмалын 6, хайгуулын 16 тусгай зөвшөөрөл хүчин төгөлдөр байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад ашиглалтын талбай 5-аар нэмэгдэж, хайгуулын талбай 5-аар буурсан. | |
| | | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | 0 | 9 | 2 | Айраг, Даланжаргалан, Улаанбадрах, Хатанбулаг, Хөвсгөл сумдын нутагт ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа явуулж байсан “Асралт хайрхан дэлгэрэх” ХХК, “ЭНТЭ” ХХК, “Хутагт өлзийт говь” ХХК, “Хос орчлон” ХХК, “Террам Ресурсез Майнинг” ХХК, “Кингдаймонд” ХХК-ийн 7 тусгай зөвшөөрөл цуцлагдсан.<br>Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2022 оны А/128 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг тус аймгийн ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүдийн талбайд ажиллаж хууль тогтоомжийн хэрэгжилтийг шалгаж, Даланжаргалан сумын нутагт үйл ажиллагаа явуулж буй “Айраг-Индмин” ХХК (МҮ-016936), “Аривжих энерги” ХХК (МҮ-020962), “Баялаг жонш” ХХК (МҮ-005294), “Блюскай хорс” ХХК (МҮ-018496), “Гүн-Орд” ХХК (МҮ-015222), “Дасайн-Уул” ХХК (МҮ-011915), “Стар флюорит” ХХК (МҮ-020726), “Шашир трейд” ХХК (МҮ-010258), Айраг сумын нутагт үйл ажиллагаа явуулж буй “Таванбаатар” ХХК (МҮ-003315), “Экилешия” ХХК (МҮ-014111)–иудын тусгай зөвшөөрлийг цуцлуулах үндэслэлтэй гэсэн санал, дүгнэлт гарч, орон нутгийн мэргэжлийн байгууллага, холбогдох сумдаас тодруулга, мэдээллийг авч Байгаль орчин аялал жуулчлалын яаманд хүргүүлсэн. | 100 |
| | Уул уурхайн бүтээгдэхүүний тээвэрлэлтийг байгаль орчинд сөрөг нөлөөгүйгээр зохион байгуулахад шаардлагатай арга хэмжээг авч ажиллана. | Хэрэгжүүл сэн арга хэмжээний тоо | 4 | 12 | 12 | Мандах суманд үйл ажиллагаа явуулж буй “Их говь энержи” ХХК нь аймгийн Засаг даргын 2012 оны А/534 дугаар захирамжаар батлагдсан орон нутгийн чанартай авто замын трассын дагуу сайжруулсан болон хатуу хучилттай авто зам бариагүй, байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлсэн тул дээрх замын трассыг аймгийн Засаг даргын 2022 оны А/537 дугаар захирамжаар хүчингүй болгосон.<br>Уул уурхайн бүтээгдэхүүний тээвэрлэлтийн байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөг бууруулах зорилгоор Айраг, Даланжаргалан, Хатанбулаг, Мандах сумдад үйл ажиллагаа явуулж буй 9 аж ахуйн нэгжийн 1131,5 км орон нутгийн чанартай авто замын трассыг аймгийн Засаг даргын захирамжаар батлан, хатуу хучилттай, | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | сайжруулсан авто зам барьж тээвэрлэлт хийх үүрэг чиглэлийг өгсөн. “Тавантолгой-Зүүнбаян” чиглэлийн 414,6 км төмөр зам, “Тавантолгой-Манлай-Ханги” чиглэлийн хүнд даацын хатуу хучилттай авто зам, “Зүүнбаян-Ханги” чиглэлийн 226,9 км төмөр замыг тус тус барьж ашиглалтад оруулсан. | |
| ***Үндсэн чиг үүрэг 3.3**. Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, борлуулалтын сүлжээг өргөжүүлж, гол нэрийн зарим хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг орон нутгаас хангаж, импортыг орлох, экспортын баримжаатай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжих.* | | | | | | | |
| **Зорилт: 3.3.1.** Атрын IV аяныг хэрэгжүүлж, орон нутгийн онцлогт тохирсон газар тариалангийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх замаар хүн амын хүнсний ногооны хангамжийг тогтвортой өсгөнө. | Газар тариалан эрхлэгчдийг сургаж дадлагажуулах, мэргэжилтэй ажилтан бэлтгэх, хүний нөөцийг бэхжүүлэх арга хэмжээг зохион байгуулна. | Арга хэмжээ | 3 | 6 | 2 | Аймгийн “Политехник коллеж”-ийн хүлэмжийн аж ахуй, жимс жимсгэнэ, фермерийн аж ахуйн мэргэжилтэй ажилтан бэлтгэх ангийг 25 суралцагч амжилттай төгсөн, шинээр 35 суралцагч элсүүлж хүний нөөцийг бэхжүүлсэн. | 90 |
| | | Оролцогчдын тоо | 150 | 200 | 645 | Тариалан эрхлэгчдийн чадавхжуулах, мэргэжилтэй ажилтан бэлтгэх ажлын хүрээнд "Дэлхийн зөн Монгол" Олон улсын байгууллагын “Гамшигт тэсвэртэй орон нутаг” төсөл, “Монгол ногоо” төсөл, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамтай хамтран, 2021-2022 онд 7 удаагийн танхимын сургалт, 8 удаагийн цахим сургалт, 1 удаагийн туршлага солилцох аяллыг зохион байгуулж, давхардсан тоогоор нийт 645 тариаланчийг хамруулсан. | 100 |
| | Тариалангийн талбайн хөрсийг хамгаалж, үржил шимийг сайжруулан, бордоо, ургамал хамгааллын зохистой байдалд хяналт тавина. | Шинжилгээнд хамруулсан талбайн хэмжээ | 70/га/, | 31/га/ | 97,6 га | Тариалангийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.7-д “Агрохими, агрофизикийн шинжилгээг таван жил тутамд тариалангийн газрын эзэмшигч, ашиглагч өөрийн хөрөнгөөр хийлгэнэ” гэж заасны дагуу “Дорнын говийн тариаланчид” төрийн бус байгууллага, Дархан-Уул аймгийн ургамал газар тариалан сургалт эрдэм шинжилгээний хүрээлэнгийн хөрс судлалын лабораторитой хамтран, аймгийн тариалангийн 97,6 га талбайд хөрсний чанар, төлөв байдалд агрохимийн шинжилгээ хийж, сорилын дүн, зөвлөмжийг тариаланчдад хүргүүлсэн. | 100 |
| | | Хяналт шалгалтын тоо | 2 | 8 | - | Тариалангийн зориулалтаар ашиглагдаж буй 14 сумын 67 тариаланчийн 102 га талбайн хөрсний төлөв байдалд газар дээр нь очиж 14 удаа заавар зөвлөмж өгсөн. | 100 |
| | Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох шинэ сортын үрийг үржүүлэн хангамжийг нэмэгдүүлнэ. | Сортын тоо | 2 | 5 | 5 | Шинээр солонгосын бууцай, байцаа, салат навчны 3 төрлийн сортын үрийг сумдад тариалан туршсан. Сорт сорилтын ажлын хүрээнд тарвас, амтат гуаны 2, эртийн байцааны 1, сонгино 1, тарвасны 1, сармис 1, бууцай 1, гүзээлзгэнэ 1, чавганы 40 ширхэг суулгац, нийт 9 төрлийн сортыг шинээр туршиж, амтат гуаны 2 сортыг | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ирээдүйтэй сортоор батлуулахаар холбогдох газарт хүргүүлсэн. Хүнсний ногоо, модны үр үйлдвэрлэлийн ажлын хүрээнд сухай 100 кг төл, тарвас 13кг амтат гуаны 13 кг үрийг ХХААХҮЯ-ны дэргэдэх “Монгол ногоо” төсөлд нийлүүлсэн. Сэлэнгэ аймаг, НҮБ-н Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагад үр нийлүүлэхээр гэрээ байгуулсан. | |
| | | Үрийн хангамжийн өсөлтийн хувь | 13 | 13 | 11 | Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас 80 хувийн хөнгөлөлттэй үнээр давхардсан тоогоор 11 нэр төрлийн хүнсний ногооны үрийг 14 суманд, 2 тн төмсний үрийг “Мөнх-Ашиг” хоршоо, “Оюун шанд” ХХК-д олгон нийлүүлж, үрийн хангамжийг 2,57 хувиар, тариалалтыг 3,1 хувиар нэмэгдүүлсэн. | 100 |
| | Өрхийн тариалангийн үйлдвэрлэлд дэмжлэг үзүүлэх замаар техник технологийг шинэчлэн, хамгаалагдсан хөрсний тариалалт /хүлэмж/, зоорийн хангамжийг нэмэгдүүлнэ. | Техник шинэчлэлтийн хувь | 20 | 40 | 21,6 | Тариалангийн талбайн хэмжээ 29%, зоорийн хангамж 10,5%, техникийн хангамж-21,6%, хамгаалагдсан хөрсний тариалалт 579 м2-аар нэмэгдсэн. Эрдэнэ, Хөвсгөл, Дэлгэрэх сумдад хэрэгжүүлсэн “Гамшигт тэсвэртэй хөдөө аж ахуй” төслийн хүрээнд Эрдэнэ, Дэлгэрэх сумдад 4 га талбайд малын тэжээлийн ургамлыг туршилтаар тариалж, бороожуулах усалгааны систем, бага оврын хадлангийн трактор, анжис, хадуур, тармуур, хаман боогч зэрэг 70,2 сая төгрөгийн техникийн шинэчлэл хийсэн. | 100 |
| | | Шинээр баригдсан зоорийн тоо-1 | 1 | 4 | 3 | Хүлэмжийн тариалалтын 579 м2, 50 тонны багтаамж бүхий механик зоорь 1-ийг шинээр ашиглалтад оруулж, 10520 м2 зуны, 900 м2 өвлийн хүлэмж, 1010 тн-ын 1 зоорьтой болсон. | 100 |
| | | Нэмэгдсэн талбайн хэмжээ | 9909 /м2/ | 1000 /м2/ | 1000 м2 | Газар тариалангийн чиглэлээр 217 өрх, 23 аж ахуйн нэгж, байгууллага үйл ажиллагаа явуулан, иргэн, аж ахуйн нэгжүүд нь төмс 25,838 га, хүнсний ногоо 63,263 га, малын тэжээл 33,90 га, жимс, жимсгэнэ 15,20 га, нийт 138 га талбай, бага оврын трактор 72, үрлэгч 5, ухагч 3, 37 га-ын дуслын усалгааны систем, 900 м2 өвлийн хүлэмж 2ш, 10520 м2 зуны хүлэмж 65 ширхэг, 950 тонны багтаамж бүхий 22 зоорийг үйл ажиллагаандаа ашигласан. | 100 |
| | Газар тариалан эрхлэгчдийг хөнгөлөлттэй зээл, гадаад, дотоодын төсөл хөтөлбөрт хамруулан дэмжих замаар | Тариалангийн чиглэлээр олгосон газрын хэмжээ | 16 /га/ | 16/га/ | 99.59 га | ХХААХҮ-ийн яамнаас 2021-2022 онд 80 хөнгөлөлттэй үнээр олгосон давхардсан тоогоор 21 нэр төрлийн хүнсний ногооны үрийг 14 суманд, 2 тн төмсний үрийг “Мөнх-Ашиг” хоршоо, “Оюун шанд” ХХК-д нийлүүлж, үрийн хангамжийг 2,57 хувиар тариалалтыг 3,1 хувиар нэмэгдүүлсэн. Газар тариалангийн үйлдвэрлэлийг дэмжин Айраг, Даланжаргалан, Замын-Үүд, Иххэт, Өргөн, Сайншанд, | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ. | | | | | Иххэт, Хатанбулаг сумд 22 иргэнд 99,59 га газрыг тариалангийн зориулалтаар эзэмшүүлсэн. | |
| | | Хөнгөлөлттэй зээлд хамрагдсан иргэдийн тоо | 7 | 20 | 21 | Айраг, Даланжаргалан, Замын-Үүд, Өргөн, Сайншанд, Иххэт сумд 22 иргэнд 99,59 га газрыг тариалангийн зориулалтаар эзэмшүүлэн дэмжлэг үзүүлсэн. Засгийн газраас хэрэгжүүлсэн 3 хувийн хүүтэй хөнгөлөлттэй зээлд 4 иргэн, 1 хоршоо хамрагдаж 69,6 сая төгрөг, Сайхандулаан, Мандах, Хатанбулаг сумд "Хоршоо хөгжүүлэх сан"-гаас 3 иргэнд 55.0 сая төгрөг, нийт 124,6 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг олгосон.<br>Хүнсний ногоо тарих, боловсруулах хөнгөлөлттэй зээл авах хүсэлт ирүүлсэн 14 сумын 338 иргэн, 32 аж ахуйн нэгжийн хүсэлт, мэдээллийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд уламжилж, зээлийн шаардлага хангасан 4 иргэн, 1 хоршоо 69.6 сая төгрөгийн зээлийг арилжааны банкаар дамжуулан авсан. “Хөгжлийн шийдэл” ТББ, арилжааны 5 банктай хамтран хөнгөлөлттэй зээл, хамрагдах боломж, анхаарах асуудлын талаар 1 удаагийн сургалт, хэлэлцүүлгийг зохион байгуулж, 22 тариалан эрхлэгч танхимаар, цахимаар 10 сумын 17 иргэн хамрагдаж мэдээлэл авсан.<br>Гадаад, дотоодын хөнгөлөлттэй зээлийн талаарх мэдээллийг 16 төрийн байгууллага, хэвлэл мэдээллийн хэрэгслээр (DTV) давхардсан тоогоор 14864 иргэдэд хүргэсэн. | 100 |
| | | Санхүүжилт /сая төг/ | 55.0 | 120.0 | 194,2 сая | Газар тариалан эрхлэгчдийг дэмжиж 194,2 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын дэмжлэг үзүүлсэн байна. | 100 |
| | | Хүн амын төмс, хүнсний ногооны хангамжийн хувь | 10.7 | 20.0 | 29.1 | Ургац хураалтын эцсийн дүнгээр 123,9 тн төмс, 403,0 тн хүнсний ногоо, 1,48 тн жимс, жимсгэнэ, нийт 528,3 тн ургац хураан авч, өмнө оноос хураан авсан ургацын хэмжээ 29,1 хувиар нэмэгдэж, хүн амын төмс, хүнсний ногооны хангамж 0,1 хувиар өссөн. | 100 |
| **Зорилт 3.3.2.**<br>Мал аж ахуйн гаралтай түүхий эдийг бэлтгэх, боловсруулах, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн | Гол нэрийн зарим хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжиж хүн амын хүнсний хангамжийг нэмэгдүүлнэ. | Мах, махан бүтээгдэхүүний үйлдвэр, цехийн тоо | 6 | 11 | 9 | Мах, махан бүтээгдэхүүний үйлдвэр, цехийн тоо болж нэмэгдсэн. | 90 |
| | | Гурилан бүтээгдэхүүний | 36 | 42 | 42 | Гурилан бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхлэх зөвшөөрөлтэй 42 аж ахуйн, нэгж, цех байна. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| үйлдвэрлэлийг дэмжих замаар малчид, иргэдийн орлогыг нэмэгдүүлнэ. | | үйлдвэр, цехийн тоо | | | | | |
| | | Сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэр, цехийн тоо | 4 | 10 | 3 | Сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэлээр 3 шинэ цех бий болсон. | 90 |
| | | Санхүүжилт /сая.төг/ | 253.0 | 480.0 | 220.0 сая | Гол нэрийн зарим хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэлд 220.0 сая төгрөгийн санхүүжилтийг зарцуулсан. | 90 |
| | Стратегийн хүнсний улирлын нөөц бүрдүүлэх, хадгалалт, тээвэрлэлт, түгээлтийн үйл ажиллагааг өргөжүүлж, тавих хяналтыг сайжруулна. | Гэрээ байгуулсан ААН-ийн тоо-17 | 17 | 13 | 45 | Аймгийн Засаг даргын 2020 оны А/825 дугаар захирамжаар "Хүнсний хангамжийн шуурхай штаб"-ыг байгуулан, хүн амын стратегийн хүнс-мах, сүү, гурилаар орон нутгийг тогтвортой хангах, улирлын нөөц бүрдүүлэх гэрээг 14 сумын 2 хоршоо, 4 иргэн, 49 аж ахуйн нэгжтэй байгуулсан. | 100 |
| | | Хяналт шалгалтад хамрагдсан ААН, иргэдийн тоо -51 | 51 | 79 | 69 | Дээрх аж ахуй нэгжүүдийн нөөц бүрдүүлэлт, хадгалалт, тээвэрлэлтийн явцад 5 удаагийн хяналт шалгалтыг хийж зөвлөгөө, мэдээллээр ханган ажиллахын зэрэгцээ Мэргэжлийн хяналтын газрын төлөвлөгөөт бус хяналт шалгалтад хүнсний үйлдвэрийн 1, хүнсний худалдааны 5, нийтийн хоолны 69 обьект хамруулан, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хоол үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар улсын байцаагчийн “Үүсч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх тухай” зөвлөмж, үйл ажиллагааг зогсоох 2 акт, ажлын байрны 1 дүгнэлт, 4 албан шаардлага хүргүүлсэн. Илэрсэн зөрчил дутагдалд мэргэжил арга зүйн зөвлөгөөг өгч, сэрэмжлүүлэх 4 төрлийн мэдээллийг цахим орчинд байршуулсан.<br>“Хүнсний аюулгүй байдлыг хангах” сургалтад Сайншанд, Мандах, Эрдэнэ, Өргөн сумдын хүнсний худалдаа, нийтийн хоолны үйлчилгээ эрхлэгч 107 төлөөллийг хамруулан, хяналтыг сайжруулсан. | 100 |
| | Сумдад мал нядлах эрүүл ахуйн шаардлага хангасан төвлөрсөн цэг байгуулах, малын гаралтай экологийн цэвэр бүтээгдэхүүнийг зах | Шинээр байгуулсан цэгийн тоо | 7 | 6 | 7 | Мах хадгалах стандартын шаардлага хангасан 340 тонны багтаамж бүхий зориулалтын зоорьтой “Хайрхан” малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний зах, “Суман зурхай” ХХК, мөн мал төхөөрөх 1, мах боловсруулах /хиам/ 2, дайвар бүтээгдэхүүний 1 үйлдвэр, мал нядалгааны 7 цэг үйл ажиллагаа явуулсан. | 100 |
| | | Шинжилгээнд | 31.5 | 94.5 | 123,7 | Мал эмнэлгийн нэгдсэн системийг 2021 онд бүрэн нэвтрүүлэн, мал эмнэлгийн үзлэг, шинжилгээний 14451 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | зээлд нийлүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ. | хамрагдсан махны хэмжээ /тн/ | | | | хүсэлт хүлээн авч, эрүүл ахуйн шаардлага хангасан мах 123,7 мянган тонн, арьс, шир 131777 ширхэг, ноос, ноолуур 32,5 мянган тонн, 148649 толгой амьд мал, амьтанд эрүүл болохыг баталгаажуулан 14257 ширхэг гэрчилгээ олгосон. | |
| | Ноос, ноолуур, арьс шир боловсруулах, нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх хувийн хэвшлийн санал санаачилгыг дэмжинэ. | Боловсруулах үйлдвэр, цехийн тоо | 13 | 23 | 11 | Ноос, ноолууран бүтээгдэхүүн үйлдвэрлэх чиглэлээр 6 иргэн, 1 аж ахуйн нэгж, 4 хоршоо, арьс, ширний анхан шатны боловсруулалтын чиглэлээр 2 иргэн үйл ажиллагаа явуулж, орон нутгийн иргэдийн захиалгын дагуу бэлэн хувцас, бэлэг дурсгалын зүйл, хонины элдсэн нэхий, хурганы арьс, үстэй дээл, монгол гэрийн эсгий дээвэр, гудас зэргийг үйлдвэрлэн зах зээлд нийлүүлсэн. | 90 |
| | | Санхүүжилт- /сая.төг/ | 20.0 | 80.0 | 110.0 | Засгийн газраас арилжааны банкаар дамжуулан хэрэгжүүлсэн "Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө"-ний хүрээнд нийт 213 иргэн 3,8 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг хөдөө аж ахуй, түүхий эд бэлтгэх чиглэлээр авсан. Суран эдлэл, арьс ширэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх чиглэлээр 3 иргэнд Эрдэнэ, Өргөн, Мандах сумд Хоршоо хөгжүүлэх сангаар дамжуулан нийт 30.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгож дэмжлэг үзүүлсэн.<br>"Шинэ хөдөө" төслийн хүрээнд Айраг, Даланжаргалан, Иххэт, Алтанширээ, Мандах, Сайхандулаан, Өргөн, Эрдэнэ сумдад олгосон "Нэхий элдэгч" машин, "Арьстай мах хуулах" машиныг орон нутгийн иргэдэд гэрээгээр ашиглуулан, үйл ажиллагааг жигдрүүлсэн. Алтанширээ сумын "Олон ширээ" хоршоо 107 гишүүнтэйгээр үйл ажиллагаа явуулж, "Хоршоо хөгжүүлэх сан"-гаас мал чанаржуулах, махыг үйлдвэрийн аргаар бэлтгэх чиглэлээр үйл ажиллагаагаа өргөтгөхөд 80,0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийн дэмжлэг үзүүлэн, ноос, ноолуурын холбооны гэрчилгээ авч хоршооны гишүүдийн бэлтгэсэн 40 тн ноолуурыг ангилан ялгаж эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг "ГОЁЛ" үндэсний үйлдвэрт нийлүүлсэн. | 100 |
| | Үндэсний үйлдвэрүүдэд чанар, стандартын шаардлага хангасан түүхий эд нийлүүлсэн малчдыг урамшуулалд | Үндэсний үйлдвэрт тушаасан түүхий эд нийлүүлэлтийн хувь | 5 | 20 | 20 | Монголын арьс, ширний итгэмжлэгдсэн төлөөлөгчийн эрхтэй 45 төлөөлөгч, мал аж ахуй гаралтай түүхий эд бэлтгэн нийлүүлэгч 19 хоршоо 14 суманд ажиллан, үндэсний томоохон үйлдвэрүүдэд хонь, тэмээний ноос нийлүүлж, 14 сумын давхардсан тоогоор нийт 6085 малчин, мал бүхий өрхөд 2,1 тэрбум төгрөгийн урамшууллыг олгосон. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хамруулах ажлыг зохион байгуулна. | | | | | | |
| Зорилт 3.3.3. Малын чанар, ашиг шимийг сайжруулах, биотехнологийн ололтыг нэвтрүүлэн эрчимжсэн аж ахуйг хөгжүүлнэ. | “Дэлгэрэхийн улаан” омгийн ямааны тархалтыг нийт хээлтүүлэгчийн 30 хувьд хүргэн нэмэгдүүлж, үрийг генийн санд хадгалуулна. | Шинээр тархаан сайжруулсан хээлтүүлэгчийн тоо | 8900 | 1000 | 469 | Нутгийн шилмэл омгийн ямааны тархалт, ямаан сүргийн чанар, ашиг шимийн гарцыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд “Дэлгэрэхийн улаан омог”-ийн 469 толгой өсвөр хээлтүүлэгч бэлтгэн Улаанбадрах, Мандах, Алтанширээ, Өргөн, Даланжаргалан Замын-үүд сумдын 107 малчин өрхөд нийлүүлсэн. | 90 |
| | | Генийн санд хадгалуулсан үрийн тоо | 0 | 70 | 3000 | Малын удмын сангийн үндэсний төвтэй хамтран "Дэлгэрэхийн улаан омог"-ийн ямааны 3000 үрийг генийн санд хадгалуулсан ба хээлтүүлэгч ямааны тоо 1764 толгой хүрч, орон нутгийн нийт хээлтүүлэгчийн 30 хувьд тархсан. | 100 |
| | Мал сүрэгт эзлэх өндөр ашиг шимт малын тоог өсгөх замаар малын чанар, ашиг шимийн гарцыг нэмэгдүүлнэ. | Өндөр ашиг шимт малын тоон өсөлтийн хувь | 0.5 | 4 | 2,9 | Малын чанар, ашиг шимийн гарцыг нэмэгдүүлэхээр “Дэлгэрэхийн улаан омог"-ийн ишгэн ухна 469, барга, үзэмчин үүлдрийн 201 хурган хуц, нийт 670 толгой өсвөр хээлтүүлэгч бэлтгэн бойжуулсан. Биотехнологийн дэвшилтэт технологийг нэвтрүүлэн зохиомол хээлтүүлгийг орон нутагт зохион байгуулах ажлын хүрээнд Алатау, Хар тарлан үүлдрийн 257 толгой үхэр , 2382 нутгийн монгол хонь, дэлгэрэхийн улаан омгийн ямааны нийт 2639 толгой малд шингэлсэн үр болон гардан хээлтүүлэг хийж нутгийн малын ашиг шимийг сайжруулсан. Алтанширээ, Сайншанд сумд “Хоршоо хөгжүүлэх сан”-гаас мал чанаржуулах, махыг үйлдвэрийн аргаар бэлтгэх, эрчимжсэн аж ахуйн эрхлэх 2 иргэн, аж ахуйн нэгжид 113,0 сая, “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан”-гаас “Цагаан сүүний буян” ХХК, “Өлзийт баян мод” ХХК-д 360,0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгосон. Өндөр ашиг шимт малын тоо 78376 толгойд хүрч, 5 төрөл дээрээ 0,5%-иар өссөн нь нийт мал сүргийн 2,9 хувийг эзэлж байна. | 100 |
| | Сумдад эрчимжсэн аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа явуулах хувийн хэвшлийн санал санаачилгыг дэмжинэ. | Эрчимжсэн аж ахуйн тоо | 61 | 72 | - | “Мөрөөдлийн говь” ХХК нь Сайншанд сумын 6 дугаар багт хувийн 650,0 сая төгрөгийн хөрөнгөөр 60000 тахианы механикжсан ферм байгуулж, эхний ээлжинд 30000 өндөглөгч тахиатайгаар орон нутгийн иргэдэд өндөг нийлүүлэн үйл ажиллагаа нь тогтмолжсон. | 90 |
| | | Төслийн тоо, Санхүүжилт /сая төг/ | 3<br>200.0 | 4<br>390.0 | 2<br>330.0 | "Солид Партнерс групп" ХХК нь төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд Дорноговь аймагтай хамтран "Монгол тэмээ Дорноговь" төслийг хэрэгжүүлэн ингэний сүүг боловсруулан хуурай сүү, молоко зэрэг эцсийн | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | бүтээгдэхүүн үйлдвэрлэн экспортлох үйлдвэрийг Замын-Үүд суманд, үйлдвэрт шаардагдах ингэний сүүг цуглуулах эрчимжсэн фермерийг Мандах, Хатанбулаг, Улаанбадрах, Хөвсгөл, Сайншанд сумдад байгуулахаар малчид, иргэдэд танилцуулга мэдээллийг хүргэж эхэлсэн.<br>Мандах сумын сум хөгжүүлэх сангаас эрчимжсэн мал аж ахуйн 1 төсөлд 7,0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл, Алтанширээ, Сайншанд сумд хоршоо хөгжүүлэх сангаас мал чанаржуулах махыг үйлдвэрийн аргаар бэлтгэх, эрчимжсэн аж ахуйн эрхлэх 2 иргэн, аж ахуйн нэгжид 113,0 сая, жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас сүү, сүүн бүтээгдэхүүн боловсруулах 2 төсөлд 360,0 сая төгрөгийн санхүүжилтийн дэмжлэг үзүүлэн, хувийн хэвшлийн санал санаачилгыг дэмжин ажилласан. | |
| | Малчид иргэдийн захиалгын дагуу, бод, бог малд зохиомол хээлтүүлэг хийнэ | Зохиомол хээлтүүлэгт хамрагдсан малын тоо | 448 | 484 | 5278 | Биотехнологийн дэвшилтэт технологийг нэвтрүүлэн зохиомол хээлтүүлгийг орон нутагт зохион байгуулах ажлын хүрээнд 257 толгой Алатау, Хар тарлан үүлдрийн үхэрт, 2382 толгой нутгийн монгол хонь, "Дэлгэрэхийн улаан омог"-ийн ямаа, нийт 2639 толгой малд шингэлсэн үр болон гардан хээлтүүлэг хийсэн. | 100 |
| | | Өсөлтийн хувь | 30 | 50 | 59,5 | 2020 оноос 59,5 хувиар нэмэгдүүлсэн. | 100 |
| **Зорилт 3.3.4.**<br>Бэлчээрийн төлөв байдал, даацад тулгуурлан нөхөн сэргээлтийг хийж, бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлж, ашиглалтыг сайжруулна. | Бэлчээр ашиглалтын нөлөөллийг фотомониторингийн аргаар тодорхойлж, сум бүр орон нутгийн онцлогт тохирсон бэлчээр ашиглах журам, менежментийн төлөвлөгөөг батлан хэрэгжүүлнэ. | Судалгаанд хамруулсан сумын тоо | 14 | 14 | 14 | Засгийн газрын 286 дугаар тогтоолын дагуу 8 дугаар сард бэлчээрийн төлөв байдлын, ургац тодорхойлох ажлыг 14 сумын 54 багийн 72 бэлчээрийн төлөв байдлын ажиглалтын цэгүүдэд гүйцэтгэхэд Айраг, Даланжаргалан, Замын-Үүд, Сайншанд сумдын бэлчээр даац хэтэрсэн, бусад сумдад мал нэмж бэлчээх боломжтой гэж 2022 онд тогтоогдсон ба одоогоор хонин толгойд шилжүүлснээр 4473731.9 толгой мал бэлчээрлэж байна. 2022-2023 онд хонин толгойд шилжүүлснээр 434,6 мянган толгой малыг хүнсэнд болон зах зээлд борлуулах тооцоо гарсан. | 100 |
| | | Бэлчээр ашиглах журам, менежментийн төлөвлөгөө шинээр батлуулса | 3 | 5 | 7 | Айраг, Өргөн, Мандах, Улаанбадрах, Сайхандулаан, Хөвсгөл, Сайншанд сумд “Бэлчээр ашиглах, отор нүүдэл зохицуулах журам”-ыг батлуулан мөрдөж эхэлсэн. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | н сумын тоо | | | | | |
| | Зарим сумдын бэлчээрт хөнөөл учруулж буй үлийн цагаан оготнотой тэмцэх, доройтлыг бууруулах, нөхөн сэргээх ажлыг зохион байгуулна. | Нөхөн сэргээсэн бэлчээрийн талбай | 60000/га/ | 60000/га/ | - | Ургамал хамгаалал эрдэм шинжилгээний хүрээлэнтэй хамтран “Бэлчээрийн ургамалд хөнөөл учруулж буй хөнөөлт мэрэгчдийн хаврын тодотгох судалгаа"-ны ажлыг Айраг, Алтанширээ, Даланжаргалан, Иххэт, Дэлгэрэх сумдын нутагт гүйцэтгэсэн. Дээрх 5 сумын бэлчээрийн 153000 га талбайд буюу бэлчээрийн газрын 26.5 хувьд хөнөөлт мэрэгч болох “Үлийн цагаан оготно”-ы тархалт, нягтшил нь хэсэгчилсэн болон үргэлжилсэн тархалттай гэсэн зөвлөмж, дүгнэлт гарсан.<br>Мэргэжлийн байгууллагаас ирүүлсэн зөвлөмж, дүгнэлтийг орон нутгийн малчид, иргэдэд танилцуулах, бэлчээрийн ургамалд хөнөөл учруулж буй хөнөөлт мэрэгчтэй энгийн механик, биологийн аргаар тэмцэх арга, аргачлалыг гарын авлага хэлбэрээр давхардсан тоогоор 690 гаруй иргэдэд хүргэсэн. | 70 |
| | Төр, хувийн хэвшлийн хөрөнгөөр бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлнэ. | Шинээр гарсан, сэргээн засварласан худгийн тоо | 33 | 60 | 61 | Бэлчээрт 3202 худаг ашиглагдаж байгаа нь нийт бэлчээрийн 40,3 хувийг усжуулдаг. Улсын төсвийн 157.5 сая төгрөгийн хөрөнгөөр “Эхний эхэн” ХХК сумдын бэлчээрт шинээр инженерийн хийцтэй 5 худаг гаргах ажлыг 60 хувьтай гүйцэтгэж байна.<br>Алтанширээ, Даланжаргалан, Дэлгэрэх, Иххэт, Өргөн, Мандах, Улаанбадрах, Замын-Үүд сумдын СОНХС-ийн 204.2 сая төгрөгийн санхүүжилтээр инженерийн хийцтэй 21 худаг шинээр гаргасан. Айраг сумын Орон нутгийн хөгжлийн сангийн 18 сая төгрөгийн хөрөнгөөр 3 гар худаг сэргээн засварласан.<br>Айраг, Даланжаргалан, Эрдэнэ сумдын 3 малчин хувийн хөрөнгөөр инженерийн хийцтэй 3 худаг шинээр гаргаж, 3 гар худгийг сэргээн засварласан. Дээрх 26 худгийг шинээр болон сэргээн засварласнаар 39,0 мянган га бэлчээрийг усжуулж, 54,6 мянган толгой мал услах нөхцөл бүрдсэн. | 100 |
| **Зорилт 3.3.5.**<br><br>Мал аж ахуйг тогтвортой хөгжүүлэх, байгаль цаг уурын эрсдэлээс хамгаалах, бэлэн | Хөдөө аж ахуйн салбарын цаг үеийн мэдээ, мэдээллийг шуурхай хүргэх “Масс мессеж” үйлчилгээг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ. | Илгээсэн мессеж тоо | 98000 | 10000 | 256763 | Мал аж ахуйн салбарын цаг үеийн мэдээ, мэдээллийг малчдад шуурхай хүргэх зорилгоор аймгийн Засаг даргын А/33, А/241 дугаар захирамжаар 4,9 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэн, "Мобиком", "Скайтел"ХХК-тай тус тус гэрээ байгуулан “Масс мессеж” үйлчилгээг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, цаг агаарын болон цаг үеийн мэдээллийг давхардсан тоогоор нийт 256763 иргэн, малчинд хүргэсэн. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлнэ. | | Хадлангийн салааны тоо | 2 | 5 | 4 | Замын-Үүд суманд 2, Даланжаргалан, Иххэт сумдад тус бүр 1 хадлангийн салаа үйл ажиллагаа явуулан, хадлан тэжээл бэлтгэж хэвшсэн. | 90 |
| | Хадлан тэжээл бэлтгэх менежментийг сайжруулж, малын тэжээлийн ургамал тариалах ажилд иргэд, хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлнэ. | Малын тэжээл тариалсан хэмжээ /га/ | 6.5 | 7.5 | 61,9 | “Дэлхийн зөн Монгол” Олон улсын байгууллагын “Гамшигт тэсвэртэй орон нутаг” төслийн хүрээнд сумдын газар тариалан эрхлэгч, малчдын 45 төлөөллийг Төв аймгийн Баян-Чандмань суманд малын тэжээл тариалах чиглэлээр талбай бэлтгэх, тариалалтын хийх явцтай газар дээр нь танилцуулж туршлага судлуулсан. Дэлгэрэх, Эрдэнэ суманд 3 га талбайд малын тэжээлийн ургамлыг 20,0 гаруй сая төгрөгийн бороожуулах усалгааны систем, бага оврын хадлангийн трактор, анжис, хадуур, тармуур, хаман боогч олгож, 5 удаагийн танхимын сургалт, 1 удаагийн туршлага судлах аялалд давхардсан тоогоор 150 гаруй малчдыг хамруулсан.<br>Төслийн үр дүнг Даланжаргалан, Дэлгэрэх, Иххэт, Өргөн, Хатанбулаг, Эрдэнэ сумдад туршиж 33.90 га талбайд малын тэжээлийн тариалалт хийсэн нь өмнө оноос тариалалтыг 1 га-аар нэмэгдүүлсэн. Иххэт сумын иргэн 20-25 га талбайд ногоон тэжээл тариалан 18 тн ургац хураан авсан.<br>Улсын төсвийн 100,0 сая төгрөгийн санхүүжилтээр Мандах, Сайхандулаан сумдад малын тэжээлийн ургамал тариалах, хадлан тэжээл бэлтгэхэд шаардагдах техник, тоног төхөөрөмж худалдан авах тендер зарлагдсан. | 90 |
| | | Өвс, тэжээл /тн/ | 400 /12 | 700/17 | 850/232 | Аймгийн нөөцөд 100 тн өвс, 80 тн тэжээл, сумдын нөөцөд 560 тн өвс, 420 тн тэжээл бэлтгэхээр тогтоосны дагуу хэрэгжилтийг 91.7 хувьтай хангаж, аймгийн нөөцөд 270 тн өвс, 61,5 тн тэжээл, сумдын нөөцөд 580.6 тн өвс 171.4 тн тэжээл бэлтгэсэн. | 100 |
| | Малын тооноос хамааруулан өвс, тэжээлийн шаардлагатай нөөцийг бүрдүүлэн, стандартын дагуу хадгална. | Аймаг, сумдын өвс, тэжээлийн нөөц бүрдүүлэлтийн хувь | 53 | 70 | 91,7 | Аймгийн 14 сум мал аж ахуйн салбарын өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангахад сумын аюулгүйн нөөцөд өвс, тэжээлийн аюулгүйн нөөц бүрдүүлэн хадгалах агуулахтай. Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 277 дугаар тогтоолоор аймгийн нөөцөд 100 тн өвс, 80 тн тэжээл, сумдын нөөцөд 560 тн өвс, 420 тн тэжээл бэлтгэхээр тогтоосон. Тогтоолын хэрэгжилтийг 91.7 хувьтай хангаж, аймгийн нөөцөд 270 тн өвс, 61,5 тн тэжээл, сумдын нөөцөд 580.6 тн өвс 171.4 тн тэжээл бэлтгэсэн.<br>Сумдын бэлчээрийн даац, газар зүйн байршил, отор нүүдлийн төлөв байдлыг харгалзан Хөвсгөл, Өргөн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | сумдад сум дундын өвсний аюулгүй нөөцийг бүрдүүлж, 222 тонн өвсийг татан төвлөрүүлсэн. | |
| ***Ерөнхий чиг үүрэг 3.Засаглалын бодлогыг хэрэгжүүлэх*** | | | | | | | |
| ***Үндсэн чиг үүрэг 4.1.*** *Хүний хөгжлийг хангасан ухаалаг, тогтвортой, сайн засаглалыг бэхжүүлэн, цахим технологид тулгуурласан төрийн үйлчилгээг эрчимжүүлж, төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн хамтын ажиллагаа өргөжүүлэх.* | | | | | | | |
| **Зорилт 4.1.1.**<br><br>Төрийн үйлчилгээг шуурхай, хүртээмжтэй хүргэх нөхцөлийг бүрдүүлж, төрийн цахим үйлчилгээг хөгжүүлнэ. | Төрийн байгууллагуудад цахим хэрэглээг үе шаттай нэвтрүүлж, мэдээллийг шуурхай солилцох нөхцөлийг сайжруулна. | Цахим систем нэвтрүүлсэн сум, байгууллагын тоо | 5 | 33 | 125 | Иргэд болон төрийн албан хаагчдыг төрийн үйлчилгээний цахим программ ашиглах, үйлчилгээ авах, тоног төхөөрөмж дээр ажиллах зэргээр чадавхжуулах сургалт өдөрлөгийг 14 удаа зохион байгуулж 500 гаруй хүнийг хамруулсан.<br>Төрийн 13 байгууллагын 151 албан хаагчдыг тоон гарын үсэгтэй болсноор лавлагаа мэдээлэл гаргах, албан бичиг цахимаар боловсруулах, төрийн сангийн нэгдсэн системд тайлан мэдээ хүргүүлэх, төрийн үйлчилгээг цахимаар үзүүлэх байдлаар албан ажилд хэрэглэсэн.<br>Засгийн газрын 2022 оны 377 дугаар тогтоолын дагуу аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтэц, орон тоог шинэчлэн батлуулан, төрийн үйлчилгээ-мэдээллийн төвийн ажилтны орон тоо 3, архивын тасагт мэдээллийн технологи хариуцсан ажилтан 1,цахим шилжилтийг эрчимжүүлэх зорилгоор 14 сумын Засаг даргын Тамгын газрын бүтэц орон тоонд өөрчлөлт оруулж олон нийттэй харилцах, төрийн цахим үйлчилгээний ажилтны орон тоог бий болгож, төрийн байгууллагын дотоод үйл ажиллагааны нэгдсэн системийг нэвтрүүлэх, төрийн үйлчилгээг цахимаар үзүүлэх операторын үйлчилгээ, цахим шилжилттэй холбоотой үйл ажиллагааны хэрэгжилтийг хангах, төрийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэх нөхцөлийг бүрдүүлсэн. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | “Төрийн байгууллагын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн систем”-ийг төрийн болон төрийн өмчит 125 байгууллагад нэвтрүүлэн албан бичиг солилцох, өргөдөл гомдол бүртгэх, цаг бүртгэл хөтлөх байдлаар ашиглаж байгаа ба төрийн байгууллагуудад цахим хэрэглээг нэмэгдүүлсэн. | |
| | Мэдээлэл, харилцаа холбооны технологийн дэвшлийг төрийн үйлчилгээнд нэвтрүүлж иргэд, байгууллагад үзүүлэх төрийн үйлчилгээг цахимжуулан хүртээмжийг нэмэгдүүлнэ. | Цахим үйлчилгээ ний тоо | 52 | 129 | 73 | Айраг, Сайхандулаан сумдын “Төрийн үйлчилгээний нэгдсэн төв”-д иж бүрэн компьютер, хэвлэгч төхөөрөмж, хурууны хээ, иргэний үнэмлэх уншигч, тоон гарын үсгийн гэрчилгээ тээгч зэрэг төрийн үйлчилгээг операторын хэлбэрээр үзүүлэхэд шаардлагатай тоног төхөөрөмжийг нийлүүлж, ажиллах нөхцөл, иргэдийн үйлчлэх боломжийг бүрдүүлснээр аймгийн бүх сумдад операторын үйлчилгээг бүрэн нэвтрүүлсэн.<br>Төрийн үйлчилгээний лавлах суурин утсыг ажиллуулан “call center” үйлчилгээгээр дамжуулан нэг дороос төрийн болон төрийн өмчит 18 байгууллагын 45 төрийн үйлчилгээний талаарх мэдээлэл авах нөхцөлийг бүрдүүлж нийт 942 дуудлагад хариу өгч, төрийн цахим үйлчилгээг орон нутгийн мэдээллийн хэрэгслүүдээр 21 постер, 6 видео шторк бэлтгэн байршуулсан.<br>Сумдын ЗДТГ-аар дамжуулан нийт 1650 гарын авлага, 640 зурагт хуудсыг аж ахуй нэгж, байгууллагын мэдээллийн самбаруудаар, “Өнөөгийн Дорноговь сонин" болон "Дорноговь-2022" сэтгүүлд нийт 12 постер, мэдээлэл байршуулан 5500 ширхэг хэвлүүлж иргэдэд хүргэсэн.<br>Аймгийн 15 төрийн байгууллагын 73 үйлчилгээг төрийн цахим үйлчилгээний нэгдсэн /e-mongolia.mn/ системд нэвтрүүлэн, 268 үйлчилгээг нэгдсэн системээр дамжуулан авах боломжийг бүрдүүлж, 353 төрлийн лавлагаа, мэдээллийг 269007 удаа гаргаж үйлчилсэн. | 90 |
| | Төрийн байгууллагын үйл ажиллагааны мэдээллийн ил тод байдлыг сайжруулж, иргэд, олон нийтийн оролцоог хангана. | Цахим хаягтай сум, байгуулл агын тоо | 4 сум, 10 агентлаг | 10 сум, 20 агентлаг | 12 сум, 48 байгууллага | Албаны цахим хаягаар дамжуулан 10000 гаруй цаг үеийн мэдээлэл, 7500 гаруй захиргааны шийдвэр, 200 гаруй постер, 100 гаруй видео шторк болон бусад холбогдох мэдээллийг байршуулж нийт 150,000 гаруй хандалт авсан.<br>Аймгийн Засаг даргын баталсан удирдамжийн дагуу “Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай” хуулийн хэрэгжилтийг хангах, иргэдийн мэдээлэл хайх, хүлээн авах нөхцөлийг бүрдүүлж, салбарын үйл ажиллагааны мэдээллийг албаны цахим хуудсаар тогтмол хүргэж буй | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байдлыг 38 байгууллагад үнэлгээ өгөх, зөвлөн туслах ажлыг зохион байгуулан, нийтлэг гарсан 13 алдаа зөрчлийг арилгах үүрэг чиглэлийг хүргүүлсэн.<br>Аймгийн Засаг даргын Тамгын газрын албаны цахим хуудасны шинэчлэлтийг “Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай” хуулийг хангаж цэсийн өөрчлөлт, харагдах байдал, өргөдөл гомдлын хэсгийн шинэчлэлтийн хөгжүүлэлтийг “Ухаалаг Засаглал” ТББ“-аар гүйцэтгүүлэн үйл ажиллагааны ил тод байдлыг нэмэгдүүлсэн.<br>Төрийн байгууллагын мэдээ мэдээллийг цахимаар дамжуулан авах нөхцөлийг бүрдүүлэн албаны цахим хуудсыг 12 сум, төрийн болон төрийн өмчит 48 байгууллага ашиглаж байгаа нь нийт сум, байгууллагын 92 хувийг эзэлж өмнөх оноос 13-аар нэмэгдүүлсэн. | |
| **Зорилт 4.1.2.**<br><br>Төрийн бодлогын залгамж чанарыг ханган, мэргэшсэн, тогтвортой, чадварлаг, ёс зүйтэй төрийн албыг бэхжүүлж, төрийн үйлчилгээний чанар, үр нөлөөг дээшлүүлнэ. | Төрийн захиргааны байгууллагад чиг үүргийн иж бүрэн шинжилгээ хийж, ажил үүргийн давхцал, хийдлийг арилгах бодлогын шинэчлэлийг хэрэгжүүлнэ. | Шинжилгээ хийсэн байгууллагын тоо | 0 | 28 | 21 | Сайншанд, Замын-Үүд сумдын Засаг даргын Тамгын газар, Захирагчийн ажлын алба, Хот тохижилтын байгууллагын үйл ажиллагаанд чиг үүргийн шинжилгээ хийх үүрэг хүргүүлж, чиг үүргийн шинжилгээг асуулга, ажлын байрны зураг авалтын аргаар хийж цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулан ирүүлснийг үндэслэн, сумын Захирагчийн ажлын алба, Хот тохижилтын байгууллагыг нэгтгэх замаар чиг үүргийн давхардал, хийдлийг арилгах арга хэмжээ авч ажилласан.<br>Сумдын Засаг даргын Тамгын газрын бүтцэд чиг үүргийг шинжилгээ хийсний үндсэн дээр аймгийн Засаг даргын 2022 оны А/230 дугаар захирамжаар дотоод ажил хариуцсан мэргэжилтний албан тушаалын ангилал зэрэглэлийг өөрчлөн, төрийн цахимаар хүргэх операторын үйлчилгээ, сумын Засаг даргын Тамгын газрын архив, албан хэрэг хөтлөлтийн ажлыг хариуцуулахаар жишиг албан тушаалын тодорхойлолт, 39 төрийн захиргааны албан тушаалын ажлын байрны шинжилгээг асуулгын аргаар авч 3 албан тушаалын чиг үүргийг салгаж, 2 албан тушаалын чиг үүргийг өөрчилж, 3 албан тушаалыг шинээр бий болгон аймгийн Засаг даргын 2022 оны А/256 дугаар захирамжаар аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтэц, орон тоог үйл ажиллагааны давхардал, хийдэлгүй байхаар шинэчлэн баталсан. | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Боловсрол, шинжлэх ухааны яамнаас аймаг, нийслэлийн Боловсрол, шинжлэх ухааны газрын бүтэц, орон тоог жишиг байдлаар баталсантай холбогдуулан Дорноговь аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын бүтэц, орон тоог аймгийн Засаг даргын 2022 оны А/340 дүгээр захирамжаар баталж давхардал, хийдлийг арилгасан. | |
| | Орон нутагт дутагдалтай байгаа салбарын мэргэжлээр төрийн албанд шаардлагатай байгаа хүний нөөцийг бэлтгэнэ. | Бэлтгэсэн хүний нөөц | 40 | 70 | 55 | Орон нутгаас суралцах элсэгчдийн тоог нэмэгдүүлэх, нэн шаардлагатай мэргэжлийн эмч, эмнэлгийн мэргэжилтэн бэлтгэх, оюутнуудад сургалтын төлбөрийн дэмжлэг үзүүлэх, төгсөгчдийг хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажиллуулах үр дүнтэй хөшүүргийг бий болгох, нийгэм эдийн засгийн баталгааг хангах зэрэг асуудлуудыг хэрэгжүүлэхээр аймгийн Засаг дарга, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн захиралтай хамтран ажиллах гэрээ байгуулсан.<br>"Зайлшгүй хэрэгцээтэй, дутагдалтай байгаа мэргэжлээр оюутан элсүүлэх, суралцаж байгаа оюутнуудын судалгаанд үндэслэн орон нутагт ажиллуулах талаар их, дээд сургуулиудтай хамтран ажиллах", "Мэргэшсэн, ур чадвар бүхий албан хаагч, менежерийг орон нутагт урьж ажиллуулах асуудлыг судлан шийдвэрлэх, тэдгээрийн гэр бүлийг ажлын байраар хангах", "Төрийн захиргааны албан тушаалын болон ирээдүйд үнэ цэнэ нь өсөн нэмэгдэх мэргэжлийн судалгааг тогтмол шинэчлэх" зэрэг бодлогын зорилтуудыг тусган Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 09/01 тогтоолоор батлуулсан.<br>Монгол Улсын багшийн их сургуульд багш мэргэжлээр орон нутгаас суралцаж байгаа 1-4 дүгээр курсийн оюутнуудын судалгааг гаргаж, дутагдалтай байгаа дуу хөгжмийн багш мэргэжлээр суралцаж буй 9 оюутны сургалтын төлбөрийн тэтгэлгийг олгосон.<br>Орон нутагт боловсон хүчин бэлтгэх, эрэлттэй мэргэжлээр суралцагч оюутнуудыг дэмжих зорилгоор 2020-2023 онд инженер, боловсрол, соёл, урлаг, мэдээллийн технологи, мал эмнэл зүй, газрын тосны салбар, сувилагч зэрэг орон нутагт нэн шаардлагатай мэргэжлээр суралцаж байгаа 350 оюутанд 500,0 сая гаруй төгрөгийн сургалтын төлбөрийн дэмжлэгийг аймгийн Засаг дарга, Дорноговь аймгийн нутгийн зөвлөл, Улсын Их Хурлын гишүүдээс үзүүлж, дэмжлэгт хамрагдсан оюутнуудыг төгсмөгц орон нутгийн | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | төрийн байгууллагад 90 хувийг нь ажлын байраар хангасан. | |
| | Төрийн байгууллагын сургалтын орчныг сайжруулж, төрийн албан хаагчдыг чадавхжуулах бодлого баримтлана. | Сургалтад хамрагдсан албан хаагчийн хувь | 80 | 95 | 90 | Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, бусад яам агентлагаас зохион байгуулсан сургалтад 150, үндэсний чуулган, хэлэлцүүлэгт давхардсан тоогоор 100 гаруй албан хаагчийг, Удирдлагын академийн эрхэлсэн болон ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 12, мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалтад 22, мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад 32, шинээр томилогдсон албан хаагчдыг чиглүүлэх сургалтад 40 албан хаагчийг тус тус хамруулан мэдлэг ур чадварыг дээшлүүлсэн.<br>Төрийн анхан шатны нэгж дэх удирдлагын чиг үүргийг хэрэгжүүлж буй албан хаагчдын мэдлэг, чадварыг дээшлүүлэх зорилгоор “Төрийн бүтээмжийн сэргэлтийг хэрэгжүүлэх нь” сэдэвт Багийн Засаг дарга нарын нэгдсэн сургалтыг 2022 оны 10 дугаар сард зохион байгуулж 14 сумын 65 багийн Засаг даргыг хамруулж "Төрийн бодлого, нутгийн удирдлага", "бүртгэл, статистик", "төрийн үйлчилгээг иргэдэд хүргэх аргазүй", "хуулиар хүлээсэн үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх нь" бүлэг сэдвүүдээр цогц мэдлэг олгосон.<br>Аймгийн Засаг даргын 2022 оны А/233 дугаар захирамжаар 2022 онд зохион байгуулах сургалт, зөвлөгөөний нэгдсэн төлөвлөгөөг 42 арга хэмжээтэй байхаар төлөвлөн баталж 40 сургалтыг танхим болон цахимаар зохион байгуулж 100,0 сая гаруй төгрөгийг зарцуулж төрийн албан хаагчдыг ажлын байран дээр нь сурган чиглэл бүрээр мэргэшүүлсэн.<br>Аймгийн Засаг даргын Тамгын газарт ухаалаг самбар, лед дэлгэц зэргийг байршуулж 120,0 сая төгрөг, 10 сум, 15 байгууллагын сургалтын танхимд засвар хийх, техник тоног төхөөрөмжөөр хангах зэрэг арга хэмжээнд 30,0 сая гаруй төгрөгийг тус тус зарцуулж цахим хурал, сургалт зохион байгуулах нөхцөлийг бүрдүүлж албан хаагчдын суралцах орчныг сайжруулсан. | 90 |
| | Төрийн албан хаагчийн харилцаа хандлага, ёс зүй, сахилга хариуцлагыг дээшлүүлж, шинэ соёлыг төлөвшүүлнэ. | Болзолт уралдааны шалгуур хангасан байгууллагын тоо | 0 | 35 | 25 | Аймгийн Засаг даргын 2021 оны "Төрийн албан хаагчийн ёс зүй харилцаа, хандлагыг дээшлүүлэх" 01 тоот албан даалгавар гаргаж хэрэгжүүлэн ажиллалсан. 14 сум, Засаг даргын эрхлэх хүрээний 28 агентлаг албан даалгаврын хүрээнд ажлын төлөвлөгөө гаргаж, | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | биелэлтийг хагас, бүтэн жилээр гаргаж үр дүнг нь тооцон хэрэгжүүлсэн.<br>Төрийн албанд шинээр томилогдсон 72 албан хаагч, Алтанширээ сумын 84 албан хаагч, Сайншанд сумын Засаг даргын Тамгын газрын харьяа төсөвт байгууллагын 400 албан хаагч, Сайншанд сумын 13 цэцэрлэгийн 104 албан хаагч, 50 хүний нөөцийн мэргэжилтэн, 9 агентлаг дарга, 8 хэлтэс, тасгийн дарга, 26 мэргэжилтэн, 13 сумын Засаг даргын Тамгын газрын дарга, хууль эрх зүйн асуудал хариуцсан 26 албан хаагч буюу давхардсан тоогоор нийт 779 төрийн албан хаагчдад төрийн албан хаагчийн ёс зүй, сахилга хариуцлагыг дээшлүүлэх, ёс зүйтэй, цогц чадамжтай, шинийг санаачлагч байх, манлайлагч төрийн албан хаагчийг бэлтгэх, төрийн бүтээмжийг нэмэгдүүлэх зорилгоор соён гэгээрүүлэх сургалтыг зохион байгуулсан.<br>Иргэн, хуулийн этгээдтэй харилцах, тэдэнд үйлчилгээ үзүүлэхдээ төрийн албан хаагчдын үйл ажиллагаа, үйлчилгээний үндсэн шаардлагыг тогтоож хэвшүүлэх зорилгоор аймгийн Засаг даргын 2022 оны А/686 дугаар захирамжаар "Дорноговь аймгийн төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчдын үйл ажиллагаа, үйлчилгээний стандарт"-ыг шинэчлэн баталж мөрдүүлж, хяналт тавин, төрийн албан хаагчдын үйл ажиллагаа, харилцаа, ёс зүй, хувцаслалт зэргийн стандартыг тодорхой тусгасан.<br>Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний байгууллагын дэргэд 51 ёс зүйн зөвлөл ажиллаж төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүйн талаар 7 гомдол хүлээн авч шийдвэрлэсэн. | |
| | Төрийн албанд жендэрийн мэдрэмжтэй бодлого хэрэгжүүлнэ. | Жендэрийн мэдрэмжтэй баримт бичгийн хувь | 60 | 80 | 80 | Жендерийн хэвшмэл байдлыг халах, жендерт суурилсан хүчирхийллийн талаар иргэдийн ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлэх чиглэлээр "Жендерт суурилсан хүчирхийллийн эсрэг"-ийн үндэсний сургагч багшаар 1 албан хаагчийг бэлтгэн, 486 иргэд, албан хаагчдад 12 удаагийн сургалт зохион байгуулж, жендерийн тухай ойлголт, жендерт суурилсан хүчирхийлэл, түүнээс урьдчилан сэргийлэх сургалтыг зохион байгуулсан.<br>Хүний эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, жендерийн эрх тэгш байдлыг хангах, ажлын байран дахь ялгаварлан гадуурхалтын аливаа хэлбэрээс урьдчилан сэргийлэх, үл тэвчих орчныг бүрдүүлэх чиглэлээр аймгийн 14 сум, 25 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | агентлаг нь хөдөлмөрийн дотоод журамдаа жендерийн асуудлыг тусгах, хөтөлбөр боловсруулах, өдөрлөг, сургалт зохион байгуулах зэргээр албан хаагчдын хөдөлмөр эрхлэлт болон хөдөлмөрийн харилцаанд жендерээр ялгаварлан гадуурхах, хууль тогтоомжид зөвшөөрснөөс бусад тохиолдолд эрэгтэй, эмэгтэй хүйсийн аль нэгэнд давуу эрх олгохгүй байх жендерийн бодлогыг баримтлан хэрэгжүүлж, хяналт тавин ажилласан. | |
| | Орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулна. | Орон нутгийн өмчит байгууллагын хувь | 89 | 100 | 143 | Засгийн газрын 2020 оны 9 дүгээр тогтоолын дагуу зохион байгуулагдаж буй төрийн болон орон нутгийн өмчийн Улсын үзлэг, тооллогын үйл ажиллагаанд хяналт тавих, тооллогын арга зүйн зөвлөгөө өгөх ажлын хэсгийг аймгийн Засаг даргын 2022 оны 04 дүгээр сарын 18-ний өдрийн А/262 дугаар захирамжаар нийт 13 хүний бүрэлдэхүүнтэй байгуулан, 14 ажил төлөвлөгөөнд тусгагдсанаас 9 арга хэмжээг зохион байгуулж, нийт улсын үзлэг тооллогод 149, Орон нутгийн өмчит байгууллага хамрагдахаас 149 байгууллагад арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.<br>Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 58 дугаар тогтоол, 2022 оны 07/04 дүгээр тогтоолоор 17 байгууллагын ашиглагдахгүй хөрөнгийг акталж данснаас хасах зөвшөөрөл олгон, ашиглах боломжтой илүүдэлтэй 7 байгууллагын 501.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг хэрэгцээтэй байгууллага руу нь балансаас балансад шилжүүлсэн.<br>Дээрх 2 тогтоолоор худалдан борлуулагдахаар батлагдсан 3 сум, 14 байгууллагын 20 ширхэг авто машиныг худалдан борлуулах шийдвэр гарсны дагуу 2022 онд нийт 25 удаагийн нээлттэй дуудлага худалдааг зохион байгуулж нийт 96 оролцогч оролцож, нийт 42,9 сая төгрөгийн төсвийг бүрдүүлэн орлогын төлөвлөгөөг 45 хувиар давуулан биелүүлж тогтоолын хэрэгжилтийг хангаж ажилласан. | 100 |
| ***Үндсэн чиг үүрэг 4.2.*** *Иргэдийг аюулгүй, амар тайван, гамшигийн эрсдэлгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх.* | | | | | | | |
| **Зорилт 4.2.1.**<br><br>Иргэдийн аюулгүй, амар тайван байдлыг хангана. | Улсын хилийн халдашгүй дархан байдал, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг хангах зорилгоор хилийн ангиудад | Хил хамаалах туслах хүчний зөвлөлийн ажлын төлөвлөгө | 97 | 100 | 100 | Хил хамгаалалтад туслах хүчний орон тооны бус зөвлөлийн 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний нийт 7 зорилт, 45 арга хэмжээг хэрэгжүүлж ажиллалаа. Тус арга хэмжээний хүрээнд хилийн цэргийн 0108 дугаар ангийн алба хаагчдын 28 айлын орон сууцны барилгын засвар, Хилийн цэргийн 0129 дүгээр ангийн алба хаагчдын орон сууцны гадна, дотор сантехникийн засвар, | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | орчин үеийн техник, технологийн дэвшлийг нэвтрүүлэх, хилийн торон саадыг шинэчлэх, хилчдийн ажиллах орчин нөхцөлийг сайжруулахад дэмжлэг үзүүлнэ. | өний хэрэгжилтийн хувь | | | | Хилийн цэргийн 0168 дугаар ангийн 0137 дугаар салбарын хариуцсан хэсгийг бүхэлд нь өндөр хүчин чадал бүхий камерын хамгаалалтад шилжүүлж “Цахим салбар” болгоход зориулж аймгийн Засаг даргын захирамжаар анги тус бүрт 50,0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.<br>Хилчдийн ажиллаж амьдрах нөхцөлийг сайжруулах зорилгоор холбогдох төрийн болон төрийн бус байгууллага, Хил хамгаалалтад туслах хүчний орон тооны бус зөвлөлийн байгууллагуудтай хамтран орон нутгийн төсвөөс нийт 160,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар хилийн ангиудын үйл ажиллагааг иргэд олон нийтэд сурталчлан таниулах, хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх нөлөөллийн ажлуудыг хийж гүйцэтгэсэн.<br>Монгол Улсын хэмжээнд мөрдөгдөж байгаа хууль, тогтоомжийг сурталчлах, дотоодын цэргийн алба хаагчдын хуул, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, гарч болох аливаа эрсдлээс урьдчилан сэргийлэх зорилгоор “Хуульчид-Хилд” арга хэмжээг Прокурорын газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Цагдаагийн газар, Тагнуулын ерөнхий газрын Дорноговь аймаг дахь хэлтэс, Хатанбулаг, Хөвсгөл, Улаанбадрах сумын Засаг даргын Тамгын газар, Хатанбулаг сумын Сум дундын цагдаагийн тасаг, Хууль зүйн туслалцааны төвийн хуульчдын холбооны салбартай хамтран зохион байгуулж хилийн ангийн төв, болон цэргийн салбарын бие бүрэлдэхүүнээс гадна хил хамгаалах туслах хүчний гишүүд, хилийн суурьшлын бүсэд үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагуудын алба хаагчдад сургалт мэдээлэл, хууль зүйн зөвлөгөө өгч ажилласан. | |
| **Зорилт 4.2.2.**<br><br>Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлнэ. | Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл болгож, нутаг дэвсгэрийн онцлог, хүн ам, гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдал болон судалгаанд | Төлөвлөсөн ажлын хэрэгжилтийн хувь | 90 | 100 | 100 | ГХУСАЗСЗ-ийн 2022 оны 01 дүгээр тогтоолоор 10 дэд бүлэг 50 арга хэмжээ бүхий заалттай гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж, орон нутгийн төсвөөс нийт 530,0 сая төгрөгийг урьдчилан сэргийлэх ажилд зарцуулан ажилласан.<br>Орон нутгийн хэмжээнд үйлдэгдэж байгаа гэмт, хэрэг, зөрчилд сар, улирал тутамд дүн шинжилгээ хийж өсөлттэй гэмт хэргийг бууруулахад чиглэсэн олон талт арга хэмжээг хэрэгжүүллээ. “Иргэдээ сонсъё”, “Хүүхэд хөгжил-2022”, ”Нээлттэй хаалганы өдөрлөг” зэрэг 28 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | суурилсан ажил, арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлнэ. | | | | | өдөрлөг, улс болон орон нутгийн хэмжээнд хэрэгжүүлсэн “Хүүхэд бүр хайрлагдах эрхтэй”, “Соёлтой жолооч, соёлтой зорчигч”, “Намайг алгас”, “Сэрэмжлүүлье”, “Залилагчид бүү боломж олго” зэрэг 20 гаруй төрлийн нөлөөллийн аян, “Авлигаас урьдчилан сэргийлэх дэвжээ”, “Өсвөрийн сэргийлэгч-2022”, “Замын хөдөлгөөний цагаан толгой”, “Ногоон гэрэл цагаан шугам” зэрэг 10 төрлийн тэмцээн уралдаан, сургалт, сурталчилгаа, зөвлөгөө мэдээллээр дамжуулан төрийн болон хувийн 9450, хувиараа хөдөлмөр эрхлэгч 3200, малчин 8300, оюутан 2300, сурагч 3680, ажилгүй 125,0, (цахим орчинд давхардсан тоогоор 430,0 мянга иргэдэд түгээсэн) нийт 345,0 мянга гаруй иргэдэд хууль, эрх зүйн мэдлэг олгосон.<br>Гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцөлийг арилгах хүрээнд нийт 200 гаруй албан мэдэгдэл хүргүүлж биелэлтийг тооцон ажилласан.<br>Замын-Үүд сумын нутаг дэвсгэрт аймаг, орон нутгийн хөгжлийн сангийн 150,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэж болзошгүй цэгүүдийг камерын нэгдсэн хяналтад бүрэн оруулснаас гадна бусад сумдаас 120,0 гаруй сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар камержуулалт, 350,0 гаруй сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар гэрэлтүүлэг шинээр нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулж иргэд, оршин суугчдын амар тайван, аюулгүй амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлэн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөөг үр дүнтэй хэрэгжүүлэн ажилласан.<br>Аймгийн хэмжээнд 12 сарын байдлаар нийт 621 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үе /490/-с 131 буюу 26,7 хувиар өсч, гэмт хэргийн илрүүлэлт 66,1 хувь байгаа нь өмнөх оны мөн үе /54,7/-с 11,4 хувиар өссөн. | |
| | Хяналтын камерийн нэгдсэн төвийг Сайншанд, Замын-Үүд сумдад байгуулах, бусад сумдад дэвшилтэт технологи бүхий камержуулалтын нэгдсэн системийг нэвтрүүлэх. | Ажлын хэрэгжилтийн хувь | 50 | 100 | 100 | Сумдын хяналтын камерын нэгдсэн судалгааг гаргасан бөгөөд 2024 оныг хүртэл шат дараатайгаар камержуулахаар төлөвлөсний дагуу 2021 онд орон нутгийн хөгжлийн сангийн нийт 139,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Айраг, Алтанширээ, Өргөн, Улаанбадрах, Эрдэнэ, Сайншанд сумдад камержуулалтын болон засварын ажлыг хийснээс олон нийтийн газруудыг 30.7 сая төгрөгийн зардлаар 5 цэгт 16 камер нэмж байрлуулсан. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Цагдаагийн ерөнхий газрын даргын 2020 оны А/48 дугаар тушаалаар батлагдсан “Дүрст бичлэгийн техник хэрэгслийг цагдаагийн байгууллагын мэдээллийн нэгдсэн сүлжээнд холбох журам”-ын дагуу дүрс бичлэгийн техник хэрэгсэлд тавигдах шаардлагыг баримтлан цагдаагийн газрын теле хяналтын нэгдсэн сүлжээнд холбох ажлыг зохион байгуулсан.<br>2022 онд Замын Үүд сумын нутаг дэвсгэрт аймаг, орон нутгийн хөгжлийн сангийн 150,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэж болзошгүй цэгүүдийг камерын нэгдсэн хяналтад бүрэн оруулснаас гадна бусад сумдаас 120,0 гаруй сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар камержуулалт, 350,0 гаруй сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар гэрэлтүүлэг шинээр нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулж иргэд, оршин суугчдын амар тайван, аюулгүй амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлснээр ажлын хэрэгжилт 100 хувийн гүйцэтгэлтэй байна. | |
| | Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг шинэ түвшинд гаргаж, түр хамгаалах байрыг зарим суманд байгуулж, урьдчилан сэргийлэх, нөлөөллийн арга хэмжээг төр, иргэний нийгэм, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан өргөжүүлнэ. | Ажлын хэрэгжилтийн хувь | 50 | 100 | 100 | Хууль зүй, дотоод хэргийн яам болон “Хүүхэд эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх төсөл", “Сайншанд салхин парк” ХХК-тай 2022 онд хамтран 19,0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгээр Сайншанд сумын түр хамгаалах байрны орчин нөхцөлийг сайжруулан, хөгжлийн бэрхшээлтэй, өндөр настай иргэдэд үйлчилгээ үзүүлэх тоног төхөөрөмжийн хангалтыг нэмэгдүүлж, хохирогчдод ганцаарчлан зөвлөгөө өгөх болон чөлөөт цагаа өнгөрүүлэх орчин нөхцөлийг бүрдүүлсэн.<br>Сайншанд, Замын-Үүд сумдын түр хамгаалах байранд 2021 онд 61, 2022 онд 27 иргэнийг хүлээн авч хууль, эрх зүйн зөвлөгөө, өмгөөлөл, эрүүл мэнд, боловсрол, сэтгэл зүйн үйлчилгээг тогтмол хүргэж, гэр бүлд нь эргэн нэгтгэсэн.<br>Хүчирхийллийн шалтгаан нөхцөлийг тогтоох, арилгах чиглэлээр гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгдэж болзошгүй, аюулын зэрэг өндөртэй айл өрхийн судалгааг тухай бүр гаргаж, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж болзошгүй этгээдүүдийг байнгын хяналтад авч, хүчирхийллээс татгалзуулах нөлөөллийн ажил, арга хэмжээг хамтарсан багийн хамтаар зохион байгуулсан. Эдгээр ажлын үр дүнд тухайн зорилтот бүлгийн иргэдэд хяналт тавих, эргэх холбоотой ажиллах боломж бүрдсэн. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх аймгийн дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний дагуу гэр бүл, хүүхдийн хүчирхийлллээс урьдчилан сэргийлэх, хамтарсан багийн үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэх зорилгоор шаардагдах санхүүжилтийг шийдвэрлэж ,бичил төслийн уралдаануудыг хэрэгжүүлэн ажилласнаар зорилтот бүлгийн 3200 гаруй иргэдэд эрх зүйн мэдлэг олгосноос гадна төслийн хүрээнд Даланжаргалан сум, хамтарсан багаас санаачлан түр хамгаалах байрыг шинээр тохижуулан хохирогчдод үйлчилгээ үзүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн. | |
| | Зам тээврийн осол, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үр нөлөөтэй бодлогыг хэрэгжүүлэх замаар замын хөдөлгөөнд оролцогчдын хандлага, соёл, дадал, хариуцлагыг дээшлүүлж, зам тээврийн ослыг бууруулна. | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 80 | 100 | 100 | Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлээр 2022 онд хийж хэрэгжүүлэх үйл ажиллагааны 4 зорилт 26 арга хэмжээ бүхий төлөвлөгөө гарган хэрэгжилтийг хангаж, 36,4 сая төгрөгийг зарцуулсан. Замын сангийн 1,3 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Сайншанд сумын холбогдох 4 газарт авто зам шинээр барих, 3 цэгт авто зогсоол шинээр барих, шинээр баригдсан автозамуудад 7 ширхэг хурд сааруулагч, 64 ширхэг замын тэмдэг тэмдэглэлээ байршуулах, Говьсүмбэр-Замын-Үүд чиглэлийн хатуу хучилттай авто замын Өлзийт, 64, 30, 31, 35-р зөрлөг, Өргөн сумын уулзварын орчим зэрэг 10 цэгт 30 сая төгрөгийн санхүүжилтээр нойр сэргээгч дэржигнүүр байршуулах зэрэг ажлыг хийж гүйцэтгэсэн.<br>Энэ төрлийн гэмт хэрэг, зөрчилд хүүхдүүд өртөж хохирохоос урьдчилан сэргийлэх зорилгоор 9,5 сая төгрөгийн санхүүжилтээр “Ногоон гэрэл, цагаан шугам”, “Замын хөдөлгөөний цагаан толгой”, “Өсвөрийн сэргийлэгч” зэрэг тэмцээн уралдааныг зохион байгуулж шилдгүүдийг шалгаруулан 21 сургууль, 13 цэцэрлэгийн 510 гаруй сурагчдад замын хөдөлгөөний аюулгүй байдлын дүрмийн мэдлэг олгосон.<br>Улс, орон нутгийн хэмжээнд зохион байгуулагдсан “Уусан бол бүү жолоод”, “Аажуу явбал аяндаа хүрнэ дээ”, “Соёлтой жолооч, соёлтой зорчигч” зэрэг нөлөөллийн арга хэмжээний хүрээнд 10-15 удаагийн яриа таниулга, 120 гаруй төрлийн зурагт хуудас, 45 шторк, контент, подкаст ярилцлага, 93 төрлийн сургалт мэдээлэл болон жолоочид хүргэх 6000 ширхэг зурвас, 8000 ширхэг гарын авлага, тараах материалаар дамжуулан иргэдийг эрх зүйн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | боловсрол олгосноос гадна Олон нийтийн 6 цагдааг замын хяналт, шалгалт, хөдөлгөөн зохицуулалтад хүч нэмэгдүүлэн, нийт 40 алба хаагч 24 цэгийн байршилд тогтмол хяналт тавин 21180 зөрчил, согтуу тээврийн хэрэгсэл жолоодсон 1017, эрхийн үнэмлэхгүй явсан 579 зөрчил илрүүлэх, түүнчлэн босоо тэнхлэгийн авто зам дагуух 800 бод малд цацруулагчтай хүзүүвч зүүлгэх зэргээр зам тээврийн осол, хэрэг үйлдэгдэхээс сэргийлж ажилласнаар "Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах" төлөвлөгөөг 100 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжүүллээ. | |
| | Цагдаа олон нийтийн хамтын ажиллагааг эрчимжүүлж, олон нийтийн цагдаагийн ажилтны орон тоог нэмэгдүүлж, ажиллах таатай нөхцөлийг бүрдүүлэн, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг сурталчлах, соён гэгээрүүлэх ажлуудыг зохион байгуулна. | Төлөвлөсөн ажлын хэрэгжилтийн хувь | 50 | 100 | 100 | Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн Тэргүүлэгчдийн 2021 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 11 дүгээр тогтоолоор олон нийтийн цагдаа нарын тоог 33 байхаар баталснаас 2021 онд 22, 2022 онд 13 олон нийтийн цагдаа үүрэг гүйцэтгэн, 38,0 сая төгрөгийн иж бүрэн хөдөлмөр хамгааллын хувцасны хангалт хийж, ажиллах нөхцөлөөр хангасан.<br>Олон нийтийн цагдаа нарт Зөрчлийн болон Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулга, бусад шинээр гарсан эрх зүйн талаар жилд 2-3 удаагийн уулзалт, сургалтыг зохион байгуулж, холбогдох мэдээллийг хүргэсэн.<br>Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх зорилгоор олон нийтийн цагдаа нарыг урьдчилан сэргийлэх бүх төрлийн эргүүл, хяналт шалгалтын ажилд тогтмол үүрэг гүйцэтгүүлж байгаа бөгөөд тэдгээрээс иргэдийг соён гэгээрүүлэх, тэдгээрийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх ажлын хүрээнд төрийн 58 байгууллагын 430 алба хаагч, төрийн бусад 120 байгууллагын 685 ажилтан, малчин иргэд 1420, ажилгүй 2350, нийт 4885 иргэнд хууль, эрх зүйн мэдээлэл хүргэсэн.<br>Олон нийтийн цагдаагийн ажилтнууд нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр хариуцсан нутаг дэвсгэрт үүрэг гүйцэтгэн, хууль тогтоомж зөрчсөн 822 зөрчил илрүүлж, 98 иргэнийг эрүүлжүүлэн саатуулах байранд, 361 иргэнийг ар, гэр асран хамгаалах хүнд нь хүлээлгэн өгч ажилласан.<br>Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр бэлтгэсэн 23,0 мянган ширхэг зурагт хуудас, санамж, сэрэмжлүүлэг, мэдээ мэдээллийг иргэдэд хүргэж, гэмт | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хэрэг, зөрчлийн шинжтэй 830 дуудлагад цагдаагийн албан хаагчдын хамт үүрэг гүйцэтгэсэн. | |
| | Соёл урлагаар дамжуулан олон нийтийг соён гэгээрүүлэх үйл ажиллагааг идэвхжүүлэн, бүх төрлийн донтолтоос урьдчилан сэргийлэх, зөв хэрэглээг төлөвшүүлэх сургалт сурталчилгааны ажлыг хийж, салбар дундын хамтын ажиллагааг бэхжүүлнэ. | Үндэсний хөтөлбөрийн төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 92 | 100 | 100 | Хүүхдийн эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, ажлыг соёл урлагаар дамжуулан сурталчлах, түгээн дэлгэрүүлэх зорилгоор аймгийн Саран хөхөө театрт 10,0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлж “Гэрэл асаа” ёс зүйн драмын жүжгийн уран бүтээл туурвиж 2021-2022 онуудад нийт 3200 гаруй үзэгчдэд хүргэсэн.<br>Эх оронч үзлийг бага наснаас нь ухамсарлуулах агуулгатай "Эх орондоо харих болтугай" жүжгийг сургуулийн өмнөх боловсрол, цэцэрлэгийн 650 хүүхэд, бага ангийн 3400 хүүхэд, дунд ахлах ангийн 3200 хүүхэд үзэж сонирхсоноос гадна нийтэд танигдсан олны танил хүмүүсээр дамжуулан иргэдэд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн мэдээлэл хүргэх зорилгоор “Зогсохгүй” контентийн багтай хамтран "Хүчирхийлэл хүн бүхэнд хамаатай" контентыг цахим орчноор дамжуулан 93,0 мянга гаруй иргэдэд хүргэсэн.<br>Монгол Улсын Ерөнхий сайдын санаачилгаар 21 аймагт шинэ үеийн залуу хамтлаг дуучдаар төлөөлүүлэн хүүхэд, залуучуудыг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн нөлөөллийн ажил, арга хэмжээг 2022 оны 07 дугаар сарын 03-ны өдөр "Тоонот-21" төслийн багтай хамтран тус аймагт зохион байгуулан, орон нутгийн телевиз, сонины газруудтай хамтран 380 гаруй төрлийн мэдээлэл, сурталчилгааны ажлыг иргэдэд хүргэснээс гадна 5,5 сая төгрөгөөр масс мессеж, цахим болон танхимын сургалт, хэлэлцүүлгээр дамжуулан давхардсан тоогоор 72,0 мянга гаруй иргэдийг хамруулж эрх зүйн боловсролыг нь дээшлүүлснээр хөтөлбөрийн төлөвлөгөөг 100 хувьтай хэрэгжүүлсэн. | 100 |
| **Зорилт 4.2.3.** Хууль сахиулах салбарын материаллаг баазыг бэхжүүлэх, алба хаагчдын ажиллах орчин нөхцөлийг сайжруулна. | Барилга байгууламжийг шинээр барих, засвар шинэчлэлт хийх, техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангахад дэмжлэг үзүүлнэ. | Дэмжлэгийн тоо | 2 | 3 | 4 | Аймгийн Засаг дарга 2022 онд Хууль, эрх зүйн хэлтсийн харьяа агентлагууд болох Цагдаагийн газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Шүүхийн шинжилгээний алба болон Тагнуулын хэлтсийн үйл ажиллагаатай танилцан сайдтай байгуулсан гэрээний хүрээнд цаашид хэрхэн ажиллах талаар тодорхой үүрэг чиглэлүүдийг өгсөнөөс гадна хэвийн үйл ажиллагааг нь хангах зорилгоор тодорхой дэмжлэгүүдийг үзүүлсэн.<br>Тухайлбал: аймгийн Цагдаагийн газрын албан бэлэн байдлыг хангах зорилгоор 120,0 сая төгрөгийн өртөг бүхий 1 тээврийн хэрэгсэл, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | газрын албан хэрэгцээнд зориулж 50,0 сая төгрөгийн өртөг бүхий 1 тээврийн хэрэгсэл, Хил хамгаалах салбарт 160,0 сая төгрөг, Тагнуулын хэлтэст 32,0 сая төгрөгийг хөрөнгө санхүүгийн дэмжлэгийг үзүүлж хамтран ажиллалаа. | |
| | Төрийн архивыг стандартын шаардлагад нийцсэн зориулалтын байртай болгож, үндэсний санах ой архивын баримтын хадгалалт, хамгаалалтын нөхцөл, аюулгүй байдлыг хангана. | Стандартын шаардлага хангасан барилгын ажлын гүйцэтгэлийн хувь | 0 | 100 | 70 | Аймгийн Засаг даргын 2021 оны А/364 дүгээр захирамжаар "Төрийн архивын аюулгүй ажиллагааг хангах арга хэмжээний 2021-2024 оны төлөвлөгөө"-г батлуулан, хэрэгжилтийг хяналтад авч ажилласан.<br>Аймгийн Засаг даргын 2022 оны А/561 дүгээр захирамжийн хүрээнд 19.2 сая төгрөгийн санхүүжилтээр Төрийн архивын мэдээллийн технологийн техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийг иж бүрэн шинэчилж, архивын мэдээллийн сангийн аюулгүй ажиллагааг 100% хангасан.<br>Төрийн архивын стандартын шаардлагад нийцсэн байр барих асуудлын судалгаа мэдээллийг гаргасан. | 70 |
| **Зорилт 4.2.4.**<br><br>Уламжлалт бус аюулын хүчин зүйлсийн болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох чадавхыг бэхжүүлж, төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллага, иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ. | Орон нутгийн гамшгаас хамгаалах чадавхыг нэмэгдүүлэн, бэлэн байдлыг хангаж, гамшгийн эрсдэлийг бууруулна. | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 97 | 100 | 100 | Сайншанд сумын ерөнхий зориулалтын мэргэжлийн ангийг чадавхжуулах сургалтыг 11 дүгээр сард зохион байгуулж "Галын аюулгүй байдлын тухай хууль", "Мэргэжлийн ангийн дүрэм", "Гамшгаас хамгаалах бэлтгэл, бэлэн байдал", "Эмнэлгийн анхны тусламж" сэдвүүдээр 130 гаруй ажилтан, алба хаагчийн гамшгаас хамгаалах мэдлэг, ур чадварыг дээшлүүлсэн.<br>Шадар сайдтай аймгийн Засаг даргын байгуулсан төлөөлөн хэрэгжүүлэх гэрээг хэрэгжүүлэх ажлын хүрээнд аймгийн Засаг даргын 2022 оны А/58 дугаар захирамжаар гамшгаас хамгаалах иж бүрэн дадлага, сургуулийг Сайхандулаан, Хатанбулаг сумдад, гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэгийг Мандах Хөвсгөл сумдад зохион байгуулан, сумдын Онцгой комисс, Засаг даргын Тамгын газар, аж ахуй нэгж, байгууллага, иргэдийн төлөөллийг оролцуулж, олон нийтийн оролцоонд суурилсан гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээг хийн, нийт 1432 ажилтан алба хаагч, иргэнийг хамруулсан. | 100 |
| | Олон нийтийн оролцоонд түшиглэсэн гамшгаас хамгаалах арга хэмжээний чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ. | Арга хэмжээний үр дүн, биелэлтийн хувь | 95 | 100 | 100 | "Газар хөдлөлтийн гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, таниулах өдөр"-ийг 03 дугаар сарын 23-ны өдөр, "Гамшгийн эрсдэлийг бууруулах олон улсын өдөр"-ийг "Иргэд олон нийтэд хүргэх эрт сэрэмжлүүлэг, арга хэмжээ" уриан дор 10 дугаар сарын 13-ны өдөр тус тус тэмдэглэн өнгөрүүлж, гамшгаас урьдчилан сэргийлэх, өөрийн болон бусдын амь насыг авран хамгаалахад | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | чиглэсэн дадлага сургалт зохион байгуулж нийт 563 иргэнийг, "Гамшгаас хамгаалах тухай хууль" болон "Галын аюулгүй байдлын тухай хууль", "Гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийлгэх хэрэгцээ шаардлага", "Гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх", "Авргач мазаалай" зэрэг сэдвээр танхимын сургалтыг Сайншанд сумын 11, 12, 13 дугаар цэцэрлэгийн багш, ажилчид, хүүхэд, багачуудын төлөөлөл нийт 144 хүнийг хамруулан зохион байгуулсан.<br>“Аюулгүй амьдрах ухаан”, “Бэлэн бай” сургалтын багцаар зохион байгуулсан танхимын сургалтад Ерөнхий боловсролын сургуулийн 4 багш, 42 сурагчийг хамруулан, болзошгүй гамшиг, ослоос өөрийгөө болон бусдыг авран хамгаалах аргад суралцсан. Болзошгүй гамшиг, аюулт үзэгдлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ сэдвээр ерөнхий боловсролын сургуулийн нийгмийн ажилтан, холбогдох байгууллагуудын мэргэжилтнүүдтэй хамтран 1 удаагийн танхимын сургалт зохион байгуулж, 118 эцэг эх, асран хамгаалагчид зөвлөмж өгсөн.<br>Сайхандулаан, Мандах, Хөвсгөл, Хатанбулаг, Сайншанд сумдад Гамшгаас хамгаалах иж бүрэн сургууль, бэлэн байдлын үзлэг, мэргэжлийн ангийн чадавхижуулах сургалт хийхэд нийт 956 иргэн хамрагдаж, гамшгаас хамгаалах мэдлэгээ дээшлүүлсэн.<br>Сумдын Засаг даргын Тамгын газрын холбогдох албан тушаалтан, багийн Засаг дарга нарт “Үер, уснаас үрсээ хамгаалья” аяны удирдамж, төлөвлөгөөний талаар танилцуулан хэрэгжилтийг хангаж ажиллах, гамшиг, осол цаг агаарын аюулт үзэгдлээс урьдчилан сэргийлэх талаар малчид, иргэдэд өгөх зөвлөмж бүхий 9 төрлийн 700 гаруй сэрэмжүүлэг, мэдээллийг тараасан. | |
| | Цаг агаарын аюулт үзэгдэл, гамшгийн үеийн мэдээллийг амжиж анхааруулах системийг бий болгон, малчид, иргэдэд шуурхай хүргэх ажиллагааг сайжруулна. | Ажлын гүйцэтгэлийн хувь | 98 | 100 | | Аймгийн Засаг даргын Тамгын газрын болон Онцгой байдлын газрын цахим хуудсаар дамжуулан иргэд, малчдыг болзошгүй цаг агаарын аюулт үзэгдлээс урьдчилан сэргийлж, өрхийн бэлэн байдлыг хангахыг анхааруулсан зөвлөмж, мэдээлэл байршуулж, нийт 13000 гаруй хүний хандалтыг авсан.<br>Ус цаг уур орчны шинжилгээний төвөөс цаг агаарын сэрэмжлүүлэг, анхааруулга мэдээллийг хүлээн авч, Гал түймэр унтраах, аврах 17, 23, 33 дугаар ангиуд болон орон нутгийн хэвлэл, мэдээллийн байгууллагуудад | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хүргүүлж 8 удаагийн мэдээ мэдээллийг 10 удаагийн давтамжтайгаар нэвтрүүлсэн.<br>Аймгийн Засаг даргын 2021 оны А/33 захирамжаар 2,1 сая, 2022 оны А/241 дүгээр захирамжаар 2,9 сая төгрөгийг тус тус зарцуулан Мобиком, Скайтел компануудтай гэрээ байгуулж, “Масс мессеж” үйлчилгээгээр дамжуулан байгаль, цаг уурын аюулт үзэгдэл болох цасан болон шороон шуурга, гарч болзошгүй эрсдлээс урьдчилан сэрэмжлүүлэх болон цаг үеийн мэдээллийг нийт давхардсан тоогоор 107359 иргэд, малчдад шуурхай хүргэн ажилласан. | |
| | Мэргэжлийн хяналтын байгууллагын хяналт, шалгалтын хараат бус, шударга, ил тод байдлыг ханган үр нөлөөг нэмэгдүүлж, хяналтыг сайжруулна. | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 96 | 100 | 90 | Аймгийн Засаг даргын 2022 оны А/248 тоот захирамжаар аймгийн Нэгдсэн эмнэлэгт эмчилгээний чанарын хяналт, эрүүл ахуй халдвар хамгааллын хяналтаар, А/560 дугаар захирамжаар Сайншанд сумын 1,2 дугаар багийн 23 аж ахуй нэгж, 14 иргэний хүнс, худалдаа үйлчилгээний газруудад эрүүл ахуй халдвар хамгааллын хяналтаар, Хууль зүй, дотоод хэргийн сайдаас өгөгдсөн үүргийн хүрээнд Хатанбулаг сумын Ханги хилийн боомтод ачаа тээврийн үйл ажиллагаа явуулж буй 27 аж ахуйн нэгжид эрүүл ахуй халдвар хамгаалал, хүнсний чанар стандартын хяналтаар тус тус төлөвлөгөөт бус шалгалт хийж гүйцэтгэсэн.<br>Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны “Танхимын сургалтад шилжих тухай” А/38 дугаар тушаал гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2022 оны А/623 дугаар захирамжаар боловсролын болон сургалтын байгууллагуудын хичээлийн шинэ жилийн бэлтгэл ажилд урьдчилан сэргийлэх хяналт, шалгалтыг 3 удаа хийж давхардсан тоогоор боловсролын салбарын 111 обьектыг хамруулан гарсан зөрчил, дутагдалд улсын байцаагчийн албан шаардлага, зөвлөмж хүргүүлж, биелэлтэд хяналт тавьж ажилласан. | 90 |
| ***Үндсэн чиг үүрэг 4.3***. Хөрш болон өндөр хөгжилтэй орнууд, тэдгээрийн муж, хотуудтай хамтын ажиллагаа хөгжүүлэн, олон тулгуурт гадаад харилцааны бодлогыг хэрэгжүүлж, аймгийнхаа эдийн засаг, нийгмийн хөгжилд дэмжлэг авах нөхцөлийг бүрдүүлэх. | | | | | | | |
| **Зорилт 4.3.1.**<br>Хөрш болон өндөр хөгжилтэй орнууд, олон улсын байгууллагатай хамтын | Хөрш болон өндөр хөгжилтэй орнуудтай уламжлалт харилцаагаа үргэлжлүүлж, шинээр бусад улсуудын муж, хотуудтай хамтын | Гэрээ, санамж бичгийн тоо | 8 | 15 | 13 | Дорноговь аймаг болон Шизуока мужтай найрамдалт харилцаа, хамтын ажиллагаа тогтоосны 10-н жилийн ойн баярыг тэмдэглэн өнгөрүүлж, цар тахлын улмаас зогсонги байдалд орсон хамтын ажиллагаагаа үргэлжлүүлэн Шизуока мужид 13 албан хаагчийг сургаж, Шизуока мужаас 20 гаруй хүний бүрэлдэхүүнтэй | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| ажиллагаагаа өргөжүүлэн, гадаад харилцааны үр өгөөжийг нэмэгдүүлнэ. | ажиллагааг хөгжүүлнэ. | | | | | холбогдох салбарын удирдлага, мэргэжилтнүүдийн 3 удаагийн албан ёсны айлчлал зохион байгууллаа.<br>Мөн найрамдалт хамтын ажиллагаагаа үргэлжлүүлэн ахлах ангийн сурагч солилцоо хөтөлбөрийг хэрэгжүүлж 12 дугаар сард 25 хүүхэд, 2 багш, аймгийн ЗДТГ-ын 1 мэргэжилтнийг Шизуока мужид туршлага судлуулахаар шийдвэрлэсэн. БНХАУ-н Сычуань мужийн Жанжякоу хоттой 2 талын цаашдын хамтын ажиллагааг хөгжүүлэхэд харилцан санал солилцох, ӨМӨЗО-ны Хөх Хотын Гадаад харилцааны албатай гадаад хамтын ажиллагааг сэргээх, БНХАУ-аас Замын-Үүдэд суугаа Ерөнхий консулын газартай муж, хот, хошуудтай хамтын ажиллагаагаа гүнзгийрүүлэх асуудлаар тус тус цахим хурал зохион байгуулж ажилласан.<br>Бүгд Найрамдах Турк Улсын Сакарья хотын захирагчтай аймаг, хотын хооронд боловсрол, эрүүл мэнд, спорт, аялал жуулчлал, түүх, соёл урлагийн салбарт хамтран ажиллах, мэргэжилтэн солилцоо, бизнес эрхлэгчдийн хамтын ажиллагааг хөгжүүлэхэд чиглэсэн төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх зорилгоор ах дүү хотын харилцаа тогтоох, харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлэх тухай харилцан ойлголцлын “Санамж бичиг”-ийг байгуулсан.<br>Оросын Холбооны Улсын Эрхүү мужтай эдийн засаг, нийгэм, шинжлэх ухаан, боловсрол, аялал жуулчлал, соёл урлаг болон бусад салбарт найрсаг, түншлэлийн харилцааг хөгжүүлэх чиглэлээр хамтран ажиллах "Санамж бичиг” байгуулах зөвшөөрөл авахаар аймгийн Засаг даргын 2022 оны 01/1354 дүгээр албан бичгээр, Сайншанд сум, БНХАУ-ын Сычуань мужийн Пенжоу хоттой Найрамдалт харилцаа, хамтын ажиллагааны “Санамж бичиг” байгуулахаар харилцан тохиролцсоны дагуу зөвшөөрөл авахаар аймгийн 2022 оны 01/825 дугаар албан бичгээр холбогдох газарт хүсэлт хүргүүлсэн. | |
| | Төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудыг гадаад орнуудын ижил төстэй байгууллагуудтай холбож, үр ашигтай хамтын ажиллагааг | Хамтын ажиллагаатай байгууллагын тоо | 13 | 20 | 17 | Дорноговь аймаг, Япон улсын Шизуока мужтай найрамдалт харилцаа, хамтын ажиллагаа тогтоосны 10 жилийн ойн хүрээнд Дорноговь аймгийн Сайншанд сумын Ерөнхий боловсролын 5 дугаар сургууль, Япон Улсын Шизуока мужийн Жёохокү сургуультай хамтран ажиллах эхлэлийг тавьж, “Тогтвортой хөгжлийн зорилго (SDG)” сэдвээр панел хэлэлцүүлэгийг зохион байгуулсан бөгөөд | 90 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хэрэгжүүлэхэд бодлогоор дэмжинэ. | | | | | цаашид япон хэлний сургалт, цахим хичээл, багш, сурагч харилцан солилцох хөтөлбөрийг хамтран хэрэгжүүлнэ.<br>Хамтын ажиллагааны гол багана болсон “Ахлах ангийн сурагч солилцох хөтөлбөр”-т хамрагдах 25 сурагч, 3 багш тус мужид хүрэлцэн очиж, шинэ туршлага хуримтлуулах, Япон улсын хэл, соёлтой танилцах аялалыг хийсэн бөгөөд 10 жилийн хугацаанд Шизуока мужийн 165 сурагч, Дорноговь аймгийн 24 багш, 220 сурагч харилцан айлчлалыг тус тус хийсэн.<br>Аймгийн иргэдийн, эрүүл аюулгүй орчинд амьдрах ая тухтай орчин нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор Азийн хөгжлийн банкны 6.3 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Сайншанд сумын Төв цэвэрлэх байгууламжийг энэ онд багтаан ашиглалтад оруулсан ба тус байгууламжийн үйл ажиллагааг хэвийн явуулах, инженер техникийн ажилчдыг чадавхжуулах зорилгоор Шизуока муж, “Жайка” Олон Улсын байгууллагатай хамтран 3 жилийн хугацаатай төсөл хэрэгжүүлж онол, дадлага хэлбэрээр танхимаар болон цахимаар сургалтууд зохион байгуулж байна.<br>Тайлант онд Шизуока мужийн бохир ус цэвэрлэх байгууламжийн салбарын инженер, мэргэжилтнүүд 2 удаа ирж, аймгийн цэвэрлэх байгууламжийн үйл ажиллагаатай газар дээр нь танилцаж, дадлагажуулах ажлыг хийсэн. | |
| | Хүний хөгжил, нийгэм, эдийн засгийн салбарт гадаадын хөрөнгө оруулалтыг татахад дэмжлэг үзүүлнэ. | Гадаадын хөрөнгө оруулалтт ай төсөл хөтөлбөр | 2 | 4 | 3 | Япон улсын Шизуока мужийн төлөөллүүд гадаад хамтын ажиллагааг эрчимжүүлэх, солилцооны хөтөлбөрийг эхлүүлэх зорилгоор Дорноговь аймагт айлчлах үеэрээ 2 жил гаруй зогссон байсан ахлах ангийн сурагч солилцоо, Төрийн захиргааны албан хаагчийн богино хугацааны сургалт, бохир ус цэвэрлэх байгууламжийн албан хаагчдыг чадавхжуулах сургалт зэрэг уламжлал болгон зохион байгуулагдаж ирсэн хөтөлбөрүүдийг дахин хэрэгжүүлэн, цэвэрлэх байгууламжийн чиглэлээр тус мужаас холбогдох мэргэжилтнүүд “Чандмань-Илч” ОНӨХХК-д 2 удаа ирж ажилласан бол Дорноговь аймгийн мэргэжилтэн, инженер техникийн ажилчдаас бүрдсэн тус бүр 6 хүний бүрэлдэхүүнтэй багийн 1-р ээлж энэ оны 10-р сард, 2-р ээлж 12-р сард, төрийн захиргааны чиглэлээр 1 албан хаагч энэ оны 10-р сард 2 долоо хоногийн хугацаанд тус мужийн Засаг даргын Тамгын газарт ажиллаж, чадавхжуулах багц сургалтад хамрагдсан. | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Хятад-Монгол Улсын Дипломат харилцааны 73 жилийн ойн хүрээнд БНХАУ-аас Замын-Үүдэд суугаа Ерөнхий консулын газраас Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад 20,0 сая төгрөгийн мөнгөн тэтгэмжийн дэмжлэг, ӨМӨЗО-ны 6 аймгаас хандивласан 20,0 сая төгрөгийн үнэ бүхий эмнэлгийн хамгаалалтын хувцас, хэрэгсэл, 25 сая төгрөгийн үнэ бүхий “HUAWEI” брендийн ухаалаг самбарыг тус тус хүлээлгэн өгөв. ОХУ-ын ТОП 10 сургуулийн нэг М.К.Аммасовын нэрэмжит Хойд Дорнодын холбооны их сургууль, Арктикийн соёл урлагийн их сургууль, Сахагийн БНУ-ын хөгжмийн их сургуулиудтай урт хугацааны түншлэлийн харилцаа тогтоох, аймгийн хэмжээнд уул уурхай, барилга, дэд бүтэц, мэдээллийн технологийн ажилтнуудыг мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулах, биеийн тамир спорт, урлаг, соёл, орос хэлний багш нарын ур чадварыг нэмэгдүүлэх сургалт, хөтөлбөрүүдийг эхлүүлэх, салбар бүрийн багш, оюутан, сурагч солилцооны хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх зэрэг олон чиглэлээр хамтран ажиллахаар боллоо. | |
| ***Үндсэн чиг үүрэг 4.4.*** *Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагын ажлын уялдаа холбоог хanган орон нутгийн хамгаалалтын тогтолцоог бэхжүүлж, цэргийн албыг иргэний төлөвшил, эх оронч үзэл, хүмүүжлийн үндэс байх бодлогыг хэрэгжүүлэх.* | | | | | | | |
| **Зорилт 4.4.1.** Батлан хамгаалах чиглэлээр гарсан хууль тогтоомжийн биелэлтийг хангах ажлыг тайван болон онцгой нөхцөлийн үед хэрэгжүүлнэ. | Үндэсний аюулгүй байдлыг хангах аймгийн бодлогын баримт бичгийг боловсруулан хэрэгжүүлнэ. | Бодлогын баримт бичгийн боловсруулалтын хувь | 0 | 100 | 98.5 | "Үндэсний аюулгүй байдлыг хангах 2022 оны нэгдсэн төлөвлөгөө"-г боловсруулан баталж 98.5 хувьтай хэрэгжүүлэн ажилласан. | 100 |
| | Батлан хамгаалах салбарын бодлогыг орон нутагт хэрэгжүүлнэ. | Бодлогын хэрэгжилтийн хувь | 60 | 100 | 100 | Батлан хамгаалах бодлого, үйл ажиллагааг сурталчлах зорилгоор БХЯ-тай хамтран тус яамны нээлттэй өдөрлөгийг 2022 оны 05 дугаар сард Сайншанд сум болон Зүүнбаян багт зохион байгуулж цэргийн төв архивын лавлагаа олгох, цэргийн төв эмнэлгийн нарийн мэргэжлийн эмч нарын үзлэг, оношилгоо, цэргийн дуу бүжгийн чуулгын тоглолт, гардан тулааны үзүүлэх тоглолт, уулзалт хэлэлцүүлэг зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэн, батлан хамгаалах салбарын бодлогыг 300 гаруй хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг давхардсан тоогоор 3100 иргэнд хүргэн ажиллалаа. Батлан хамгаалах бодлого, хууль тогтоомжийг орон нутагт сурталчлан “Соёмбо” сонин, орон нутгийн DSB телевиз, аймгийн Засаг даргын Тамгын газрын цахим хуудас, “Өнөөгийн Дорноговь | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | нутгийн мэдээ” сонинд нийт 12 удаа мэдээлэл нийтлүүлсэн.<br>Цэргийн албаны тухай хуулийн дагуу “Хугацаат цэргийн албаны тухай”, “Цэргийн гэрээт алба”, Цэргийн дүйцүүлэх алба”, “Оюутан-цэрэг” сургалт, “Цэргийн бүртгэл” зэрэг 5 төрлийн гарын авлага, материал бэлтгэн ерөнхий боловсролын сургууль төгсөгчид, сум, багийн Засаг дарга нарт албан бичиг болон, албан даалгавраар 1500 ширхгийг хүргүүлэн ажилласан. Ерөнхий боловсролын сургуулийн төгсөх ангийн 120 сурагчдад БХИС, ХСИС-ийн үйл ажиллагаа, сургалтын онцлог, элсэлтийн шалгалтын журмын талаар 1 удаа мэдээлэл хүргэсэн.<br>Аймгийн Засаг даргын 2022 оны А/357 дугаар захирамжаар аймгийн Засаг даргын нэрэмжит аймгийн аварга шалгаруулах Цэрэг-спортын “Дөл” цогцолбор тэмцээний I,II шатны шалгаруулалтыг орон нутагт зохион байгуулж “Тэргүүн байр”-т шалгарсан Сайншанд сумын 5 дугаар сургуулийн тасаг Улсын аварга шалгаруулах тэмцээнд амжилттай оролцож 13 дугаар байр эзэлсэн. | |
| | Орон нутгийн хамгаалалтын тогтолцоог бүрдүүлж, дайчилгааны төлөвлөлтийг шинэчилнэ. | Төлөвлөгөөний шинэчлэгдсэн хувь | 70.6 | 100 | 100 | Орон нутгийн хамгаалалтыг сум, орон нутагт зохион байгуулах бэлтгэлийг хангах үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангах зорилгоор 14 сумдад ОНХ-ын төлөвлөлтийг шинээр боловсруулан тодотголыг хийж мэргэжил арга зүйгээр ханган ажилласан.<br><br>Дайчилгааны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3,9 дүгээр зүйлийн 9.2, 9.4, 18 дугаар зүйлийн 18.1.1, Батлан хамгаалахын сайдын мн/21 дүгээр тушаал, Зэвсэгт хүчний Жанжин штабын дүрмийн 2 дугаар зүйлийн 2.1.3.10 дахь заалт, Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын стратегийн 600/02 удирдамжийн дагуу 2022 оны 05 дугаар сард “Зэвсэгт хүчний ангийг бие бүрэлдэхүүн, техникээр нөхөн хангах” төлөвлөгөөг шинэчлэн, хавсралт тооцоог боловсруулж, Зэвсэгт хүчний Жанжин штабын даргаар батлуулсан. Зэвсэгт хүчний анги, салбаруудтай дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүн, техникээр нөхөн хангах байдлаар тодотгон, тооцоо судалгааг гарган тодотгол хийсэн. | 90 |
| | Хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлж, “Оюутан-цэрэг” | Төлөвлөгдсөн арга хэмжээний | 95 | 100 | 70 | Цэргийн штабаас 2022 онд Оюутан-цэрэг сургалтыг зохион байгуулахаар төлөвлөн бэлтгэл ажлыг ханган ажилласан боловч Батлан хамгаалахын Сайдын шийдвэрээр цуцлагдсан. | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | сургалт, хугацаат цэргийн алба хаагчдын тоог нэмэгдүүлнэ. | гүйцэтгэлийн хувь | | | | | |
| ***Үндсэн чиг үүрэ 4.5.** Төрийн байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүнг дээшлүүлэх* | | | | | | | |
| **Зорилт 4.5.1.** Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын цар хүрээг нэмэгдүүлж, төрийн байгууллагуудын ажлын үр дүнг сайжруулна. | Төрийн албан хаагчдыг хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын чиглэлээрх арга зүйгээр хангаж, мэдлэг ур чадварыг сайжруулна. | Төлөвлөгдсөн арга хэмжээний гүйцэтгэлийн хувь | 95 | 100 | 100 | Хяналт-шинжилгээ, үнэлгээний талаарх ойлголтыг нэмэгдүүлэх, төрийн болон орон нутгийн бодлогын баримт бичгийг хяналтад авах, хэрэгжилтийг эрчимжүүлэх, тайлагнах болон үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ хийх арга зүйд сургах “Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн” аймгийн нэгдсэн сургалт, зөвлөгөөнийг зохион байгуулж, 9 агентлагийн дарга, 8 хэлтэс, тасгийн дарга, 26 мэргэжилтэн, 13 сумын Засаг даргын Тамгын газрын дарга, хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн 69 хүнийг хамруулсан.<br>“Хяналт-шинжилгээ, үнэлгээний талаарх ерөнхий ойлголт”, “Төрийн болон орон нутгийн бодлогын баримт бичгийг хяналтад авах нь”, “Бодлогын баримт бичгийг төлөвлөх, тайлагнах арга зүй” “Цаг төлөвлөлт”, “Төрийн албан хаагчийн нийгмийн баталгаа, сургалтын хөтөлбөр боловсруулах арга зүй”, ““Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журмын өөрчлөлт”, “Төрийн албан хаагчийн ёс зүй, хувцаслалт, сахилга хариуцлага”, “2021 оны үйл ажиллагаанд хийгдсэн хяналт-шалгалтын дүн” зэрэг мэдээлэл арга зүйн зөвлөгөөг өгч ажилласан. | 100 |
| | Төрийн байгууллагуудын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын ажлыг тогтмолжуулж, үр дүнг дээшлүүлнэ. | Төлөвлөгдсөн арга хэмжээний гүйцэтгэлийн хувь | 90 | 100 | 100 | Санхүүгийн хяналт, дотоод аудитын албатай хамтран зүүн бүсийн /Алтанширээ, Дэлгэрэх, Иххэт, Өргөн, Эрдэнэ/ сумдын Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын дарга, төсөвт байгууллагын дарга, нябо, нярав зэргийг хамруулсан сургалтад “Хяналт-шинжилгээ, үнэлгээний талаарх ерөнхий ойлголт”, “Тайлан бичих арга зүй” сургалт мэдээллийг хийсэн.<br>Агентлагийн дарга нарын болон сумдын Засаг дарга нартай хийсэн уулзалтаар хагас болон бүтэн жилийн тайланг ирүүлэх хугацаа, цаг үеийн ажил, анхаарах асуудал, тайланд баримтлах чиглэлийн талаар сургалт, мэдээллийг улирал бүр хийсэн.<br>Аймгийн Нэгдсэн эмнэлэг, Эрүүл мэндийн газрын үйл ажиллагаанд явцын хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж ажилласан. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын баталсан удирдамжийн дагуу Хүнс, хөдөө аж ахуйн газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Мал эмнэлгийн газрын үйл ажиллагаанд хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж, хангалтгүй болон эрчимжүүлэх шаардлагатай гэсэн үнэлэлт дүгнэлтийг өгч, холбогдох удирдлагуудад хариуцлага тооцох саналыг хүргүүлсэн. | |
| | Хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим сангийн ашиглалтыг сайжруулж, баяжуулалт, шинэчлэлтийн ажлыг зохион байгуулна. | Цахим сангийн ашиглалт, баяжуулалтын хувь | 80 | 100 | 100 | Ухаалаг засаглал ТББ-тай хамтран ажиллаж, Хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим сангийн ашиглалтыг сайжруулж, нэмэлтээр 14 сумдын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр болон шинээр батлагдсан аймгийн ИТХ-ын тогтоолоор батлагдсан зорилтот хөтөлбөрийг байршуулсан.<br>Хяналт-шинжилгээ үнэлгээний мэдээллийн цахим санг ашигласнаар төрийн албан хаагчдын ажлын хариуцлага сайжирч, цаг хугацаа хэмнэх, төрийн ажлын бүтээмж тодорхой хэмжээнд нэмэгдсэн. Аймгийн Засаг даргын эрхлэх хүрээний асуудлын 25 агентлаг, 4 төсөвт байгууллага, 14 сумын Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагаанд бүрэн нэвтрүүлж, Хууль тогтоомж тогтоол шийдвэрийн хэрэгжилт, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн жилийн хөгжлийн төлөвлөгөө, дэд болон зорилтот хөтөлбөрийн тайланг хагас болон бүтэн жилээр авч хэвшин, цахим системийг 100% нэвтрүүлсэн. | 100 |
| ***Ерөнхий чиг үүрэг 5. Ногоон хөгжлийн бодлого*** | | | | | | | |
| ***Үндсэн чиг үүрэг 5.1***. *Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглаж, дэвшилтэт техник, технологи нэвтрүүлж, хүрээлэн буй орчны бохирдол, доройтлыг бууруулж, иргэдийн эрүүл орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх.* | | | | | | | |
| **Зорилт 5.1.1.**<br><br>Агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлнэ. | Агаарын бохирдлыг бууруулах өрхийн ухаалаг хэрэглээг бий болгох, цахилгаан халаалтыг дэмжих, дулааны станцын зуухыг утаа баригчтай болгох зэрэг арга хэмжээг судалж хэрэгжүүлнэ. | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | 1 | 12 | 5 | Байгаль орчин, аялал жуулчлалын яамны, Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооноос 427,0 сая төгрөгийн санхүүжилтээр “Чандмань илч” ОНӨХХК-ийн харьяа Сайншанд сумыг дулаанаар хангах 3 зууханд уутат шүүлтүүр, үнс баригч суурилуулах ажлыг "Термомастер" ХХК хийж байна. Температурын хамгаалалттай хавхлага болон үнс зөөвөрлөгч ишнек авчрах ажил хил хаасантай холбогдуулан хүлээгдэж, шатны тавцан болон үнс баригчны дотор дулаалгын ажил хийгдэж ажил 70 хувийн гүйцэтгэлтэй хийгдсэн.<br>Сайншанд сумын агаарын чанарыг 2 бүсэд хувааж, 1-р бүсэд 4368 өрх, 2-р бүсэд 2509 өрхийг хамруулан судалгаа болон бүсэд дагаж мөрдөх журмын төслийг боловсруулан, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | болон аймгийн Засаг даргын хамтарсан тушаалаар батлуулахаар хүргүүлсэн. Байгаль орчин, аялал жуулчлалын яамны 45,0 сая төгрөгийн санхүүжилтээр Агаар дахь тоосны дээж авах зориулалт бүхий явуулын багаж авах ажлыг аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төв гүйцэтгэхээр үнэлгээний хороог байгуулан холбогдох материалыг бүрдүүлэн 12 сард багтаан уг багажийг ашиглалтад оруулах төлөвлөгөөтэйгөөр ажиллаж байна.<br>Эрчим хүчний зохицуулах хорооны 2020 оны 481 дүгээр тогтоолын хүрээнд 2020 онд 2302 өрхийн 1,364,150.10кВт.ц ашиглалтад 103,7 тэрбум төгрөгийн хөнгөлөлт, Засгийн газрын 2020 оны 221-р тогтоолын хэрэгжилтээр аймгийн хэмжээнд 9554 аж ахуйн нэгж байгууллага, 113932 өрх, нийт 123486 хэрэглэгчийг 4,5 тэрбум төгрөгийн хөнгөлөлтөд хамруулсан. | |
| | Орон нутгийн нүүрсний уурхайг түшиглэн сайжруулсан түлшний үйлдвэр байгуулах замаар агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлнэ. | Шахмал түлшийг хэрэглээг хүргэсэн өрхийн хувь | 0 | 10 | 9 | Аймгийн нутаг дэвсгэрт 14 аж ахуйн нэгж нүүрс олборлолт баяжуулалтын чиглэлээр үйл ажиллагаа явуулж олборлож буй нийт нүүрсний 99 хувийг экспортолсон.<br>Орон нутгийн нүүрсний уурхайг түшиглэн сайжруулсан шахмал түлшний үйлдвэр байгуулах ТЭЗҮ боловсруулах тендерийг Эрчим хүчний яамнаас зарласан болович тендер шалгаруулалт хойшлогдсон.<br>Чандмань-Илч, Чандмань бадрал ОНӨХХК, УБТЗ-ын Барилга ашиглалт үйлчилгээний 3-р ангийн нийт 25 уурын зуух ажиллаж, жилдээ 80,0 мянган тн түүхий нүүрс ашиглан иргэд аж ахуйн нэгж, байгууллагыг дулаан, эрчим хүчээр хангаж, мөн айл өрх 5,0 мянган тн, нийт 85.0 мянган тн нүүрсийг Шивээ-Овоо, Бага нуур, Таван толгойн уурхайгаас 98 хувийг, 2 хувийн Даланжаргалан сумын нүүрсний уурхайнуудаас авч ашиглаж байна.<br>Даланжаргалан суманд "Ачир" ХХК, "Говийн шандаст хүлэг" ХХК жилд 1.9 сая тн нүүрс угааж баяжуулах хүчин чадалтай 2 үйлдвэр ашиглалтад орсноос 2022 онд "Говийн шандаст хүлэг "ХХК ажиллаж 0,7 сая тн нүүрс баяжуулан экспортолсон. | 90 |
| **Зорилт 5.1.2.**<br><br>Усны нөөцийг бохирдол, хомсдлоос | Газрын доорх усны чанар, нөөцөд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийн үнэлгээг мэргэжлийн | Арга хэмжээний тоо | 1 | 9 | 4 | Галба-Өөш Долоодын говийн сав газрын захиргаанаас Газрын доорх усны чанар, нөөцөд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийн үнэлгээг мэргэжлийн байгууллагаар хийлгүүлсэн. | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| сэргийлэх, хүн амыг баталгаат ундны усаар хангах нэгдсэн менежментийг сайжруулна. | байгууллагаар хийлгэж, урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээг хэрэгжүүлнэ. | | | | | Дэлгэрэх, Алтанширээ, Даланжаргалан, Хатанбулаг сумдын ундны усны эрүүл ахуйн хамгааллалтын бүс тогтоож хашаажуулан, Өргөн, Эрдэнэ, Сайншанд сумдын эрүүл ахуйн хамгаалалтын бүсийн хашааг засуулж шаардлагад нийцүүлсэн. Сайншанд сумын унд ахуйн усны эх үүсвэр Зээгийн хөтлийн газрын доорх усны орд, Эрдэнэ сумын унд ахуйн усны эх үүсвэр 18-ын худгийн газрын доорх усны орд дээр газар тариалан эрхэлж буй иргэн, ААН-ийн талбайгаас хөрс, усны дээж авч, Ус, цаг уур орчны шинжилгээний төвийн лабораторид шинжлүүлсэн.<br>Зээгийн хөтлийн газар доорх усны ордын тэжээгдлийн мужид цугларсан хур хог хаягдлыг цэвэрлэж газар тариалан эрхлэгч, жуулчны баазын үйл ажиллагаа эрхлэгчдэд одоогийн ашиглаж буй нүхэн жорлонг буулгах, нөхөн сэргээх, стандартын шаардлагад нийцсэн ариун цэврийн байгууламж барих шаардлагыг хүргүүлсэн. | |
| | Сумын төвүүдийн ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийн дэглэмийг нарийвчлан тогтоож мөрдүүлж хэвшүүлнэ. | Эрүүл ахуйн бүс тогтоосон худгийн тоо | 50 | 65 | - | Орон нутгийн усан сан бүхий газрын онцгой хамгаалалтын бүс болон ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүстэй давхцуулан олгосон 139 иргэн, аж ахуйн нэгжийн судалгааг гарган холбогдох газарт хүргүүлсэн. Усны нөөцийг бохирдож, хомстохоос хамгаалах, урьдчилан сэргийлэх зорилгоор Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2022 оны 09 , 11 дүгээр албан даалгавар тус тус гарсантай холбогдуулан усны сан бүхий газар, түүний хамгаалалтын бүс, ойр орчмын 88,5 га талбайг цэвэрлэж, 178,7 тн хог хаягдлыг 29 тээврийн хэрэгсээр төвлөрсөн хогийн цэгт төвлөрүүлсэн. Даланжаргалан сумын 3 аж ахуйн нэгжийн 4, Сайншанд 1 худаг, Дэлгэрэх 1, Мандах 2, Улаанбадрах 2, Алтанширээ 1 худагт эрүүл ахуйн бүсийг шинээр тогтоон хашаажуулж, тэмдэгжүүлсэн. Усны нөөцийг бохирдож, хомстохоос хамгаалах, хөрсний бохирдлыг бууруулах зорилгоор хөрсний бохирдол үүсгэгч хүчин зүйлийн томоохон шалтгаан болж буй 18 нүхэн жорлонг буулган хөрсөнд үзүүлэх сөрөг нөлөө бууруулсан. | 90 |
| | Булаг, шанд, рашааны ундаргын эхийг хамгаалж, тохижуулах ажлыг үргэлжлүүлнэ. | Хамгаалж тохижуулсан булгийн тоо | 68 | 12 | 4 | 2022 онд Гадаргын усан хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлын 12.0 сая төгрөгийн хөрөнгөөр Хөвсгөл сумын “Бөөрийн хурал”, Эрдэнэ сумын “Уртын булаг”, Иххэт сумын “Хөгцөт” булаг, Хатанбулаг суманд ОНХС-ийн 5,3 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар “Хатны булаг” нийт 4 суманд 4 булгийн эхийг хашиж хамгаалж тохижуулан | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | усны сан бүхий газрын ашиглалт, хамгаалалтыг сайжруулсан.<br>Сумдад Усны сан бүхий газрын хамгаалалтын бүсийн дэглэмийг мөрдүүлэх, түүний орчмын газрын хог хаягдлыг цэвэрлэх ажил хийгдсэн. Нийт 52 ААНБ, 404 иргэн, ажилтан, албан хаагчид оролцон булаг шанд, рашааны эхийг хамгаалж тохижуулах, сэргээн засварлах, ойр орчмын 88,5 га талбайн ахуйн хог хаягдлыг цэвэрлэх ажлыг 29 автомашин техник хэрэгслээр, 178,7 тн хог хаягдлыг цэвэрлэн сумдын төвлөрсөн хогийн цэгт төвлөрүүлсэн | |
| | Сумдын ундны усыг чанарын шинжилгээнд хамруулж, цэнгэгжүүлэх төхөөрөмжийг суурилуулах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлж, стандартын шаардлага хангасан ундны усаар хангана. | Цэвэршүүлэх төхөөрөмж суурилуулсан худгийн тоо | 35 | 40 | 55 | Сумдын төвийн хүн амын ундны усанд ашиглаж буй 55 худгийг шинжилгээнд хамруулж цэнгэгжүүлэх төхөөрөмж суурилуулах шаардлагатай гэсэн дүгнэлт гарч, үе шаттайгаар 35 худгийг стандартад нийцүүлсэн. Усны чанар, стандартыг сайжруулах ажлын хүрээнд “Байгаль хамгаалах нөхөн сэргээх зардал”-ын 20,0 сая төгрөгийн санхүүжилтээр Улаанбадрах суманд 1 худаг, Улсын төсвийн 200,0 сая төгрөгийн санхүүжилтээр Алтанширээ суманд 1 худаг, Сайхандулаан сумын 2 худагт ус цэвэршүүлэх, зөөлрүүлэх төхөөрөмж шинээр суурилуулж, Хөвсгөл сумын 1 худгийн цэвэршүүлэх төхөөрөмжийг сэргээн засварласан. | 100 |
| **Зорилт 5.1.3.** Гэр хороолол, аялал жуулчлалын газруудын ариун цэврийн байгууламжийг боловсронгуй болгох жишиг төсөл хэрэгжүүлж, сайн туршлагыг дэлгэрүүлнэ. | Ариун цэврийн байгууламжийг боловсронгуй болгох дэвшилтэт технологийг нэвтрүүлэх нөлөөллийн ажлыг зохион байгуулна. | Сайжруулсан ариун цэврийн байгууламжтай өрхийн тоо | 0 | 500 | 341 | Нүхэн жорлон угаадасны нүхний MNS 5924: 2015 стандартыг сумдад хүргүүлэн, “Өнгө Нэм” ТББ-тай хамтран “Хог хаягдлын менежмент”-ийг сайжруулах сургалтыг 2 удаа зохион байгуулж хог хаягдлыг ангилан ялгах, цуглуулах, шингэн хаягдлын менежмент, стандартын бие засах газрын чиглэлээр мэдээлэл сургалтыг иргэд, аж ахуйн нэгж байгууллагын төлөөлөл 130 хүнийг танхимаар, 14 сумын ЗДТГазар, төрийн байгууллагуудын дарга эрхлэгч 70 хүнийг цахимаар тус тус сургалтад хамруулсан.<br>Хөрсний бохирдол үүсгэгч хүчин зүйлийн томоохон шалтгаан болж буй нүхэн жорлонгийн хэрэглээг бууруулах, цаашлаад зогсоох чиглэлээр Мандах сумын гэр хорооллын 80 өрхийн нүхэн жорлонг булшилж, орчин үеийн стандартын шаардлага хангасан боловсон ариун цэврийн байгууламж суурилуулсан.<br>Гэр хорооллын 60 айл өрх, 13 аж ахуйн нэгж, байгууллагын стандартын шаардлага хангасан /соруулдаг/ ариун цэврийн байгууламж, 15 өрх био 00-той болж, 61 өрх | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | төвлөрсөн шугам сүлжээнд холбогдож, 112 айл өрх ариун цэврийн байгууламжаа шинэчилж, хөрсний бохирдлыг бууруулсан. | |
| | Хөрс бохирдуулагч эх үүсвэрийг бууруулахад олон нийтийн оролцоог эрчимжүүлнэ. | Мэдээлэл сурталчилгаанд хамрагдсан ААНБ, иргэдийн тоо | 1500 | 1500 | 1700 | "Өнгө Нэм" ТББ-тай хамтран "Хог хаягдлын менежмент" 2 удаагийн сургалтад 200, "Намрын ногоон өдрүүд", төрийн байгууллагуудын "Нээлттэй хаалганы өдөрлөг" зэрэг олон нийтийг хамарсан 6 арга хэмжээнд 1500 гаруй гарын авлага, хөрсний бохирдлыг бууруулахад иргэдийг уриалах зорилгоор өрхийн ариун цэврийн байгууламжийг байгаль орчинд ээлтэйгээр шийдэх 3 удаагийн зөвлөмж чиглэл, Био 00 болон стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжийн хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр 25 постер, 3 видео танилцуулга, зурагт хуудсыг хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, байгууллагын цахим хуудсаар олон нийтэд хүргэж, 12000 гаруй хандалт авсан.<br>Сайншанд сумын 8 дугаар багийн нутагт "Эко говь" төслийн хүрээнд худалдаа, үйлчилгээний 6 газар, 2 зах, 7 нийтийн орон сууц, 4 сургууль, 14 цэцэрлэгийн орчимд 33 ширхэг ангилан ялгах хогийн сав байршуулж, 80 тн хогийг төвлөрүүлэн, 400 тн хогийг дахин боловсруулж, 450 гаруй сандал, хашааны шон, таг, авто зогсоолын хөдөлгөөн хязгаарлагч зэргийг үйлдвэрлэн зах зээлд нийлүүлсэн. | 100 |
| | | Ариун цэврийн байгууламжийн тоо | 150 | 150 | 168 | Хөрсний бохирдол үүсгэгч хүчин зүйлийн томоохон шалтгаан болж буй нүхэн жорлонгийн хэрэглээг бууруулахад анхаарч Байгаль орчин, аялал жуулчлалын яамны 200,0 сая төгрөгийн санхүүжилтээр Мандах сумын гэр хорооллын 80 өрхийн нүхэн жорлонг булшилж, орчин үеийн стандартын шаардлага хангасан боловсон ариун цэврийн байгууламж суурилуулсан.<br>Гэр хорооллын 60 айл өрх, 13 аж ахуйн нэгж, байгууллагын стандартын шаардлага хангасан /соруулдаг/ ариун цэврийн ариун цэврийн байгууламж, 15 өрх био 00-той болж, 61 өрх төвлөрсөн шугам сүлжээнд холбогдсон. | 100 |
| **Зорилт 5.1.4.** Ан амьтдын амьдрах орчныг тэтгэх, нүүдлийн замыг чөлөөлөхөд иргэн, аж ахуйн | Зарим сумдад сэргээгдэх эрчим хүчээр ажилладаг худаг гаргах, бороо цасны ус хуримтлуулах хөв | Усан хангамжийг нэмэгдүүлсэн тоо | 0 | 4 | 6 | Иххэт суманд "Болор оюун жонш" ХХК-ийн 2,0 сая төгрөгийн санхүүжилтээр агнуурын бүс нутаг "Хамар ус", "Хар цав" нэртэй газруудад 2 тонны багтаамжтай 2 хөв, Хөвсгөл суманд "Сора интернэшнл" ХХК нь 35,0 сая төгрөгийн хувийн хөрөнгөөр зэрлэг ан амьтны усалгаанд зориулан сэргээгдэх эрчим хүчээр ажилладаг автомат | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| нэгжийн оролцоог нэмэгдүүлнэ. | цөөрөм байгуулж зэрлэг амьтдын ус хангамжийн эх үүсвэрийг бүрдүүлнэ. | | | | | системтэй 1 худаг шинээр, Хатанбулаг сумын орон нутгийн хөгжлийн сангийн 5,3 сая төгрөгийн санхүүжилтээр "Хатны булаг"-ийн эхийг хашиж хамгаалах ажлын хүрээнд шинээр 1 хөв цөөрөм, 2 хөв цөөрмийг сэргээн, Сайхандулаан, Хатанбулаг сумдын 2 иргэн энгийн уурхайн 2 худагт сэргээгдэх эрчим хүчний төхөөрөмж суурилуулж бэлчээрийн усан хангамж, зэрлэг амьтдыг ундаалах боломжийг тус тус бүрдүүлсэн.<br>Бэлчээрт нийт 3202 худаг ашиглагдаж, нийт бэлчээрийн 40,3 хувийг усжуулдаг бөгөөд үүнээс 6 худаг сэргээгдэх эрчим хүчээр ажиллаж байна. | |
| | Дэд бүтэц, бүтээн байгуулалтын төслүүдийг хэрэгжүүлэхэд ан амьтдад үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах бодлогыг хэрэгжүүлнэ. | Ажлын гүйцэтгэлийн хувь | 0 | 100 | 100 | Даланжаргалан, Иххэт, Өргөн, Сайншанд сумдад 544 боодол өвсийг бэлтгэж, зэрлэг амьтдын тархац газруудад байршуулан био техникийн арга хэмжээг хэрэгжүүлж 10 удаагийн эргүүлийн ажлыг хийж өргөс тор авах, нүхэн гарцыг чөлөөлөх ажлуудыг гүйцэтгэсэн. ‘’Оюу Толгой’’ ХХК-ийн санхүүжилтээр Байгаль, зэрлэг амьтдыг хамгаалах нийгэмлэгээс “Зэрлэг амьтдын нүүдлийн замд тулгарч буй нөлөөллийг бууруулах төсөл”, “Хууль бус антай тэмцэх төсөл”-үүдийг хэрэгжүүлсэн. “Өмнийн говийн бүс нутагт хууль бус ан тэдгээрийн эд, эрхтэн бүтээгдэхүүний хууль бус худалдаатай тэмцэх" төслийн хүрээнд Зэрлэг амьтдын хууль бус анг бууруулах, улмаар таслан зогсоох зорилго бүхий уг төсөл Хатанбулаг, Хөвсгөл, Улаанбадрах, Эрдэнэ, Өргөн, Мандах сумдад хэрэгжиж хяналт шалгалтын ажлуудыг зохион байгуулсан.<br>“Улаанбаатар төмөр зам” ХНН, “Газрын тос боловсруулах үйлдвэр”, “Бишрэлт түшлэг” ХХК, “Алтраг Ахас” ХХК, “АНУ майнинг” ХХК, “Төвшин” ХХК, “Mongolia флюр спар” ХХК-иудад зэрлэг ан амьтдад биотехникийн арга хэмжээ авах, амьдрах орчныг тэтгэж хөв, цөөрөм байгуулах, хууль бус үйл ажиллагаатай тэмцэх талаар санал зөвлөмж хүргүүлэн, зэрлэг амьтдыг хамгаалах, нүүдлийн замыг чөлөөлөх зорилгоор төмөр замын 825, 914, 958 дугаар тэмдэгтийн 1.5 км газарт хоёр талын торыг чөлөөлсөн.<br>Хатанбулаг, Улаанбадрах сумдын иргэд, малчдын санал, хүсэлтийн дагуу төрийн байгууллагаас Зүүнбаян-Ханги чиглэлийн төмөр зам, Тавантолгой-Ханги чиглэлийн авто замын бүтээн байгуулалтын ажил гүйцэтгэж буй 21 компанийн төлөөлөлтэй уулзалт, хэлэлцүүлгийг зохион | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байгуулж, мал, амьтан чөлөөтэй нүүдэллэх гарц гармын хоорондын зайг ойртуулах, олшруулах, тор, хашлага хийхгүй байх шаардлагыг тавьснаар 600 гаруй хулан адуу, 1200 гаруй цагаан зээр чөлөөтэй нэвтрүүлсэн. | |
| **Зорилт 5.1.5.** Хог хаягдлын менежментийг сайжруулж, дахин боловсруулах үйлдвэрлэлийг дэмжинэ. | Зарим сумдын хог хаягдлыг ангилан төвлөрүүлэх , аюултай хог хаягдлыг цуглуулах цэг байгуулна. | Төвлөрүүлсэн аюултай хог хаягдал /тн/ | 100 | 200 | 195 | Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны санхүүжилтээр аюултай хаягдал түр хадгалах агуулахын барилга угсралтын ажлыг гүйцэтгэгч “Цомбон тоосго” ХХК гүйцэтгэж барилга байгууламжийг байнгын ашиглалтад өгөх улсын комисс ажиллуулахаар захиалгыг хүргүүлсэн. Аймгийн Засаг даргын 2022 оны А/312 дугаар захирамжаар аюултай хог хаягдлын тооллого зохион байгуулахаар удирдамж, маршрутыг батлуулан ажиллаж шатахуун, томилолтын зардалд 1.4 сая төгрөг зарцуулсан. Аймгийн хэмжээний 14 сумын 17 эрүүл мэндийн төв, Замын-Үүд суман дахь Гаалийн газар, ашигт малтмал газрын тосны газрын харьяа Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨҮГ, уул уурхайн олборлолт, баяжуулалтын чиглэлээр авто засвар, тээвэр, авто замын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 25 аж ахуйн нэгж, нийт 32 аж ахуйн нэгж байгууллагад хадгалагдаж байгаа 130 нэр төрлийн 66.4 тн хатуу, 31.6 тн шингэн хаягдлыг бүртгэж тооллогод хамруулсан. Хадгалагдаж байгаа аюултай хаягдлыг дийлэнхийг химийн бодисын сав баглаа боодол, ашигласан тос масло эзэлж байна. Бүртгэлд хамрагдсан аж ахуйн нэгж байгууллагуудад аюултай хог хаягдлыг эх үүсвэр дээр нь хууль журмын дагуу түр хадгалах, эрх бүхий этгээдэд шилжүүлж дахин боловсруулах, устгуулах зөвлөмжийг албан бичгээр хүргүүлсэн. Аймгийн Засаг даргын 2022 оны А/309 дүгээр захирамжийн дагуу Айраг, Иххэт, Замын-Үүд сумын 1-р сургууль, Өргөн, Сайншанд сумын 1,2,3,5 дугаар сургуульд хадгалагдаж байсан 257 нэр төрлийн химийн хорт болон аюултай 750 кг хуурай, 310 литр шингэн, 216 ширхэг бохирдсон сав баглаа боодлыг "Түмэн-Эгшиг" ХХК-тай гэрээ байгуулан зориулалтын байгууламжид саармагжуулан шатааж устгасан. 2021-2022 онд эрүүл мэндийн салбараас 97.9 тн, Уул уурхайн салбараас 4 тн, Боловсролын салбараас 1.1 тн нийт 103 тн аюултай хог хаягдлын зориулалтын байгууламжид устгаж, уул уурхайн салбараас 97.7 тн аюултай хаягдлыг дахин боловсруулж, уул уурхайн салбар 36.7 тн, гаалийн байгууллага 5.5 тн нийт 42.2 тн аюултай хаягдлыг хаягдлыг | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | савлаж хадгалж байна. Эрүүл мэнд, сорилт шинжилгээ, Уул уурхайн баяжуулалт, авто засвар, зам барилгын үйл ажиллагаа явуулдаг нийт 32 аж ахуйн нэгжийг аюултай хог хаягдал үүсгэгчийн бүртгэлд бүртгэж дугаар олгосон. | |
| | Хог хаягдлыг цэвэрлэх, ангилах, цуглуулах арга хэмжээг хэрэгжүүлж, дахин боловсруулах үйлдвэрлэлийг бодлогоор дэмжинэ. | Үйлдвэрийн тоо/дахин боловсруулсан хог | 1/2 70тн | 2/2000 тн | 1/200 | 2021-2022 онд Нийтийн эзэмшлийн гудамж талбайд бүх нийтийн хог цэвэрлэгээг цэвэрлэгээг сар бүрийн 25, тэмдэглэлт болон томоохон баярын арга хэмжээний өмнө буюу 91 удаагийн цэвэрлэгээнд давхардсан тоогоор 3250 аж ахуйн нэгж, байгууллага, 21063 иргэнийг хамруулан, 8500 га талбайн 3240 тн хог хаягдлыг хогийн цэгт төвлөрүүлсэн. Ахуйн хог хаягдлыг цуглуулах, түр хадгалах 280 хогийн бункерыг байршуулан, 39 хог зөөврийн автомашин, 123 үйлчилгээний ажилтан ажиллаж, нийт айл өрх аж ахуйн нэгж байгууллагаас 300.0 мянган тн хог хаягдлыг төвлөрсөн хогийн цэгт зөөвөрлөж дарж булшилсан. Дэлгэрэх, Мандах, Эрдэнэ, Өргөн, Улаанбадрах сумдууд хог хаягдлын төвлөрсөн цэгийг түрж булшлах, Алтанширээ, Замын-Үүд, Хатанбулаг, Хөвсгөл, Сайншанд сумдад улс, орон нутгийн 892,8 сая төгрөгийн хөрөнгөөр хог зөөврийн 19 автомашин шинээр худалдан авч хог хаягдлыг цуглуулж тээвэрлэж байна. Иргэн аж ахуйн нэгж байгууллагууд хуванцар 80, гялгар нийлэг хаягдал 40, цаас кардон 45, лааз 25 тн-ыг ангилж цуглуулан Эко Говь дахин боловсруулах үйлдвэр, Улаанбаатар хотын дахивар хаягдлын цэгт нийлүүлсэн. Шилээ дахин амьдруулъя аяны хүрээнд архи пивны 57000, хүнсний ногооны 7000 ширхэг шилийг цуглуулж дахин ашиглалтад шилжүүлж мөн гудамж талбайгаа 20 тн хаягдал шилийг цуглуулж Улаанбаатар хотын дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлсэн. Эко говь дахин боловсруулах үйлдвэрийн үйл ажиллагаанд шаардлагатай түүхий эд, нөөцийг бүрдүүлэх зорилгоор худалдаа, үйлчилгээний 6 газар, 2 зах, 7 нийтийн орон сууц, 4 сургууль, 14 цэцэрлэгийн орчимд нийт 33 ширхэг ангилан ялгах хогийн сав байршуулж дахивар хаягдлыг ангилж төвлөрүүлсөн. Сайншанд сумын наадмын талбайн үзэгчдийн суудлыг шинэчлэхээр Эко Говь дахин боловсруулах үйлдвэрийн хуванцар нийлэг хаягдлыг дахин боловсруулж хийсэн сандалын савхан бэлдэц 1520 ширхэгийг худалдан авах суурилуулахад зориулан 13.0 сая төгрөг зарцуулсан. | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| **Зорилт 5.1.6.**<br>“Ногоон Дорноговь” арга хэмжээг хэрэгжүүлж, ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлнэ. | Ногоон байгууламжийг нэмэгдүүлж, мод тарьж, ургуулсан иргэд, аж ахуйн нэгжийг дэмжиж, урамшуулна. | Тарьсан модны тоо, урамшуулсан иргэд, ААНБ | 45000/10 | 45000/10 | 13.287/712 | Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар орон даяар өрнүүлж буй “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнд нэгдэж 20 сая мод тарих зорилт тавин, 14 сум 237990, уул уурхайн компани 27854, сайн дурын холбоод 1000, “Их сумт хайрхан” ХХК 22450, “Оюу гарден” ХХК 3200, “Шамбала инженеринг” ХХК 32000, "Борхойн Баян бүрд" ОНӨААТҮГ 50055, Зэвсэгт хүчний 366-р анги 400, нийт 374949 ширхэг мод тарьж, ургуулсан. Хашаатай өрх бүрийг 5-аас доошгүй модтой болгох зорилгоор тус аймгаас сонгогдсон УИХ-ын гишүүдийн санаачилгаар 30,0 сая төгрөгийн шагналын сантай “Ногоон Дорноговь” аяныг зарлаж, 80 өрх, 5 аж ахуйн нэгж байгууллага, Сайншанд, Замын-Үүд, Иххэт сумдад орон нутгийн онцлог, давуу талд түшиглэн ургуулах боломжтой олон төрлийн мод тарьж ургуулсан 5 иргэн, 2 аж ахуйн нэгжийг шагнаж тус тус шалгаруулан урамшуулсан.<br>“Эрдэнэс таван толгой” ХК, Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний жанжин штаб "Сая тонн - Сая мод" хөтөлбөрийг хэрэгжүүлэн Зүүнбаян-Таван толгой чиглэлийн 416 км төмөр зам дагуу байгуулсан ойн зурваст 3 төрлийн 500 ширхэг, улсын чанартай авто зам дагуу 49 байгууллага 3 төрлийн 650 ширхэг модыг тарьж хашаажуулсан.<br>Хавар, намрын мод тарилтаар давхардсан тоогоор 3244 өрх 9 төрлийн 20259 ширхэг мод, 712 ААНБ,10043 иргэн, 22.1 га талбайд 14 төрлийн 185190 ширхэг мод, нийтийн эзэмшлийн 16.9 га талбайд 7 төрлийн 55646 ширхэг модыг суулгаж нийт 45.5 га талбайд 261095 ширхэг мод тарьж ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлсэн. | 90 |
| | Мод үржүүлгийн газруудын үйл ажиллагааг дэмжиж заган ой, ховор ургамлыг хамгаалах, нөхөн сэргээх ажилд иргэд, төрийн бус байгууллагуудын оролцоог идэвхжүүлнэ. | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | 1 | 10 | 6 | “Борхойн Баян Бүрд” ОНӨААТҮГ-ын мод үржүүлгийн талбайн хүлэмжид говийн ховор ургамлууд болох хармаг, сухай, жигд зэрэг 4 төрлийн ургамлыг 320 м² талбайд үрээр болон мөчрөөр үрслүүлсэн. Мөн ховор бутлаг ургамлын үрийн нөөцийг бүрдүүлэх ажлыг зохион байгуулж хайлаас модны 3 кг, загийн 1 кг үр, сухай модны 500 ширхэг мөчир бэлтгэж үр, суулгацын нөөцийг бүрдүүлсэн.<br>Сайншанд сумын “Гэр бүлийн талбай”, “Залуучуудын талбай”, 4 замын уулзвар, 1-р 58 айлын зүүн тал болон авто зам дагуу, “Жаргалан” хүүхдийн зуслан, нийт 5,34 га газарт талхлагдсан хөрсийг ургамалжуулах зорилгоор цэцгийн мандлын үр, замын эко хавтанд царгасын үр | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | суулгах ажлыг 14 цэцэрлэгийн багш ажилчид хийж гүйцэтгэн, байнгын усалгаа, арчилгааг “Тохижилт-Сайншанд” хот тохижилтын газар хийж ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлсэн.<br>“Монцемент Бюлдинг Материалс” ХХК Өргөн сумын цэцэрлэгт хүрээлэнд хармагны модыг тарьж нутагшуулахаар "Чонон хармаг", "Ямаан хармаг" нийт 3000 ширхгийг тарьж ургуулсан.<br>Даланжаргалан сумын “Чойрын богд ХХК-ийн 3,3 га, Сайншанд сумын “Мөрөөдлийн говь” ХХК-ийн 10 га, Хилийн цэргийн 0168-р ангийн 0,4 га, Зэвсэгт хүчний 336 дугаар ангий 30 га талбайд “Мод үржүүлэг-Агро экологийн төв”, Сайншанд сумын 1 иргэн “Зээгийн хөтөл”-д 10 га, нийт 55,7 га талбайд мод үржүүлгийн газар шинээр ашиглалтад оруулан, говийн унаган ургамал заг, сухай, алтан харгана, буйлс, хайлаас, улиас зэрэг модны 1,4 сая гаруй үрсэлгээг амжилттай хийж, хаврын тарилтад ашиглах нөхцөлийг бүрдүүлсэн. Ханги хилийн боомтод мод үржүүлгийн газар, бортого үйлдвэрлэх цех байгуулах иргэний санаачилгыг дэмжиж, 2 га газар олгосон ба цахилгааны асуудлыг шийдвэрлэсэн.<br>“Арвин РММС” ХХК жимс, жимсгэнийн агро парк 30 га талбайд байгуулахаар зураг төсөв, ТЭЗҮ-ийг боловсруулан дэд бүтэц шийдвэрлэхэд шаардлагатай техникийн нөхцөл авах хүсэлтийг холбогдох газруудад хүргүүлсэн. | |
| **Зорилт 5.1.7.**<br>Уул уурхайн олборлолт, дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажил болон эзэн холбогдогчгүй эвдэрсэн газрыг нөхөн сэргээх ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ. | Эзэн холбогдогчгүй эвдэрсэн газрын тооллого, судалгааны ажлыг мэргэжлийн байгууллагатай хамтран тогтмол зохион байгуулж, нөхөн сэргээлтийг үе шаттайгаар хийнэ. | Нөхөн сэргээсэн талбай хэмжээ | 30 га | 30 га | 30 га | Байгаль орчны судалгаа, шинжилгээний “Жэмр” ХХК-тай 2021 онд гэрээ байгуулан, 13 сумын нутагт эвдэрсэн газрын тооллого, судалгааны ажлыг гүйцэтгүүлж, 148 байршил газрын 3545 га талбай бүртгэлд хамруулан, тооллого, судалгааны үр дүнг танилцуулах, байгаль орчин, уул уурхай, нөхөн сэргээлтийн чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээний талаар танхимын 2, цахим 5 удаагийн уулзалт, сургалтыг зохион байгуулж, давхардсан тоогоор төрийн байгууллагын 261 төлөөллийг хамруулсан.<br>Аймгийн хэмжээнд уул уурхай, дүйцүүлэн хамгаалах, төмөр замын бүтээн байгуулалт хийгдсэнтэй холбоотой техникийн 403.36 га, биологийн 2 га талбайд 821276.1 мян.төгрөгийн зардлаар техникийн нөхөн сэргээлт хийсэн байгааг мэдээллийн санд оруулсан. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Уул уурхайн олборлолт болон төмөр зам, авто зам, барилга байгууламж барихтай холбоотой эвдэрсэн газруудыг нөхөн сэргээнэ. | Нөхөн сэргээлтийн хувь | 95 | 100 | 95 | Уул уурхайн ашиглалт, хайгуулын үйл ажиллагааны явцад эвдэгдсэн газрын нөхөн сэргээлт хийгээгүй “Саруул сайн” ХХК, “Дуулгант эко” нөхөрлөл, “Казмон контакт” ХХК, “Чандмань илч” ОНӨХХК-иудтай холбоотой хэрэг бүртгэлтийн хэрэг нээн мөрдөн шалгах ажиллагаа явуулсан.<br>Ханги-Зүүнбаян" чиглэлийн 222.6 км төмөр замын бүтээн байгуулалтын ажлын хүрээнд Хөвсгөл, Хатанбулаг сумдын нутагт ашигласан 20 карьерын 350.66 га-г, Даланжаргалан-Бор-Өндөр чиглэлийн 50.2км хатуу хучилттай автозамд ашигласан 7 карьерын 34.38 га-г, Нийт 385.04 га талбайн техникийн нөхөн сэргээлтийг холбогдох сумд тус тус хүлээн авсан.<br>Уул уурхайн компаниуд дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд техникийн 18.32 га, биологийн 2 га талбайд 87,4 сая төгрөгийн хөрөнгөөр нөхөн сэргээлт хийж орон нутагт хүлээлгэн өгч актаар баталгаажуулсан. | 90 |
| **Зорилт 5.1.8.** Сайн дурын байгаль хамгаалагчдыг дэмжиж, байгаль орчны чиглэлээр ажиллах иргэд, олон нийтийн оролцоог идэвхжүүлнэ. | Иргэний нийгмийн байгууллагатай хамтран иргэдэд экологийн боловсрол олгох ажлыг эрчимжүүлнэ. | Зохион байгуулсан сургалтын тоо, хамрагдсан хүний тоо | 3/3 600 | 3/8000 | 10/ 18248 | Нутаг орноо танин мэдэх, бахархах үзлийг төлөвшүүлэх зорилгоор “Хүн болох багаасаа”, “Говь нутгийн бахархал”, “Ёс суртахуун”, “Эко цэцэрлэг”, “Гэрээр суралцах” хөтөлбөрт арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж, 1211 хүүхэд, 30 гаруй багшийг оролцуулсан.<br>Аймгийн “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөл”-өөс хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, энэ төрлийн гэмт хэргийн хор уршгийг иргэд, олон нийтэд таниулах, тэдний эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, соён гэгээрүүлэх зорилгоор зохион явуулсан “Байгалиа хамгаалъя” нэгдсэн арга хэмжээг хэрэгжүүлж, “Миний дуу хоолой байгалийг хамгаалж чадна” аян, “Байгалиа бүтээе”, "Монголын баялаг 330" төсөл, “Эко орчныг бүтээх жил”-ийн аян нөлөөллийн арга хэмжээг хэрэгжүүлсэн.<br>Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ялган ангилах нөлөөллийн арга хэмжээг "Эко говь" төсөлтэй хамтран хэрэгжүүлж, 75 удаагийн нөлөөллийн ажлыг цахим орчинд өрнүүлж, 42769 орчим иргэнд мэдээлэл өгч, гарын авлага материалаар хангасан.<br>Иргэдийн экологийн боловсролыг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан 10 төрлийн томоохон сургалт, арга хэмжээнд давхардсан тоогоор 18248 иргэн, 140 гаруй багш хамруулсан. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Байгаль хамгаалах сайн дурын идэвхтэн байгаль хамгаалагчдыг ажиллуулж, урамшуулна. | Шинээр томилогдсон хүний тоо | 20 | 80 | 55 | Алтанширээ, Даланжаргалан, Иххэт, Мандах, Сайншанд, Сайхандулаан, Улаанбадрах, Хатанбулаг, Эрдэнэ, Өргөн, Хөвсгөл, Замын-үүд сумдын нутагт хамаарах орон нутгийн тусгай хамгаалалттай нэр бүхий 31 газрын 584037.51 га талбайг хариуцан ажиллах 55 иргэнтэй гэрээ байгуулан, салбарын хууль тогтоомж, дүрэм журмын шинэчлэл, цаг үеийн мэдээ мэдээллээр хангаж, 4 удаагийн цахим, 1 удаагийн танхимын сургалт арга хэмжээнд оролцуулан, байгаль хамгаалагчаар томилж үнэмлэх олгосон. | 100 |
| **Зорилт 5.1.9.** Аймгийн Тусгай хамгаалалттай газар нутгийн стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлж, газар нутгийн хэмжээг нэмэгдүүлнэ. | Тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг 32 хувьд хүргэж, холбогдох мэдээллийн санд бүртгүүлэн баталгаажуулж, хамгаалалтыг сайжруулна. | Тэмдэгжүүлсэн газрын тоо | 15 | 35 | 32,9 | Улаанбадрах, Мандах, Иххэт, Сайншанд, Даланжаргалан сумдын улс, орон нутгийн тусгай хамгаалалттай 24 байршил газар, Хатанбулаг суманд түүх соёлын дурсгалт, орон нутгийн хамгаалалттай 12 байршил газрыг тус тус тэмдэгжүүлсэн. Тусгай хамгаалалттай 31 газрын 584037.51 га талбайг эзэнжүүлэх, хамгаалалтыг сайжруулах зорилгоор 55 идэвхтэн байгаль хамгаалагч томилсон.<br>Аймгийн нийт нутаг дэвсгэрийн 32.9 хувийг улсын болон орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутаг эзэлдэг. Алтанширээ сумын “Хайлсан шанд”, “Холбоогийн уул”, “Баянбуурал”, Эрдэнэ сумын “Цант хайрхан”, “Хар дэлийн шүү”, Хөвсгөл сумын "Уушны говийн өргөтгөл" зэрэг 52290.3 га газрыг орон нутгийн тусгай хамгаалалтад авсан. | 100 |
| | Газар доорх усны орд, усан сан бүхий газруудыг орон нутгийн тусгай хамгаалалтад авна. | Хамгаалалтад авсан усан сан бүхий газрын тоо | 1 | 2 | 2 | Зээгийн хөтлийн газрын доорх усны ордын тэжээгдлийн мужийг усан сан бүхий байгалийн нөөц газрын ангиллаар аймгийн тусгай хамгаалалтад авч, хамгаалалтын дэглэм мөрдүүлэх ажилд хяналт тавьж 2 удаагийн сургалт сурталчилгааг зохион байгуулж давхардсан тоогоор 856 иргэнийг хамруулсан.<br>Хатанбулаг сумын Баянмод газрын доорх цэнгэг усны орд, Мандах сумын Нарангийн хоолойн газрын доорх усны орд, Эрдэнэ сумын Ар гашууны худаг орчмын газруудыг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаар хэлэлцүүлэхээр холбогдох материалыг бэлтгэсэн.<br>Сумын Иргэдийн төлөөлгчдийн хурлын 2022 оны 7/39, 7/40, 7/41 дугаартай "Зарим газар нутгийг орон нутгийн тусгай хамгаалалтад авах тухай" тогтоолуудаар Хайлсан шанд, Холбоогийн уул, Баянбуурал нэртэй 28476.23 га газруудыг байгалын унаган төрх, өвөрмөц тогтоц бүхий түүх соёлын дурсгалт газар ангиллаар 30 жил орон | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | нутгийн тусгай хэрэгцээнд авч, тухайн талбайг Ашигт малтмалын газрын Геологи, уул уурхайн кадастрын бүртгэлд бүртгүүлсэн.<br>Усны нөөцийг бохирдож, хомстохоос хамгаалах, урьдчилан сэргийлэх зорилгоор Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2022 оны 09, 11 дүгээр албан даалгаврын хүрээнд усны сан бүхий газар, түүний хамгаалалтын бүс, ойр орчмын 88,5 га талбайг цэвэрлэж, 178,7 тн хог хаягдлыг 29 тээврийн хэрэгсээр төвлөрсөн хогийн цэгт төвлөрүүлсэн.<br>Даланжаргалан сумын 3 аж ахуйн нэгжийн 4, Сайншанд 1 худаг, Дэлгэрэх 1, Мандах 2, Улаанбадрах 2, Алтанширээ 1 худагт эрүүл ахуйн бүсийг шинээр тогтоон хашаажуулж, тэмдэгжүүлсэн. Усны нөөцийг бохирдож, хомстохоос хамгаалах, хөрсний бохирдлыг бууруулах зорилгоор хөрсний бохирдол үүсгэгч хүчин зүйлийн томоохон шалтгаан болж буй 18 нүхэн жорлонг буулган хөрсөнд үзүүлэх сөрөг нөлөөг бууруулсан.<br>Даланжаргалан сумын 3 аж ахуйн нэгжийн 4, Сайншанд 1 худаг, Дэлгэрэх 1, Мандах 2, Улаанбадрах 2, Алтанширээ 1 худагт эрүүл ахуйн бүсийг шинээр тогтоон хашаажуулж, тэмдэгжүүлсэн. | |
| ***Ерөнхий чиг үүрэг 6. Орон нутаг, хөдөөг хөгжүүлэх*** | | | | | | | |
| ***Үндсэн чиг үүрэг 6.1.*** *Орон нутгийн хөгжил* | | | | | | | |
| **Зорилт 6.1.1.**<br><br>Орон нутаг, хөдөөгийн хөгжлийг дэмжиж, дэд бүтцийг хөгжүүлэн иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлнэ. | Зарим сумдын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулах болон шинээр боловсруулна. | Хот хөгжлийн төлөвлөгөө боловсруулсан сумын тоо | 0 | 5 | 3 | Айраг сумын 2040 он хүртэлх хот хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлыг сумын орон нутгийн хөгжлийн сангийн 62,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар “Инженер геодези” ХХК-иар гүйцэтгүүлж, 650 га газрыг хамруулан төлөвлөлт хийн, сум, орон нутгийн удирдлага болон иргэд олон нийтээр 3 удаа хэлэлцүүлж, саналыг тусган эцэслэн боловсруулж, Барилгын хөгжлийн төвд хянагдан, магадлалын дүгнэлт гаргуулж, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулж, батлуулахаар хүргүүлсэн.<br>Өргөн сумын 2040 он хүртэлх хот хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах ажлыг сумын орон нутгийн хөгжлийн сангийн 34.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар "Тэнжин" ХХК-иар гүйцэтгүүлж, 380 га газрыг хамруулан төлөвлөлт хийсэн. Ерөнхий төлөвлөгөөний боловсруулалтын ажил дуусаж сум, орон нутгийн удирдлагуудад эцсийн шатны тайланг хүргүүлж санал авсан. | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Сайншанд хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу тус сумын 1, 2, 3, 4, 7 дугаар багийн нутаг дэвсгэрт 332 га газарт хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах ажлыг орон нутгийн төсвийн 150.0 сая төгрөгийн өртгөөр "Инженер геодези" ХХК-иар гүйцэтгүүлсэн.<br>Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг сум, орон нутгийн удирдлага болон иргэд олон нийтээр хэлэлцүүлж, саналыг тусган эцэслэн боловсруулж, Барилгын хөгжлийн төвд хянуулж, магадлалын дүгнэлт гаргуулахаар хүргүүлсэн. | |
| | Сайншанд, Замын-Үүд сумдын суурьшлын бүсэд хот суурины хөгжлийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулж, дахин төлөвлөлтийг үе шаттайгаар хэрэгжүүлнэ. | Төлөвлөгд сөн ажлын гүйцэтгэли йн хувь | 0 | 100 | 90 | Сайншанд сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 04/01 тогтоолоор гэр хорооллын газрыг шинэчлэн зохион байгуулах дахин төлөвлөх, төсөл хэрэгжүүлэх газрын байршлыг баталсан. 2023 оны эхний улиралд багтаан төр, хувийн түншлэлийн хүрээнд Сайншанд сумын 2-р багийн Дэнжийн хэсэгт байршилтай хуучны 2 давхар барилгуудыг буулган, дахин төлөвлөлт хийж 170 айлын орон сууц барих төслийг эхлүүлэхээр тооцоо судалгааны ажил хийгдсэн.<br>Сайншанд хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу тус сумын 1, 2, 3, 4, 7 дугаар багийн нутаг дэвсгэрт 332 га газарт хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах ажлыг орон нутгийн төсвийн 150.0 сая төгрөгийн өртгөөр гүйцэтгэж дуусган, магадлалын дүгнэлтийг албажуулахаар холбогдох байгууллагад хүргүүлсэн.<br>Замын-Үүд сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг 2030 он хүртэл хугацаатайгаар төлөвлөн, 3 дугаар багт 48 га талбайд шинэ суурьшлын бүс байгуулахаар шийдвэрлэж, 2017 онд "Нийслэлийн зураг төсвийн хүрээлэн" ХХК-д хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний зураг төслийг боловсруулсан.<br>Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу тухайн хэсэгт 50, 150 хүүхдийн цэцэрлэг, Иргэдийн хөгжлийн төвийн барилгууд баригдсан ба Соёл урлагийн ордон, 640 хүүхдийн сургууль, Өрхийн эмнэлгийн барилгууд баригдаж байгааг хяналтад авч ажилласан. Мөн 1.1 км автозам, 2.6 км дугуйн зам барих ажил хийгдсэн. | 90 |
| | Сайншанд суманд "Шинэ найрамдал" суурьшлын бүс байгуулна. | Хэсэгчилсэ н ерөнхий төлөвлөгө ө | 0 | 100 | 100 | Сайншанд сумын 7-р багийн нутаг дэвсгэр Нисэхийн хэсэгт 317 өрхийн 30.37 га газарт дахин зохион байгуулалт хийж, Орон нутгийн төсвийн 12.22 тэрбумын хөрөнгө оруулалтаар дулаан станц, цэвэр, бохир усны | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | боловсруулах ажлын гүйцэтгэлийн хувь | | | | шугам, 1.59 км автозам, Өлзийт хорооллын айл өрхийг цахилгаанд холбох ажлыг хийж гүйцэтгэн шинээр суурьшлын бүс байгуулах ажлыг эхлүүлсэн.<br>Дээрх суурьшлын бүсэд "Мандах наран-5" орон сууцны хороолол, "Саран хөхөө" театрын барилга, төвлөрсөн хангамж бүхий амины орон сууцны хороолол, төрийн үйлчилгээний нэгдсэн цогцолбор, Ерөнхий боловсролын сургууль зэрэг барилга бүтээн байгуулалтын ажлуудыг хийж гүйцэтгэхээр төлөвлөн, ажлууд эхэлсэн. | |
| | “Хашаандаа сайхан амьдаръя” санаачилгын хүрээнд амины орон сууц, гэр хорооллын айл өрхийг төвлөрсөн инженерийн шугам сүлжээнд холбох судалгааг хийж, төр, хувийн хэвшлийн санхүүжилтээр үе шаттайгаар хэрэгжүүлнэ. | Шинээр төвлөрсөн шугам сүлжээнд холбогдсон амины орон сууц, гэр хорооллын айл өрхийн тоо | 50 | 200 | 531 | Сайншанд сум нь Чандмань-Илч ХХК-тай хамтран 1, 3, 8-р багийн гэр хорооллын 60 өрхийг төвлөрсөн цэвэр, бохир усны шугамд 2021 онд холбосон. Орон нутгийн төсвийн 270,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Сайншанд сумын 6-р багийн Чойлонгийн гудамжинд цэвэр, бохир усны төв шугам татах, 3 дугаар багт цэвэр, бохир усны нэгдсэн шугам татах ажлууд хийгдэж, нийт 158 айл өрх төвлөрсөн шугам сүлжээнд холбогдох боломжийг бүрдүүлсэн.<br>Орон нутгийн төсөв, Орон нутгийн хөгжлийн сангийн 516.5 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Сайншанд сумын 1-р багийн гэр хорооллын гудамжаар Ш90мм голчтой 412м HDPE цэвэр усан хангамжийн шугам, Ш150мм, 200мм голчтой 740м бохир усны шугам татах, 6-р багийн Жанчивын гудамжинд ф90 мм-ийн голчтой 350м цэвэр усны шугам татах, 8-р багийн Үзүүрийн 11-р гудамжинд ф90 мм-ийн голчтой 403м цэвэр усны төв шугам татах, 4-р багийн гэр хороололд ф90 мм-ийн голчтой 490м цэвэр усны шугам татах ажлууд тус тус 2022 онд хийгдсэн.<br>"Чандмань-Илч" ХХК-аас төвлөрсөн инженерийн шугам сүлжээнд холбогдох техникийн нөхцөлийн зөвшөөрлийг 114 иргэнд олгон, 63 айл өрх төвлөрсөн инженерийн шугам сүлжээнд холбогдсон.<br>Замын-Үүд суманд “Чандмань бадрал” ОНӨХХК ус хангамжийн 1100 метр, дулаан хангамжийн 1211 метр, ариутгах татуургын 339 метр шугам сүлжээний ажлыг гүйцэтгэж нийт 197 айл өрх, аж ахуй нэгж, албан байгууллагыг холбон, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2-р дугаар багийн Өртөөний гудамжинд 200 метр урт дулааны шугамын ажил 100% гүйцэтгэж дууссан. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Замын-Үүд сумын орон нутгийн хөгжлийн сангийн 249.6 сая төгрөгийн санхүүжилтээр Сүлд багийн 11 болон 12 дугаар хэсэгт 730м бохир усны төвийн шугам сүлжээ татах ажлыг “Замын-Үүдийн дулааны станц” ТӨҮГ гүйцэтгэж, 65 айл өрх төвлөрсөн шугам сүлжээнд холбогдсон.<br>2022 оны 11 сарын 15-ны өдрийн байдлаар 10 суманд нийт 531 өрхийг төвлөрсөн шугам сүлжээнд холбосон. | |
| | Хот, суурин газруудад үерийн ус зайлуулах далан, суваг, шуудууг нэмэгдүүлэх ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ. | Шинэчлэн засварласан болон шинээр барьсан сувагчиллын урт | 1.1 км | 1.5 км | 0.97 км | Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн нэмэлт санхүүжилтийн МОН3388 төсөл, Барилга хот байгуулалтын яам болон “Комфорт импекс” ХХК-ийн хооронд байгуулсан “Дорноговь аймгийн Цэвэрлэх байгууламж болон бусад туслах үйлчилгээ”-ний ажил гүйцэтгэх А1.2.2-2021/84 дугаартай гэрээнд 2022 оны 10 сарын 28-ны өдөр оруулсан нэмэлт өөрчлөлтөөр “Дорноговь аймгийн Сайншанд сумын үерийн хамгаалалтын барилга байгууламж, замын ус зайлуулах шугамын ажил”-ыг санхүүжилтийг 640,6 сая төгрөг болгож ажлын тоо хэмжээг өөрчилж баталсан.<br>Зураг төслийг боловсруулах ажлыг "Хайдро дизайн прожект" ХХК-аар гүйцэтгүүлсэн.<br>Сайншанд сумын 1, 6-р багийн нутаг дэвсгэрт 520 м урттай борооны ус зайлуулах шугам хоолой, 380м урттай үерийн хамгаалалтын суваг хийх ажлыг "Компорт импекс" ХХК хийж гүйцэтгэж байгаа бөгөөд 70%-ийн гүйцэтгэлтэй ажилласан. | 70 |
| | Сумдад “Тэгш гудамж” төсөл хэрэгжүүлнэ. | Төлөвлөгдсөн ажлын гүйцэтгэлийн хувь | 0 | 100 | 70 | Улаанбадрах сумын 4-р багийн рашаанд гудамжны 23 иргэний 1.725 га газарт “Тэгш гудамж” төслийг хэрэгжүүлж, гэр байрны айл өрхийг хашаажуулах ажлыг “Мандах таун” ХХК 211,933,680 төгрөгийн хөрөнгөөр гүйцэтгэн, иргэдийн амьдрах таатай нөхцөл, эдийн засгийн эргэлтэд орох боломжийг бүрдүүлж өгсөн.<br>Замын-Үүд суманд төслийн хүрээнд 2022 онд Ди Вай Кэй Би ХХК-тай Барилга хот байгуулалтын яам 1,062,000,018 төгрөгөөр 2022 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс 2023 оны 09 дүгээр сарын 30-ний өдрийг хүртэл гүйцэтгэхээр гэрээ байгуулсан. Гүйцэтгэл 40%-тай | 70 |
| | Орон сууц нийтийн аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа явуулах бүтцийг бий | Төлөвлөгдсөн ажлын гүйцэтгэлийн хувь | 0 | 100 | 90 | Сайншанд сумын шинэ суурьшлын бүсэд 11.2 МВт-ын халаалтын зуухны эх үүсвэр, гадна дулаан хангамж, ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ шинээр барих ажлыг орон нутгийн төсвийн 10,0 тэрбум төгрөгийн хөрөнгө | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | болгох замаар орон сууцны ус, дулаан хангамж, ариутгах татуургын шугам сүлжээний засвар үйлчилгээг сайжруулах асуудлыг судалж шийдвэрлэнэ. | | | | | оруулалтаар “Чандмань-Илч” ОНӨХХК гүйцэтгэж байгаа бөгөөд гадна шугам сүлжээ, бохир усны насосны станц, цэвэр усны насосны станцын барилгын угсралтын ажлууд бүрэн дууссан.<br>Чойр-Сайншанд чиглэлд цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц барих зориулалтаар 7.8 га газрыг орон нутгаас 2021 онд шийдвэрлэж газрын гэрчилгээг олгосон. Цахилгаан дамжуулах агаарын шугамын холбогдох трассыг 2022 онд хянаж батлуулан дэмжлэг үзүүлж хамтран ажилласан.<br>Сайншанд сумын дулаан хангамжийг хоёрдогч хэлхээнд шилжүүлэх ажлын хүрээнд төв садны хашаанд 1, 4-р 58 байрны урд талд-1, 9 дүгээр цэцэрлэгийн баруун талд-1, 5-р 58 байрны хойно-1 ус дулаан дамжуулах төвийн нийт 4 барилгыг Эрчим хүчний яамны төслийн санхүүжилтээр "Одкон холдинг" ХХК, гадна шугам холболтыг Чандмань-Илч ОНӨХХК тус тус хийж гүйцэтгэн, 100% ашиглалтад оруулсан. | 90 |
| | | | | | | | |